



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 07 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ПҮРЭВ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2025 оны 07 дугаар сарын 03-ны өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	3-26
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	27-134

1. Улсын Их Хурлын чуулганаар Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэх	28-29
2. Улсын Их Хурлын чуулганаар Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэх	29-30
3. Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, үргэлжлэл/	30
4. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 05 дугаар дүгнэлт /Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай/	31-34
5. Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан нарын 40 гишүүн 2025.06.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	34-37
6. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	37-63
7. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/	63-77
8. “Тогтоолын төсөл буцаах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолыг танилцуулах	77

- 9.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газрын 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/ 77-85
- 10.Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/ 85-101
- 11.“Зээлийн хүүг бууруулах хүрээнд авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл 101-130
- 12.Батлагдсан хууль, тогтоолын эцсийн найруулга сонсох 130-132

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит
чуулганы 07 дугаар сарын 03-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 81 гишүүн хүрэлцэн ирж, 64.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 05 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: О.Амгаланбаатар, Х.Баттулга, Б.Дэлгэрсайхан, П.Наранбаяр, Д.Цогтбаатар, Д.Энхтуяа;

Чөлөөтэй: Л.Оюун-Эрдэнэ, Ө.Шижир;

Эмнэлгийн чөлөөтэй: Н.Алтанхуяг, Д.Бум-Очир, А.Ганбаатар, Л.Гантөмөр, С.Лүндэг, П.Мөнхтулга;

Хоцорсон: Ж.Алдаржавхлан-2 цаг 27 минут, Т.Аубакир-10 минут, Ц.Баатархүү-05 минут, М.Бадамсүрэн-08 минут, Ж.Батжаргал-04 минут, Ж.Батсуурь-26 минут, Ж.Бат-Эрдэнэ-10 минут, Ш.Бямбасүрэн-02 минут, Б.Жавхлан-11 минут, Д.Жаргалсайхан-54 минут, Б.Заяабал-02 минут, Ц.Мөнхтуяа-02 минут, О.Номинчимэг-06 минут, Н.Номтойбаяр-07 минут, С.Одонтуяа-01 минут, Ц.Сандаг-Очир-10 минут, Ц.Туваан-02 минут, Б.Түвшин-10 минут, Б.Хэрлэн-02 минут, О.Цогтгэрэл-09 минут, Б.Чойжилсүрэн-05 минут, Б.Энхбаяр-2 цаг 36 минут, Ж.Энхбаяр-06 минут, Д.Энхтүвшин-06 минут, М.Энхцэцэг-14 минут, Р.Эрдэнэбүрэн-15 минут.

Нэг.Улсын Их Хурлын чуулганаар Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэх

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д “Засгийн газрын хуралдааны шийдвэрийг үндэслэн Ерөнхий сайд Үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд бичгээр хүсэлт тавьсан бол Улсын Их Хурлын дарга төслийг чуулганаар яаралтай хэлэлцэх эсэхийг нэгдсэн хуралдаанд оруулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлүүлнэ.” гэж заасны дагуу Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцүүлэхээр 2025 оны 07 дугаар сарын 03-ны өдөр ЗГ/92 дугаартай албан бичиг ирүүлсэн болохыг танилцуулав.

Д.Амарбаясгалан: Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	40
Татгалзсан	54
Бүгд	94

42.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Энхбаярын “дэмжсэн” санал эсрэг гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Ж.Энхбаярын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	46
Татгалзсан	50
Бүгд	96

47.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Уг асуудлыг 14 цаг 14 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Улсын Их Хурлын чуулганаар Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэх

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д “Засгийн газрын хуралдааны шийдвэрийг үндэслэн Ерөнхий сайд Үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд бичгээр хүсэлт тавьсан бол Улсын Их Хурлын дарга төслийг чуулганаар яаралтай хэлэлцэх эсэхийг нэгдсэн хуралдаанд оруулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлүүлнэ.” гэж заасны дагуу Засгийн газраас 2025 оны 07 дугаар сарын 03-ны өдөр Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн болохыг танилцуулав.

Д.Амарбаясгалан: Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	65
Татгалзсан	38
Бүгд	103

63.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн тул Төсвийн тогтвортой байдлын тухай

хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 14 цаг 17 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, үргэлжлэл/

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа нар байлцав.

“Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Д.Амарбаясгалан: Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны саналаар Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналаар санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	79
Татгалзсан	25
Бүгд	104

76.0 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 14 цаг 19 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 05 дугаар дүгнэлт /Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Гангабаатар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа нар байлцав.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 05 дугаар дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Гангабаатар танилцуулав.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, П.Сайнзориг нар үг хэлэв.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 05 дугаар дүгнэлттэй танилцав./14:29/

Уг асуудлыг 14 цаг 29 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан нарын 40 гишүүн 2025.06.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, **анхны хэлэлцүүлэг**/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Г.Алтанцэцэг, Л.Баянмөнх, С.Дунжидмаа, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд ахлах зөвлөх Б.Хатантуул, Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Нарантуяа нар байлцав.

Төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Э.Одбаяр танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан хариулж, тайлбар хийв.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооноос гаргасан, Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	68
Татгалзсан	41
Бүгд	109

62.4 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	77
Татгалзсан	32
Бүгд	109

70.6 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Уг асуудлыг 14 цаг 41 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, **анхны хэлэлцүүлэг**/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Хөгжлийн

санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, мөн газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, Б.Нандингэрэл, С.Дунжидмаа, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Нарантуяа нар байлцав.

Төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, Б.Бейсен, Ж.Баярмаа, Б.Заяабал, Ц.Мөнхтуяа, Д.Энхтүвшин, О.Номинчимэг нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн, Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

НЭГ.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Д.Амарбаясгалан: 1.Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “1/12 дугаар зүйлийн 12.1.24 дэх заалт: “12.1.24. тухайн жилийн төсвийн тухай хуульд заасан улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг орон нутгийн ерөнхий орлогын данснаас татан төвлөрүүлэх.”” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар, Б.Пүрэвдорж нар үг хэлэв.

Зөвшөөрсөн	70
Татгалзсан	39

Бүгд 109
64.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан, Б.Баярбаатар, Ш.Бямбасүрэн, Д.Ганбат, Б.Заяабал, Ч.Лодойсамбуу, М.Нарантуяа-Нара, Д.Пүрэвдаваа, П.Сайнзориг, Да.Цогтбаатар, Б.Уянга, Г.Уянгахишиг, Д.Үүрийнтуяа /цаашид ажлын хэсэг гэх/ нарын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн 72
Татгалзсан 37
Бүгд 109
66.1 хувийн саналаар дэмжигдлээ.

ХОЁР. “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Д.Амарбаясгалан: 1.Ажлын хэсгийн гаргасан, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, Х.Ганхуяг, Ц.Туваан нар үг хэлэв.

Зөвшөөрсөн 67
Татгалзсан 42
Бүгд 109
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

ГУРАВ. “Алт-3” аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Д.Амарбаясгалан: 1.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтын “Алт-3” аяныг 2025 оны ... дугаар сарын ..-ны өдрөөс эхлэн орон даяар зарлан хэрэгжүүлсүгэй” гэснийг “дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Г.Занданшатар/-т даалгасугай” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн 71
Татгалзсан 38
Бүгд 109
65.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дахь заалтын “2. “Алт-3” аяныг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатарт даалгасугай. Үүнд:” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	70
Татгалзсан	39
Бүгд	109

64.2 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дахь заалтын 4 дэх дэд заалтын “боловсруулан” гэсний дараа “Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэж нэмж, мөн дэд заалтын “Алтны” гэснийг, мөн дэд заалтын “батлуулах” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	70
Татгалзсан	39
Бүгд	109

64.2 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төсөлд доор дурдсан агуулгатай 3, 4 дэх заалт нэмэх:

“3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо /Ц.Даваасүрэн/-нд даалгасугай.

4.Энэ тогтоолыг Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	73
Татгалзсан	36
Бүгд	109

67.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал:

Д.Амарбаясгалан: 1.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дахь заалтын 2 дахь дэд заалтад “эрх үүргийн харилцааг тодорхой болгож,” гэсний дараа “төсөл хэрэгжиж байгаа суманд үр өгөөжийн дийлэнхийг үлдээж” гэж нэмж, мөн дэд заалтын “эрх зүйн орчныг өөрчлөх” гэснийг “эрх зүйн орчныг сайжруулж, хууль тогтоомжийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэж өөрчилж, мөн дэд заалтын “арга хэмжээг шуурхай авах” гэснийг болон 3 дахь дэд заалтын “арга хэмжээг авах” гэснийг тус тус хасах гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн гишүүн Б.Уянга, Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн нар үг хэлэв.

Зөвшөөрсөн	54
Татгалзсан	55

Бүгд 109
49.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дахь заалтын 5 дахь дэд заалтын “эргэлтэд оруулах” гэсний дараа зорилгоор “Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах, хилийн заагт өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын 2020 оны 46 дугаар тогтоол, “Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай” 2020 оны Монгол Улсын Их Хурлын 47 дугаар тогтоолын холбогдох хавсралтад өөрчлөлт оруулах Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд яаралтай өргөн мэдүүлэх” гэж нэмэх гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Б.Батбаатар, Х.Булгантуяа, Да.Цогтбаатар, Х.Тэмүүжин нар үг хэлэв.

Зөвшөөрсөн 37
Татгалзсан 71
Бүгд 108
34.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

3.Ажлын хэсгийн гаргасан, Тогтоолын төслийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 6 дахь дэд заалт нэмэх:

“6/Тогтоолын төслийн 2 дахь заалтын 5 дахь дэд заалтад заасан нөхцөлийг хангах үүднээс хөрөнгө оруулагч, тусгай зөвшөөрөл эзэмшигчид учирч байгаа хүндрэл, үүний дотор газар ашиглахтай холбоотой асуудлыг судлан, эрх зүйн орчныг сайжруулж, хууль тогтоомжийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.” гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Ц.Даваасүрэн, Б.Мөнхсоёл, Ж.Бат-Эрдэнэ нар үг хэлэв.

Зөвшөөрсөн 55
Татгалзсан 53
Бүгд 108
50.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

ДӨРӨВ. Найруулгын санал:

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Д.Амарбаясгалан: 1.Ажлын хэсгийн гаргасан, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллууд дэмжигдсэнтэй холбогдуулан эдгээр хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн зүйл, хэсэг, заалтын дугаарыг өөрчлөх, агуулга зарчмыг хөндөхгүйгээр үг хэллэг, найруулгын шинжтэй засвар хийх гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг үг хэлэв.

Зөвшөөрсөн	71
Татгалзсан	37
Бүгд	108

65.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дуусав.

Хууль, тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 16 цаг 18 минутад хэлэлцэж дуусав.

Долоо.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Н.Энхбаяр, мөн зөвлөлийн гишүүн Ж.Дэлгэрсайхан, Н.Ууганбаатар, А.Энхбат, Монгол Улсын ерөнхий аудиторын орлогч З.Цэдэнжав, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газрын дарга Д.Баттогтох, Макро эдийн засгийн бодлогын газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Мөнгөнсүх, Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн дарга О.Мөнхтөр, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, мөн газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, Эрчим хүчний яамны Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан,

Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, мөн хэлтсийн референт С.Төрмөнх, Ч.Сарантуяа, Хяналт шалгалтын газрын референт Д.Мөнхтуяа нар байлцав.

Хуулийн төслүүдийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл, төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан төсвийн санал нь Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71.7.2, 71.7.3-т заасан шаардлагыг хангасан эсэх талаарх дүгнэлтийг Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу нар танилцуулав.

Төсвийн байнгын хорооноос нэгтгэн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёолол

НЭГ.Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Нэг.Ажлын хэсгийн санал:

Д.Амарбаясгалан: 1.Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Ж.Алдаржавхлан, А.Ариунзаяа, Х.Баасанжаргал, Ц.Баатархүү, М.Бадамсүрэн, Р.Батболд, Ж.Батжаргал, П.Ганзориг, Б.Заяабал, Ц.Идэрбат, Ц.Мөнхбат, Б.Мөнхсоёл, Ч.Номин, Б.Түвшин, Б.Пунсалмаа, Д.Пүрэвдаваа, Р.Сэддорж, Ц.Туваан /цаашид “ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр төсвийн зардал хооронд зохицуулалт хийх санал

1.1.Зардал бууруулах санал:

-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх зардалд зориулж Удирдлагын академид олгодог санхүүжилтийг 2,600.0 сая төгрөгөөр;

-Дэд сайдын томилгоог хойшлуулахтай холбоотойгоор урсгал зардлыг 2,189.7 сая төгрөгөөр;

-Сангийн сайдын төсвийн багц дахь Засгийн газрын нөөц сангийн зардлыг 16,336.9 сая төгрөгөөр;

-Нэгдсэн төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн төслийн урсгал зарлагын цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, зээлийн хүүгийн төлбөр, гадаад зээл, тусламжийн эх үүсвэрээс санхүүжих зардал, үйл ажиллагааны орлогоос бүрэн санхүүждэг зардлаас бусад урсгал зардлыг 0.3 хувиар буюу

30,649.0 сая төгрөгөөр тус тус бууруулан, эдгээр эх үүсвэрээр дараах арга хэмжээний санхүүжилтийг нэмэгдүүлэх. Үүнд:

1.2.Урсгал зардал нэмэгдүүлэх санал:

-Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газраас татаж авсантай холбогдуулан холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарын урсгал зардлыг 1,144.0 сая төгрөгөөр;

-Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын төсвийн урсгал зардлыг 1,000.0 сая төгрөгөөр;

-Гэр бүл, хүүхдийн хэрэг маргааныг шийдвэрлэх анхан болон давж заалдах шатны шүүхийг шинээр байгуулах бэлтгэл ажлыг хангахад шаардагдах зардалд зориулж Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын төсвийн багцын урсгал зардлыг 12,581.5 сая төгрөгөөр;

-Олон улсын гэрээ хэлэлцээрийн хүрээнд Монголын талын хариуцах зардал буюу Монгол-Германы хамтарсан Технологийн дээд сургуулийн татаасыг 517.5 сая төгрөгөөр, Монгол-Япон эмнэлгийн татаасыг 1,600.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн Боловсролын сайдын төсвийн багцын урсгал зардалд нийт 2,117.5 сая төгрөгийг нэмж тусгах;

-Мөнгө угаах, хөрөнгө буцаах, үндэстэн дамнасан болон авлига албан тушаалын хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой болон прокурорын байгууллагын гэрээгээр хүлээсэн зарим зардлыг санхүүжүүлэхэд зориулж Улсын ерөнхий прокурорын төсвийн багцын урсгал зардлыг нийт 1,307.9 сая төгрөгөөр;

-“Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт “Дотоод хэргийн их сургуулийн шинжлэх ухаан, инновацын чадавхыг нэмэгдүүлнэ” гэж заасан зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд Дотоод хэргийн их сургуулийн урсгал зардлыг 458.0 сая төгрөгөөр;

-2025 оноос хос бичигт шилжүүлэх ажлыг эрчимжүүлэхтэй холбогдуулан Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн ажлын албаны урсгал зардлыг 936.7 сая төгрөгөөр;

-Говийн бүс нутгийг усжуулах, усан хангамжийг нэмэгдүүлэх хүрээнд хийгдэх судалгаа, шинжилгээний төслийн нэгжийн зардлыг 230.0 сая төгрөгөөр;

-Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академийн үйл ажиллагааны урсгал зардалд зориулж Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн багцын урсгал зардлыг 1,000.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэх.

1.3.Хөрөнгийн зардал нэмэгдүүлэх санал:

-Төслийн 2 дугаар хавсралтын ХХ.3.2-т тусгагдсан “Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг 19,000.0 сая төгрөгөөр;

-Төслийн 2 дугаар хавсралтын XII.1.3.2-т тусгагдсан “Боловсролын салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг 7,400.0 сая төгрөгөөр;

-Төслийн 2 дугаар хавсралтын XI.1.1-д тусгагдсан “Гадаргын ус хуримтлуулах хөв цөөрөм байгуулах /Баруун бүс/” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг 4,600.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	65
Татгалзсан	46
Бүгд	111

58.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Бусад Байнгын хорооны санал:

Д.Амарбаясгалан: 1.Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрамын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтад тусгагдсан Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн 35.3.1.1 дэх дэд заалтын “Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг чадавхжуулах сургалтад хамрагдах хүн” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин “100,000” гэснийг “15,000” гэж өөрчлөх гэсэн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	68
Татгалзсан	44
Бүгд	112

60.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрамын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн 35.3.2 дахь заалтад тусгагдсан “Аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадварыг сайжруулна” гэсэн хөтөлбөрийг бүхэлд нь хасах гэсэн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо, Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	68
Татгалзсан	44
Бүгд	112

60.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрамын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтад тусгагдсан Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн 35.4.1.1 дэх дэд заалтын “Зорилтот бүлгийн залуучуудын нийгмийн оролцоо, үйлчилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлнэ” гэсэн шалгуур үзүүлэлтийн зорилтот түвшин “46 хувь” гэснийг “30 хувь” гэж өөрчлөх гэсэн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо, Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	71
Татгалзсан	41

Бүгд 112
63.4 хувийн саналаар дэмжигдлээ.

**Гурав.Төсвийн байнгын хорооны гишүүдээс
гаргасан санал:**

Д.Амарбаясгалан: 1.Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяагийн гаргасан, Нэгдсэн төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн төслийн урсгал зардлын цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, зээлийн хүүгийн төлбөр, гадаад зээл, тусламжийн эх үүсвэрээс санхүүжих зардал, үйл ажиллагааны орлогоос бүрэн санхүүждэг зардлаас бусад урсгал зардлыг 0.01 хувиар буюу 1,000.0 сая төгрөгөөр бууруулж, мөн дүнгээр Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын багцын Биеийн тамир, спортын улсын хорооны Монгол Улсад зохиогдох олон улсын тэмцээний санхүүжилтийг нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн 69
Татгалзсан 42
Бүгд 111
61.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Р.Батболдын гаргасан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багцын “Хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг дэмжих татаас урамшуулал”-ыг 15,000.0 сая төгрөгөөр бууруулж, мөн дүнгээр тус сайдын төсвийн багцын “Шинэ хоршоо хөдөлгөөний зээлийн батлан даалтын сан”-гийн төсвийг нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн 41
Татгалзсан 71
Бүгд 112
36.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

**Дөрөв.Зарчмын зөрүүтэй саналын томьёололд нийцүүлэн
хуулийн төсөлд өөрчлөлт оруулах санал:**

Д.Амарбаясгалан: 1.Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн гаргасан, Төслийн болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэнтэй уялдуулан төсвийн ерөнхийлөн захирагчдын зарцуулах зардалд өөрчлөлт оруулах, төслүүдийн зүйл, хэсэг, заалтын дугаарлалт болон тэдгээрийн эшлэлийг нийцүүлж өөрчлөх, үг хэллэг, нэр томьёог жигдлэх засварыг хийх, мөн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд төслийн код өгөх, дугаар, эдийн засгийн ангилал, хэрэгжих хугацааг саналын томьёололд нийцүүлэн өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн 62
Татгалзсан 50
Бүгд 112
55.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

ХОЁР.Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал:

Нэг.Ажлын хэсгийн санал

Д.Амарбаясгалан: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын ХХҮИ.1.9-д тусгагдсан “Шинэ Ховд” үйлдвэр технологийн паркийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт /Ховд, Жаргалант сум/, хэрэгжих хугацаа 2022-2025 он, төсөвт өртөг 36,134.9 сая төгрөг, санхүүжих дүн 18,184.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг 1,721.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	38
Татгалзсан	74
Бүгд	112

33.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Хоёр.Бусад Байнгын хорооны санал

Д.Амарбаясгалан: 1.Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, Б.Хэрлэн нарын гаргасан, Боловсролын сайдын төсвийн багцын урсгал зардлын Бараа үйлчилгээний бусад зардлыг 5,800.0 сая төгрөгөөр бууруулж, мөн дүнгээр Төрийн өмчит их, дээд сургуульд олгох татаасыг нэмэгдүүлэх гэсэн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны болон Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	51
Татгалзсан	61
Бүгд	112

45.5 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Гурав.Төсвийн байнгын хорооны гишүүдээс гаргасан санал:

Д.Амарбаясгалан: 1.Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалангийн гаргасан, Нэгдсэн төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн төслийн урсгал зардлын цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, зээлийн хүүгийн төлбөр, гадаад зээл, тусламжийн эх үүсвэрээс санхүүжих зардал, үйл ажиллагааны орлогоос бүрэн санхүүждэг зардлаас бусад урсгал зардлыг 0,045 хувиар буюу 4,500.0 сая төгрөгөөр бууруулж энэ эх үүсвэрээр дараах төсвийн ерөнхийлөн захирагчдын урсгал зардлыг нэмэгдүүлэх. Үүнд:

-Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын төсвийн багцын урсгал зардлыг 2,000.0 сая төгрөгөөр;

-Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн багцын урсгал зардлыг 1,500.0 сая төгрөгөөр;

-Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын Биеийн тамир, спортын улсын хорооны Монгол Улсад зохиогдох олон улсын тэмцээний зардлыг 1,000.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэх гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	44
Татгалзсан	68
Бүгд	112

39.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар Монгол Улсын Ерөнхий сайдын төсвийн багцын судалгааны зардлыг 2,900.0 сая төгрөгөөр бууруулж, мөн дүнгээр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын багцын Усны газрын урсгал зардлыг нэмэгдүүлэх гэсэн саналаа татаж авсан тул санал хураалт явагдаагүй болно.

3.Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшингийн гаргасан, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын төсвийн багцын Ойжуулалтын хөтөлбөрийн зардлыг 2,990.0 сая төгрөгөөр бууруулж, мөн дүнгээр тус сайдын төсвийн багц дахь Усны нөөц, нуур, гол мөрний менежментийн хөтөлбөрийн зардлыг нэмэгдүүлэх гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин саналаа тайлбарлаж, үг хэлэв.

Зөвшөөрсөн	12
Татгалзсан	100
Бүгд	112

10.7 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

4.Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатарын гаргасан, Боловсролын сайдын төсвийн багцын Нийслэлийн боловсролын газрын урсгал зардлыг 2,600.0 сая төгрөгөөр бууруулж, мөн дүнгээр Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын урсгал зардлыг нэмэгдүүлэх гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар саналаа тайлбарлаж, үг хэлэв.

Зөвшөөрсөн	44
Татгалзсан	68
Бүгд	112

39.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

5.Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар, Д.Пүрэвдаваа нарын гаргасан, Сангийн сайдын төсвийн багцын Засгийн газрын нөөц сангийн зардлыг 84.6 сая төгрөгөөр бууруулж, мөн дүнгээр Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын даргын төсвийн бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг нэмэгдүүлэх гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	38
Татгалзсан	74
Бүгд	112

33.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

6.Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатарын гаргасан, Монгол Улсын Ерөнхий сайдын төсвийн багцын урсгал зардлыг 3,700.0 сая төгрөгөөр бууруулж, мөн дүнгээр төслийн 2 дугаар хавсралтад “Нэгдсэн эмнэлгийн барилга, 100 ор /Баян-Өлгий, Өлгий сум/ төслийн нэмэлт санхүүжилт”, төсөвт өртөг, санхүүжих дүн 3,700.0 сая гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	35
Татгалзсан	77
Бүгд	112

31.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

7.Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатарын гаргасан, Сангийн сайдын төсвийн багцын Засгийн газрын нөөц сангийн зардлыг 1,781.1 сая төгрөгөөр бууруулж, мөн дүнгээр төслийн 2 дугаар хавсралтын ХҮЛ.1.12.Гэр хорооллын шугам сүлжээ /Өвөрхангай, Арвайхээр сум/ гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг нэмэгдүүлэх гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	29
Татгалзсан	83
Бүгд	112

25.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

8.Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалангийн гаргасан, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын төсвийн багцын урсгал зардлыг 2,976.0 сая төгрөгөөр бууруулж, мөн дүнгээр төслийн 2 дугаар хавсралтын IY.2.3.1-д тусгагдсан “Шинжлэх ухааны академийн харьяа хүрээлэнгийн Хэрэглээний Биотехнологийн лабораторийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг нэмэгдүүлэх гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	36
Татгалзсан	76
Бүгд	112

32.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

9.Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаярын гаргасан, Сангийн сайдын төсвийн багцын Засгийн газрын нөөц сангийн зардлыг 50,000.0 сая төгрөгөөр бууруулж, төсвийн тэнцлийг сайжруулах гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн, Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа нар тайлбар хийв.

Зөвшөөрсөн	57
Татгалзсан	55
Бүгд	112

50.9 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаярын гаргасан, Эдийн засаг, хөгжлийн сайдын төсвийн багцын урсгал зардлын гадаад томилолтын зардлыг 1,212.2 сая төгрөгөөр бууруулж, төсвийн тэнцлийг сайжруулах гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн 55

Татгалзсан 57

Бүгд 112

49.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

11.Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатарын гаргасан, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын “Эрчим хүчний реформын үндэсний хороо”-ны зардлыг 400.0 сая төгрөгөөр бууруулж, мөн дүнгээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багцын Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын урсгал зардлыг нэмэгдүүлэх гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар саналаа тайлбарлаж, үг хэлэв.

Зөвшөөрсөн 31

Татгалзсан 81

Бүгд 112

27.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дуусав.

Хуулийн төслүүдийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 02 минутад хэлэлцэж дуусав.

Найм.“Тогтоолын төсөл буцаах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолыг танилцуулах

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа нар байлцав.

Д.Амарбаясгалан: Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.12 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас Тогтоох нь:

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр Монгол Улсын Их Хуралд Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хууль санаачлагчид нь буцаах нь зүйтэй гэсэн Байнгын хорооны санал дүгнэлтийг нэгдсэн

хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул хууль санаачлагчид буцаасугай.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Улсын Их Хурлын тогтоолыг уншиж танилцуулав. /17:03/

Уг асуудлыг 17 цаг 03 минутад хэлэлцэж дуусав.

Ес.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газрын 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Н.Энхбаяр, мөн зөвлөлийн гишүүн Ж.Дэлгэрсайхан, Н.Ууганбаатар, А.Энхбат, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Хөрөнгө оруулалтын бодлого зохицуулалтын газрын дарга Б.Анар, Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газрын дарга Д.Баттогтох, Макро эдийн засгийн бодлогын газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Хөгжлийн нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Мөнгөнсүх, Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн дарга О.Мөнхтөр, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам нар байлцав.

Төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, Ж.Баярмаа нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Сангийн сайд Б.Жавхлан нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Д.Амарбаясгалан: 1.Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Ж.Алдаржавхлан, А.Ариунзаяа, Х.Баасанжаргал, Ц.Баатархүү, М.Бадамсүрэн, Р.Батболд, Ж.Батжаргал, П.Ганзориг, Б.Заяабал, Ц.Идэрбат, Ц.Мөнхбат, Б.Мөнхсоёл, Ч.Номин, Б.Түвшин, Б.Пунсалмаа, Д.Пүрэвдаваа, Р.Сэддорж, Ц.Туваан /цаашид ажлын хэсэг гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн Эдийн засгийн үндсэн үзүүлэлт дэх Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/ 2026 онд “5.7” гэснийг “6.0” гэж, 2027 онд “6.3” гэснийг “6.5” гэж, Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ /тэрбум төгрөг/ 2026 онд “31,720.4” гэснийг “33,479.5” гэж, 2027 онд “33,761.0” гэснийг “35,628.6” гэж, Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2026 онд “30.9” гэснийг “31.7” гэж, 2027 онд “29.3” гэснийг “30.4” гэж, Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/ 2026 онд “32,839.8” гэснийг “33,479.5” гэж, 2027 онд “34,626.0” гэснийг “35,628.6” гэж, Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2026 онд “32.0” гэснийг “31.7” гэж, 2027 онд “30.0” гэснийг “30.4” гэж, Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/ 2026 онд “-1,119.4” гэснийг “0” гэж, 2027 онд “-865.0” гэснийг “0” гэж, Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2026 онд “-1.1” гэснийг “0” гэж, 2027 онд “-0.7” гэснийг “0” гэж, Нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/ 2026 онд “29,666.4” гэснийг “30,314.5” гэж, 2027 онд “31,452.6” гэснийг “33,282.2” гэж, Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2026 онд “28.9” гэснийг “28.7” гэж, 2027 онд “27.3” гэснийг “28.4” гэж, Нэгдсэн төсвийн суурь тэнцэл /тэрбум төгрөг/ 2026 онд “2,054.0” гэснийг “3,165.0” гэж, 2027 онд “2,308.4” гэснийг “2,346.4” гэж, Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2026 онд “2.0” гэснийг “3.0” гэж, Засгийн газрын өрийн нийт хэмжээ /тэрбум төгрөг/ 2026 онд “51,350.0” гэснийг “52,750.0” гэж, 2027 онд “51,939.0” гэснийг “52,794.0” гэж, Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс хуваарилах зардлын Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2026 онд “2.6” гэснийг “2.5” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	53
Татгалзсан	59
Бүгд	112

47.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлангийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	66
Татгалзсан	46
Бүгд	112

58.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн үг хэлэв.

Д.Амарбаясгалан: 1.Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Ж.Алдаржавхлан, А.Ариунзаяа, Х.Баасанжаргал, Ц.Баатархүү, М.Бадамсүрэн, Р.Батболд, Ж.Батжаргал, П.Ганзориг, Б.Заяабал, Ц.Идэрбат, Ц.Мөнхбат, Б.Мөнхсоёл, Ч.Номин, Б.Түвшин, Б.Пунсалмаа, Д.Пүрэвдаваа, Р.Сэддорж, Ц.Туваан /цаашид ажлын хэсэг гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн Эдийн засгийн үндсэн

үзүүлэлт дэх Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/ 2026 онд “5.7” гэснийг “6.0” гэж, 2027 онд “6.3” гэснийг “6.5” гэж, Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ /тэрбум төгрөг/ 2026 онд “31,720.4” гэснийг “33,479.5” гэж, 2027 онд “33,761.0” гэснийг “35,628.6” гэж, Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2026 онд “30.9” гэснийг “31.7” гэж, 2027 онд “29.3” гэснийг “30.4” гэж, Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/ 2026 онд “32,839.8” гэснийг “33,479.5” гэж, 2027 онд “34,626.0” гэснийг “35,628.6” гэж, Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2026 онд “32.0” гэснийг “31.7” гэж, 2027 онд “30.0” гэснийг “30.4” гэж, Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/ 2026 онд “-1,119.4” гэснийг “0” гэж, 2027 онд “-865.0” гэснийг “0” гэж, Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2026 онд “-1.1” гэснийг “0” гэж, 2027 онд “-0.7” гэснийг “0” гэж, Нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/ 2026 онд “29,666.4” гэснийг “30,314.5” гэж, 2027 онд “31,452.6” гэснийг “33,282.2” гэж, Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2026 онд “28.9” гэснийг “28.7” гэж, 2027 онд “27.3” гэснийг “28.4” гэж, Нэгдсэн төсвийн суурь тэнцэл /тэрбум төгрөг/ 2026 онд “2,054.0” гэснийг “3,165.0” гэж, 2027 онд “2,308.4” гэснийг “2,346.4” гэж, Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2026 онд “2.0” гэснийг “3.0” гэж, Засгийн газрын өрийн нийт хэмжээ /тэрбум төгрөг/ 2026 онд “51,350.0” гэснийг “52,750.0” гэж, 2027 онд “51,939.0” гэснийг “52,794.0” гэж, Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс хуваарилах зардлын Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2026 онд “2.6” гэснийг “2.5” гэж тус тус өөрчлөх гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн 66

Татгалзсан 46

Бүгд 112

58.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны Төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Д.Амарбаясгалан: 1.Ажлын хэсгийн гаргасан, Хууль тогтоомжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсгийг тус тус үндэслэн хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн 65

Татгалзсан 47

Бүгд 112

58.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дуусав.

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

Арав.Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Эрчим хүчний яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга бөгөөд Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Ерэн-Өлзий, мөн яамны Гэрээ, эрх зүйн газрын дарга Г.Эрхэмбаяр, мөн газрын ахлах мэргэжилтэн Б.Нямсүрэн, Эрчим хүчний сайдын орон тооны зөвлөх Б.Нямаа, орон тооны бус зөвлөх Д.Лхамсүрэн нар байлцав.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Б.Мажигсүрэн, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, төслүүдийн хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ш.Бямбасүрэн нар танилцуулав.

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа хуралдааныг 17 цаг 35 минутаас 18 цаг 13 минутад даргалав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар, Н.Наранбаатар, Ж.Золжаргал, М.Энхцэцэг нарын тавьсан асуултад Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд, Р.Сэддорж нар үг хэлэв.

Д.Амарбаясгалан: 1.Байнгын хорооны саналаар Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	77
Татгалзсан	35
Бүгд	112

68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	74
Татгалзсан	38
Бүгд	112

66.1 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	73
Татгалзсан	39
Бүгд	112

65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 18 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

Арваннэг. “Зээлийн хүүг бууруулах хүрээнд авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, мөн банкны дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, Банк, санхүүгийн эрх зүйн хэлтсийн захирал Ө.Мөнх-Ундарга, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц, мөн хорооны Банк бус санхүүгийн байгууллагын газрын дарга Б.Итгэлсүрэн, Хуль, эрх зүйн хэлтсийн дарга Ж.Мөнх-Оргил, Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Б.Мажигсүрэн, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Тогтоолын төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, П.Сайнзориг, С.Эрдэнэбат, Ц.Идэрбат, Х.Булгантуяа, Г.Уянгахишиг, Ц.Баатархүү, М.Бадамсүрэн, О.Цогтгэрэл, Б.Жавхлан нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, Сангийн сайд Б.Жавхлан, Монгол банкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц нар хариулж, тайлбар хийв.

Д.Амарбаясгалан: Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.4-т “Нэгдсэн хуралдаан шаардлагатай гэж үзвэл уг асуудлыг дахин хэлэлцүүлэхээр холбогдох Байнгын хороонд буцааж болно.” гэж заасны дагуу Эдийн засгийн байнгын хороонд буцаав.

Уг асуудлыг 20 цаг 06 минутад хэлэлцэж дуусав.

Арванхоёр. Батлагдсан хууль, тогтоолын эцсийн найруулга сонсох

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан дараах хууль, тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Үүнд:

1.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /20:07/

Дагалдан гарсан:

2.Захиргааны ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /20:07/

3.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /20:07/

4.“Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /20:08/

5.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /20:08/

Дагалдан гарсан:

6.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /20:08/

7.Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа. /20:09/

8.“Ногоон санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх, эрх зүйн орчныг сайжруулах талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /20:09/

9.“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс

эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /20:09/

10.“Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /20:10/

11.“Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /20:10/

Уг асуудлыг 20 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 12 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 6 цаг 05 минут үргэлжилж, 126 гишүүнээс 112 гишүүн хүрэлцэн ирж, 88.9 хувийн ирцтэйгээр 20 цаг 10 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ГЭРЭЭТ АЖИЛТАН

Д.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 07 дугаар сарын 03-ны өдөр,
Пүрэв гараг Төрийн ордон “Их хуралдай” танхим 14 цаг 05 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. 81 гишүүн бүртгэгдэж 64.3 хувиар ирц хүрсэн байна. 2025 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанаар дараах 16 асуудлыг хэлэлцэнэ ээ.

Нэгдүгээрт Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулна.

За үүний өмнө Засгийн газраас бас нэн яаралтай горимоор Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг бас сая өргөн мэдүүлсэн. Тэгэхээр тэрийг Улсын Их Хурлаараа яаралтай хэлэлцэх эсэх асуудлаар эхний асуудал яваад 2 дахь нь Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна. Шууд санал хураалт явахаар байгаа 2 дугаарт.

Гуравдугаарт, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 5 дугаар дүгнэлтийг хэлэлцэнэ.

Дөрөвдүгээрт, Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Шууд санал хураалттай байгаа.

4 дүгээрт Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

5 дугаарт Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулна.

7 дугаарт Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

8 дугаарт Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

9 дүгээрт Зээлийн хүүг бууруулах хүрээнд авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

10 дугаарт Хууль батлагдсан баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

10 дугаарт Барбадос улстай дипломат харилцаа тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

12 дугаарт Эсватинийн Хаант Улстай дипломат харилцаа тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

12 дугаарт Бүгд Найрамдах Тринидад ба Тобаго Улстай дипломат харилцаа тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

14 дүгээрт Бүгд Найрамдах Ботсвана Улстай дипломат харилцаа тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

14 дүгээрт Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнийг томилох тухай асуудлыг хэлэлцэнэ. 15 дугаарт.

16 дугаарт Засгийн газарт чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

17 дугаарт баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсоно оо.

За ингээд хэлэлцэх асуудалдаа орёе.

Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ. Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 6 дугаар сарын 26-ны өдөр Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг өргөн мэдүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-д Засгийн газрын хуралдааны шийдвэрийг үндэслэн Ерөнхий сайд Үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэхээр УИХ-д бичгээр хүсэлт тавьсан бол УИХ-ын дарга төслийг чуулганаар яаралтай хэлэлцэх эсэхийг нэгдсэн хуралдаанд оруулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлүүлнэ гэж заасны дагуу Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн

төслүүдийг УИХ-ын чуулганаар яаралтай хэлэлцүүлэхээр 2025 оны 7 дугаар сарын 3-ны өдөр ЗГ/92 дугаартай албан бичиг ирүүлсэн.

Одоо Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг УИХ-ын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлдье. Гишүүд санал хураалтдаа бэлдье. Чойжилсүрэн сайд санал хураалтад бэлдье.
Санал хураалт.

1.Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг УИХ-ын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна аа. Санал хураалт.

Яаралтай хэлэлцэх эсэх асуудал явж байгаа. Өчигдөр чинь Эдийн засгийн байнгын хороо хэлэлцэх эсэхийг нь шийдчихсэн байсан. Жадамбаагийн Энхбаяр сайд горимын санал гаргая.

Ж.Энхбаяр: Би сая дэмжиж өгсөн боловч энэ юун дээрээ жоохон хоцорсон уу, гар жоохон нойтон байсан уу нэг эсрэг гарчихлаа. Та нэг дахин санал явуулж өгөөч,

Д.Амарбаясгалан: Жадамбаагийн Энхбаяр сайдын гаргасан горимын саналаар санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт явуулъя аа. Санал хураалт.

Горимын санал дэмжигдсэнгүй. Өчигдөр Эдийн засгийн байнгын хороо, намын бүлгүүд ойлголцоод дэмжих ёстой гэж шийдээд орж ирж байгаа гэж ойлгосон. Тэгээд одоо дахиад ярьж дээ. Хэрвээ одоо намын бүлгүүд энэ асуудал дээр энэ хуулийг яаралтай хэлэлцэх нь зүйтэй гэж үзвэл дараачийн маргааш өдрийн чуулганд бас ахиж оруулж санал хурааж явна. Өнөөдөр байнгын хороон дээрээ энэ асуудлаа дахиж хэлэлцээд явах нь зүйтэй байх аа гэж бодож байна. За горимын санал дэмжигдсэнгүй, үндсэн санал дэмжигдсэнгүй, биш ээ буцаад татагдвал яаралтай эсэх байхгүй юу. Биш биш.

14:14

Д.Амарбаясгалан: Дараагийн асуудалд оръё.

Яаралтай хэлэлцэх эсэх асуудал шийдэгдсэний дараа хуулийн төслөө хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явагдана процессын хувьд.

УИХ-ын чуулганы чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ. УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-д Засгийн газрын хуралдааны шийдвэрийг үндэслэн Ерөнхий сайд Үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэхээр УИХ-д бичгээр хүсэлт тавьсан бол УИХ-ын дарга төслийг чуулганаар яаралтай хэлэлцэх эсэхийг нэгдсэн хуралдаанд оруулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлүүлнэ гэж заасны дагуу Засгийн газраас 2025 оны 7 дугаар сарын 3-ны өдөр Төсвийн тогтвортой байдлын тухай

хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-ын чуулганаар яаралтай хэлэлцүүлэхээр УИХ-д өргөн мэдүүлсэн.

Одоо Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-ын чуулганаар яаралтай хэлэлцэхээр хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна аа. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Одоо санал хураалтын томъёоллыг танилцуулъя. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-ын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя аа. Санал хураалт.

65 гишүүн буюу 63.1 хувиар санал дэмжигдлээ. Яаралтайгаар хэлэлцэх асуудал шийдэгдлээ.

Энэ Даваасүрэн гишүүн эхний асуудал чинь ийм учиртай шүү. УИХ-аар яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлнэ. Түүнийг УИХ-ын дарга УИХ-д хуралдаанд оролцож байгаа гишүүдэд санал хураалт явуулаад олонх нь дэмжих юм бол яаралтай горимоор хэлэлцээд явна. Олонх нь дэмжихгүй тохиолдолд ердийн горимоор хэлэлцээд явдаг биш биш. Та буруу ойлгоод байна. Түүнээс хуулийн төслийн хэлэлцэх эсэх гэдэг чинь тусдаа асуудал байхгүй юу. Энэ чинь яаралтайгаар хэлэлцэх эсэх асуудал.

14:17

Д.Амарбаясгалан: Хэлэлцэх асуудалд оръё. Дараагийн асуудалд оръё.

Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 санхүүгийн нэгдсэн тайлан болон Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай УИХ-ын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

УИХ-ын гишүүд Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны санал дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж хариулт авч дууссан. Одоо Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны саналаар санал хураалт явуулна аа. Гишүүд санал хураалтад бэлдье. Санал хураалт.

Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай УИХ-ын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор. За 2, 3 гишүүн хурууны хээгээ уншуулж болохгүй гэнэ ээ. Ахиад уншуул.

Хуулийн төслийг сая яаралтай горимоор хэлэлцэх болсонтой холбогдуулаад УИХ-ын чуулганаар яаралтай хэлэлцэхийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн тул Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай УИХ-ын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

79 гишүүн буюу 76 хувиар дэмжигдлээ. Тогтоолын төсөл батлагдлаа.

14:19

Д.Амарбаясгалан: Дараагийн асуудалд оръё.

Монгол Улсын ҮХЦ-ийн 2025 оны 5 дугаар дүгнэлтийг хэлэлцэнэ. ҮХЦ-ийн дүгнэлтийг ҮХЦ-ийн гишүүн Дашбалбарын Гангабаатар танилцуулна аа. Индэрт урьж байна.

Д.Гангабаатар: Монгол УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхэнд Монгол Улсын ҮХЦ-ийн 2025 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 5 дугаар дүгнэлтийг танилцуулж байна аа.

Монгол Улсын ҮХЦ-ийн дунд суудлын хуралдааныг ҮХЦ-ийн дарга Г.Баясгалан даргалж, ҮХЦ-ийн гишүүн Ж.Эрдэнэбулган, илтгэгч Д.Гангабаатар, Л.Өлзийсайхан, Б.Болдбаатар нарын бүрэлдэхүүнтэй, хуралдаан нарийн бичгийн даргаар Б.Эрдэнэбаярыг оролцуулан ҮХЦ-ийн хуралдааны танхимд нээлтээ хийв ээ.

ҮХЦ-ийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч иргэн П.Эрхэмбаяр, Э.Эрдэнэцэцэг болон мэргэжилтнээр Татварын Ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн нар оролцлоо. За энэхүү хуралдаанаар Монгол УИХ-аас 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан ХХОАТ-ын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2, 5 дугаар зүйлийн 4, 10 дугаар зүйлийн 2, 3, 14 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийг тус тус зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв ээ.

ҮХЦ-ийн 2025 оны 5 дугаар дүгнэлт нь нийт 25 нүүр, түүний үндэслэл хэсэг нь дангаараа 10 нүүр болсон учраас та бүхний дүгнэлтийн үндэслэл хэсгийг товчилж тогтоох эсэхийг бүхэлд нь уншиж сонсгоё оо.

Үндэслэл. УИХ албан татвар тодорхойлох онцгой бүрэн эрхийнхээ хүрээнд 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр хууль ХХОАТ-ын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийг энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасны дагуу тухайн жилийн орлогыг тодорхойлоход 0-120 сая төгрөг хүртэлх албан татвар ноогдуулах орлого олсон тохиолдолд 10 хувиар, 120,000,001-ээс 180 сая хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 120 сая төгрөг дээр 120 сая төгрөгөөс дээш давсан орлогод 15 хувиар, 180 сая төгрөгөөс дээш албан татвар ноогдуулах орлого олсон тохиолдолд 21 сая төгрөг дээр 180 сая төгрөгөөс дээш давсан орлогод 20 хувиар нэмж тооцон албан татвар ноогдуулна гэж өөрчлөн найруулсан байна аа.

Татвар бий болгох хувь хэмжээ тогтоох, хураах, хөнгөлөх, чөлөөлөх, буцаан олгох нь хууль тогтоогчийн онцгой бүрэн эрх бүрэн эрхэд хамаарах бөгөөд УИХ нь татвар тогтоох, ногдуулах талаар гаргасан шийдвэртэйгээ холбогдуулан сонгогчдын өмнө ардчилсан сонгуулийн дагуу хариуцлага хүлээдэг. Тиймээс татвар бий болгох, ногдуулах эсэх нь Үндсэн хуулийн зарчим, хүний эрх, эрх чөлөө, тэгш эрхийг зөрчсөн, дур мэдэн татварын хэт өндөр хувь хэмжээ тогтоосноос бусад тохиолдолд ардчилсан ёс, эрх мэдэл хуваарилах хүрээнд ҮХЦ-ийн харьяалан шийдэх маргаанд үл хамаарах улс төрийн бодлогын асуудал гэж үзнэ ээ.

Иргэний мэдээлэлд зөвхөн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого шууд бус орлогод шаталсан татвар ноогдуулж бусад орлогод шаталсан хувь хэмжээгээр татвар ноогдуулаагүй нь тэгш байдлын зарчмыг зөрчсөн гэжээ. Зарим орлогод орлогын төрөл, шаталсан татвар ноогдуулах эсэх, татварын хувь хэмжээг хэрхэн тогтоох нь татвар хураалтын үр ашиг, татвар тайлагнах, хянан шалгах системийн онцлог, эдийн засгийн нөхцөл байдал, бизнес эрхлэгчдийг дэмжих, татвараас зайлсхийх эрсдэл зэрэг олон хүчин зүйлийг харгалзан шийдвэрлэх улс төрийн бодлогын асуудал байна аа.

Харин орлогын түвшнийг харгалзан өндөр орлоготой иргэдэд бусдаас илүү өндөр хэмжээгээр татвар ноогдуулахаар заасан маргаан бүхий хуулийн зохицуулалт...

Д.Амарбаясгалан: Индрийн микрофон өгье.

Д.Гангабаатар: Тэгш байдал, эрх тэгш байх, ялгаварлан гадуурхахгүй байх зарчмыг хөндсөн байх тул Үндсэн хуульд нийцсэн эсэхийг хянах нь зүйтэй байна аа. Тэгш байдлын зарчим нь татвар төлөгчийн орлогын түвшин, эдийн засаг, санхүүгийн чадавхад тохирсон хувь хэмжээгээр татвар ноогдуулахыг шаарддаг. Маргаан бүхий хуулийн зохицуулалт татвар төлөгчийн санхүүгийн чадавхыг үндэс болгосон байх тул тэгш байдлын зарчмыг зөрчсөн гэж үзэхээргүй байна аа.

Хуулийн өмнө эрх тэгш байх зарчим нь хууль хүн бүрд тэгш үйлчлэх, хуулийн хэрэгжилт, хэрэглээнд ялгаварлан гадуурхалт үүсгэхгүй байх агуулгыг илэрхийлнэ. ХХОАТ-ын шаталсан хувь хэмжээг тогтоохдоо дур мэдэн хуулийг хэрэглэх, үндэслэлгүйгээр ялгаварлах байдлаар хуулийг хэрэгжүүлэх боломжийг хязгаарлаж холбогдох этгээдэд хуулийн заалт тэгш үйлчлэхээр хуульчилсан байх тул эрх тэгш байх зарчмыг зөрчөөгүй байна аа.

Маргаан бүхий хуулийн зохицуулалт нь 120000001-ээс дээш жилийн орлоготой татвар төлөгчийн хөдлөх үл хөдлөх эд хөрөнгийг хөрөнгө шударгаар олж авах, эзэмших эрхийг хөндөж, хөрөнгө чинээгээр ялгамжтай хандсан байна аа. Ийнхүү хуулиар ялгамжтай хандсан нь бодитой үндэслэл бүхий буюу дур мэдэн ялгаварлаагүй, төрийн хууль ёсны зорилгод нийцсэн зайлшгүй байх тэнцвэртэй байх шалгуурыг тус тус хангаж байх тул Үндсэн хуулиар хориглосон ялгаварлан гадуурхалт гэж үзэх үндэслэлгүй байна аа.

Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн нэг дэх хэсэг, 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн нэг дэх заалт ҮХЦ-д маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон Монгол Улсын Үндсэн хуулийн нэрийн өмнөөс дүгнэлт гаргах нь.

1.ХХОАТ-ын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2, 5 дугаар зүйлийн 4, 10 дугаар зүйлийн 2, 3, 14 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийг тус тус зөрчөөгүй байна.

2.Энэхүү дүгнэлтийг УИХ-д уламжилсугай. Даргалагч Г.Баясгалан, гишүүд Ж.Эрдэнэбулган, Д.Гангабаатар, Л.Өлзийсайхан, Б.Болдбаатар. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: За баярлалаа. Одоо Монгол Улсын ҮХЦ-ийн дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх УИХ-ын гишүүд нэрээ өгье өө.

Нийт 2 гишүүн нэр өгсөн байна. Манай УИХ-ын гишүүн Лодойсамбуу нарын гаргасан гомдлыг ҮХЦ хэлэлцэж шийдвэр гарсан байна. За Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуулт асууж үг хэлье.

Б.Пүрэвдорж: Тэгэх дээр энэ ҮХЦ-ийн дүгнэлтийг бол би зөвшөөрч байгаа. Ер нь бол энэ зах зээлийн журмаар явдаг зүйлийг хэт татвар хураахын тулд тэр урьд авсан үнээсээ хямдхан зарахгүй байх. Энэ одоо зүйл бол Үндсэн хуулийг яалт ч үгүй зөрчинө л дөө. Тэгэх дээр ер нь бол одоо ингээд тодорхой захиргааны аргаар зарим нэгэн зүйлийг шийдвэрлэх гэж үүнийхээ дагуу хууль гаргадгийн бас нэг тодорхой гор нь ингэж гарч байгаа. Энэ дээр мэдээж одоо бүх бизнесүүд, бүх одоо үл хөдлөх хөрөнгө худалдаж худалдан авч байгаа тийм үү. Дараачийнх нь юм уу? За уучлаарай, тэгвэл.

Би тэгвэл бас нэг зүйл бас зарын шинжтэй юм хэлчихье. Өнгөрсөн за уучлаарай, би нөгөө дараагийн нөгөө ХЗБХ-оор орсон юугаа ярьчихаж. Уучлаарай. Би нөгөө Баасанхүү гүйж орж ирээд ямар асуудал хэлэлцэж байгаа юм гээд шууд яриад явчихдагтай адилхан болчихлоо уучлаарай.

Тэгэх дээр би өнгөрсөн 2 дахь өдөр Лхагвасүрэн Монгол банкны ерөнхийлөгчид албан бичиг хүргүүлсэн. Үүний дагуу хариу ирсэн байж байгаа. Тэгээд ирэх нэг дэх өдөр ахмадын тэтгэврийн асуудлаар Лхагвасүрэн ерөнхийлөгч өөрийнхөө одоо эрх мэдлийн хүрээнд Монгол банкны мөнгөний бодлогын хороог хуралдуулах шийдвэр гаргаж энэнийхээ дагуу ахмадын тэтгэврийн асуудлыг шийдвэрлэхээр болж байгаа. Тэгэх дээр хуучин хэвээр нь одоо шийдэх тэр талаараа нь ажиллаач ээ гэдэг ийм хүсэлтийг тавьсан. Тэгэх дээр энд одоо манай ахмадууд гадаа тэгж наранд наршин ингэж удаан суух хэрэггүй ээ. Тэртээ тэргүй одоо нэг дэх өдөр зарлагдсан учраас үүнийхээ дагуу асуудал шийдэгдээд явах байх аа гэж найдаж байна аа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууж, үг хэлье.

П.Сайнзориг: Цэцийн энэ дүгнэлтийг анх бол мэдээлэл гаргагч нь П.Эрхэмбаяр, Эрдэнэцэцэг болон одоо өнөөдрийн УИХ-ын гишүүн Лодойсамбуу нарын хүмүүс гаргасан юм байна лээ. Яах вэ зүгээр асуудлыг бол ойлгож байгаа. Тэгэхдээ татварын асуудал маш нарийн учраас энийг бас бодолтой, ер нь зүгээр энэ Цэцийн шийдвэртэй холбоотойгоор өөрчлөлт орохоор бол бас сайн ажлын хэсэг гаргаж ажиллаасай гэдэг зүйлийг би бас хүсэж байгаа юм.

Ер нь энэ шаталсан татварын асуудлыг бас Хассуурийн Ганхуяг гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг бас нэлээн сайн судалж байгаа. Тэгэхээр энийг бол ер нь зүгээр асуудлуудыг бас мэргэжлийн байнгын хороо яг одоо бас ултай суурьтай одоо өөрчлөлтийг оруулах ажлын хэсэг гаргах, тэрийгээ мэргэжлийн холбоод болон олон нийтээр бас санал авч бас нэг энэ үл ойлголцол одоо гарахгүй байдлаар бас асуудалд хандаасай гэдэг зүйлийг зүгээр горимын хувьд хэлж байгаа юм.

Тэгээд ер нь зүгээр яах вэ энэ Цэцийн шийдвэрүүд дээр бас итгэсэн төлөөлөгчөөр оролцох, ер нь УИХ аливаа шийдвэр гаргахдаа Цэцийн шийдвэртэй холбоотойгоор үндэслэлээ сайн бичиж өгөх энэ асуудлыг манай байнгын хороодууд

бас яг хаа хаанаа анхаарах шаардлагатай байгаа юм аа. Үндэслэлээ зөв сайн бичвэл бас Цэц УИХ яг ийм үндэслэлээр бас энэ асуудалд ингэж хандаж байгаа юм байна гээд шийдвэрүүдээ бас одоо үндэслэлтэй гаргах, эргэж харж үзэх нөхцөлүүд бол бүрдэх юм байна лээ гэдэг зүйлийг би зарчмын хувьд хэлж байгаа юм аа. За баярлалаа.

Д.Амарбаясгалан: УИХ-ын гишүүд асуулт асууж хариулт авч үг хэлж дууслаа. Монгол Улсын ҮХЦ-ийн 2025 оны 5 дугаар дүгнэлттэй танилцлаа.

14:29

Д.Амарбаясгалан: Дараагийн асуудалд оръё.

Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх ТББХ-ны санал дүгнэлтийг УИХ-ын гишүүн Жудагийн Баярмаа танилцуулна. Төслийн талаарх ТББХ-ны санал дүгнэлтийг УИХ-ын гишүүн Эрдэнэбилэгийн Одбаяр танилцуулна. Индэрт урьж байна.

Э.Одбаяр: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

УИХ-ын гишүүн Жаргалан нарын 40 гишүүн 2025 оны 6 дугаар сарын 23-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай төслийн хэлэлцэх эсэх анхны асуудлыг УИХ 2025 оны 6 сарын 26-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлдүүлэхээр ТББХ-нд шилжүүлсэн билээ.

Байнгын хороо 2025 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн хуралдаанаараа хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол УИХ-ын чуулганы тухай хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцлээ.

Хуулийн төсөлтэй холбогдуулан УИХ-ын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал ирээгүй тул УИХ-ын гишүүн Одбаяр Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.24-д заасныг үндэслэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгээр эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн бөгөөд хуулийн төслийг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө өө.

УИХ-ын эрхэм гишүүд ээ, Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх ТББХ-ны санал дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал хандуулсан явдалд баярлалаа.

Д.Амарбаясгалан: За баярлалаа. Одоо УИХ-ын гишүүд Байнгын хорооны санал дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн нэг гишүүн байна. За Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуулт асууя.

С.Эрдэнэболд: За санаачлагчид зориулж 2, 3 асуулт байна. 1 дүгээрт Монголын тулгуур төр гэсэн ойлголт байгаа. Бид 1962 онд бас эзэн Чингис хааны 800 жилийн ойг тэмдэглэх тухай нэлээн их хөдөлж одоо бараг 70 шахам жилийн өмнө өмнө шүү дээ. Тэгээд энэ үйл явдал болоод энэний улмаас бас хэлмэгдүүлэлт болж байсан. Ингээд 90 он гараад Нууц товчооны ой болоод, ардчилсан хувьсгал өрнөөд, 2009 оноос өгсүүлээд энэ түүхэн үйл явдлуудад бас аль болохоор одоо хүндэтгэлтэй хандах, байгаа чигээр нь өвийг нь авч үлдэх энэ зүйлс явж байсан. Тэгээд ер нь бол 2012 оноос өгсүүлээд яг энэ тулгар төрийн гээд Хүннү гүрний буюу манай эриний манай тооллын нийтийн тооллын өмнөх 209 оноос энэ тоог аваад байдаг.

Тэгэхээр ер нь болбол энэ археологийн одоо судлагдахуун, олдворууд дээр үндэслээд маш олон улсуудын улс төрийн бас энэ цаад бодлого нь одоо монгол ойлголтоор бол нөгөө алтан аргамжны бодлого нь болбол төрт улсынхаа өв соёл түүхийг уртасгах ийм хандлагатай байдаг. Тэгээд тэр утгаараа болбол энэ археологийн өв, бичмэл өв гээд мөн бас Монголын одоо хадны зургийн өв гээд эдгээр өвүүд дээрээ бодоод энэ тулгар төр гэдэг ойлголтыг бас цааш нь одоо нэгэнт хууль гарч байгаа бол уртасгах ямар боломж байдаг юм бэ? Энэ 1 дүгээр асуулт нь. Хоёр мянгаад жилийн түүх болбол яг Хүн гүрний өв гэдгээр нь тусад нь авч үзэх шаардлагатай юу?

Дараагийн асуулт нь болохлоор 12 жилийн хугацаанд ардчилсан хувьсгалын ойг ингээд тодорхой оруулаад яваад байдаг байсан. Тэгээд сүүлд нь хасагдчихсан. Тэгэхээр бид бол аль болохоор энэ өнгөрсөн түүхэндээ хүндэтгэлтэй хандах, улс төржүүлэхгүй байх. Ялангуяа 20 дугаар зууны түүх буюу 1911 оны эрх чөлөө тусгаар тогтнолоо сэргээн мандуулсан үйл явдал, 1921 оны үйл явдал. За мэдээж 1961 онд НҮБ-д статус квоотой болсон үйл явдал, 1989 он, 1990 онд өрнөсөн ардчилсан хувьсгалын үйл явц гээд эдгээрийг ингээд оролдохгүй баймаар байгаа юм. Одоо саяхны жишээ гэхэд л одоо нэг нам олонх болонгуутаа Сүхбаатарын талбайг Чингисийн талбай болгочихдог. Дараа нь цөөнх болонгуут нэр нь өөрчлөгдөөд буцаад Сүхбаатарын талбай болчихдог. Ингээд нөгөө аль намд засгийн эрх нь байгаагаас хамаарч энэ одоо төв талбайгаа нэрийг нь өөрчилдөг ч гэдэг юм уу, үндэсний их баяр наадмынхаа тодотголыг нь чимгийг нь өөрчилдөг ч гэдэг юм уу. Энэ байдалдаа бид нар ер нь цэг тавих ёстой юм шиг байгаа юм аа.

Тэгэхээр энэ дээр яг энэ одоо Жаргалан гишүүний тэргүүлж санаачилж орж ирж байгаа энэ хуулийн төсөл дээр цаашдаа энэ одоо Монгол түмний бахархал, өв соёл, уламжлал, Монголын төрт ёсны амьд халуун дархлааг бид хуулиар шинэчлэн одоо ингэж тодорхойлох гэж байгаа бол эдгээр зохицуулалтууд болбол яаж орж ирж байгаа вэ нэгд.

2 дугаарт энэ нь цаашлаад ямар үнэ цэнтэй юм бэ? Мөн одоо энэ үндэсний эв нэгдэл монгол үндэстний оюун санааны тусгаар тогтнол, цаашлаад ирээдүйд чиглэсэн энэ үнэ цэнийг бүтээх үйл хэрэгт энэ ямар ач холбогдолтой юм бэ? Энэ хуулийн үнэ цэн ямар тусгалтай юм бэ гэдгийг бас асууя аа.

Д.Амарбаясгалан: Хууль санаачлагч Батбаярын Жаргалан гишүүн хариулт өгье.

Б.Жаргалан: Үндэсний их баяр наадмын тухай хуулийн өөрчлөлтийн үзэл санааг дэмжиж, бас хамтран хууль санаачилсан Эрдэнэболд гишүүн дэмжиж үг

хэлсэнд баярлалаа. Тэгэхээр хууль санаачлагчдын үзсэнээр Үндэсний их баяр наадам бол манай улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, үндэсний эв нэгдэл, төрт ёс, түүх соёл, өв уламжлал, зан заншлыг бэлгэдсэн монголчууд бидний уламжлалт их баяр, үндэсний их баяр наадамтайгаа хамтатгаад бид бол өнгөрсөн хугацаанд Монгол Улсын түүхэнд онцгой хувь нэмэр оруулсан, Монголын төрт ёсны уламжлалд бас онцгой хувь нэмэр оруулсан энэ түүхэн үйл явдлуудыг бас тэмдэглэж, иргэдийн ой ухамсарт бас сануулж, нэгдмэл энэ үнэт зүйлээрээ бахархах бас ийм боломж бололцоо олддог.

Тийм ч утгаараа одоо үеийн үед бол одоо жишээлбэл тулгар төрийн байгуулагдсаны ой, Их Монгол улс байгуулагдсаны ой, үндэсний тусгаар тогтнолоо сэргээн тогтоосон Үндэсний эрх чөлөөний хувьсгалын ой, Ардын хувьсгалын ардчилсан хувьсгалын ойн баяр наадмуудыг бол одоо бас зарим цаг үеүдэд бид нар бол хамтатган бас ийм тэмдэглэж байсан туршлагауд байгаа. Тэгэхээр энэ парламент энэхүү хуулийг баталснаараа Үндэсний их баяр наадмын одоо энэ үзэл санаанд бол бас яг жинхэнэ утгаараа ийм үзэл санааны өөрчлөлт оруулж бас Монгол Улсын нэн шинэ үеийн түүхэнд тохиосон голлох үйл явдлуудыг бол бас ингэж хамтатган тэмдэглэх энэ одоо үзэл санааны өөрчлөлтийг бол оруулж ирж байгаагаараа бас их онцлог. Тэгээд энэ парламентын бас түүхэн шийдвэрүүдийн нэг байна гэдэгт итгэж байна. Тэгээд дэмжсэнд баярлалаа.

Д.Амарбаясгалан: За баярлалаа. Хариулт өгчихлөө. Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа.

Одоо Байнгын хорооны гаргасан горимын саналаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Санал хураалт явуулъя.

Байнгын хорооны гаргасан горимын саналаар санал хураалт явуулна. Байнгын хорооноос Үндэсний баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна аа. Санал хураалт.

68 гишүүн буюу 62.4 хувиар горимын санал дэмжигдлээ.

Горимын санал. Одоо эцэслэн батлах санал хураалт явуулна. Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Үндэсний баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулна.

Хуулийн төслийн эцэслэн батлуулах хувилбарыг ТББХ бэлтгэн гишүүдэд тараасан байна. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2-т нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд УИХ-ын нийт гишүүний олонх дэмжсэн бол хууль эцэслэн баталсанд тооцно оо гэж заасан. За санал хураалт.

Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя аа. Санал хураалт.

77 гишүүн дэмжлээ. Хуулийн төсөл батлагдлаа.

За энэ хууль маань гишүүд бас энэ төрийн байгууллагууд энэ баяр наадам зохион байгуулах комиссынхонд анхааруулах нь 1 дүгээрт энэ хууль өнөөдөр хэдийгээр эцэслэн батлагдаж байгаа ч гэсэн хуулийн хэрэгжиж эхлэх хугацаа, Ерөнхийлөгчийн хоригийн хугацаа зэрэг асуудлаас үүдэлтэйгээр 7 сарын 10-ны өдрөөс хэрэгжиж эхлэх боломж нь бүрдэнэ. Тэгэхээр нөгөө баяр наадмыг зохион байгуулах комисс болон бусад түвшинд өнөөдрийн хуульд орсон өөрчлөлт бүрэн тусгагдаж орж ирэхгүй байх талтай. Энэ дээр одоо гишүүд маань зөв ойлгож хандахгүй хууль батлагдсан байхад хууль зөрчлөө гэдэг асуудлыг баяр наадмын баярын өдрүүдээр хэрүүл болгож асуудал дэвшүүлэхгүй байхыг та бүхнээсээ хүсье ээ.

14:41

Д.Амарбаясгалан: Дараагийн асуудалд орёё.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал дүгнэлтийг УИХ-ын гишүүн Жадамбаагийн Баясгалан танилцуулна аа. Индэрт урьж байна.

Ж.Баясгалан: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдөр УИХ-д Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн 2 хууль, УИХ-ын 2 дугаар тогтоолын 2 тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг УИХ-ын 2025 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар явуулж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороо болон холбогдох байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2025 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Монгол УИХ-ын тогтоол Алт 3 аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Монгол УИХ-ын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж дараах санал дүгнэлтийг та бүхэнд танилцуулж байна.

УИХ-ын Эдийн засгийн байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд Алт 3 аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Монгол УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцэн санал дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд ирүүлсэн. Төсвийн байнгын хорооны хуралдаанаар Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу Монгол УИХ-ын тогтоолын төслүүд болон хуулийн төслүүдийг зүйл бүрээр нь хэлэлцэн төслүүдийн тухай

зүйлтэй холбогдуулан ажлын хэсэг УИХ-ын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг нэг бүрчлэн хэлэлцэж санал хураалт явууллаа.

УИХ-ын даргын 2025 оны 292 дугаар захирамжаар байгуулагдсан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийг хэлэлцүүлэхэд бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгээс Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан Засгийн газарт чиглэл өгөх тухай Монгол УИХ-ын 52 дугаар тогтоол, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Монгол УИХ-ын 54 дүгээр тогтоолын холбогдох заалтуудыг бүрэн хэрэгжиж дуусаагүй гэж үзэн Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Монгол УИХ-ын тогтоолын төслийг хууль санаачлагчид нь буцаах мөн Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд тусгагдсан төсвийн орлогыг аль нэгэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд тусгасан төсвийн орлогыг аль нэгэн этгээд эсвэл үйл ажиллагаандаа тусгайлан оноохгүй байх зохицуулалтыг хасах саналуудыг гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх бөгөөд харин ажлын хэсгээс гаргасан Алт 3 аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Монгол УИХ-ын тогтоолын холбогдох заалтуудад өөрчлөлт оруулах санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжээгүй болно.

Хууль тогтоолын төслүүдийг Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн дагуу хуулийн дагуу зүйл бүрээр нь хэлэлцэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг олонхын дэмжлэг авсан аваагүйгээр нь бүлэглэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал дүгнэлт зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг та бүхэнд хүргүүлсэн болно.

УИХ-ын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье ээ.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: За баярлалаа. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Болдын Жавхлан Сангийн сайд, Жигжидийн Ганбат Сангийн яамны ТНБД, Сэрээтэрийн Жавхланбаатар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны ТНБД, Ханджавын Батжаргал Боловсролын яамны ТНБД, Чойгүнсэнгийн Чимидсүрэн Татварын ерөнхий газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль эрх зүйн газрын дарга, Энхтөрийн Батмөнх Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга, Лувсанвандангийн Ичинноров Сангийн яамны төсвийн орлогын хэлтсийн дарга, Пүрэвдоржийн Бат-Эрдэнэ Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга, Булганхүүгийн Ганзориг Сангийн яамны хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Рэгзэнгийн Мягмаржав Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага арга зүйн газрын дарга.

Одоо УИХ-ын гишүүд Байнгын хорооны санал дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагддаггүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна аа. Ирцийн дараалалд оруулъя. Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн асуулт асууя. Мөнхбаясгалан гишүүн сая энд явж байх шиг байсан чинь яав. За Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуулт асууя.

С.Эрдэнэбат: Төсөв дагасан хуулиудтай холбоотой асуулт асууя аа. Энэ төсвийн тодотголтой холбоотойгоор төрийн албан хаагчдын цомхотгол, олон төрийн өмчийн үйлдвэрийн газруудын цомхотгол, тэтгэмж гээд энэ асуудлууд байгаа. Тэгэхээр энэ асуудлыг хуулийн дагуу хэрхэн яаж хийх гэж байгаа юм. Бүгд хуультай. Зүгээр одоо тогтоол шийдвэр гаргангуутаа цомхотгол, өөрчлөлт, нэмэгдэл юмнуудыг бол хасчих. Нэг тал дангаараа шийдчих бол боломж байдаггүй. Тэгэхээр энэ тал дээр тэр тэтгэмжтэй холбоотой асуудлуудыг хэрхэн яаж тусгасан бэ. Төсөв хөрөнгө нь яг хаана суусан бэ, ямар тооцоо гарсан бэ гэдэг зүйлийг бол асуумаар байна аа.

Мөн зарим нь бол хуулиар маш олон жил болж тогтоосон нэмэгдлүүд дээр бол байж байгаа. За үүнтэй холбоотой ямарваа нэгэн одоо хасагдах ийм зүйлүүд бол гарах уу, үгүй юү гэдэг дээр бол би асуумаар байна.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Санжаадорж дарга 4 дүгээр индэр.

М.Санжаадорж: Сангийн яам Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Гишүүний асуултад хариулъя аа. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуультай хамт Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг болбол өргөн барьсныг Засгийн газрын зүгээс эргүүлэн татсан байгаа. Үүнтэй холбоотойгоор мөн төсвийн тодотголыг бол дагаж одоо батлагдах ёстой байсан УИХ-аас одоо чиглэл өгөх тогтоолын төслийг болбол ажлын хэсэг дээр болон Төсвийн байнгын хороон дээр бол буцаах нь зүйтэй гээд үзчихсэн байгаа. Тэгэхлээр болбол ямарваа нэгэн хуулийн одоо төрийн албан хаагчийн хуулийн хүрээнд одоо авч байгаа тэтгэвэр тэтгэмж, цалин хөлсний асуудал болбол одоо хөндөгдөхгүй тийм юм болж байгаа тийм.

Д.Амарбаясгалан: Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн тодруулж асууя.

С.Эрдэнэбат: Тэгэхээр өнөөдөр бас төрийн албаны өдрийн өдөр байгаа. Тэгээд нэг зүйлийг бас цаашдаа ч гэсэн төсөв хэлэлцэхэд бол анхаарах нь зүйтэй. 20, 30 жилийн өмнө төрийн албанд орж итгэл өгч ажиллаж ирсэн залуучууд өнөөдөр одоо тэтгэвэрт гарахад дөхчихсөн хэдхэн жил ч гэсэн үлдчихсэн байж байгаа. Тэгээд ийм учраас энэ нөгөө нийгмийн итгэлцэл буюу төрийн албанд насаараа зүтгэсэн энэ хүмүүсийн итгэлийг цаг үеийн хүндрэлээс болоод ялангуяа олон жил явж ирсэн ийм зүйлүүдээр дахин битгий оролдооч ээ. Магадгүй ирэх жил энэ асуудлуудыг намар тийшээ бас зарим хуулиудыг оруулж ирнэ гэдэг ийм байр суурийг бас илэрхийлээд байх шиг байна лээ Сангийн яам.

Тийм учраас ийм зүйлээр бол аль болохоор битгий оролдоорой. Тэгэхгүй бол одоо юу болж байна вэ гэхээр маш олон төрийн албан хаагч нар ер нь төрийн албанаас одоо гаръя аа холдье оо. Олон жил байж байсан нөгөө итгэж байсан тэтгэвэр тэтгэмжтэй холбоотой асуудлуудын маань нэг өдөр хууль оруулж ирээд

үзэгний үзүүрээр өөрчилчих ийм эрсдэл байна аа гэдэг ийм одоо үл итгэлцлийн байдал нэг буруу тийшээ эргэх юм бол төрийн алба...

Д.Амарбаясгалан: Буланы Бейсен гишүүн асуулт асууя.

Б.Бейсен: Энэ төсөв дагасан хуулиудаар энэ зарим чухал зоонозын байгууллагуудын төсвийн асуудал яригдаж байна л даа. Манайх чинь ОХУ-тай Засгийн газрын хоорондын гэрээгээр тахлын голомттой Сэлхмийн нуруу дээр 3 тахлын голомт бий. Нөгөө талаар тэр улсууд чинь 2 сар одоо шинжилгээ судалгаа хийх ёстой. Ийм чухал салбаруудын төсөв хасагдаад энэ ямар учиртай юм бол төрийг асууя.

Д.Амарбаясгалан: Хэн хариулт өгөх вэ. ЭМЯ-аас хүн байна уу? Сангийн яам, Төсвийн бодлого, зохицуулалтын газрын дарга Санжаадорж дарга 4 дүгээр индрээс хариулт өгье.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Төсвийн тодотголтой холбоотойгоор бид зардал хасахдаа болбол нэг л зарчмаар хассан байгаа. Тэр нь бид нар эхний ээлжид болбол одоо яалт ч үгүй бууруулж болохгүй зардлууд бол ялгаж авсан. Энэ нь болбол өндөр насны тэтгэвэр, тэтгэмж, дээрээс нь хүүхдийн мөнгө, мөн хүнтэй холбоотойгоор буюу статистик тоотой холбоотойгоор үржигдэж орж байдаг.

Өөрөөр хэлбэл хүүхэд цэцэрлэгийн хүүхдийн хоол ч байдаг юм уу тиймээ ийм зардлуудыг бид нар хасагдаад байгаагүй хасаагүй ээ. Бусад байгууллагуудын хувьд болбол ямар нэгэн одоо ялгаж байгууллагаар нь тусгайлан бол ялгаагүй, зөвхөн зардлын ангиллаар түрүүчийн хэлдгээр бол ялгаж байсан байгаа. Тэгэхлээр болбол эрүүл мэнд болон одоо шүүх ч байдаг юм уу эсвэл одоо нийгмийн хэв журмыг сахиулах бүх байгууллагуудын хувьд бол ижил зарчмаар бол хасагдчихаад байгаа юм. Зарим байгууллагуудын хувьд бол ялгаатай одоо хувь процентын хувь гарч байгаа. За энэ нь бол ямар асуудал байна гэхлээр 1-6 дугаар сарын хувьд бол зарим байгууллагын хувьд бол ажлаа түлхүү төлөвлөөд ажил нь эхлээд явчихсан байгууллагуудын хувьд бол арай өөр гарчхаж байгаа. Яагаад гэхлээр 1-6 дугаар сарыг бид нар огт одоо хасалтад оруулалгүйгээр 7 сараас эхлээд 12 сар хүртэлх бүх зардлыг бол ижил зарчмаар бол ингээд хасчхаад байж байгаа. Ийм байгаа тийм баярлалаа.

Д.Амарбаясгалан: Буланы Бейсен гишүүн тодруулж асууя.

Б.Бейсен: Энэ зоонозын 2 улсын Засгийн газрын комиссын одоо хоорондын хэлэлцээрээр 6, 7 сард одоо 8 сард шинжилгээ хийх ёстой. Гэтэл энэ антиген худалдаж авах мөнгө тэгээд тэнд ажиллах нөгөө ажилчдын томилолт энэ тэр бүгд хасагдсан байна. ОХУ-ын талаас хилийн яг энэ зоонозын өвчин голомттой 3 бүсийн шинжилгээ хийх юмыг хасаад хаячихсан байна гээд өнөөдөр тийм асуудал ярьж байна. Нийтдээ 29 сая төгрөг хассан байна. Яг жинхэнэ ажиллах юуных нь. Зоонозын өвчин гарвал яах юм. Одоо энэ тал дээр одоо яагаад ингээд хассан юм бол?

Д.Амарбаясгалан: Нэмэлт хариулт өгье 4 дүгээр индэр.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Бейсен гишүүний асуултад хариулъя аа. Зоонозын өвчин судлал гэхгүйгээр ер нь эрүүл мэндийн салбар дээр бас ижил зарчмаар жишээ нь 9 хувийн орон тооны бууралт бол яваад ороод ирчхэж байгаа юм. Гэхдээ болбол эрүүл мэндийн салбарын хувьд бид бол салбарынхантай нь бас ярилцсан. Ямар байдлаар та хэд ингээд энэ төсөвтэй одоо нэгэнт ингээд ижилхэн зарчмаар хасагдаж байгаа учраас энэ төсөвтөө багтааж ингээд оноо давах, мөн одоо энэ халдварт өвчин болон энэ малаас хүнд халдварлах энэ зоонозын асуудал, тэгээд мөн энэ бусад асуудлууд дээрээ ажиллана шүү гэдэг болбол ийм зүйлүүдийг нь бол бид нар цаг тухай нь бүр мэдээллийг нь өгөөд явж байсан байгаа. Тэгэхээр өөрөөр хэлбэл тэр 29 сая төгрөг дутагдаж байгаа асуудлыг бол Эрүүл мэндийн сайд бол өөрийнх нь батлагдсан багцын хүрээндээ болбол шийдээд явчих бүрэн боломжтой гэж бид үзэж байгаа. Нөгөө талдаа одоо энэнээс өөр сонголт болбол байхгүй болчихож байгаа л гэсэн үг тийм. Яг зоонозыг бол тусгаад л бид нар...

Д.Амарбаясгалан: Жудагийн Баярмаа гишүүн асуулт асууя.

Ж.Баярмаа: Та бүгдийн энэ өдрийн амрыг эрье. Төсвийн тодотголтой цуг дагалдаж орж ирж байгаа хуулиудаас нэг асуулт байна аа. Энэ төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах гээд 70.5 буюу Төсвийн захирагч тухайн жилийн батлагдсан төсвийг зохистой удирдаагүйн улмаас авлага өр төлбөр үүсгэсэн нь тухайн албан тушаалтан ажлаас чөлөөлөгдөх үндэслэл болно гэсэн байна. Тэгэхээр 70.4 буюу яг энэ 70.5 дугаар зүйл бол нэмэлт шинээр орж ирж байгаа гэж ойлголоо. 70.4 нь болохоор төрийн захиргааны төв байгууллага төсвийн төслийг боловсруулж батлуулахдаа үндэслэлгүй тоо мэдээнд тулгуурласан болбол бас албан тушаалаас чөлөөлөгдөх үндэслэл болно гээд. Ийм хариуцлагын заалт уг нь байгаа юмаа 70.4.

Тэгэхээр ерөөсөө энэ их олон төсвийн тодотгол хийж, энэ их олон удаа төсвийн хүрээний мэдэгдлийг дахин боловсруулж тэгээд төсвийн хүрээний мэдэгдэлтэй нийцүүлж төсвийн тодотголоо хийх ёстой атал дандаа эсрэгээрээ явж ингэж их будилж байгаагийн хариуцлагыг хэн нэгэн хүн хүлээх ёстой юм уу, ёсгүй юм уу. Яг энэ 70.4 дээр заасан үндэслэлгүй тоо мэдээнд тулгуурлаж гэж байгаа шүү дээ. Тэгэхээрээ одоо энэ ингээд бүтэлгүйтээд яваад байгаа чинь үндэслэлгүй тоон мэдээнд тулгуурласан гэж үзэх юм уу, юу гэж үзэх юм бэ? Тэгээд өмнөх энэ хуулийн заалтаа хэрэгжүүлж хэн нэгэн хүнд хариуцлага тооцоогүй байж байж нэмэлтээр дахиад ийм шал худлаа ажилладаггүй ийм хуулийн заалт оруулах хэрэг байгаа юм уу?

Тэгээд энэ 70.4-өөр үндэслэлгүй тоо баримтад тулгуурлаж худал үнэн тооцоолол гаргасны үндсэн дээр энэ их олон тодотгол хийж байгаатай холбоотойгоор хэн нэгэнд хариуцлага тооцсон тухай ер нь түүх байдаг болбол тэр түүхээс нэг хэлж өгөх арга байна уу? Тэгээд энэ 70.5 буюу шинээр энэ заалт чинь дахиад хэрэгжих баталгаа байна уу? Ер нь энэ төсөвтэй холбоотойгоор хариуцлага тооцдог энэ механизм ер нь ажиллана гэдэгт би л лав итгэхээ больчихоод байна. Энэ дээр хариулт авъя.

Д.Амарбаясгалан: Хэн хариулт өгөх вэ? Аудит Наранчимэг дарга хариулт өгье. 3 дугаар индэр.

Ц.Наранчимэг: Баярмаа гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Наранчимэг байна аа. Манай төрийн аудитын байгууллага бол Төрийн

аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан шаардлагын дагуу хариуцлага тооцох буюу ажлаас халах гэсэн ийм хариуцлагын 2 албан шаардлагыг хүргүүлдэг. Төрийн аудитын байгууллагаас гаргасан тайлантай төсвийн ерөнхийлөн захирагч нар танилцаад саяны Баярмаа гишүүний хэлсэн төсвийн тухай хуулийн 70.3, 70.4-өөр өөрсдөө ажлаас чөлөөлөх хүртэлх хариуцлагыг тооцох бүрэн боломжтой байгаа. Энэ 2 заалтаар бол манайх хариуцлага тооцох албан шаардлага өгдөггүй. Төрийн аудитын тухай хуулиа баримталж хариуцлага тооцох албан шаардлагыг өгдөг байгаа.

Д.Амарбаясгалан: Жудагийн Баярмаа гишүүн тодруулж асууя.

Ж.Баярмаа: Яах вэ мэдээж төсвийн ерөнхийлөн захирагч тус бүр тусдаа түүгээрээ бас хариуцлага хүлээх байх л даа. Би энэ төсвийг боож зангидаж яг улсын нэгдсэн төсөв болгож оруулж ирээд байгаа тэр төрийн захиргааны төв байгууллагыг л аминдаа хэлээд байгаа юм л даа. Одоо өөрөөр хэлбэл Сангийн яам. Тэгэхээр энэ төсвийг чинь боож оруулж ирж байгаа субъект чинь Сангийн яам. Тэгэхээр Сангийн яам чинь энэ үндэслэлгүй тоо баримт дээр тулгуурлаж төсөв төсөл болгож оруулж ирээд батлуулаад байгаа дээрээ хариуцлага хүлээхгүй юм уу гэж л асуугаад байна л даа. Энийг би ганц яриад байгаа юм биш энэ сонгогчид маш их асууж байна. Савсал хийвэл төсвөө тодотгоод байх юм. Энэ чинь ямар учир начиртай юм бэ. Яагаад буруу тооцоолоод байдаг юм. Тэгээд буруу тооцоолсны үндсэн дээр хэн нэгэн хүн хариуцлага хүлээдэггүй юм уу гээд ингээд ерөөсөө асуугаад зүгээр суулгахгүй байна.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн дарга Хассуурийн Ганхуяг гишүүн хариулт өгье.

Х.Ганхуяг: Төсөв бооно гэдэг маань өөрөө угаасаа төсвийн хүрээний мэдэгдэлдээ тааруулж л тоонууд дээрээ боож орж ирж байгаа шүү дээ. Тэгээд төсвийн хүрээний мэдэгдлийг тухайн үед бол Эдийн засгийн хөгжлийн сайд тухайн үед ч яах вэ одоо ч гэсэн Эдийн засгийн хөгжлийн сайд төсвийн хүрээний тоонуудыг өгдөг юмаа. Тэгээд тэр хүрээ гаргахдаа өөрөө алдаатай л гаргасан байна гэсэн үг. Ноднин жилийн одоо өдийд бид нар Эдийн засгийн хөгжлийн сайдыг томилж байхад бол эдийн засаг 7 хувийн өсөлттэй байлаа. 5.5 тэрбумын бид нар валютын нөөцтэй байлаа. За экспорт бол бид нар урьд өмнө түүхэнд байгаагүй хэмжээний экспортод одоо нөөц экспорттой байлаа. Тэгээд тэр юун дээрээ л таамаглаад л энэ төсвийн хүрээ орж ирсэн юм шиг байгаа юм. Тэгээд тэрнээсээ болоод л одоо төсвийн хүрээндээ таарагдаад уягдаад л энэ төсөв орж ирж л байгаа юм л даа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Жудагийн Баярмаа гишүүн дахин тодруулж асууя.

Ж.Баярмаа: Юу л даа Ганхуяг гишүүн ээ. Энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөл чинь бүүр аргаа барчихсан хөөрхий. Төсвийн тодотголд нийцүүлж төсвийн хүрээний мэдэгдлээ өөрчлөхдөө гээд бүүр ийм өгүүлбэрүүд ерөөсөө хаа сайгүй яваад байгаа байхгүй юу. Тэгэхээр төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэх биш эсрэгээрээ эхлээд тодотголын чинь төсөл нь гарчхаад яваад байгаа шүү дээ. Бид нар мэдэж байгаа шүү дээ. Төсвийн тодотгол чинь гарчихсан. Тэрэнд нийцүүлж буюу тэр Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тэр чинь нэг 7.3, 4, 5-ыг бүхэлд нь зөрчөөд яваад байгаа л даа. Тэгэхээр Эдийн засгийн яам руу л та аминдаа чихэх гэж оролдож байна л даа. Тэгэхээр би болбол тэгж бодохгүй байна. Тодотголоо дагаж төсвийн хүрээний мэдэгдэл чинь яваад байгаа энийг бүгд мэдэж байгаа.

Д.Амарбаясгалан: Хассуурийн Ганхуяг гишүүн хариулт өгье.

Х.Ганхуяг: Тийм төсвийн тогтвортой байдлын хууль дээр бид нар бол яалт ч үгүй өнөөдрийн үүссэн байгаа нөхцөл байдлыг бол оруулж өгөх ёстой байхгүй юу. Тогтвортой байдлын хууль гэхээрээ бид нар нэг аймаар сүрхий хууль баталчихсан гэж бодоод байдаг юм. Алдаатай юмнууд бас байгаа юм. Сая энэ тодотгол өргөн барихдаа төсвийн хүрээний мэдэгдэл, таны ярьж байгаа наад таны ярьж байгаа бүх асуудал чинь зөв. Гэхдээ бид нар нөгөө хуулийнхаа юундаа л баригдчихаад байгаа юм. Тийм учраас энэ Төсвийн тогтвортой байдлын хуулиа хөндөж оруулж ирье гэдэг асуудлыг ажлын хэсгийн хүрээнээс Төсвийн байнгын хороон дээр бас ярьсан юмаа. Тэгэхгүй бол энэ чинь ерөөсөө амьдралд нийцэхээ больчихлоо шүү дээ. Энэ чинь яг тухайн үедээ амьдралдаа нийцүүлээд бид нар бас шаардлагатай бол энэ хуулийн шинэчлэлтээ хийгээд л явахаас өөр арга байхгүй. Яалт ч үгүй одоо өнөөдөр бид нар төсвийн тодотголыг хийх гэхээр төсвийн хүрээний мэдэгдлээ оролдох хэрэгтэй болно. Төсвийн хүрээний мэдэгдлээ хийх гэхээр сарын өмнө баталчихсан байгаа төсвийн хүрээний мэдэгдлээс болоод одоо бас хөндөлт хийж болохгүй болж байна. Өнөөдөр төсөв батлагдангуут 3 сар төсөв өргөн барьж болохоо больчихно. Ингээд асуудлууд байгаад байгаа байхгүй юу. Тэгээд энэ өөрчлөлтүүд чинь бүгдээрээ энэ 25 онд 1 сарын 1...

Д.Амарбаясгалан: Төсвийн байнгын хороон дарга Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн хариулт өгье.

Ц.Даваасүрэн: Тийм Баярмаа гишүүний асуугаад байгаа бол нөгөө Сангийн сайд, Эдийн засгийн сайд 2-т энэ буруу тоон үзүүлэлтүүд орж дахин дахин тодотгоод байхад яагаад хариуцлага тооцохгүй байна аа гэдэг л асуулт байна шүү дээ. Тэгэхээр хуучин бол ингэж тооцож болдог байсан юм. Тухайн сайдыг бид нар өргөх эрхтэй байсан байхгүй юу. Одоо ингээд алдаатай ороод ирэх юм болбол алдаатай гэж үзэх юм болбол Улсын Их Хурлын гишүүд тухайн сайдыг одоо хууль зөрчсөн гэж үзээд ингээд өргөчихдөг байсан. Одоо байхгүй. Одоо зөвхөн Ерөнхий сайд өөрөө хариуцлага тооцож шаардлагатай гэвэл огцруулах асуудлыг нь огцруулах, томилох асуудал нь Ерөнхий сайд руу шилжчихсэн байхгүй юу. Тийм учраас нөгөө сайд нарт хариуцлага тооцох асуудал болбол Их Хурлын хүрээнд их төвөгтэй болсон. Бас нэг 2 дахь нэг заалт байдаг байсан юм. Дэгийн тухай хуульд. Хагас жил тутам сайд нарын ажлын тайланг хэлэлцээд тэгээд дүгнэлт гаргадаг байсан байхгүй юу. Тэгсэн энэ заалтыг Дэгийн тухай хуулиас бас аваад хаячихсан юм байна лээ.

Д.Амарбаясгалан: Даваасүрэн гишүүнд нэг минут нэмж өгье.

Ц.Даваасүрэн: Тэгэхээр Их Хурлын одоо хариуцлага тооцох механизм болбол байхгүй болчихсон гэсэн үг. Дэгийн тухай хуульд байсан тэр УИХ-ын гишүүдийн өргөө УИХ сайд нартай огцруулах асуудал ярьдаг байсан энэ тэр бүгдийг нь аваад хаячихсан. Тэгэхээр Их Хурал үндсэндээ сайд нартай хариуцлага ярихад болбол шүдгүй арслан болсон гэсэн үг. Одоо бол зөвхөн Ерөнхий сайдтай л тэгэхээр хэрвээ энэ асуудал одоо ингээд ийм юм байна аа гэж үзэх юм бол бид нар нэр бүхий гишүүд гарын үсэг цуглуулаад энэ оруулж ирж байгаа хуурамч үзүүлэлттэй төсвийнхөө хүрээнд хариуцлага хүлээх асуудал болбол Ерөнхий сайдтай ярьж болно.

Д.Амарбаясгалан: Батжаргалын Заяабал гишүүн асуулт асууя.

Б.Заяабал: Та бүхэндээ өдрийн мэнд хүргэе ээ. Өнөөдөр Монгол Улсад бас энэ төрийн орчин цагийн төрийн албаны байгууллага үүсэж байгуулагдсаны 30 жилийн ой тохиож байна. Энэнтэй холбогдуулаад Монгол төрийн албанд ажиллаж байгаа, ажиллаж байсан нийт төрийн албан хаагчдадаа энэ баярын өдрийн мэндийг бас хүргэе ээ.

УИХ-ын энэ 2025 оны төсвийн тодотголыг дагаж 3 хууль, 2 тогтоол орж ирсэн. Нэг хууль нэг тогтоолыг нь ингээд татаж авч байгаа юм байна. За татаж авч байгаа нэг хуулийн асуудал нь бас энэ төрийн албан хаагчидтай холбоотой төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль байсан. Нэлээдгүй төрийн албаны одоо нийгмийн баталгааг хангах чиглэлтэй байсан заалтуудыг байхгүй болгох ийм одоо зохицуулалтуудыг оруулж ирсэн, хувь хэмжээг нь бууруулах ийм зохицуулалтууд оруулж ирсэн байсан. Засгийн газар бас энэ хуулийгаа татаж авсанд их баяртай байна аа. Яагаад би энийг хэлээд байгаа юм бэ гэхлээр төрийн алба гэдэг бол аль ч улсад тухайн нийгмийнх нь дундаж давхаргыг бүрдүүлж байдаг, дундаж давхаргынх нь баталгаа болж явдаг аа баталгаа болж явдаг.

Өнөөдөр Монголын төрд зүтгэж байгаа энэ албан хаагчид чинь яг Монгол төр Монгол Улсын одоо нийт иргэдийн нийт айл өрхийн дундаж давхаргатай айлын хэмжээнд байж чадаж байна уу гэдэг дээр Монголын төр бид нар бас дүгнэлт хийх ёстой шүү. Энэ дээр ямар ч дүгнэлт хийхгүйгээр энэ одоо хувь хэмжээ, нийгмийн баталгааг бууруулсан ийм хууль тогтоолуудад тогтоолуудыг бол оруулж ирдэг нь буруу гэдгийг бас энэ дээр бас онцгойлж хэлэхийг хүсэж байна аа.

Ингээд дагаж оруулж ирсэн хуулиудтай холбоотой ганц хоёр зүйлүүдийг асууя аа. 1 дүгээрт нь энэ ААНОАТ-ын тухай хууль дээр сургууль, цэцэрлэгийн барилга барих юм болбол ААНОАТ-аас хөнгөлөлт үзүүлэх ийм заалт орж ирж байгаа. Энэ дээр би тооцоо судалгааг бас ажлын хэсэг дээр асуусан. Нийт хэчнээн сургууль, цэцэрлэгийн барилга барих гэж байгаа юм бэ. Энэнтэй холбоотой хэчнээн хэмжээний татварын орлого нь цаад аж ахуйн нэгжүүдэд хөнгөлөлт болж, бизнест нь хувь нэмэр болж үлдэх юм бэ. Төсвийн орлого хэдээр яг энэнтэй холбоотойгоор буурах юм бэ гэдэг ийм тодорхой асуулт асуусан. Энэ дээрээ бас энэ дээр давхар хариулт авахыг хүсэж байна аа.

2 дугаарт нь энэ төсвийн тухай хуулийн бас 2 дахь хэсгийн заалт байгаа. Төсвийн захирагч одоо авлага өр төлбөр үүсгэсэн байвал албан тушаалаасаа чөлөөлөгдөх үндэслэл болно оо гэж ингэж зааж оруулж ирсэн байгаа. Өнөөдөр бодит амьдрал дээр сумын ЭМТ-ийн дарга эм нь одоо санхүүжилт нь ирэхгүйтэй холбоотой эм дутагддаг, хүнд өвчтөн нь хүрээд ирдэг, сумдаа байдаг ганц нэг аптекаасаа эм зээлээд эмчилгээгээ хийдэг. Эмнэлгийн сумын хүн эмнэлгийн байгууллага одоо харж байгаад хүн үхүүлж чадахгүй. Ингээд өр авлагатай ингээд санхүүгийн тайлан жилдээ гараад явдаг. Санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтээр бол 5 их наядын өр өглөг төрийн байгууллагууд үүсгэсэн байна аа гэсэн ийм дүгнэлт гарч ирсэн байгаа юм. Тэгэхлээр энэ одоо ямар учиртай яагаад ийм заалт оруулж ирсэн юм бэ.

Бид нар өнөөдөр ийм арга хэмжээ авна гэж заалт оруулахаасаа өмнө яагаад өр төлбөр үүсээд байгаа юм бэ гэдэг дээрээ Сангийн яам бас энэ дээр бас бодлого гаргах ёстой байсан гэж ингэж үзэж байгаа юм. Энэ дээрээ та нар яг энэ өр

төлбөрийг цаашид гаргахгүй байх үүднээс ямар арга хэмжээ бас бодлого төлөвлөж байгаа вэ гэдэг ийм 2 дахь асуулт асууя аа.

3 дугаарт нь алт хөтөлбөртэй тогтоолтой холбоотой бас асуулт асуумаар байна аа. Увс аймгийн Түргэн сум, Увс аймгийн Өмнөговь сум дээр өнөөдөр энэ Алт хөтөлбөрийн шуугианаар асар их хэмжээний өмнө нь А лиценз авчихсан аж ахуйн нэгжүүд олборлолт үйл ажиллагаагаа явуулна гээд тэнд ард иргэдийн эсэргүүцэлтэй тулж байгаа юм. Тэрийг нь явуулахгүй гэсэн багийн дарга Засаг дарга эд нар бүгдээрэнг нь шүүх хяналтын байгууллага руу шилжүүлээд явж байна л даа. Гэтэл тэр ус, ус ундны яг ийм эх үүсвэр газар байгаад байдаг. Иргэдийн болон мал амьтны унд ундны одоо дутагдалд орох ийм нөхцөл байдал үүсээд байгаа юм. Тэгэхлээр чинь иргэд амьжиргаагаа алдахгүйн тулд тэмцэхээс өөр аргагүй нөхцөл...

Д.Амарбаясгалан: Туваан гишүүн. За Дамдинням сайд хариулт өгье.

Г.Дамдинням: Нэлээн олон асуултууд байх шиг байна. Би зүгээр өөрийнхөө хариуцсан хэсэг дээр бас хариулт хэлье ээ. 1 дүгээрт яах вэ юу байгаа юм аа. Алт аян гэж тогтоолын төсөл орж ирсэн. Тэгээд энд болбол ерөөсөө 1 зүйлийг бас ойлгох хэрэгтэй. Юу вэ гэхээр бид хамгийн тэргүүн эгнээнд энэ ондоо багтаад үйл ажиллагаа нь эхлэхэд металаа өгч чадах өөрөөр хэлбэл Монгол банканд алтаа тушааж чадах үйлдвэрээ барьчихсан үндсэн ордуудын асуудлыг ярьж байгаа шүү. Шороон орд энд байхгүй. Алт аяны хүрээнд угаасаа шороон орд яригдаагүй байгаа. Яригдахгүй.

2 дугаарт болбол таны ярьсан тэр Увс аймагтай холбоотой асуудлууд бол энэ алт аяны хүрээнд бол яригдаж байгаа асуудал байхгүй ээ. Тайван амгалан байж болно.

3 дугаарт бид энэ дараачийн ээлжид болбол энэ төрийн өмчийн компаниуд дээр байгаа алтны үндсэн ордын лицензүүдийг үйл ажиллагаанд оруулах төлөвлөгөөг одоо боловсруулаад явж байна. Ер нь болбол энэ алт тогтоолыг дагаад яг нэр координацаараа УИХ-д орж ирж танилцуулагдаад, зөвшөөрлөө аваад явна аа, УИХ Зөвшөөрвөл хөдөлнө. УИХ зөвшөөрөхгүй болбол хөдлөхгүй ээ. Ийм л одоо ойлголттой байж өгье дөө та бүхэнд тийм.

Д.Амарбаясгалан: Сангийн яам Санжаадорж дарга.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Гишүүний асуултад хариулья аа. Өр төлбөртэй холбоотой асуудал бол одоо төсвийн тухай хууль дээр болбол 3 заалт байдаг. Төсвийг бол төсвийн шууд бүх захирагч нарын хувьд бол төсвийг зохистой удирдаж авлага өр төлбөр үүсэхгүй байх үүрэгтэй 1 дүгээрт.

2 дугаар одоо хамгийн чухал үүрэг юу вэ гэхлээр батлагдсан төсвийн хүрээнд л зарлага гаргах эрхтэй, бүр эрх нь үүргээсээ гадна. Тэгэхлээр өөрөөр хэлбэл УИХ-аас баталчихсан энэ төсвийн хүрээнд л зарлага гаргана уу гэснээс тэрнээс илүү мөнгөөр зарлага гаргаж, өр төлбөр үүсгэж, эсвэл орж ирээгүй орлого нь буюу санхүүжилтийг нь өгөөгүй байхад өөрөө өр үүсгээд явж байна гэдэг бол энэ өөрөө төсвийнх нь том зарчмыг эвдчихээд байгаа юм. Тэгэхлээр энэ асуудал маань болбол явж байна. Нөгөө талдаа болбол та ингэж асууж байна. Өр төлбөр бол одоо

ингээд нэмэгдээд байна аа энэнтэй энэнгүйгээр. Тэгэхлээр бид болбол одоо энэ дээр болбол 2 янзын чиглэлээр болбол ажиллах ёстой гэж харж байгаа.

1 дүгээрт болбол мэдээж хэрэг төсөв батлагдсаны...

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя нэг минут нэмж өгье.

М.Санжаадорж: Уучлаарай, төсөв батлагдсаны дараа бол Үндэсний аудитын газар бол батлагдсан гүйцэтгэл дээр болбол ингээд ажилладаг болбол төсвийн жилийн дундуур бол санхүүгийн хяналт болбол ажиллах ёстой. Манай дээр бол санхүүгийн хяналт бол байдаг. Төсвийн ерөнхийлөн захирагч болгонд байгаа. Энэ санхүүгийн хяналт маань илүү их эрсдэлд суурилсан байдлаар болбол зааж зөвлөх байдлаар болбол ажиллах ёстой л гэж бид харж байгаа. Нөгөө талдаа бол энэ өр үүсээд байгаад энэ өр авлагын хэмжээг болбол бид нар цаашдаа хязгаарлахдаа нэг талдаа энэ саяын хэлсэн одоо энэ зааж зөвлөх энэ ажлаа хийхээс гадна нөгөө талдаа санкцын асуудал заавал байх ёстой л гэж хараад байгаа юм. Тэгэхлээр болбол нэгэнт хуульд заачихсан энэ санкцын асуудлаар нь оруулж ирж ярьж байгаа юм.

Мөн хуулийн заалтыг нь та ингээд харах юм болбол тухайн төсвийг зохисгүй удирдаж гэдэг нэг ийм агуулга байгаад байгаа юм. Өөрөөр хэлбэл зохисгүй удирдаж гэдэг нь тэр гамшиг ослын асуудал бол биш ээ, эрүүл мэнд дээр одоо үүсэж байгаа одоо цар тахлын асуудал биш ээ л гэж хэлэх гээд байгаа юм. Тэгэхлээр яг удирдаж болох асуудал...

Д.Амарбаясгалан: Заяабал гишүүн тодруулж асууя.

Б.Заяабал: Тэгэхлээр тэр санхүүжилттэй холбоотой асуудлуудыг цогцоор нь сууриар нь шийдэхгүй болбол орон нутаг дээр бол аягүй олон проблемууд үүсдэг юм байна лээ шүү. Санхүүжилт орж ирээгүй юм чинь гэдэг байдлаар эмнэлгийн эрхлэгч өвчтэй хүн гэнэт одоо өвдөөд ороод ирчихсэн хүнийг үхүүлж болохгүй шүү дээ. Эмнэлгийн үйлчилгээ төрийн үйлчилгээ явж л байх ёстой. Тэгэхлээр энэ санхүүжилтийнхээ системүүдийг бид нар бас ойр анхаарах ёстой шүү. Дээрээс нь маш олон хуулиудаар төсвийн захирагч нарт баахан мөнгө гаргах үүргийг заагаад өгчихсөн байгаад байдаг. Төсвийнх нь тухай хууль дээр нь ямар ч тийм мөнгийнх нь эх үүсвэрийг нь тодорхой хийж өгөөгүй. Одоо ахмадын асуудлыг шийдэхтэй холбоотой цалингийн 3 хувиар асуудлыг шийдэж болно ч гэдэг юм уу гэх мэтчилэн төсөв дээр мөнгө нь тавьж өгөөгүй мөртөө бусад хуулиудаар мөнгө гаргах ийм үүргүүдийг нь оноочихсон энэтэй чинь холбоотой ингээд төсвөөсөө мөнгө гаргачихаар эргээд аудитаар асуудал дүгнэлт гаргадаг нэг баахан одоо хууль зөрчсөн хүн болоод хувирчихдаг ийм асуудал үүсээд...

Д.Амарбаясгалан: Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн асуулт асууя.

Ц.Мөнхтуяа: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе ээ. Төсвийн тодотгол дагаж оруулж ирсэн хууль тогтоомжийн төслүүдтэй холбоотой 3 асуулт асууя. ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт заалт оруулахаар оруулж ирсэн. Өмчийн хэлбэр харгалзахгүй цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн зориулалтаар цэцэрлэг, сургуулийн барилга байгууламж шинээр барих, татварын нэг хувийн хөнгөлөлт эдлэхээр оруулж ирсэн. Эндээс 2 асуулт урган гарч байгаа.

1 дүгээрт төрөөс үзүүлэх татварын хөнгөлөлтөөр хувийн сургууль, цэцэрлэг барих нь хэр зохимжтой вэ. Зөвхөн төрийн өмчийн цэцэрлэг, ЕБС барьж өгсөн тохиолдолд энэ татварын хөнгөлөлтийг нь эдэлж болохгүй юм уу гэсэн нэг асуулт байна.

2 дугаарт Монгол төрийн боловсролын сайд хүн одоо хувийн эрх ашгийн үүднээс хандаж болохгүй. Саяхан Оюун-Эрдэнийн Засгийн газар огцроод сайдын үүрэг гүйцэтгэгч хийж байхдаа Мэргэжлийн Их сургуулийн шаардлагыг илэрхий хангаагүй байхад журмын бус ажлын хэсгээр нөгөө Шинэ Монгол дээд сургуулийг Шинэ Монгол их сургууль болгосон ийм юу гарсан. Тэгэхээр энэ дээр одоо эрх ашгийн ашиг сонирхлын зөрчил байна аа гэж үзэж байгаа. Үүн дээр бас тайлбар сонсох гэсэн чинь Наранбаяр сайд бас алга байна аа. Энийг асуучихъя нэгэнт асуулт бэлдээд ирсэн.

Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд бас байхгүй байна. Төсвийн тодотголоо дагаад гуя дагаж хүзүү гэдэг шиг төрийн албаны хууль төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг одоо дордуулахыг оролдсон нэмэлт, өөрчлөлтүүд оруулж ирэхээр тусгаад азаар олон нийт гишүүдийн эсэргүүцэлтэй тулгараад шүүмжлэлд өртөөд Засгийн газар төслөө буцааж авсан. Одоо удахгүй ирэх намар хэдхэн сарын дараа 2026 оны төсөв хэлэлцэнэ ээ. Энэ үеэр бас дахиад тэр нөгөө заалт чинь ороод ирэхгүй гэсэн баталгаа алга аа тэр хууль. Тэгэхээр төрийн албан хаагчид бол маш их айдастай байна аа. Энийгээ дахиж оруулж ирэх юм уу, ирэхгүй юм уу гэдгийг бас асуумаар байна аа. Гол нь бол энэ Аубакир сайд, Наранбаяр сайд хоёроос асуух асуулт байсан. Хоёулаа алга байна. Тэгээд хэн нэг нь хариулчих уу?

Д.Амарбаясгалан: Төсөв дагуулж хамт өргөн мэдүүлсэн хуулиуд учраас Сангийн сайд төлөөлж хариулъя. Ер нь яг энэ хэлэлцүүлэг болбол Байнгын хорооны санал дүгнэлттэй холбогдуулж Байнгын хороон дарга болон ажлын хэсэг хариулт өгөх үүрэгтэй юм байгаа юм. Сангийн сайд хариулт өгчихье.

Б.Жавхлан: Мөнхтуяа гишүүний асуултад хариулъя аа. Би тэр татвартай холбоотой хэсэг дээр нь хариулъя. Өнгөрсөн жилээс энэ зохицуулалт орж ирсэн. Тэгэхээр ер нь манай яг нийгмийн суурь дэд бүтцийн салбарууд цаашдаа бидэнд хэрэгцээтэй байгаа төрийн үйлчилгээ төрийн үйлчилгээг явуулах энэ хөрөнгө оруулалт бүхий байр одоо ийм хичээлийн байр, СӨБ-ын түвшинд, ЕБС-ийн түвшинд ч маш их шаардлагатай байгаа. Та тэр судалгаануудыг харсан байх тиймээ. Энэ чинь 100-гаад цэцэрлэг, 100-гаад сургууль хэрэгтэй байгаа юм нэмж. Төсөвт өртөг нь 5.6 их наяд гэж байгаа юм. Хойтон бид одоо боловсролын жил болгон зарлах гэж байгаа. Гэтэл одоо төсөв маань нэлээн агших гээд байдаг. Гэтэл нийгмийн хэрэгцээ маань тийм байж байдаг.

Тийм учраас бид өөр боломжит бүх эх үүсвэрүүдийг энэ дээр дайчилж ашиглая аа л гэж байгаа юм. Төсвөөс бүгдийг нь ч чадахгүй, 10-ны 1-ийг нь ч чадахгүй. За тийм учраас одоо гадаад, дотоодын хөрөнгө оруулалтууд, төр, хувийн хэвшлийн түншлэл энэ бүх боломжит эх үүсвэрүүдийг дайчилж, тэд нар дээр одоо гол хөшүүргүүдийг нь тавьж өгч байж энэ нийгмийн хөрөнгө оруулалтуудыг бид нар татаж чадна аа. Тэгэхгүй болбол энэ салбарууд чинь өөрөө одоо тийм ашгийн төлөө өндөр хөрөнгө оруулагч нарыг татах ийм боломж ашгууд бол өгөөж байдаг бага учраас хөрөнгө оруулалтууд гарч ирдэггүй ээ. Тийм учраас энэ хөшүүрэг болбол нэлээн бас боломжийн хөшүүрэг болох болов уу гэж ингэж бодож байгаа.

Энэ хууль ашиглаж эхэлснээс хойш ялангуяа одоо спортын салбар, нийгмийн бусад өөр, одоо соёлын салбаруудад ч гэдэг юм уу нөгөө төсвөөс бид нар хангалттай хөрөнгө оруулалт авч чаддаггүй, хийж чаддаггүй тэр салбарууд дээр түлхүү орж ирж байгаа нь яг одоо цаг үеэ олсон, байгаа оносон ийм хууль зохицуулалт болж байна аа гэж ингэж харж байгаа. Ингээд энэ дээр нэмэх нь одоо энэ сургууль, цэцэрлэгийн асуудлууд ороод ирэхээр бас төрөөс нэлээн ачааллыг нь ийшээ аваад явчих болов уу гэж ингэж бодож байгаа. Төрийн ч бай, хувийн ч бай тэнд боловсролын үйлчилгээ үзүүлэх учраас одоо яг бидний дутагдаад байгаа тэр орон зайн дээр одоо орж ирэх тун боломжийн ийм зохицуулалт болчихлоо гэж ингэж харж байгаа. Одоо таны салбарынхан ч тэр, бодлогын яам нь ч тэр энийг маш баяртай хүлээж авч байгаа. Өөрсдөө ч ийм санал өмнө нь одоо гаргаж байсан юм.

Тийм учраас ийшээгээ бас хөрөнгө оруулагч нар нэлээн орох болов уу. Нөгөө 200 сургууль, цэцэрлэгээс чинь тодорхой хэмжээний ачааллыг нь хувийн хэвшил ингээд хөрөнгө оруулалт хийгээд үүрээд явах болов уу гэж ингэж бодож байна тийм. Тэгэхээр нөгөө татсан хууль чинь одоо тэгээд жилийн дотор одоо буцааж дахиж энэ асуудал бол яригдахгүй шүү дээ тиймээ. Та тэгэхээр тэрэнд санаа зоволтгүй.

Д.Амарбаясгалан: Мөнхтуяа гишүүн тодруулж асууя.

Ц.Мөнхтуяа: Жавхлан сайдад баярлалаа. Төрийн албан хаагчид бол айлтгүй ажлаа хийх орчин нөхцөл бүрдсэн гэж ойлголоо. Тэр хувийн сургууль, цэцэрлэгийг төрийн мөнгөөр барина аа гэдэг дээр л гайхаад хүмүүс асуугаад байгаа юм л даа. Тэрнээс төрийн сургууль, цэцэрлэгүүдийг барих дээр бол би юм яриагүй. Төрийн тэр дэмжлэгээр хувийн сургууль, цэцэрлэг барина аа гэдэг нь өөрөө бас их сонин санагдаад байгаа юм. Хувийн ашиг сонирхол харагдаад байгаа байхгүй юу. Тэгээд тэрийг л би асууж байгаа юм.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд хариулт өгье.

Б.Жавхлан: Мөнхтуяа гишүүн ээ, төрийн мөнгөөр төсвийн мөнгөөр барьж байгаа зүйл ерөөсөө огт биш шүү. Хэрвээ тийм өнцгөөр ярих юм бол өмнө батлагдчихсан одоо дэмжигдээд явж байгаа бүгдийг нь тийм өнцгөөр тайлбарлаад, унагаагаад энэ чинь бүүр хачин юм болно. Тэгэхээр хүн өөрийнхөө хувийн хөрөнгөөр, компани хувийнхаа хөрөнгөөр хөрөнгө оруулалтууд хийгээд тэгээд нийт борлуулалтын орлогынхоо нэг хүртэл хувьтай тэнцэх татвар дээрээсээ хөнгөлөлт л авах юм байгаа юм тийм. Дээрээс нь бас хэлж байна ААН-үүд ашигтай гараад татвар төлөхөөр болбол тэр татвараас нь одоо нийт борлуулалтын орлогын нэг хувьтай тэнцэх хэмжээний хөнгөлөлт эдэлнэ ээ л гэсэн үг юм байгаа юм тийм.

Д.Амарбаясгалан: Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуулт асууя.

Д.Энхтүвшин: ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбоотой нэг асуулт байна аа. Өнгөрсөн оны 8 сарын 30-нд төсвийн тодотгол хэлэлцэх үеэрээ бид нар Татварын тухай хуулийн энэ 22.9 дээр өөрчлөлт оруулсан байгаа. Тэгээд энэнээс хойш энэ заалт дээр бол хувийн хэвшилд бас нэлээн хэрэгтэй заалтууд байгаа. Зүгээр би бас дахиад сануулаад бас хэлчихье. Энийг бас ААН-үүд маань бас анхаарч сайн судалж бас ашиглаарай гэж хэлмээр байна. Байгаль хамгаалах болон ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийн асрамжийн чиглэлээр мөн соёлын өвийг хамгаалах сэргээх, номын сан, музей барих чиглэлээр нийтийн эзэмшлийн зам талбайд хөрөнгө оруулалт, спортын

барилга байгууламж, олимпын төрлийн тэмцээн уралдаан зохион байгуулах, олимпын спортын холбоо, баг тамирчид, дасгалжуулагчдад санхүүгийн дэмжлэг үзүүлэх, сургалтын төлбөрийн хөнгөлөлтүүд байгаа зарим шаардлага хангасан. Тэгээд судалгаа шинжилгээний зориулалтаар олгосон тэтгэлэг гэх мэтчилэнгээр нэлээн олон зүйлүүдийг одоо татвар ноогдох орлогоосоо нэг хувьтайд татвар ноогдох орлогынхоо нэг хувьтай тэнцэх хэмжээний ийм хөнгөлөлтийг эдлэх бололцоо байгаа.

Тэгээд энэ хууль маань уул нь энэ оны 1 сарын 1-ээс хэрэгжиж эхэлсэн байгаа. Батлагдаад одоо 10 сар болчихсон байгаа. Энэ дээр 22.11 дээр нь журам батлах ёстой байгаа. Тэгээд энэ журам маань одоо 8 сар, 10 сар өнгөрчхөөд байхад батлагдаагүй байна аа. Тэгээд энэ явцаа хэлж өгөөч ээ, өөрөөр хэлбэл энэ хуулиуд маань, энэ журам маань, бид нар яах вэ гоё хууль яриад байдаг, журмууд маань батлагдахгүй болбол ААН-үүдийн хувьд ч гэсэн тодорхойгүй байдлууд бий болоод одоо яг энэ нь яаж хэрэгжих юм гэдэг байдлууд бас ийм тодорхойгүй байдлууд гарч ирээд байна. Өмнө нь Ерөнхий сайд бас уриалга бас гаргаж байсан. Энийг өөр юманд ашиглахгүй зөвхөн одоо утаа бууруулах чиглэлээр ашиглая аа гээд.

Тэгэхээр энэ журам маань хэзээ гарах вэ? Журмын явц хэзээ байгаа вэ? Тэгэхгүй бол бид нар энэ гоё заалтыг одоо яаж ч өөрчлөөд хэрэглэж чадахгүй ингээд удаад яваад байна аа. Энийг энэ явцыг 1 дүгээрт асуумаар байна. 2 дугаарт энэ нэг заалттай Татварын ерөнхий газраас ч юм уу энэ заалттай холбоотойгоор нийт хэдэн төгрөгийн хөнгөлөлт үзүүлэх боломжтой гэсэн тооцоолол байгаа вэ? Ийм 2 асуулт байна.

Д.Амарбаясгалан: Татварын ерөнхий газрын дарга Чимэдсүрэн хариулт өгье. 4 дүгээр индэр.

Ч.Чимэдсүрэн: Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Татварын ерөнхий газар Чимэдсүрэн. ААНОАТ-ын 22.9 дүгээр заалт, 2024 оны 8 дугаар сарын 30-нд батлагдсан, 9 дүгээр сарын 19-өөс эхэлж мөрдсөн байгаа. Өнгөрсөн өөрөөр хэлбэл 4 дүгээр улиралд болбол энэ хэрэгжээд эхэлсэн гэсэн үг. Өнөөдрийн байдлаар нийт татварын албанд илгээсэн төслийн тоо бол 87, мөнгөн дүнгээрээ бол 44.5 тэрбумын 7 яаманд харьяалагдах ийм төсөл санхүүгийн дэмжлэгийг болбол ирүүлсэн байгаа. Тэгээд түрүүний хэлснээр болбол тэр 22.9.11-д нь болбол салбарын яамд нь болбол тусгай тэр шаардлага, стандартаа баталж, хяналт тавих ийм чиг үүрэгтэйгээр байгаа. Тэгээд 5 сарын байдлаар болбол бүх яамдууд холбогдох стандарт шаардлагаа болбол баталсан байгаа гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуулт асууя.

О.Номинчимэг: За бүгдэнд нь өдрийн мэнд хүргэе. Энэ төсөв дагаж төсвийн тодотгол дагаж орж ирсэн ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиас асуулт байна аа. Уг нь ажлын хэсгийн дарга Туваан даргаас асуумаар байх юм байхгүй юм. Энэ чуулганд чинь ажлын хэсгийн дарга нь, Байнгын хорооны дарга нь хариулах ёстой биз дээ. Хоёулаа алга байна шүү дээ. Энэ нөгөө энэ Заяабал гишүүн ч хөндлөө, Мөнхтуяа гишүүн ч хөндлөө. Энэ ер нь яг ямар бодлого яваад байна аа? Бид нар яах вэ Боловсролыг дэмжих жил гээд гоё одоо зөв уриа гаргаад ингээд явж байгаа. Гэхдээ боловсрол дээр чинь хамгийн чухал асуудал энэ чинь цаашдаа угаасаа манай нийгэм ямар нийгэм байх вэ ямар хүнээ бүтээх вэ,

үнэхээр бид нар хүмүүнлэг ардчилсан иргэнлэг нийгмээ бүтээх үү гэдэг чинь бол боловсролын асуудал чинь суурь асуудал шүү дээ. Тэгээд одоо боловсрол дээр хувийн сургууль, улсын сургуулийн тэгш бус байдал үүнээс үүдсэн хүүхдүүдийн, сургалтын чанар ингээд бүх нийгмийн юманд чинь боловсролын энэ суурь асуудал нөлөөлдөг.

Тэгтэл энэ дээр төрийн өмчийн сургуулийг бол ойлгох юм энийг. Тэгтэл өмчийн хэлбэр харгалзахгүй гээд хувийн сургуулиудад хөрөнгө оруулалт оруулах юм болбол цэцэрлэгт бас хөрөнгө оруулах юм болбол татварын чинь хөнгөлөлт үзүүлнэ ээ гэдэг бодлого орж ирж байна. Энэ байж болшгүй шүү дээ. Тийм л юм бол энэ Мөнхтуяа гишүүний ярьж байгаа зөв шүү дээ. Энэ чинь олох ёстой орлого байхгүй юу төрийн. Татвараа авах ёстой юмаа л больё гэж байгаа шүү дээ. Тэгээд тийм л юм бол тэр татвараа аваад энэ 40 тавиулаа 1 өрөөнд шахцалдаад сууж байгаа улсын сургуулийнхаа анги танхим, 3 ээлжээр сураад 8, 9 цаг тарж байгаа улсын сургуулиудынхаа анги танхимыг зарцуулахад зориул л даа. Яагаад хувийн сургуулийн хувийн цэцэрлэг рүү хөрөнгө оруулахыг ингээд дэмжээд байгаа юм бэ.

Уг нь энэ төсөвтэй хамт УИХ-ын тогтоол орж ирсэн. Энүүгээрээ бас нэлээн зоригтой алхам авъя аа гээд төрийн бус өмчийн цэцэрлэг, сургуульд олгож байгаа хувьсах зардлын санхүүжилтийг зогсооно гээд орж ирсэн. Даанч энэ тогтоол маань өөрөө татагдчихсан. Ингээд нийгмийн тэгш байдлаа хангая гэвэл, шударга байдлаа хангая гэвэл бид нар чинь боловсролын салбараас л эхлэх ёстой шүү дээ. Тэгээд энэнтэй холбоотой асуулт байна. Сангийн яам бодвол хариулах байх. Энэ ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж ирснээр төсөвт энэ төсвийн тодотгол чинь яаж нөлөөлж байгаа юм бэ? Орлого чинь яаж буурах юм эсвэл ихсэх гээд байгаа юм уу? Энэнийхээ тооцооллын хэлж өгөөч. Санжаа дарга мэдэж байгаа бид нар сая Хууль тогтоомжийн тухай хууль батлахдаа төсөв дагуулж янз бүрийн хууль оруулж ирэхээ больё. Төсөвт болбол зөвхөн төсвийн урсгал зардал орлогод тэнцэлттэй нөлөө үзүүлэх ийм хуулиудаа л оруулж ирье. Энэ концепцыг батлаад энэ хууль тогтоомжийн хууль чинь батлагдчихсан шүү дээ. Тэгээд энэ ААНОАТ-ын хууль чинь тэгвэл ямар нөлөө үзүүлнэ гэж та нар тооцоолол хийгээд төсөв төсвийн тодотгол дагуулж орж ирж байгаа юм.

Д.Амарбаясгалан: За хариулт өгье Сангийн сайд Болдын Жавхлан.

Б.Жавхлан: Номинчимэг гишүүний асуултад хариулъя аа. Энэ хууль ноднин 9 сараас хойш хэрэгжиж эхэлж байгаа. Хэрвээ тийм өнцгөөс ярих юм бол одоо энүүгээр зөвшөөрчихсөн аль хэдийн эхэлчихсэн байгаа спорт, соёл бусад нийгмийн салбарууд дээр чинь дандаа л хувийнх шүү дээ. Дандаа л хувийн секторууд. Төрийн байгууллага гэх юм бол Эрдэнэт үйлдвэрээс юм уу эсвэл ЭТТ-оос ч юм уу эсвэл өөрөө хаанаас байдаг юм Дархан төмөрлөгийн үйлдвэрээс гэх юм уу тэндээс хийгдэж байгаануудыг л зөвхөн одоо спорт, соёл урлагийн нийгмийн суурь салбарууд дээр дэмжинэ, бусад нь болохгүй ээ гэж болохгүй байхгүй юу. Ийм сургууль, цэцэрлэгийн хөрөнгө оруулалтууд чинь ингээд нэг удаа барих хөрөнгө оруулалтын зардлаас цаашаагаа 30, 40 жил, 50 жил өнөөдөр явчихсан байгаа цэцэрлэгүүд ч байна. Эдгээрийнх чинь урсгал зардал нь бүүр хэдэн 10 дахин одоо төсөв дээр ачаалал ирдэг гэсэн үг.

Хувийн сектор өөрсдөө хөрөнгө оруулалт хийгээд энэ чинь төсвийн мөнгө учраас арай болоогүй байгаа мөнгө шүү энэ чинь. Өөрсдөө хөрөнгө оруулалт хийгээд цаашаа урсгал зардлаа аваад явна аа гэх юм бол энэ нь болж байгаа юм.

Хэрвээ таны ярьж байгаагаар хийчхээд төрд шахчих юм бол тэрийг нь одоо төр аваад цаашаагаа урсгал зардлыг нь тавиад ингээд явна аа гэх юм болбол ямар ч нэмэр байхгүй. Төсөв дээрээс ямар ч ачаалал авахгүй ээ гэсэн үг. Сургууль, цэцэрлэгээ бариад өөрсдөө хөрөнгө оруулалтаа хийгээд цаашаагаа урсгал зардлаа өөрсдөө хариуцаад ингээд одоо бизнесийн эрүүл харилцаагаар ингээд аваад явах нь болбол тэр тухайн одоо компани, ААН хувь хүмүүсийн өөрсдийнх нь эрсдэлийн асуудал сонголтын асуудал шүү дээ. Тэгээд ийм зохицуулалтаар орж ирж байгаа гэсэн үг. Энэ тодотголд бол ямар нэг хамаа байхгүй. Хойтон харин боловсролын жил болгож зарлана аа гэдгийгээ Засгийн газар зарласан. Энэ бодлогыг ч гэсэн үргэлжлүүлнэ ээ гэдгийгээ ч зарласан.

Тийм учраас хойтонгийн тайланг одоо санхүүгийн тайланд жилд ийм боломжууд байгаа шүү, энэ салбар луу хөрөнгө оруулалт хийгээрэй. Цаашаагаа өөрсдөө урсгал зардлаа аваад явах юм байна шүү гэдэг ийм ойлголтыг эрт өгч байна аа гэсэн үг. Өөрөөр хэлбэл хувийн сектор энэ дээр төсөвлөх төлөвлөх бизнесээ одоо 1, 2 жилээр харах энэ боломжуудыг нь тавьж өгч, эрт хийж байна аа гэсэн үг юм байгаа юм.

Д.Амарбаясгалан: Номинчимэг гишүүн тодруулъя.

О.Номинчимэг: Жавхлан сайд аа би бас юм уншдаг хүн. Энэ хууль чинь хэзээ батлагдаад, ямар зорилгоор батлагдаж байгаа батлагдсан хууль гэдгийг мэднэ ээ. Энэ бол угаасаа төр хийх ёстой нийтийн эзэмшлийн зам талбай байдаг юм уу, нийгмийн салбар төрийн өөрөө үйл ажиллагаагаа хийх ёстой юманд хувийн хэвшлийн энэ механизмыг, татварын механизмыг л ашиглая гэж байгаа шүү дээ. Тэрнээс хувийн өмчийг баяжуулахын төлөө, хувийн өмчийг их болгохын төлөө энэ татварын механизмыг ашиглая гэсэн концепцтой биш байхгүй юу. Тэгээд энэ 22.9 дээр чинь бүгдээрээ яг юу юунд зарцуулах вэ гэдэг чинь байгаа шүү дээ. Мэдээж хувийн хэвшлээс татварын хөнгөлөлт. Гэхдээ зарцуулагдах зүйл нь болбол дандаа нийтэд ашиг тустай, нийтийн эзэмшлийн зүйлүүдэд.

Тэгээд 22.9.9 дээр чинь угаасаа байгаа шүү дээ. Төрийн болон орон нутгийн өмчийн боловсрол эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд та хэд хөрөнгө оруулалт хийвэл мөнгө зарвал татвараас чөлөөлөгдөнө өө гээд. Төрийн өөрсдийнх нь хийх ёстой юманд л та нар өгөх юм болбол чөлөөлөгдөнө өө гээд. Одоо энүүгээр чинь болохоор л хувийн өмчид өгөх гэж байгаа болбол чөлөөлөгдөнө өө гэдэг агуулга бодлого орж ирж байгаа шүү дээ.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан нэмэлт хариулт өгье.

Б.Жавхлан: Соёлын үйлчилгээ, спортын үйлчилгээ, боловсролын үйлчилгээг 100 хувь төр өөрөө авч явна гэдэг хаана ч, ямар ч тийм хуулийн зохицуулалт байхгүй ээ. Манай боловсролын салбарын түвшин түвшнийх нь бүх хөрөнгө оруулалтуудыг Төр өөрөө дийлэхгүй байна аа. Төсвөөс дийлэхгүй байна аа. Цаашдаа энэ улам хумигдана аа. Ийм үед одоо хувийн хэвшил гаднын хөрөнгө оруулалтуудыг энэ салбарт татах нь амин чухал болж ирж байна аа. Цаашдаа одоо бид хэдэн жилийн дараанаас энэ өсөн нэмэгдэж байгаа энэ одоо хэрэгцээ шаардлагыг бид төр улам л даахгүй болж ирнэ.

Тийм учраас л одоо ийм бид нар дараагийн өөр боломжит эх үүсвэрүүд рүү ийм хуулийн зохицуулалт хийж оруулж байна аа гэсэн үг. Яах аргагүй л энэ чинь

төрийн боловсролын үйлчилгээг хувийн хэвшил бас одоо үүрэлцээд явах л ийм л зохицуулалт шүү дээ.

Д.Амарбаясгалан: Номинчимэг гишүүн дахин тодруулж асууя.

О.Номинчимэг: Тэгээд харин төрийн үйлчилгээнд л одоо зарцуулах ёстой төр энийгээ их дийлэхгүй байна гэвэл төрийн өмчийн, орон нутгийн өмчийн цэцэрлэг, сургууль хийхэд л хөнгөлөлтийг нь олго л доо. Яагаад нэмж хувийн сургууль, хувийн цэцэрлэгт энийгээ өгөх гээд байгаа юм бэ? Тэр бодлогыг чинь л ерөөсөө ойлгохгүй байна шүү дээ. Тэгээд ингээд хэлэхээр А гэхээр Б гэдэг ийм хариулт одоо болно шүү дээ. Тэгээд бид нар бүгдээрээ бүх нийтийн боловсрол эрх тэгш байя гэж ярьчихаад ийм хувийн сургууль, цэцэрлэгээ дэмжсэн юм хийгээд байж болохгүй. Наранбаяр сайд мэдэж байгаа. Японд адилхан сурч байсан хүн. Японд яадаг вэ гэхээр ерөөсөө төрийн өмчийн, улсын өмчийн цэцэрлэг нь хамгийн сайн стандарттай. Хүмүүс тийшээгээ л хүүхдүүдээ өгөхийг боддог. Тэнд орж чадахгүй хүмүүс нь хувь руу өгдөг байхгүй юу. Ийм системийг л бид нар хийж байж тэр хүмүүнлэг иргэнлэг ардчилсан нийгмээ бас байгуулах үндэс суурь нь болно шүү дээ. Тэгээд энийг болбол ерөөсөө дэмжихгүй байна аа. Энийг угаасаа хууль тогтоомжийн хуулийн дагуу ч гэсэн төсөвт ямар ч хамаагүй хууль дагалдаж орж ирж байгаа нь өөрөө буруу учраас үнэхээр ийм бодлого байвал 2026 оны төсөвтэйгөө хамт энийгээ оруулж ирсэн нь дээр байх аа гэсэн ийм...

Д.Амарбаясгалан: УИХ-ын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо Байнгын хорооноос санал хураалгахаар бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулахаар байгаа. Зарчмын зөрүүтэй. Энэ дэг дээр үг хэлэх дэг алга байна шүү дээ. Үг байхгүй зарчмын зөрүүтэй 11 санал байгаа. За гишүүд санал хураалтад бэлтгэе. Гишүүд санал хураалтад бэлдье. Зарчмын зөрүүтэй 11 санал байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, УИХ-ын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Төсвийн байнгын хороо дэмжсэн санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1/12 дугаар зүйлийн 12.1.24 дэх заалт,

12.1.24.Тухайн жилийн төсвийн тухай хуульд заасан улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг орон нутгийн ерөнхий орлогын данснаас татан төвлөрүүлэх гэснийг хасах. Санал гаргасан УИХ-ын гишүүн Нанзадын Наранбаатар, Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал. Санал гаргасан гишүүн Наранбаатарт үг өгье.

Н.Наранбаатар: Гишүүдэд энэ өдрийн мэнд хүргэе ээ. Тэгээд энэ удаагийн төсвийн тодотголыг дагуулаад нэг 2 одоо бас аюултай гэх юм уу ийм хуулийн өөрчлөлт орж ирсэн юм. Төсөв дагуулаад. Түүний нэг нь болбол энэ заалт байгаа юмаа. Та бүхэн энийг бас сайн хараарай. Энэ заалт болбол аймаг, нийслэлийн орлогынх нь данс руу Сангийн яам шууд орж орлогыг нь татаж авах ийм одоо заалт нэмж орж ирж байгаа юм шүү. Нөгөө хууль нь юу байсан гэхээр зэрэг Төрийн албаны тухай хуульд төрийн албан хаагчдынхаа одоо карма руу орох ийм хуулийн төсөл орж ирснийг МАН-ын бүлэг дээр ярьж байгаад дэмжээгүй.

Хоёр дахь нь болбол одоо энэ Төсвийн тухай хууль байгаа юм шүү. Одоо энэ Төсвийн тухай хуулиар болбол аймаг, нийслэлийн данс руу нь орж орлогыг нь хурааж авах ийм одоо заалт орж ирж байгаа шүү. Тэгээд ер нь цаашдаа Сангийн яамныханд хэлэхэд орон нутгийг хөгжүүлнэ, төвлөрлийг сааруулна, эрх мэдлийг нэмэгдүүлнэ, бүсчилж хөгжүүлнэ гэж ярьж ярьчихаад ингээд зөрүүлээд нөгөө гараараа орлого бүх юмыг нь хурааж авдаг ийм одоо зүйл дахиж битгий ийм заалтууд оруулж ирээрэй гэж хүсэх байна. За баярлалаа гишүүд маань дэмжиж өгөөрэй.

Д.Амарбаясгалан: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн үг хэлье.

Б.Пүрэвдорж: Энэ төсвийн тодотгол батлагдаж байгаатай холбоотойгоор би говийн 3 аймгийн 4 сумаар явсан. Тэгээд энэ 4 сумаар явж байхад бол бид нар бүгдээрээ л одоо энэ уул уурхайн баялгаа ухуулж, энэ улсын төсөв рүү өгдөг. Тэгээд буцаад бид нарт ирэхгүй байна аа гэдэг ийм л зүйл ярьж байгаа. Тэгээд Наранбаатар гишүүний энэ саналтай би дэмжиж байгаа юм. Тэгэх дээр Өлзийт сумын 5 дугаар багийн Ичинхорлоогийн Эрдэнэбилэг энэ аймагт ганц хоёрхон зураг төсвийг хийдэг компани байдаг. Тэгээд Барилгын хөгжлийн төв рүү явуулдаг. Тэгсээр байтал 5 сарын 31-нд амжихгүй байна тэгээд. Тийм учраас энэ орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө татагдаад байна аа гэдэг зүйл ярьж байгаа.

Өмнөговь аймгийн Манлай сумын Жаргалан багийн Ж.Эрдэнэбаяр гэдэг хүн төмөр зам торгүй олон мал дайрагдаж байна аа. 10 цагаас хойш малчны буруу, 10 цагаас өмнө жолоочийн буруу гэдэг ийм зүйл ярьж байна. Энэ нь одоо юу хууль тогтоол дээрээ өөрчлөлт оруулж өгөөч ээ гэдэг ийм хүсэлтийг тавьж байна. Дорноговь аймгийн Мандах сумын Дөхөм багийн Төмөртоогоогийн Цэвээнсамбуу Мандах сумын 5 нүүрсний уурхайтай. Дээрээс нь Цагаан суваргын ордтой. Гэтэл орон нутгийн хөгжлийн санд дөнгөж 800 сая төгрөг өгдөг. 800 сая, 5 уурхай нэг одоо том орд байж байхад. Тэгээд АМНАТ-ыг илүү орон нутагтаа өгөх тэр ажлыг зохион байгуулаач. Энэ олон мянган жилийн туршид энэ эзэгтэйдүүд дээл цагаа авчирсан энэ газар нутгаа бид нар ингэж говийн тэр их халуун наранд манаж өнөөг хүртэл явчихаад, буцаагаад бид нарт ерөөсөө юм ирэхгүй байна аа гэдэг ийм л зүйл ярьж байна.

Өмнөговь аймгийн Ханбогд сумын Намнансүрэн гэж эмэгтэй сум хөгжүүлэх сангийн мөнгийг хоршоо хөгжүүлэх сангаар дамжуулж олгодог болсон. Тэгээд заавал хоршоо байгуулах гээд нэг хүн зээл авахын тулд 9 хүн ордог энэнээсээ болоод одоо олон хүн хохирох ийм ЖДҮ-лэл хөгжихгүй байх ийм нөхцөл рүү орж байна гэж. За Л.Батбуян гэдэг хүн Өмнөговь аймгийн Ханбогд сумын Л.Батбуян гэдэг хүн Өмнөговь бол хамаг одоо уул уурхайгаа бүгдийг нь ухуулаад бүх мөнгөө бүгдийг нь дээшээ Улаанбаатар хот руу татуулдаг. Тэгээд улсын төсвөөс дөнгөж 17-хон тэрбум төгрөг буцааж өгдөг. Тэгсэн мөртөө орон нутгийн хөгжлийн сангийн баахан мөнгийг нь буцаагаад аваад явчихдаг. Ийм байх юм болбол одоо энэ уул уурхай чинь орон нутагтаа сумдаа ирэхгүй болбол тэр хүмүүс чинь бүгдээрээ энийг эсэргүүцэж дургүйцэж тийм ээ, тэр нутгийн хүмүүс тоос шороо тэр бүх зүйл бүгдээрээ одоо мал малын бэлчээр мэлчээр бүх зүйлээрээ хохирч байж буцаагаад одоо орон нутагтаа энэ мөнгө төгрөг нь өгдөг ийм л зарчим руу одоо Наранбаатар гишүүний тэр яриад байгаа энэ зарчим руу явсан нь зүйтэй л гэдэг ийм зүйлийг ярьж байна шүү.

Тийм учраас дараа дараагийн төсвүүд дээрээ ялангуяа уул уурхайгаа ашиглуулж энэ улсын төсөв рүү маш их хөрөнгө татуулж байгаа тэр сумуудад илүү одоо хөрөнгө тавьж, тэндхийн хүмүүс сайхан амьдрах тэр боломжийг олгох ёстой шүү гэж хэлмээр байна аа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Хариулт байхгүй, тайлбар байхгүй. Ер нь одоо энэ төсөв татаж байгаатай холбоотой бас энэ энэний дараачийн асуудал дээр бас Жавхлан сайд ярих юм байгаа шүү. Адилхан хэрэгжиж байгаа Хүнсний хувьсгал, цагаан алт, шинэ хоршоо зэрэг хөтөлбөрүүдийг бас төсөв хуваарилахдаа ялгавартай хандсан тохиолдол гарсан зарчмын зөрүүтэй санал гарчихсан явж байгаа юм байна лээ. Тэгэхээр ер нь энэ нэг төсөв татдаг, төсөв хуваарилдаг зүйлүүд дээрээ жоохон зарчим барьж ажиллахгүй болбол цаашдаа юм явахад хэцүү болно шүү.

Мэндбаярын Мандхай гишүүн бас нэг зарчмын зөрүүтэй санал гаргачихсан байна лээ. Санал хураалт. Санал хураалтад бэлдье гишүүд. 73 гишүүн бүртгэгдсэн байна.

Нанзадын Наранбаатар гишүүний гаргасан саналыг, Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя аа.

70 гишүүн буюу 64.2 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 3 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан УИХ-ын гишүүн Цэвэгдоржийн Туваан, Баярбаатар, Бямбасүрэн, Ганбат, Заяабал, Лодойсамбуу, Нарантуяа-Нара. Пүрэвдаваа, Сайнзориг, Цогтбаатар, Уянга, Уянгахишиг, Үүрийнтуяа. Цаашид ажлын хэсэг гэх. Санал хураалт.

72 гишүүн буюу 66.1 хувиар санал дэмжигдлээ.

2.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Монгол УИХ-ын тогтоолын төслийн талаар. Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал.

1.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Монгол УИХ-ын тогтоолын төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн үг өгье.

Х.Баасанжаргал: Их Хурлын тогтоолыг бүхэлд нь тогтоолын төслийг бүхэлд нь буцааж байгааг дэмжиж байгаа. Гэхдээ энэ тогтоолын төсөл дотор хувийн сургуулиудад олгох татаасыг болих ийм шийдвэр гарсан боловч энэ нь ингээд хамтдаа буцчихлаа. Сангийн яам дараагийн удаа 2026 оны төсөв дээр энэ хувийн сургуулиудад олгож байгаа татаасыг буцаах тухай заалтаа дахиж оруулж ирээрэй гэдгийг 1 дүгээрт хэлэх гэсэн юм.

2 дугаарт мөн энэ тогтоолын төсөлтэй холбоотой Жавхлан сайд аа, та МАН-ын гишүүн социал демократ үзэл баримтлалтай нам, манай нам хэзээ ч хувийн

сургуулийн бизнесийг дэмжих ёсгүй. Маш олон хувийн сургуулиуд одоо барилга барьж байгаа тэр барилгыг нь бид нар одоо дэмжиж, татварын бодлогоор кноп дарах гээд сууж байна. Хэрвээ хувийн хэвшлүүд хувийн сургууль барих гэж байгаа болбол үүнийг бид нар татварын бодлогоор дэмжих ёсгүй. Харин хувийн хэвшил сургууль бариад түүнийгээ улсад хүлээлгэж өгөх юм бол бид нар тэр нэг хувийн татварын буцаалтыг нь дэмжих ёстой. Тэрнээс бид нар хувийн бизнесийг дэмжих ёсгүй. Хэзээ ч СДН-аас ийм үзэл баримтлалтай намаас хэзээ ч ийм бодлого гарч болохгүй ээ. Үүнийг хатуу хэлье.

Д.Амарбаясгалан: Хассуурийн Ганхуяг гишүүн үг хэлье.

Х.Ганхуяг: Баасанжаргал гишүүн ээ. Энэ нөгөө УИХ-ын тогтоол ерөөсөө буцааж байгаа шалтгаан нь Булгантуяа гишүүнээр ахлуулсан төсвийн тухай хууль, төсвийн цаглаврын тухай хууль эд нартай үндсэндээ яг 100 хувь нийцчихээд байгаа байхгүй юу. Тийм учраас тэр угаасаа энэ чинь Их Хурал дээр хэлэлцэгдээд явж байгаа болохоор энэ тогтоолын төслийг нь буцааж байгаа юм шүү тийм.

Д.Амарбаясгалан: Нэг бүлгээс 2 хүн үг хэлнэ. Цэвэгдоржийн Туваан гишүүн үг хэлье.

Ц.Туваан: Дагалдах хуулийн ажлын хэсгийг ахалж ажиллаж байгаа гишүүний хувиар нэг зүйл хэлье ээ. Энэ юу юм байгаа юм. Бид нар төсвийн тодотгол хэлэлцэж байгаа. Тэгэхээр Засгийн газраас өргөн барьсан энэ 2 Их Хурлын биш ээ, хуулийн 2 төсөл Их Хурлын тогтоолын 2 төслийн маань нэг нь энэ нөгөө 2026 оны төсөв дээр чиглэл өгөх тухай юм болчихсон байгаа юм. Хамгийн буцаах болсон гол үндэслэл нь энэ. 2026 оны төсвийг батлахдаа ийм чиглэл барина аа гэдэг нэг.

2 дугаарт нь бас манай ажлын хэсгийн гишүүд бол энэ ажлын хэсэг дээрээ маш сайн ажилласан. Тэгээд ажлын хэсгийн гишүүдийн саналаар энэ санал гарч ирж байгаа.

3 дугаарт нь УИХ-ын даргын 192 дугаар захирамжаар Булгантуяа Их Хурлын дэд даргаар ахлуулсан.

Д.Амарбаясгалан: Туваан гишүүн энэ дараачийнх нь санал хураалт шүү дээ. Өмнөх дээр нь хэлээд байна шүү дээ. Алт 3 руу ороогүй байна шүү дээ. Туваан гишүүний микрофоныг нэмж өгье.

Ц.Туваан: Тийм таны 192-оор Булгантуяа Их Хурлын дэд даргаар ахлуулсан ажлын хэсэг ажиллаад, 26 гишүүнтэй ажлын хэсэг ажиллаад санал дүгнэлтээ гаргаад Байнгын хороонд танилцуулчихсан. Одоо УИХ-ын тогтоолын төсөл болгоод батлуулах юм. Энэнтэй энэ саяын дагах дагаж өргөн барьсан тогтоолын төсөл бол агуулгын хувьд бол нэлээн давхцалтай байгаа учраас төсөл өргөн баригч одоо Засгийн газартай зөвшилцөөд бүтнээр нь татаж байгаа. Дээрээс нь Төрийн албаны тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийг МАН-ын бүлэг дээр улс төрийн шийдвэр гаргаж татсантай бас давхцаж байгаа. Ийм 3, 4 шалтгааны улмаас энэ төслийг буцаан татаж байгаа юмаа гэдгийг хэлье ээ.

Д.Амарбаясгалан: Дэмжсэн. Засгийн газар татаад авчихсан юм уу, аваагүй байна шүү дээ. Энэчээ чинь Байнгын хорооноос буцаах гэдгийг л дэмжиж орж ирж. Санал хураалт. Харин тийм. Тэгэхээр чинь одоо биднүүс санал өгч байж энэ чинь

буцах байхгүй юу. За тэгэхээр Байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт хийе ээ. Санал хураалт.

67 гишүүн буюу 61.5 хувиар санал дэмжигдлээ.

3.Алт 3 аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Монгол УИХ-ын тогтоолын төслийн талаар.

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал.

1.Тогтоолын төслийн нэг дэх заалтын Алт 3 аяныг 2025 оны он, сар, өдөр тавиагүй байх юм энэчээ. Дугаар сарын өдрөөс эхлэн орон даяар хэрэгжүүлсүгэй гэснийг дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасугай гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

71 гишүүн буюу 65.1 хувиар санал дэмжигдлээ.

2.Тогтоолын төслийн 2 дахь заалтын 2.Алт 3 аяныг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайд Занданшатарт даалгасугай. Үүнд гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

70 гишүүн буюу 64.2 хувиар санал дэмжигдлээ.

3.Тогтоолын төслийн 2 дахь заалтын 4 дэх дэд заалтын боловсруулна гэсний дараа Монгол УИХ-д өргөн мэдүүлэх гэж нэмж мөн Дэд заалтын алтны гэснийг мөн дэд заалтын батлуулах гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Энэ заалт дээр тайлбар байгаа юу? Энэ одоо тэгээд алтны төсөл болгоныг өргөн мэдүүлэх юм уу УИХ-д тэгж орж ирж байна уу, үгүй биз дээ. За санал хураалт.

70 гишүүн буюу 64.2 хувиар дэмжигдлээ.

4.Тогтоолын төсөлд доор дурдсан агуулгатай 3. 4 дэх заалт нэмэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол УИХ-ын Төсвийн байнгын хороонд даалгасугай.

4.Энэ тогтоолыг Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

73 гишүүн буюу 67 хувиар санал дэмжигдлээ.

Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал.

1.Тогтоолын төслийн 2 дахь заалтын 2 дахь дэд заалтад эрх үүргийн харилцааг тодорхой болгож гэсний дараа төсөл хэрэгжиж байгаа суманд үр өгөөжийн дийлэнхийг үлдээж гэж нэмж, мөн дэд заалтын эрх зүйн орчныг өөрчлөх гэснийг эрх зүйн орчныг сайжруулж, хууль тогтоомжийн төслийг боловсруулан УИХ-д өргөн мэдүүлэх гэж өөрчилж, мөн дэд заалтын арга хэмжээг шуурхай авах гэснийг

болон 3 дахь дэд заалтын арга хэмжээг авах гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. За Уянга гишүүн чинь ажлын хэсгийн гишүүн юм уу? Ажлын хэсгийн гишүүн санал гаргасан гишүүний хувьд Уянга гишүүнд микрофон өгье.

Б.Уянга: Энэ Төсвийн байнгын хорооны дэмжээгүй ийм 3 санал байгаад байгаа. Тэрэн дээр яах вэ өөрийнхөө миний байр суурь бол дэмжээд явчихвал энэ алт-3-ын аян л хэрэгжээд явчих юм шиг иймэрхүү байдлыг ажлын хэсэг дээр нэлээн ярилцаж ярилцаж ажлын хэсгийн 11 гишүүн дэмжээд тэгээд ингээд Төсвийн байнгын хороо руу орсон боловч унасан байдалтай байгаа юмаа. Би яг өөрийн хувь гишүүний хувьд гаргасан санал маань энэ тогтоолын төслийн 2 дахь заалтын 2 дахь дэд заалт буюу хариуцлагатай уул уурхайг төлөвшүүлэх хүрээнд хууль эрх зүйн орчныг судлаад, тэгээд УИХ-д өргөн мэдүүлэх гэсэн энэ агуулга бүхий яг энэ одоо заалтад нь тухайн төсөл хэрэгжиж байгаа газарт нь өгөөжийнхөө дийлэнхийг үлдээх байдлаар хууль тогтоомж дээрээ ажиллаад, эргэж оруулах аа гэдэг энэ саналыг гаргаж томьёолохдоо төсөл хэрэгжиж байгаа суманд гэдгээр томьёолоод оруулсан юмаа.

Тэгээд энэ маань болохоор ажлын хэсгийн гишүүд дунд ярьж байгаад бид нар дэмжээд уул нь явуулсан юм. Тэгтэл Төсвийн байнгын хороо руу орохдоо Сангийн яамны татварынхнаас холбогдоод л энэ саналаа татчих татчих, Үндсэн хууль зөрчиж байна гэсэн байдлаар холбогдоод байсан. Тэгэхдээ яг Үндсэн хуулийн 6.2-ыг нь уншаад үзэх юм бол байгалийн баялгийн үр өгөөжийг олгохдоо иргэн бүрд эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах ёстой гэсэн энэ агуулга бол 6.2-т байдаг юм аа. Тэгэхээр одоо ямар Сангийн яамны татварынхан болохоороо Дээд шүүх биш, Цэц биш хуулийн заалтыг тайлбарлаад л, яг одоо энэ Занданшатар Ерөнхий сайдад хууль эрх зүйн орчноо оруулж ирэхдээ энэ хариуцлагатай уул уурхайн агуулгыг нь судлаад ороод ир ээ гэсэн ийм зүйлийг даалгаж байгаа УИХ-ын тогтоолын төсөлд хүртэл энэ агуулгыг манайх судлахгүй ээ гээд л хасуулах хүрээнд бүх төрлөөр л одоо ингэж Төсвийн байнгын хороон дээр хүртэл дэмжихгүй байдлаар орж ирж байгаад бол харамсаж байгаа юмаа.

Тэгэхээр энэ бол хуульд бид нар заалт өөрчлөөгүй. Яг энэ Үндсэн хуулийнхаа 6.2-тоо тааруулаад төсөл хэрэгжиж байгаа газарт нь үр өгөөжийг нь дийлэнхийг нь үлддэг байдлаар нь судлаад ороод ирээч ээ, хууль эрх зүйн орчин дээрээ ажиллаач ээ гэж байхад л тэрийг нь эсэргүүцээд ингээд унасан байгаа ийм санал байгаа юмаа. Тэгэхээр гишүүд та бүхэн маань энийг бодож үзээд дэмжиж орж ирэхийг, дэмжихийг хүсье ээ.

Д.Амарбаясгалан: Цэрэнпилийн Даваасүрэн гишүүнд үг өгье.

Ц.Даваасүрэн: Үгүй ээ, Засгийн газар тэр одоо ухах гэж байгаа юмаа өөрөө өөрсдөө л хийцгээнэ биз. Их Хурлаар хийлгэж яах гээд байгаа юм. Бид нар аваад ороод ир гээд л ингээд л бид гуйгаад байгаа юм шиг харагдаад байгаа байхгүй юу. Оруулж ирэх нь өөрсдийн чинь л асуудал шүү дээ.

Д.Амарбаясгалан: Би энэ заалтыг ахиж уншаад өгөөдөхье. Тогтоолын төслийн 2 дахь заалтын 2 дахь дэд заалтад Эрх үүргийн харилцааг тодорхой болгож гэсний дараа төсөл хэрэгжиж байгаа суманд үр өгөөжийн дийлэнхийг үлдээж гэж нэмж, мөн дэд заалтын эрх зүйн орчныг өөрчлөх гэснийг эрх зүйн орчныг сайжруулж хууль тогтоомжийн төслийг боловсруулан УИХ-д өргөн мэдүүлэх гэж өөрчилж, мөн дэд заалтын арга хэмжээг шуурхай авах гэснийг болон 3 дахь дэд заалтын арга

хэмжээг авах гэснийг тус тус хасах. Нэг намын бүлгийг төлөөлж 2 хүн л үг хэлэх боломжтой. Дэмжиж дэмжсэн болон дэмжээгүй байр сууриа илэрхийлж энэ чинь харин тийм.

Тэгэхээр чинь энэ чинь тэгээд цаашлаад нөгөө АМНАТ мамнат гээд асуудлууд чинь бүр дагаад хөндөгдөөд явчих юм биш үү. Харин тийм баялгийн сангийн хууль байж байна. Маргаантай асуудал байна гүйцээн боловсруулах чиглэл өгье. Гүйцээн боловсруулах чиглэл өглөө. Харин тийм наадах чинь баялгийн сангийн үзэл баримтлалтайгаа зөрчилдөж байна. Суманд гэж болохгүй. Энэ чинь өөрөө байгалийн баялаг Монголын нийт ард түмний өмч байх ёстой. Харин тийм тэгэхээр Байнгын хороо дэмжээгүй. Тэгээд гишүүд энэчээ одоо энийг дэмжихгүй босгоод ирвэл хуулийн зөрчил үүсээд явчихна шүү дээ. Тэгвэл тэгээд Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал дэмжигдсэнгүй. Уянга гишүүний гаргасан санал боссон гэсэн үг. Хуульд нийцүүлэх ажил дээр энэ Тамгын газар котоквацын хэлтэс сайн ажиллаарай. Яг энэ Баялгийн сангийн хууль Үндсэн хуулийн үзэл баримтлалын хүрээнд нийцэж байгаа эсэх дээр асуудлыг заавал дараачийн хэлэлцүүлэг дээр оруулж ирж танилцуулна шүү. Түүнээс тодорхой хувийг гэвэл Уянга гишүүн ээ тэр нь зөв байхгүй юу. Дийлэнх гэдэг чинь өөрөө 50 дээр нэмэх нэг хувь болчихоод байгаа байхгүй юу тийм. Тэгээд судлаад гэхээр энэ чинь өөрөө хэрэгжихгүй заалтыг бид үүрэг болгож өгч байна шүү дээ. Харин тийм хэрэгжихгүй заалтаар бид үүрэг өгөх гээд байгаа байхгүй юу бас.

2.Тогтоолын төслийн 2 дахь заалтын 5 дахь дэд заалтын эргэлтэд оруулах гэсний дараа зорилгоор зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах хилийн заагт өөрчлөлт оруулах тухай Монгол УИХ-ын 2020 оны 46 дугаар тогтоол зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай 2020 оны Монгол УИХ-ын 47 дугаар тогтоолын холбогдох хавсралтад өөрчлөлт оруулах Монгол УИХ-ын тогтоолын төслийг боловсруулж УИХ-д яаралтай өргөн мэдүүлэх гэж нэмэх. Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явагдана. За Дамдинням гишүүн үг хэлье.

Г.Дамдинням: За Алт хөтөлбөрийн Алт аяны 3 аяны одоо хамгийн чухал одоо тогтоол хэрэг ингээд хэлэлцэгдээд явж байна. Туваан гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг манай Их Хурлынхан бол одоо хамтдаа бас энэ эдийн засгийн үр өгөөжийг тооцох, улс орныхоо эдийн засгийг сайжруулах энэ чиглэлд ажиллая аа гэж санаачилга гаргаад бас нэлээн сайн томьёолол оруулж ирсэн юм байгаа юмаа. Тэгээд энэ томьёоллыг бол та бүхэн маань энэ санал өгөх машиндаа хүрэхгүй байж байгаад босгож өгөх хүсэлт тавьж байна гишүүддээ. Яагаад гэвэл энийг яг бодитой хэрэгжүүлэхэд Засгийн газраас одоо оруулж ирэх үүргийг Их Хурлаас авчихмаар байгаа юм бид нар. Бүүр түрүүн бас Заяабал гишүүн асуугаад байна лаа. Тэгээд улс орон даяар ингээд асуугаад байна аа, хаана хийх гээд байгаа юм бэ гээд. Энэ бол бүүр яг тухайн газар орноор нь координацаар нь хийгээд оруулаад ир ээ гэсэн утгатай ийм л тогтоол байхгүй юу. Ийм заалт байхгүй юу.

Тэгэхээр энд бол шуурхай оруулж ирэх чиглэлийг л Их Хурал, Засгийн газарт өгч байгаа ийм тогтоол учраас та бүхэн маань энэ санал хураалт дээр дэмжихгүй

санал өгч энэ Төсвийн байнгын хороон дээр унасан энэ заалтыг дэмжиж өгөхийг хүсье ээ.

Д.Амарбаясгалан: Батын Батбаатар гишүүн үг хэлье.

Б.Батбаатар: УИХ, Засгийн газарт ийм чиглэл өгч болохгүй ээ. Тусгай хамгаалалттай газар нутгийг нийт газар нутгийн 30 хувь болгоно гэсэн зорилт байгаа. Засгийн газар энийг биелүүлэх ёстой. Тэр битгий хэл. 21 хувь нь тусгай хамгаалалттай газар нутаг байгаа Монгол Улсын газар нутгийн. Энийг 30 хувь хүргэх үүрэг даалгавар аваад ажиллаж байгаа Засгийн газарт энийгээ хасаад тэр уул уурхайг одоо тусгай хамгаалалттай газар нутаг дээр цоолоод, дунд нь хэсэг газар гаргаад, алтыг нь гаргаад ир гэдэг ийм асуудал байхгүй. Өнөөдөр энэ олон байгалийн доройтол, маш олон зүйлүүд буруу явж байгаа. Тийм болохоор энэ Дамдинням сайд Засгийн газар өөрөө нэг бодлоготой биш байгаа энэ тохиолдолд Дамдинням сайдын энэ оруулж хэлээд байгаа энэ зүйлийг дэмжих боломжгүй.

Д.Амарбаясгалан: Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн үг хэлье.

Х.Булгантуяа: Засгийн газрын 2 сайд нь 2 өөр байр суурь УИХ дээр илэрхийлээд нэг хэсгийг нь дэмжиж, нэг нь болохгүй ээ гээд ингээд байж болмооргүй байна аа. Яаралтай өргөн мэдүүлэх гээд бид нар ер нь УИХ-д яаралтай өргөн мэдүүлсэн ямар нэгэн асуудлыг хойш нь татсан зүйл ерөөсөө байхгүй шүү. Сүүлийн үед УИХ-ыг шөнө дундаар хуралдаж байна. Үүр цайтал хуралдаж байна. Ямар асуудлаар хуралдаад шөнө дундаар хулгай хийгээд байгаа юм шиг хуралдаад байна гэдэг шүүмжлэл бас их байна. Үнэнийг хэлэхэд Засгийн газраас яаралтай горимоор цаг хугацаандаа давхацсан бүх ажлыг шөнөжин, өдөржин хуралдаад зарим тохиолдолд 20 хэдэн цаг тасралтгүй хуралдаж байгаад шийдэж байгаа юм.

Тэгэхээр яаралтай оруулж ир гэдэг бид нарт үүрэг даалгавар өгвөл яаралтай оруулж ирэх гээд байна, үгүй бол одоо удах гээд байна гэдэг тийм ямар нэгэн логик бол байж болохгүй ээ. Тийм учраас энэ бол одоо 1 дүгээрт бол илүүц байх.

2 дугаарт түрүүн Батбаатар сайдын хэлж байгаагаар бид нар бас олон улсын байгууллагын өмнө Батбаатар сайд би тэгж ойлгосон тиймээ. Олон улсын байгууллагын өмнө бас энд одоо тусгай хамгаалалттай газар нутагтай холбоотой бид нар авсан үүрэг бас даалгавар байдаг учраас энийг бол ингээд яаралтайгаар гээд зөвхөн аваад шийдчих бас тийм амархан биш юм шиг байна лээ. Тэгэхээр бид нар бас УИХ нөгөө талдаа олон улсын гэрээ эрх зүйн орчноо зөрчсөн ийм шийдвэрийг Засгийн газар луу чиглүүлж өгч болохгүй гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Нэг намыг төлөөлж 2 хүн үг хэлэх дэгтэй. Даваагийн Цогтбаатар гишүүн.

Да.Цогтбаатар: Гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе ээ. Оруулж ирсэн тогтоолын төсөл нь гадаад валютын нөөцийг богино хугацаанд нэмэгдүүлэх, үр өгөөжөө өгөх, Үндэсний баялгийн сангийн хуримтлалыг нэмэгдүүлэх боломжтой алтны үндсэн ордуудын эдийн засгийн эргэлтэд оруулах гээд ийм лоозонгийн шинж чанартай оруулаад ирчихсэн байсан юм. Тэгээд энийг ажлын хэсэг дээрээ санал гаргаад аль болох ажил хэрэгч байдлаар хандъя гээд тэгээд өмнө нь 2020 онд гарч байсан тэр 46, 47 дугаар тогтоолуудыг хэрэгжилтэд нь илүү зохицуулж уялдуулж,

сайжруулж өгөх ийм тогтоолын төсөл боловсруулаад зарчмын зөрүүтэй санал гаргасан юм.

Тэгээд ажлын хэсэг дээр бол дэмжигдээд тэгээд энэхүү санал нь Байнгын хороон дээр унахдаа болбол Засгийн газрын бүрэн эрх нь өөрөө тусгай хамгаалалттай газар нутагт өөрчлөлт оруулах эрх нь Засгийн газарт байгаа учраас ажлаа хийж явуулъя гэж байгаа болбол одоо энийг Алтны үнэ гайгүй дээшээ байгаа дээр за тэр нэг газар нутгийн тусгай хамгаалалтад авчихсан байгаа газар нутгаасаа тодорхой хэсгийг нь тусгай хамгаалалтад үлдээгээд, тодорхой хэмжээг нь аваад яаралтайгаар өргөн бариад энэ ажлаа хурдан хий гээд энэ буруу болбол бид нар эсэргүүцээд явна. Зөв бол дэмжээд явна гэдэг энэ зарчмаа үндэслээд тэгээд энэ зөв хийе гэж байгаа ажлыг нь бушуухан шиг хийлгээд өгье гэдэг үүднээсээ энэ саналыг гаргаж яг тодорхой болгож уг нь болбол ажлын хэсэг дээрээ саналаа бид нар нэгтгэсэн байгаа.

Тэгээд Төсвийн байнгын хороон дээр бол энэ санал унасан. Тийм учраас Их Хурлынхаа гишүүдийг төхөөрөмждөө хүрэхгүй байж байгаад Засгийн газрыг нэг бодитой ажил хийх нөхцөл байдлыг нь бүрдүүлээд өгөөч ээ л гэж хүсэх гэсэн юм.

Д.Амарбаясгалан: Энэ зүгээр яах вэ уучлаарай. Их Хурал талаасаа одоо гүйцэтгэх засаглалын өдөр тутмын үйл ажиллагаанд оролцож байгаа хэлбэр болж харагдана шүү дээ ер нь болбол. Бид ямар нэгэн байдлаар бас Засгийн газрыг ийм чиглэл өгөх байдлаар яаралтайгаар ялангуяа оруулж ир гэж хандах гэдэг болбол бас ер нь олон асуудал дээр байж боломгүй зүйл л дээ. Тэмүүжин гишүүн үг хэлье.

Х.Тэмүүжин: Яг маргаж байгаа маргааны гол үндэслэл юу байна вэ гэхээр Засгийн газар өөрсдөө өөртөө байгаа эрх мэдлээ зоригтой хэрэгжүүлж, ашиглаж чадахгүй тэгээд УИХ-ын гишүүдийг гал баригчаар бээлий болгож ашиглах гэж оролдож байгаа байхгүй юу. Тэгээд танхимд орж ирээд Засгийн газрын 2 сайд нь хоорондоо маргалдаад, тэгээд УИХ-ын гишүүдийг 2 талдаа хуваах гэж оролдож байна шүү дээ. Энэ Засгийн газар чинь кабинетынхаа зарчмаар ажиллах ёстой. Хэрвээ сайдууд нь 2 өөр байр суурьтай бол Ерөнхий сайд нь Засгийн газрын шийдвэрийн 50 дээр нэмэх нь нэг хувь нь Ерөнхий сайд. Тэр Ерөнхий сайд нь шийдвэрээ гарга л даа. Яахаараа УИХ-д оруулж ирээд 2 талцуулаад, өөрсдийнхөө хийх ажлыг УИХ-ын гишүүдээр хийх гэж оролдож байгаа юм.

Яг үнэндээ дараа нь хэл ам гарвал бид хийгээгүй шүү дээ. Ажлын хэсгийг УИХ-ын гишүүд ахлаад бидэнд нэг ийм үүрэг өгөөд гэдэг тийм нэг матрын нулимстай үгийн ард хариуцлагагүй үлдэх гэж байгаа байхгүй юу. Та нар өөрсдөө ажлаа хий л дээ. Яахаараа УИХ-ын гишүүдийг ийм юм руу түлхэж байдаг юм. Наад хэл тогтоох эрх мэдэл чинь Засгийн газарт байна шүү дээ. Тэгээд дотроо кабинетаараа яриад шийдвэрээ гаргаач. УИХ-аас юу гуйгаад байгаа юм.

Харин ч УИХ хангалттай дэмжлэг үзүүлж байна шүү дээ. Зүгээр биднүүс ажлаа хийе ээ гэж хэлж болдоггүй юм уу. Заавал ташуур хүсээд байгаа бол хариуцлага дээр чинь УИХ харин ташуур үзүүлэх ёстой шүү дээ. Ажлаа хийгээсэй, хийгээд өгөөч ээ гэж гуйж ингэж нэг царай алдаж биднүүс шийдвэр гаргах ёстой юм уу. Тийм юм байхгүй шүү хөөе.

Д.Амарбаясгалан: Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя аа. Санал хураалт.

37 гишүүн буюу 34 хувиар санал дэмжигдсэнгүй.

3.Тогтоолын төслийн 2 дахь заалтад дор дурдсан агуулгатай 6 дахь дэд заалт нэмэх. Энэ саяын Засгийн газарт өгч байгаа үүрэг чиглэлийн дагуу зүгээр протоколд бас үлдээх нь зүйтэй байх гэж бодож байна. Дамдинням сайд, манай Батбаатар сайд нар засгаас бодвол төслөө боловсруулж оруулж ирэх байлгүй. Тэгээд одоо чуулган завсарлалчхна. Тэгээд та бүхэн үндсэндээ болбол намрын чуулганаас нааш энэ асуудлаа хэрэгжүүлж чадахгүй хэлбэр лүү бол орж байна гэсэн үг. Асуудал нь болбол хүндрэх байх. Тэгээд ирэх 7 хоногт чинь одоо нэгхэн өдрийн чуулгантай байгаа яаралтайгаар хэлэлцэж болбол амжихгүй тийм байдал руу орно. Тэгэхээр 1 талд нь болбол жоохон дөнгөлж байгаа байдал руу одоо орчхож байна гэж.

2 дугаарт нь ямар нэгэн байдлаар УИХ руу төсөл орж ирэхэд аль нэгэн ААН бас зарим төрлийн тодорхой байршлыг зааж орж ирэхгүй ээ гэдгийг бас анхаарах ёстой. УИХ болбол Засгийн газрын тийм үйл ажиллагаанд огт оролцохгүй. Саяын Тэмүүжин гишүүний болон бусад гишүүдийн хэлж байгаа үнэн. УИХ гүйцэтгэх засаглалынхаа өдөр тутмын үйл ажиллагаанд оролцохоос илүүтэйгээр үйл ажиллагаанд нь ерөнхий хяналтаа л тавьж ажиллаж байх ёстой. Тэгэхээр энэ дээрээ их тийм зарчмын байр суурьтай байгаарай. Бараг энэ заалт дөнгө болчхов уу яачхав та бүхэнд. Намрын чуулган эхэлтэл юмаа явуулж чадахгүй байдал руу өөрсдөө орчхов уу яачхав.

3.Тогтоолын төслийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 6 дахь дэд заалт нэмэх.

6.Тогтоолын төслийн 2 дахь заалтын 5 дахь дэд заалтад заасан нөхцөлийг хангах үүднээс хөрөнгө оруулагч тусгай зөвшөөрөл эзэмшигчид учирч байгаа хүндрэл үүний дотор газар ашиглахтай холбоотой асуудлыг судлан эрх зүйн орчныг сайжруулж хууль тогтоомжийн төслийг боловсруулан УИХ-д өргөн мэдүүлэх. Санал гаргасан ажлын хэсэг. Даваасүрэн гишүүн үг хэлье.

Ц.Даваасүрэн: Манай УИХ-ын гишүүд бас жоохон гэрээ шатаахгүй өөрсдийнхөө Их Хурлыг бас нэг жоохон хамгаалдаг юм байх ёстой. Морь унасан толгойгүй хүн шиг байж болохгүй шүү дээ. Одоо энэ байгаль орчныг хамгаалдаг төрийн бус байгууллагууд та нар луу чулуу шиднэ. Та нар тусгай хамгаалалттай бүс нутагт алт олборлохыг зөвшөөрчхөж байгаа байхгүй юу. Ноён ууланд алт олборлохыг та нар зөвшөөрч байгаа байхгүй юу. Одоо Их Хурал тар гэж гудамжинд бид нар луу хашхирна за юу. Та нар өөрсдөө ийм тэнэг юм хийж байна шүү дээ. Засгийн газар юугаа хийх нь тэд нар оруулаад ирээд шийдүүлэхийг нь бид нар дэмжээд явах нь бидний л асуудал. Тэрнээс биш тусгай хамгаалалттай газар нутгийг ух аа гэж Их Хурал шийддэг байж болохгүй шүү дээ. Юу хийгээд байгаа юм бэ та нар.

Д.Амарбаясгалан: 3 дахь. Мөнхсоёл гишүүн үг хэлье.

Б.Мөнхсоёл: Түрүүн бас санал хураахаас өмнө үг хэлмээр байсан, харагдаж чадсангүй. Би бас Төсвийн байнгын хорооны даргатай санал нэг байна. Бид нар Төсвийн байнгын хороон дээр энэ саналыг унагасан. Тэнд бас хэлэлцүүлэг явж байгаа. Төсөв талаас нь асуудлаа харж байгаа, бас дэмий санагдаж байна. Төсвийн тодотгол дээрээ бид нар анхаарах ёстой байсан. Далимдуулаад том том

асуудлуудыг оруулж ирээд ингээд мэдээлэлгүй, хайнга, ирц муу байхад нь далимдуулж ингэж том том асуудлыг хөндөж байгаад харамсаж байна.

Д.Амарбаясгалан: Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн үг хэлье.

Ж.Бат-Эрдэнэ: За сая УИХ-ын даргын хэлдэг яг үнэн шүү. Өөрсдөө өөрсдөө хариуцлагаасаа мултрах гэж ингэж гүйж байж УИХ-аас шийдвэрийг нь гаргуулах гэж ингэж тойрч гүйж байж одоо өнөөдөр наадах чинь дахиад 9 сард чуулган эхэлтэл хамаг ажил чинь зогсохоор хэмжээнд өөрөө өөрсдийгөө түгжихлээ шүү дээ 1 дүгээрт.

2 дугаарт ер нь болбол мэргэжлийн байнгын хороодоос гарсан саналаа гишүүд маань бас нэг хүндэтгэлтэй харж үзэж баймаар байна аа. Судалж баймаар байна аа. Дэмжсэн бол дэмжсэн, дэмжээгүй бол дэмжээгүй гэдгийг нь ямар учиртай гэдгийг нь бас жоохон харж үзэж байгаа байхгүй бол юуны төлөө энэ чинь мэргэжлийн Байнгын хороо тэнд хэдэн хүмүүс шийдвэр гаргаж байгаа билээ гэдгээ бас нэг харж байх хэрэгтэй байна аа. Сая болбол үндсэндээ өөрөө өөрсдийнхөө ажлыг сая болбол буцаад мухарлачихлаа. Хариуцлагаас тойрч гүйж байгаад асуудлыг намар хүртэл л асуудлыг болбол зогсох хэмжээнд болбол үргэлжилнэ шүү.

Д.Амарбаясгалан: За яах вэ тэр 2 дахь заалт дээрээ Төсвийн байнгын хороон дээрээ энийгээ ахиад ярилцаадах за юу Дамдинням сайд. УИХ энэ алт 3 хөтөлбөрийг дэмжихгүй биш дэмжээд байгаа шүү дээ. Нарийвчилсан энэ зүйлүүд рүү нь хэт их орохгүй байя аа л гэдэг асуудал хөндөгдөж байна гэсэн үг. Алт 3-аа дэмжиж байгаа. Тэгэхээр энэ асуудлыг Төсвийн байнгын хороон дээр хэлэлцээд 3-ны 2-оор босгож ирж оруулж ирэх боломж бас байгаа. Тэгэхээр та бүхэн энийг дахиж ярилц мэдэв үү. Нэгэнт өнгөрчихсөн санал хураагаад.

За 3 дахь асуудлаар Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэдэг саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

50.9 хувиар санал дэмжигдлээ.

Найруулгын санал. Төсвийн байнгын хороо дэмжсэн санал.

1.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллууд дэмжигдсэнтэй холбогдуулан эдгээр хууль Монгол УИХ-ын тогтоолын төслүүд, төслийн зүйл, хэсэг, заалтын дугаарыг өөрчлөх, агуулга зарчмыг хөндөхгүйгээр үг хэллэг, найруулгын шинжтэй засвар хийх. Санал гаргасан ажлын хэсэг. Номинчимэг гишүүн үг хэлье.

О.Номинчимэг: Энэ найруулгын саналыг дэмжиж байна. Гэхдээ яах вэ ажлын хэсэг энэ түрүүн дурдсан ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг ерөөсөө хөндөөгүй орж ирсэн байна лээ. Тэгээд маш энгийнээр хэлэхэд одоо улсын сургууль нийслэлд жишээ нь 50, 60 хүүхэд нэг өрөөнд, 2, 3 ээлжээр ямар нөхцөлд сурч байгаа билээ бид мэднэ. Хувийн сургууль харьцангуй гайгүй нэг 25 хүүхэдтэй тиймээ. Ингэтэл ингээд нөгөө олж болох нөөц бололцоогоо улсын сургууль буюу тэнд сурч байгаа хүүхдүүд рүү чиглүүлнэ гэхээсээ илүү ингээд нээлттэй орж ирж байгаа нь 1 дүгээрт буруу байгаа.

2 дугаарт энэ ингэж хувийн сургуулийг одоо дэмжсэнээр ачаалал буурна аа гээд байгаа юм. Гэхдээ яг үнэндээ тэр захын хороонд сурч байгаа 40, 50-иулаа сурч байгаа 3 ээлжээр сурч байгаа хүүхдүүд улсын сургууль баригдлаа гээд төлбөр төлж тийшээ очиж сурч чадахгүй байхгүй юу эдийн засгийн чадамжийн хувьд. Тэгэхээр бид улсын сургуулиа л дэмжих ёстой. Байгаа нөөц бололцоогоо тийшээгээ чиглүүлээч ээ. Боломжгүй байгаа шахцалдаад сууж байгаа тийшээгээ чиглүүлээч ээ гэдэг бодлогыг л бид нар яриад байгаа. Тэгэхээр эсрэг ийм бодлого орж ирээд байх юм. Тэгээд дээр нь төсвийн тодотголтой ямар ч холбоогүй зардал, юунд нь орлогод нь яаж нөлөөлөх юм юу ч байхгүй. Тэгээд одоо үнэндээ ингээд 7 сарын 2 боллоо. Энэ хууль батлагдлаа гээд энэ жил юу өөрчлөгдөх юм. Бүхий л улсын болон орон нутгийн төсвөөр хийж байгаа сургууль, цэцэрлэг чинь төсөв нь батлагдчихсан тэрнийхээ дагуу барилгын ажил нь явчихсан шүү дээ.

Энд одоо батлагдлаа гээд энийг хэн ашиглаж чадах вэ гэхээр байр байшин барьж байгаа хувийн сургуулиуд л ашиглаж чадна яг үнэндээ. Сүлжээ одоо том том сургуулиуд байгаа шүү дээ. Компанийн доор байдаг эд нар бүгдээрээ л өргөтгөл 3, 4 давхар том байшингууд барьж байгаа шүү дээ. Энд л ашигтай шийдвэрийг бид нар ингээд гаргах гээд ингээд төсвийн хууль дагуулаад ийм хууль оруулж ирчхээд байгаа байхгүй юу. Тэгээд энийгээ ер нь Засгийн газар нэг бодоод татаад авчхаач. Боловсролыг дэмжих жилийн хүрээнд хөрөнгө оруулалт дээр энэ татварын хөнгөлөлт үзүүлнэ гэдэг зөв өө. Тэрийгээ 2026 онд оруулаад ир. Гэхдээ зөвхөн төрийн болон орон нутгийн өмчит сургууль тиймээ. Одоо энэ яг үнэхээр хэрэгцээтэй байгаа ийшийгээ чиглүүлэх нөөц бололцоо татварын орлого болох ёстой байсан орлогоо энэ бодлогоо бариад 2026 оны төсөвтэйгөө оруулаад ирээч ээ. Одоо энийгээ татчихаач ээ.

Хувийн сургуулиудаа энэ жилдээ дэмжсэн ийм хуулийг төсвийн хууль дагуулж оруулж ирж байгаа нь буруу. Сургууль дэмжих ёстой гэхдээ хамгийн эхлээд дэмжих ёстой юм нь тэнд шахцалдаад сууж байгаа, шөнө орой хүртэл хичээллэж байгаа улсын сургуулийн хүүхдүүд байгаа шүү. Энийг л гишүүд маань гэсэн бодоод одоо Сангийн яам ч гэсэн Жавхлан сайд энийг бас нэг бодоод бодлогын шийдвэр гараач ээ гэдгийг бас хэлэх гэсэн юмаа.

Д.Амарбаясгалан: Тийм, за яах вэ ерөнхий нөгөө өргөн барьсан хуулиудтай холбоод хэлчихлээ. За санал хураалт. Найруулгын санал хураалт.

71 гишүүн буюу 65.7 хувиар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Дараачийн асуудал шууд санал хураалт байгаа шүү. Гишүүд танхимд байж байгаарай.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

16:18

Д.Амарбаясгалан: Дараагийн асуудалд оръё.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн 2 дахь хэлэлцүүлгийг хийнэ.

Төслүүдийг 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн Хассуурийн Ганхуяг танилцуулна аа. Индэрт урьж байна.

Х.Ганхуяг: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн нэг дэх хэлэлцүүлгийг УИХ-ын чуулганы 2025 оны 6 дугаар сарын 27-ны өдөр нэгдсэн чуулганаар явуулж, 2 дахь хэлэлцүүлэг бэлтгүүлэхээр бусад Байнгын хороо, Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2025 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслүүдийн 2 дахь хэлэлцүүлгийг Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлд заасныг баримтлан явуулж, дараах санал, дүгнэлтийг гарган та бүхэнд танилцуулж байна аа.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгэхтэй холбогдуулан УИХ-ын бусад Байнгын хороод эрхлэх асуудлынхаа хүрээнд Төсвийн зарлагын хяналтын дэд хороо төсвийн төслүүдийг хэлэлцээд зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хамт Төсвийн байнгын хороонд ирүүлсэн.

УИХ-ын даргын 2025 оны 291 дүгээр захирамжаар Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг УИХ-ын гишүүн Ганхуягаар ахлуулж, УИХ-ын 19 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллуулсан бөгөөд уг ажлын хэсгээс хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хүрээнд дэд ажлын хэсгүүдийг байгуулж, саналуудаа нэгтгэн Төсвийн байнгын хорооны хуралдаанаараа хэлэлцүүллээ.

2025 оны төсвийн жилд хэмнэж болох мөн зарим томилгоо хойшлохтой холбоотой зардлуудыг тодорхой хувиар бууруулах болон 2025 оны тодотголын төслөөр төсөв нь буурсан эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулж, нотолгоонд суурилсан оношилгоо, эмчилгээг нэвтрүүлэх үйл ажиллагааг тасралтгүй явуулах, боловсролын байгууллагын хүүхдэд ээлтэй, хөгжлийн бэрхшээл болон жендерийн ялгаваргүйгээр орчин бий болоход чиглүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа тасралтгүй хэвийн явуулахад шаардагдах зарим санхүүжилтийг нэмэгдүүлэх зэрэг ажлын хэсгийн 2 санал мөн УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71

дүгээр зүйлийн 71.6 дахь хэсэгт заасан болон Төсвийн байнгын хорооны гишүүдээс гаргасан 18 зарчмын зөрүүтэй саналын томьёоллуудыг нэг бүрчлэн хэлэлцлээ.

Монгол УИХ-ын чуулганы дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.9 дэх хэсэгт заасны дагуу Төсвийн байнгын хороо төсвийн төлөөлөлтэй холбогдуулан ажлын хэсэг, бусад Байнгын хороо, түүнчлэн Төсвийн байнгын хорооны гишүүдийн гаргасан санал нэг бүрийг хэлэлцэн санал хураалт явуулж, олонхын дэмжлэг авсан, аваагүйг нь бүлэглэн та бүхэнд тараасан болно.

УИХ-ын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал дүгнэлт зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсэж байна аа.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: УИХ дахь АН-ын бүлгийн санал дүгнэлтийг бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл танилцуулна. Индэрт урьж байна.

О.Цогтгэрэл: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын төсөв гэдэг бол төсвийн орлого, зарлагын механик тэнцвэржүүлэлт төдий бус эдийн засаг, нийгмийн нөхцөл байдал, төрөөс өгөх бодлогын хариулт, богино, дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөө түүнд хүрэх эдийн засгийн удирдлагын арга хэрэгсэл юмаа. Цаашлаад нэгдсэн төсвийн хүрээнд багтдаг Үндэсний баялгийн сан, Нийгмийн даатгалын сан, ЭМД-ын сангуудын төсөв нь байгалийн баялгийн орлогын менежмент, нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн үйлчилгээний чиглэлээр Засгийн газрын баримтлах бодлогын илэрхийлэл болдог оо.

Шинэ Засгийн газраас УИХ-д өргөн мэдүүлж хэлэлцүүлж буй анхны хөгжлийн бодлогын баримт бичиг болох Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль бусад дагалдах хуулиудад өөрчлөлт оруулах тухай төсөлд ийм шалгуураар үнэлэлт дүгнэлт өгөхөд ихээхэн хангалтгүй дүн авахаар байна аа. Дараах үндэслэлүүдийг бас тодруулъя аа.

1 дүгээрт нь, төсвийн тодотголд бодит шинэчлэлийн бодлого дутагдаж байна аа. Түүхий эдийн үнэ унаж, олон жилийн дундаж буюу бодит хөрсөндөө бууж буй энэ цаг үед өсөлтийн халуурлын алдааг засах бодлогын шинэчлэлийн цонх юмаа. Гэвч энэ удаагийн тодотгол нь уламжлал болсон, улиг болсон жижиг зардлын хэмнэлт улс төрийн зорилготой үр дүн багтааж цомхотгол хийнэ гэх мэт урианаас хэтэрсэнгүй ээ. Төсвийн зардлыг өнгөц засвараар бууруулж, алдагдлыг нэмэгдүүлэх ийм төлөвлөгөө болжээ. АН-ын бүлгээс 6 дугаар сарын 16-ны өдөр шинээр томилогдсон Ерөнхий сайдад хандан бодлогын шаардлагад дурдсан. Төрийн өмчит ААН-үүдийн тоог цөөлөх, олон нийтийн нээлттэй ХК болгож, үр өгөөж, бүтээмжийг дээшлүүлэх, төрийн хүнд суртал, хяналт шалгалтын дарамтаас бизнес эрхлэгчдээ

чөлөөлж, татвар, шимтгэлийн дарамтыг бууруулах, тэтгэвэр халамжийн шинэчлэл хийх, төрийг илүүд цомхон болгож төсвийн урсгал зардалд шинэчлэл хийх зэрэг чиглэлд бодитой шинэчлэл бүтцийн реформыг Засгийн газар санал болгосонгүй ээ.

2 дугаарт нь, хугацаа хожимдсон шийдвэрийн үр нөлөө хангалтгүй байхаар байна аа. Төсвийн тодотголыг цаг тухайд нь хийх нь сангийн бодлогын үр нөлөөг алдагдуулахгүй байж, эдийн засгийн мөчлөгт тохирсон зөв хариу арга хэмжээ авах үндэс болдог оо. УИХ дахь АН-ын бүлэг 2025 оны төсөвтэй холбоотойгоор 2024 оны 10 дугаар сарын 31, 12 дугаар сарын 11-ний өдрүүдэд гаргасан санал дүгнэлттэй Төсвийн орлого, зарлагын өсөлтийг бууруулж, эрсдэл багатай хэмжээнд төлөвлөх макро эдийн засгийн үзүүлэлтүүд болон нүүрсний үнийн таамаглал хэт өөдрөг байгааг бодитой болгох шаардлагатай хэмээн дүгнэж хэдхэн сарын өмнө хэдхэн сарын дараа дахин тодотгол ярих нөхцөл үүссэнийг тухайн үедээ бас анхааруулж байсан.

Оны эхний 5 сарын байдлаар нүүрсний экспортын дундаж үнэ 71 ам.доллар болж төлөвлөгөөтэй харьцуулахад 40 шахам хувиар унаснаар экспортын орлого 15 хувиар буурлаа. Нэгдсэн төсвийн орлого 11.4 их наяд болж төлөвлөгөөнөөс 10 хувийн тасалдалтай байна аа. Гэтэл төсвийн урсгал зардлаа 9.9 их наяд төгрөгийн гүйцэтгэлтэй буюу өмнөх оны мөн үетэй харьцуулахад 18 хувиар өссөн зэрэг бидний өмнөх дүгнэлтүүд зөв байсныг бас ингэж баталж байна аа. Энэ болбол бид энэ асуудлыг таасандаа бус бүх л мэргэжилтнүүд хөндлөнгийн байгууллагуудын тухайн үеийн судалгаа дүгнэлтээс тодорхой харагдаж байсан үр дүн юмаа. Гэвч Засгийн газар бодит үнэнийг үгүйсгэн тодотголоос зугтсаар нөхцөл байдлыг хүндрүүлж, энэ удаагийн тодотгол хугацаа хоцорсон. Үүний улмаас эдийн засгийн хүндрэлийг цаг алдалгүй зохицуулах боломж алдагдаж, хөрөнгө оруулалтын гүйцэтгэл сааран, бизнесийн үйл ажиллагааг саатуулж, өсөлтийн хэтийн төлөвт сөрөг нөлөө үзүүллээ.

Цаашид макро эдийн засаг экспортын гол нэрийн бүтээгдэхүүний зах зээл хэрхэх вэ. Өнөөгийн хүндрэл нь хямралын эхлэл үү, эс бол түр зуурын доголдол уу зэрэгт хариулт өгч чадаагүй, тодотголын үр нөлөө тодорхойгүй байх болно оо. Улмаар энэ оны эцэст дахин тодотгол хийх эрсдэл үүсэж болзошгүй байгааг өсөх аргагүй юмаа.

3 дугаарт нь сангийн бодлогын итгэлцэл суларч байна аа. Эрх бүхий албан тушаалтнууд хэт өөдрөг төсвөө хамгаалж, бодит байдлыг үгүйсгэсэн мэдэгдлийг зах зээлд өгч ирсний улмаас дотоод, гадаадын санхүүгийн байгууллагуудын итгэл суларч зээлжих зэрэглэл буурах эрсдэлийг өнөөдөр бас нэмэгдүүлж байна. Хөрөнгө оруулалтын гүйцэтгэл өнөөдрийн байдлаар дөнгөж 12 хувьтай, олон зуун тендер хойшилсон эсвэл шалгаруулсан боловч санхүүжилт хийгдэхгүй байгаа нь компаниудын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж, олон мянган ажлын байрыг эрсдэлд оруулж байна аа.

Мөн төсвийн сахилга бат маш хангалтгүй байгаа нь 2024 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүгнэлтээс тодорхой харагдаж байна. Төсвийн орлого, зарлагын 30 гаруй хувийн огцом тэлэлт нь бодлогын үр дүн муутай гадаадын зээл тусламжийг эдийн засгийн үр ашиггүй хөтөлбөрүүдэд ихээр зарцуулсан, төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл хангалтгүй, их хэмжээний орон тооны нэмэгдэл цалингийн санхүүжилтүүд хуулиас гадуур хийгдсэн, төсвийн сахилга хариуцлагын сайжруулах зөвлөмжүүдийг хэрэгжүүлээгүй зэрэг олон ноцтой зөрчлүүдийг Төрийн аудитын газар онцолжээ.

4 дүгээрт нь, мөчлөгт сөрсөн төсвийн бодлого хэрэгжихгүй байна аа. Монгол Улсын төсөв өнөөг хүртэл түүхий эдийн үнийн хэлбэлзлийг даган савлаж, өсөлтийн үед хяналтгүйгээр тэлдэг. Уналтын үедээ бүсээ чангалах байдалтай явж ирлээ. Зүй нь өсөлтийн үед хэт халалтаас сэргийлсэн, өр зээлээ бууруулах, хуримтлал үүсгэх харин уналтын үед түүнийгээ зарцуулж, эдийн засгаа дэмжих мөчлөг сөрсөн бодлогыг мэргэжилтнүүд зөвлөдөг олон улсын сайн туршлага ч бас ийм байдаг. Эдийн засгийн өсөлт саарч буй энэ үед Засгийн газар мөчлөг сөрсөн бодлого хэрэгжүүлэх шаардлага үүссэн байж болох ч энэ талаар тодорхой судалгаа шийдэлтэй бодлого алга.

АН-ын бүлгийн зүгээс энэ хүрээнд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна аа. Үүнд:

Дотоодын эрэлтийг дэмжих, төсвийн зарлага буюу дэд бүтэц, хүний нөөц, хүмүүн капитал, ажлын байрыг хамгаалах чиглэлд хяналттай, үр өгөөжтэй хөрөнгө оруулалтаар эдийн засгийн сэргэлтийг дэмжих. Төсвийн тогтвортой байдлын хуулийг баталсан цагаасаа хойш 14 жилд 15 удаа өөрчилснөөр анхны зарчмыг нь алдагдуулсан завхралыг засаж, дунд хугацааны тогтвортой байдлыг бэхжүүлэх шаардлагатай байна аа.

Мөн Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг мөн шинэчлэн сайжруулж, баялгийн санг улс төр, популизмын хэрэгсэл биш одоо ба ирээдүйн иргэн бүрд үр өгөөжөө өгөх урт хугацааны хуримтлал, эдийн засгийн төрөлжилтийн баталгаа болгон ашиглах.

Нэгтгэн дүгнэхэд 2025 оны төсвийн тодотгол нь орлогын бууралтыг механикаар тэнцвэржүүлсэн төдий бөгөөд бодлогын реформ агуулаагүй, хугацаа хоцорсон, сангийн бодлогын үр нөлөө тодорхойгүй, төсвийн өмнөх алдаа дутагдлуудыг залруулаагүй хэвээр байна аа.

Дээр дурдсан санал зөвлөмжүүдийг тусган тодотголыг хэлэлцүүлгийн шатанд засаж, сайжруулах боломжийг ч цаг хугацааны хувьд олгохгүйгээр яаравчлуулж буйг нь бас дурдах нь зүйтэй.

Удахгүй хоёрхон сарын дараа бид Монгол Улсын 2026 оны төсвийг хэлэлцэж эхэлнэ ээ. Тэр үед нөхцөл байдал мөн адил байвал АН-ын бүлгийн зүгээс байр сууриа бас илүү хатуу илэрхийлж ажиллах болно гэдгээ бас мэдэгдье ээ.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Төсвийн төслийн 2 дахь хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан төсвийн санал нь энэ хуулийн 71.7.2, 71.7.3-т заасан шаардлагыг хангасан эсэх талаарх УИХ-ын Тамгын газрын Төсвийн хяналт шинжилгээний асуудал хариуцсан нэгжийн дүгнэлтийг хэлтсийн дарга Даваасүрэнгийн Эрдэнэсамбуу танилцуулна аа. 3 дугаар индрээс танилцуулга хийе.

Д.Эрдэнэсамбуу: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдөр Монгол УИХ-д өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт

оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн 2 дахь хэлэлцүүлгийг Төсвийн байнгын хорооны 2025 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, олонхын дэмжлэг авсан саналуудад Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 71.13 дахь заалтын дагуу тус хуулийн 71.7.2, 71.7.3-т заасан шаардлагыг хангасан эсэх талаар дүн шинжилгээ хийж, дүгнэлтийг танилцуулж байна аа.

Төсвийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийн үеэр хөрөнгө оруулалтын 3 төсөл арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг 31 тэрбум төгрөгөөр, урсгал зардлыг 21 тэрбум 775.6 сая төгрөгөөр, эргэж төлөгдөх цэвэр зээлийг 15 тэрбум төгрөгөөр, нийт 67 тэрбум 775.6 сая төгрөгөөр төсвийн нийт зарлагыг нэмэгдүүлсэн. Мөн урсгал зардлыг 67 тэрбум 775.6 сая төгрөгөөр бууруулах зохицуулалтын саналууд гарсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.6-д заасан зарчимд нийцэж, төсвийн нийт зарлагыг нэмэгдүүлэхгүй байх нөхцөлийг хангасан байна аа.

Төсвийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулах үед олонхын дэмжлэг авсан саналууд нь Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.7.2-т заасан Засгийн газраас өргөн мэдүүлсэн төсвийн төслийн зарлагыг болон алдагдлыг нэмэгдүүлэхгүй байх шаардлагыг хангаж мөн хуулийн 71.7.3-т заасны дагуу Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3-т нийцсэн байна аа.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Болдын Жавхлан Сангийн сайд, Намжилдоржийн Энхбаяр Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, Жамсрандоржийн Дэлгэрсайхан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Нинжбатын Ууганбаатар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Амаржаргалын Энхбат Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Занданбазарын Цэдэнжав Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч, Цэвэгсүрэнгийн Наранчимэг Үндэсний Аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын тэргүүлэх аудитор, Дэлгэрийн Энхболд Үндэсний аудитын газрын гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, Идэшийн Батхүү Эдийн засаг хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Жигжидийн Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Сэрээтэрийн Жавхланбаатар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Чойгүнсэнгийн Чимэдсүрэн Татварын ерөнхий газрын дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Доржготовын Баттогтох Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаан технологийн нэгдсэн бодлогын газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга, Ганболдын Золбоо Сангийн яамны Санхүү төсвийн судалгааны газрын дарга, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль эрх зүйн газрын дарга, Огнонгийн Хуягцогт Эрчим хүчний яамны Санхүүгийн хөрөнгө оруулалтын газрын дарга, Отгондэмбэрэлийн Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Батчулууны Мөнгөнсүх Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын Салбар дундын зохицуулалтын

төлөвлөлтийн хэлтсийн дарга, Очиржанцангийн Мөнхтөр Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого зохицуулалтын газрын Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн дарга, Энхтөрийн Батмөнх Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга, Лувсанвандангийн Ичинноров Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга, Пүрэвдоржийн Бат-Эрдэнэ Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга, Булганхүүгийн Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Лувсандоржийн Гантогтох Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Рэгзэнгийн Мягмаржав Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага арга зүйн газрын дарга.

За ингээд асуулт санал байхгүй. Төсвийн байнгын хорооноос нэгтгэн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураана. Нийт 20 санал байгаа. Гаргасан саналаа тайлбарлан үг хэлж болно. Санал хураалт тус бүрийн дүнг танилцуулна. Гаргасан саналаа тайлбарлан үг хэлж болно гэж байгаа шүү дээ тиймээ. За гишүүд санал хураалтад бэлдье.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

1.Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал. Гишүүд санал хураалтдаа бэлдье. Гишүүд санал хураалтдаа бэлдье. Гишүүд санал хураалтдаа бүртгүүлье. Цогтгэрэл дарга аа санал хураалт эхлүүлье, санал хураалтаа эхлүүлье Эрдэнэбүрэн гишүүн ээ. За суугаарай. Төсвийн хэлэлцүүлэг явагдаж байгаа. Ингээд эхний саналыг танилцуулъя.

Нэг.Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал.

1.Ажлын хэсгийн санал. 1.Зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр төсвийн зардал хооронд зохицуулалт хийх санал.

1.1.Зардал бууруулах санал.

-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх зардалд зориулж Удирдлагын академид олгодог санхүүжилтийг 2.6 тэрбум төгрөгөөр;

-Дэд сайдын томилгоог хойшлуулахтай холбоотойгоор урсгал зардлыг 2 тэрбум 189.7 сая төгрөгөөр;

-Сангийн сайдын төсвийн багц дахь Засгийн газрын нөөц сангийн зардлыг 16 тэрбум 336.9 сая төгрөгөөр;

-Нэгдсэн төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн төслийн урсгал зарлагын цалин хөлс, НДШ, зээлийн хүүгийн төлбөр, гадаад зээл, тусламжийн эх үүсвэрээс санхүүжих зардал, үйл ажиллагааны орлогоос бүрэн санхүүждэг зардлаас бусад урсгал зардлыг 0.3 хувиар буюу 30 тэрбум 649 сая төгрөгөөр тус

тус бууруулан эдгээр эх үүсвэрээр дараах арга хэмжээний санхүүжилтийг нэмэгдүүлэх. Үүнд:

1.2.Урсгал зардал нэмэгдүүлэх санал:

-Төрийн албаны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газраас татаж авсантай холбогдуулан холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарын урсгал зардлыг 1 тэрбум 144 сая төгрөгөөр;

-ХЭҮК-ын даргын төсвийн урсгал зардлыг 1 тэрбум төгрөгөөр;

-Гэр бүл, хүүхдийн хэрэг маргааныг шийдвэрлэх анхан болон давж заалдах шатны шүүхийг шинээр байгуулах бэлтгэл ажлыг хангахад шаардагдах зардалд зориулж ШЕЗ-ийн даргын төсвийн багцын урсгал зардлыг 12 тэрбум 581.5 сая төгрөгөөр;

-Олон улсын гэрээ хэлэлцээрийн хүрээнд Монголын талын хариуцах зардал буюу Монгол-Германы хамтарсан Технологийн дээд сургуулийн татаасыг 517.5 сая төгрөгөөр, Монгол, Япон эмнэлгийн татаасыг 1 тэрбум 600 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн Боловсролын сайдын төсвийн багцын урсгал зардлыг нийт 2 тэрбум 117.5 сая төгрөгийг нэмж тусгах.

-Мөнгө угаах, хөрөнгө буцаах, үндэстэн дамнасан болон авлига албан тушаалын хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой болон прокурорын байгууллагын гэрээгээр хүлээсэн зарим зардлыг санхүүжүүлэхэд зориулж УЕП-ын төсвийн багцын урсгал зардлыг 1 тэрбум 307.9 сая төгрөгөөр;

-“Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт Дотоод хэргийн их сургуулийн шинжлэх ухаан инновацын чадавхыг нэмэгдүүлнэ гэж заасан зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд Дотоод хэргийн их сургуулийн урсгал зардлыг 458 сая төгрөгөөр;

-2025 оноос хос бичигт шилжүүлэх ажлыг эрчимжүүлэхтэй холбогдуулан Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн ажлын албаны урсгал зардлыг 936.7 сая төгрөгөөр;

-Говийн бүс нутгийг усжуулах, усан хангамжийг нэмэгдүүлэх хүрээнд хийгдэх судалгаа шинжилгээний төслийн нэгжийн урсгал зардлыг 230 сая төгрөгөөр;

-Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академийн үйл ажиллагааны урсгал зардалд зориулж Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгчийн төсвийн багцын урсгал зардлыг 1 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлэх.

Хөрөнгийн зардал нэмэгдүүлэх санал.

-Төслийн 2 дугаар хавсралтын 20 дугаар бүлгийн 3.2-т тусгагдсан эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж гэсэн төсөл арга хэмжээний төсөвт өртөг санхүүжих дүнг 19 тэрбум төгрөгөөр;

-Төслийн 2 дугаар хавсралтын 12 дугаар бүлгийн 1.3.2-т тусгагдсан боловсролын салбарын тоног төхөөрөмжид гэсэн төсөл арга хэмжээний төсөвт өртөг санхүүжих дүнг 7 тэрбум 400 сая төгрөгөөр;

-Төслийн 2 дугаар хавсралтын 11 дүгээр бүлгийн 1.1-д тусгагдсан гадаргын ус хуримтлуулах хөв цөөрөм байгуулах гэсэн төсөл арга хэмжээний төсөвт өртөг санхүүжих дүнг 4 тэрбум 600 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэх.

Санал гаргасан УИХ-ын гишүүн Ганхуяг, Алдаржавхлан, Ариунзаяа, Баасанжаргал, Баатархүү, Бадамсүрэн, Батболд, Батжаргал, Ганзориг, Заяабал, Идэрбат, Мөнхбат, Мөнхсоёл, Номин, Түвшин, Пунсалмаа, Пүрэвдаваа, Сэддорж, Туваан. Цаашид ажлын хэсэг гэх.

Хоёр.Бусад байнгын хорооны санал. Санал хураалт. Гаргасан саналаа тайлбарлаж үг хэлнэ. Тэгэхээр та энэ дотор алга байна шүү дээ. Санал гаргасан гишүүдийн дотор байхгүй байна. Болохгүй дэгээрээ гаргасан саналаа тайлбарлаж үг хэлэх дэгтэй. Санал хураалт.

65 гишүүн буюу 58.6 хувиар санал дэмжигдлээ. Одонтуяа гишүүн энэ ерөөсөө дэг нь гаргасан саналаа тайлбарлаж үг хэлэх боломжтой дэгтэй.

Хоёр.Бусад байнгын хорооны санал.

1.Төслийн 1 дүгээр хавсралтад тусгагдсан Соёл, спорт, аялал жуулчлалын залуучуудын сайдын 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн 35.3.1.1 дэх дэд заалтын аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг чадавхжуулах сургалтад хамрагдах хүн гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин 100 мянга гэснийг 15 мянга гэж өөрчлөх. Санал гаргасан УИХ-ын гишүүн Ч.Ундрэм. БСШУСБХ-ны дэмжсэн санал. Санал хураалт.

68 гишүүн буюу 60.7 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр хавсралтын Соёл, спорт, аялал, жуулчлалын залуучуудын сайдын 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн 35.3.2 дахь заалтад тусгагдсан аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадварыг сайжруулна гэсэн хөтөлбөрийг бүхэлд нь хасах. Санал гаргасан УИХ-ын гишүүн Ч.Ундрэм, БСШУСБХ-ны дэмжсэн, Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал. Санал хураалт.

68 гишүүн буюу 60.7 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр хавсралтад тусгагдсан Соёл, спорт, аялал, жуулчлал залуучуудын сайдын 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн 35.4.1.1 дэх дэд заалтын зорилтот бүлгийн залуучуудын нийгмийн оролцоо үйлчилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлнэ гэсэн шалгуур үзүүлэлтийн зорилтот түвшин 46 хувь гэснийг 30 хувь гэж өөрчлөх. Санал гаргасан УИХ-ын гишүүн Ундрэм, БСШУСБХ-ны дэмжсэн, Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя аа. Санал хураалт.

71 гишүүн буюу 63.7 хувиар санал дэмжигдлээ.

3.Төсвийн байнгын хорооны гишүүдээс гаргасан санал.

Нэгдсэн төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн төслийн урсгал зардлын цалин хөлс, НДШ, зээлийн хүүгийн төлбөр, гадаад зээл, тусламжийн эх үүсвэрээс санхүүжих зардал, үйл ажиллагааны орлогоос бүрэн санхүүждэг зардлаас бусад урсгал зардлыг 0.01 хувиар буюу 1 тэрбум төгрөгөөр бууруулж мөн дүнгээр Соёл спорт, аялал жуулчлал залуучуудын сайдын багцын Биеийн тамир спортын улсын хорооны Монгол Улсад зохиогдох олон улсын тэмцээний санхүүжилтийг нэмэгдүүлэх. Санал гаргасан УИХ-ын гишүүн Булгантуяа, Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя аа. Санал хураалт.

69 гишүүн буюу 61.6 хувиар санал дэмжигдлээ.

2.ХХААХҮ-ийн сайдын төсвийн багцын ХАА-н салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих татаас урамшууллыг 15 тэрбум төгрөгөөр бууруулж мөн дүнгээр тус сайдын төсвийн багцын шинэ хоршоо хөдөлгөөний зээлийн батлан даалтын сангийн төсвийг нэмэгдүүлэх. Санал гаргасан УИХ-ын гишүүн Батболд. Санал гаргасан гишүүн л үг хэлэх боломжтой. Боломжгүй дэг байхгүй. Санал хураалт.

41 гишүүн буюу 36.6 хувиар санал дэмжигдлээ. Дэмжигдсэнгүй.

Энхбаяр сайд тайлбар хэлээд байх боломжгүй. Энэ яагаад ижилхэн хэрэгжиж байгаа хөтөлбөрүүдэд ингэж ялгаатай хандаж байгаа билээ? Асуудлууд дээр адилхан хандвал хандана шүү.

Зарчмын зөрүүтэй саналын томьёололд нийцүүлэн хуулийн төсөлд өөрчлөлт оруулах тухай.

Төслийн болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэнтэй уялдуулан төсвийн ерөнхийлөн захирагчдын зарцуулах зардалд өөрчлөлт оруулах, төслүүдийн зүйл, хэсэг заалтын дугаарлалтыг болон тэдгээрийн эшлэлийг нийцүүлэн өөрчлөх, үг, хэллэг, нэр томьёог жигдлэн засварлах, засварыг хийх. Мөн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд төслийн код өгөх, дугаар, эдийн засгийн ангилал хэрэгжих хугацааг саналын томьёололд нийцүүлэн өөрчлөх. Санал гаргасан УИХ-ын гишүүн Даваасүрэн. Санал хураалт.

62 гишүүн буюу 55.4 хувиар санал дэмжигдлээ.

Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал.

Ажлын хэсгийн санал.

1.Төслийн 2 дугаар хавсралтын 27 дугаар бүлгийн 1.9-д тусгагдсан Шинэ Ховд үйлдвэр технологийн паркийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт хэрэгжих хугацаа 2022-2025 он, төсөвт өртөг 36 тэрбум 134.9 сая төгрөг, санхүүжих дүн 18 тэрбум 184.0 сая төгрөг гэсэн төсөл арга хэмжээний төсөвт өртгийг 1 тэрбум 721 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал дэмжигдээгүй босож ирлээ.

2.Бусад байнгын хорооны санал.

Боловсролын сайдын төсвийн багцын урсгал зардлын бараа үйлчилгээний зардлын бусад зардлыг 5 тэрбум 800 сая төгрөгөөр бууруулж мөн дүнгээр төрийн өмчит их, дээд сургуульд олгох татаасыг нэмэгдүүлэх. Санал гаргасан УИХ-ын гишүүн Сүхбаатарын Эрдэнэбат, Бадарчийн Хэрлэн, БСШУСБХ дэмжээгүй санал. Дэмжье. Саналын томьёолол. Санал бослоо.

Төсвийн байнгын хорооны гишүүдээс гаргасан санал.

Нэгдсэн төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн төслийн урсгал зардлын цалин хөлс, НДШ, зээлийн хүүгийн төлбөр, гадаад зээл, тусламжийн эх үүсвэрээс санхүүжих зардал, үйл ажиллагааны орлогоос бүрэн санхүүждэг зардлаас бусад урсгал зардлыг 0.045 хувиар, 4 тэрбум 500 сая төгрөгөөр бууруулж энэ эх үүсвэрээр дараах төсвийн ерөнхийлөн захирагчдын урсгал зардлыг нэмэгдүүлэх. Үүнд:

-ШЕЗ-ийн даргын төсвийн багцын урсгал зардлыг 2 тэрбум төгрөгөөр,

-Улсын дээд шүүхийн шүүхийн ерөнхий шүүгчийн төсвийн багцын урсгал зардлыг 1 тэрбум 500 сая төгрөгөөр,

-Соёл спорт, аялал жуулчлалын сайдын, залуучуудын сайдын Биеийн тамир, спортын улсын хорооны Монгол Улсад зохиогдох олон улсын тэмцээний зардлыг тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлэх. Санал гаргасан УИХ-ын гишүүн Баясгалан. Санал хураалт.

44 хувиар санал дэмжигдлээ, дэмжигдсэнгүй.

Монгол Улсын Ерөнхий сайдын төсвийн багцын судалгааны зардлыг 2 тэрбум 900 сая төгрөгөөр бууруулж мөн дүнгээр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын багцын усны газрын урсгал зардлыг нэмэгдүүлэх. УИХ-ын гишүүн Г.Ганбаатар. Санал хураалт. Ганбаа гишүүн Ганбаатар гишүүн.

Г.Ганбаатар: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая аа. Тэгээд энэ орж ирж байгаа энэ оруулсан санал дээрээ энэ Байгаль орчны сайдын багцад гол мөрний менежментийн хөтөлбөрт тусгагдсан нэлээн хэдэн зардлууд байсан юм. Тэгээд яах вэ энэ хөтөлбөрийн зардлаар бид нар хилийн бүсийн уснуудын асуудал, 333 нуур хөв цөөрөм барих асуудлууд, газар доорх усны эрэл хайгуулаа хийх ажлуудыг санхүүжүүлэхээр энэ хөтөлбөр Байгаль орчны сайд дээр байдаг. Үгүй ээ яах вэ 2025 онд энэ хөтөлбөр дээр нэг 3.2 тэрбум төгрөг төсөвлөгдсөн байсан. Үүнээс мөн Эгийн голын УЦС-ын төслийг явуулах, говийн усны төслийг хэрэгжүүлэх, төслийн багийг санхүүжүүлэхээр төсөвлөсөн байсан.

Говийн усны төслийг хэрэгжүүлэх төслийн багийнх нь санхүүжилтийн 230 сая бол Төсвийн байнгын хороон дээр дэмжигдсэн юм. Бусад одоо энэ тодотголоор эдгээр бусад мөнгөнүүд хасагдахаар үндсэндээ энэ Эгийн голын УЦС-ын асуудал үндсэндээ хүндрэлтэй байдалд орно. Гэхдээ Засгийн газрын байр суурь бол одоо энэ дээр бас Эгийн голын УЦС-ыг явуулах эсэх нь одоогоор бас тодорхойгүй байгаа

юм байна. Нөгөө талдаа энэхүү орлогын эх үүсвэр нь бас тодорхой бус байгаа учраас энэ саналаа татаж авч байна аа.

Д.Амарбаясгалан: Санал татагдлаа.

3.Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын төсвийн багцын Ойжуулалтын хөтөлбөрийн зардлыг 2 тэрбум 990 сая төгрөгөөр бууруулж мөн дүнгээр тус сайдын төсвийн багц дахь Усны нөөц, нуур, гол мөрний менежментийн хөтөлбөрийн зардлыг нэмэгдүүлэх. Санал гаргасан Банзрагчийн Түвшин. За Түвшин гишүүнд үг өгье.

Б.Түвшин: Эрхэм гишүүд ээ, энэ 2.9 тэрбум төгрөг болохлоороо нөгөө олон улсын гэрээгээр хүлээсэн Эгийн голын менежменттэй холбоотой, тэрний бэлтгэл ажлууд байгаа. Тэгээд энэ түрүүний нөгөө Одонтуяа гишүүний хэлэх гээд байсан энэ санаа байгаа. Тийм учраас кнопондоо хүрэхгүйгээр энэ төслийг дэмжиж өгнө үү.

Д.Амарбаясгалан: Санал хураалт. 12 гишүүн буюу 10.7 хувиар санал дэмжигдсэнгүй.

Боловсролын сайдын төсвийн багцын Нийслэлийн боловсролын газрын урсгал зардлыг 2 тэрбум 600 сая төгрөгөөр бууруулж, мөн дүнгээр Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын урсгал зардлыг нэмэгдүүлэх. Санал гаргасан УИХ-ын гишүүн Гомбын Ганбаатар. Ганбаатар гишүүнд үг өгье. Гомбын Ганбаатар гишүүн.

Г.Ганбаатар: Энэ санал бол яах вэ ер нь бол бид нар бас Үндэсний телевиз 340-өөд мянган радио сонсдог малчид, дээрээс нь маш олон 14 байгууллагын одоо бас гэрээгээ байгуулчихсан ажлууд үндсэндээ ингээд хэрвээ энэ төсөл батлагдахгүй бол шүүх дээр очихоор болж байгаа юм. Дээрээс нь бас энэ төрийн дамжуулалт буюу одоо тагнуул, цагдаа, үүрэн холбоо, кабелийн телевиз, ус, цаг уурын дамжуулалт ингээд энэ төсөв хэрвээ хасагдвал бүрэн зогсох юмаа. Тийм учраас гишүүдийг бас кнопондоо хүрэхгүй байж дэмжиж өгөхийг хүсье ээ.

Д.Амарбаясгалан: Санал хураалт. 44 гишүүн буюу 39.3 хувиар санал бослоо.

Сангийн сайдын төсвийн багцын Засгийн газрын нөөц сангийн зардлыг 84.6 сая төгрөгөөр бууруулж мөн дүнгээр Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын даргын төсвийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал нэмэгдүүлэх. Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналуудыг ганцыг нь унагаагаад бусдыг нь босгочхож байгаа. Дэмжээгүй саналуудыг тэгээд одоо адилхан л зарчмаар хандсан нь дээр шүү дээ. Ер нь бол адилтай л бол адилтай байх ёстой, жоохон зарчимтай байх ёстой.

За 5 дахь санал хураалт. Санал хураалт.

38 гишүүн буюу 33.9 хувиар санал дэмжигдсэнгүй.

6.Монгол Улсын Ерөнхий сайдын төсвийн багцын урсгал зардлыг 3 тэрбум 700 сая төгрөгөөр бууруулж мөн дүнгээр төслийн 2 дугаар хавсралтад Нэгдсэн эмнэлгийн барилга 100 ор, Баян-Өлгий Өлгий сум төслийн нэмэлт санхүүжилт

төсөвт өртөг санхүүжих дүн 3 тэрбум 700 сая гэсэн төсөл арга хэмжээг нэмэх. Санал гаргасан Гомбын Ганбаатар. Санал хураалт.

35 гишүүн буюу 31.3 хувиар санал дэмжигдсэнгүй.

Сангийн сайдын төсвийн багцын Засгийн газрын нөөц сангийн зардлыг 1 тэрбум 781 сая төгрөгөөр бууруулж мөн дүнгээр төслийн 2 дугаар хавсралтын 16 дугаар бүлгийн 1.12 гэр хорооллын шугам сүлжээ Өвөрхангай, Арвайхээр сум гэсэн төсөл арга хэмжээний санхүүжих дүнг нэмэгдүүлэх. УИХ-ын гишүүн Даваагийн Цогтбаатар. Санал хураалт.

29 гишүүн буюу 25.9 хувиар санал дэмжигдсэнгүй.

8.Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайдын төсвийн багцын урсгал зардлыг 2 тэрбум 976 сая төгрөгөөр бууруулж мөн дүнгээр төслийн 2 дугаар хавсралтын 4 дүгээр бүлгийн 2.3.1-д тусгагдсан ШУА-ийн харьяа хүрээлэнгийн хэрэглээний био технологийн лабораторийн тоног төхөөрөмж Улаанбаатар Баянзүрх дүүрэг гэсэн төсөл арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг нэмэгдүүлэх. Санал гаргасан Баясгалан гишүүн. Санал хураалт.

36 гишүүн буюу 32.1 хувиар санал дэмжигдсэнгүй.

9.Сангийн сайдын төсвийн багцын Засгийн газрын нөөц сангийн зардлыг 50 тэрбум төгрөгөөр бууруулж төсвийн тэнцлийг сайжруулах. Санал гаргасан УИХ-ын гишүүн Далайн Батбаяр.

Дэгээрээ ганцхан санал гаргасан гишүүн үг хэлэх дэгтэй байхгүй юу. Боломжгүй зөвхөн санал гаргасан гишүүн гаргасан саналаа тайлбарлаж үг хэлэх боломжтой тийм. Дондогмаа дарга та дэгийн тайлбар хийгээд өг дөө 1 дүгээр микрофон.

Ч.Дондогмаа: Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиас зохицуулалтыг уншиж танилцуулъя. Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71.11-д бол.

Д.Амарбаясгалан: Дэгээ сонс.

Ч.Дондогмаа: Нэгдсэн хуралдаанаар төсвийн төслийн 2 дахь хэлэлцүүлэг явуулах үед Байнгын хороо, нам, эвслийн бүлэг гишүүд, Монгол Улсын Ерөнхийлөгч, төрийн аудитын төв байгууллага гаргасан саналаа тайлбарлан үг хэлж болно. 71.12-т нэгдсэн хуралдаан энэ хуулийн 71.9-д заасан санал тус бүрээр ил санал хураалт явуулна аа гэж тус тус заасан байгаа.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны даргаар үг хэлүүлж болох уу? Үгийг нь.

Ч.Дондогмаа: Байнгын хороо гаргасан саналаа тайлбарлаж үг хэлж болно.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны дарга, Төсвийн байнгын хорооны дарга Даваасүрэн гишүүнд үг өгье. Үгүй ээ, энэ чинь уучлаарай. Даваасүрэн гишүүний үг биш юм байна.

Ц.Даваасүрэн: Энэ юу Засгийн газрын нөөц сангийн зардлыг 50 тэрбумаар бууруулчихвал Засгийн газрын нөөц байхгүй болчихож байгаа байхгүй юу. Тэгээд одоо энэ чинь байна шүү дээ. Ямар нэг асуудал, аюул манай энэ саналыг нөгөө бид нар нөгөө дэмжсэн дэмжээгүйгээр яаж байгаа учраас бид нар яагаад энэ саналыг дэмжсэн гэдэг талаараа үг хэлэх эрхтэй. Унагасан гэдэг талаараа үг хэлэх эрхтэй. Тэгэхээр энэ санал дэмжигдчих юм бол Засгийн газрын нөөц хөрөнгө гэж байхгүй. Одоо зуд турхан болбол юу ч байхгүй. Үгүй ээ тэгээд өвс мөвсөө яах юм одоо энэ чинь өвөлжилтийн бэлтгэлээ яах юм. Энэ чинь тийм юм бас байж болохгүй. Уг нь энэ дээр Батбаяр гишүүн өөрөө хаачив. Энэ зүгээр дэндүү тоглоом болно шүү. Энийг бол анхаараарай та нар.

Д.Амарбаясгалан: Санал гаргасан гишүүн алга байна. Санал хураалт.

57 гишүүн буюу 50.9 хувиар санал дэмжигдлээ.

Эдийн засаг, хөгжлийн сайдын төсвийн багцын урсгал зардлын гадаад томилолтын зардлыг 1 тэрбум 212.2 сая төгрөгөөр бууруулж, төсвийн тэнцлийг сайжруулах. УИХ-ын гишүүн Далайн Батбаяр. Санал хураалт.

49.1 хувиар санал уналаа.

Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын Эрчим хүчний реформын үндэсний хорооны зардлыг 400 сая төгрөгөөр бууруулж мөн дүнгээр Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын төсвийн багцын Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын урсгал зардлыг нэмэгдүүлэх. УИХ-ын гишүүн Гомбын Ганбаатар. Санал гаргасан гишүүн Ганбаатар гишүүнд үг өгье.

Г.Ганбаатар: Энэ оруулсан санал маань бол манай улсад энэ гэр бүлийн хүчирхийлэл өсөн нэмэгдээд байгаа нөхцөл байдлыг харгалзаад түр хамгаалах байрны үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцад Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газрын төсөвт байгаа олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний нэр нэг төрөл болох ТББ-ын харьяанд ажиллаж буй гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээний үйлчилгээнд нь зориулж 400 сая төгрөг л ердөө нэмэх зардал гаргаж байгаа юм. Тэгээд энэ 2 салбарын сайд нь нэмэх байх аа гэж бодож байна. Төсвийн байнгын хорооны гишүүний хувьд бол Төсвийн байнгын хорооны гишүүн оруулах саналыг нь манай Жаргалан гишүүн бас энэ саналыг давхар уламжилж байгаа юмаа. Дэмжиж өгөхийг хүсье ээ.

Д.Амарбаясгалан: Санал хураалт. 31 гишүүн 27.7 хувиар дэмжигдээгүй санал дэмжигдсэнгүй ээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

хуулийн төслүүдийг 3 дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

17:02

Д.Амарбаясгалан: Дараагийн асуудалд оръё.

Төсөв дагасан дээр буцаасан тогтоолыг уншиж танилцуулъя. Монгол УИХ-ын тогтоол. Тогтоолын төсөл буцаах тухай.

Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.12 дахь хэсгийг үндэслэн Монгол УИХ-аас Тогтоох нь: Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдөр Монгол УИХ-д Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Монгол УИХ-ын тогтоолын төслийг хууль санаачлагчид нь буцаах нь зүйтэй гэсэн Байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул хууль санаачлагчид буцаасугай.

17:03

Д.Амарбаясгалан: Дараагийн асуудалд оръё.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн Гомбын Ганбаатар танилцуулна аа. Индэрт урьж байна.

Г.Ганбаатар: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг УИХ-ын чуулганы 2025 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн нэгдсэн чуулганаар явуулж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2025 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол УИХ-ын чуулганы дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж, хуулийн төслүүдийг зүйл бүрээр нь хэлэлцсэн болно.

УИХ-ын даргын 2025 оны 291 дүгээр захирамжаар Монгол Улсын төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол

Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Байнгын хороо чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий Ажлын хэсгийг УИХ-ын гишүүн Х.Ганхуягаар ахлуулж, УИХ-ын нэр бүхий 19 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллалаа.

Тус ажлын хэсгээс Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгагдсан эдийн засгийн үзүүлэлтүүдийн 2026, 2027 оны төсвийн төсөөлөлд тусгагдсан тоонуудыг 2025 оны 5 дугаар сарын 30-ны УИХ-аар баталсан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд нийцүүлэн өөрчлөх санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн болно.

Мөн Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсэгт зааснаар Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, түүний нэмэлт, өөрчлөлтийг баталснаас хойш 3 сарын дотор тухайн жилийн төсвийн төсөл тодотголын төслийг өргөн мэдүүлэхийг хориглосон зохицуулалтуудтай холбоотойгоор 2026 оны төсвийн төсөөллийг төсвийн төслийг хуульд заасны дагуу 2025 оны 9 дүгээр сарын 1-ний дотор өргөн мэдүүлэх цагалбарт нийцүүлэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах нь зүйтэй гэсэн санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг та бүхэнд хүргүүлсэн.

УИХ-ын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Ням-Осорын Учрал Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Намжилдоржийн Энхбаяр Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, Жамсрандоржийн Дэлгэрсайхан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Нинжбатын Ууганбаатар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Амаржаргалын Энхбат Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Жигжидийн Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Бат-Ирээдүйн Анар Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлого зохицуулалтын газрын дарга,

Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Доржготовын Баттогтох Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаан технологийн нэгдсэн бодлогын газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга, Отгондэмбэрэлийн Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Батчулууны Мөнгөнсүх Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын Салбар дундын зохицуулалтын төлөвлөлтийн хэлтсийн дарга, Очиржанцаны Мөнхтөр Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого зохицуулалтын газрын Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн дарга, Лувсандоржийн Гантогтох Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Өрийн удирдлагын хэлтсийн дарга.

Одоо УИХ-ын гишүүд Байнгын хорооны санал дүгнэлттэй холбогдуулан урьдчилан ирүүлсэн нэрсийн дарааллын дагуу асуулт асууна аа. Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн асуулт асууя. Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуулт асууя. Буланы Бейсен гишүүн асуулт асууя. Жамбалын Ганбаатар гишүүн асуулт асууя. Жудагийн Баярмаа гишүүн асуулт асууя. Мэндбаярын Мандхай гишүүн асуулт асууя. Отгоны Саранчулуун гишүүн асуулт асууя. Цэндийн Баатархүү гишүүн асуулт асууя, Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуулт асууя. Бусад гишүүд асуултаа татлаа.

Д.Энхтүвшин: 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл дээр 2025 оны төсвийг 1.3 их наядын алдагдалтай байхаар тэнцвэржүүлсэн тэнцлийг ингэж төсөл оруулж ирсэн байна аа. Тэгээд энэнтэй холбоотой нэг асуулт байна. Төсвийн алдагдлыг яаж нөхөх гэж байгаа вэ? Тэгэхээр сонгогчидтой бас би хэдийгээр жагсаалтын гишүүд ч гэсэн сонгогчидтой уулздаг. Бид нар Дорнод аймагт бизнес эрхлэгчтэй уулзаж байхад нэг ийм асуудал ярьж байсан. Төсөв алдагдалтай батлагдахаар татварын байгууллагуудаас данс хаадаг, татварын өр нэхэж данс хааж одоо үйл ажиллагаа зогсоож авдаг ийм үйл ажиллагаа хандлагууд нэмэгддэг ээ. Тэгэхээр төсвөө та бүхэн бас алдагдалгүй баталж өгөөрэй гэж гуйж байсан.

Тэгэхээр энэ удаа ингээд төсөв маань буцаад алдагдалтай болж байна. Тэгээд өнгөрсөн хугацаанд ААН-үүдийн маань бас санхүүгийн байдал бас нэлээн сайнгүй байгаа. Данс хаадаг арга хэмжээ 2020 онд нийтдээ нэг 753 одоо энэ татвар болон НДШ-тэй холбоотой хааж байсан болбол 2024 онд 22813 ийм тохиолдол гарсан байна. Өөрөөр хэлбэл 5 жилийн дотор 30 дахин нэмэгдсэн байгаа. Өөрөөр хэлбэл үйл ажиллагаа явуулж байгаа ААН-үүдийн бараг 21 хувь нь дансаа хаалгаж байж үйл ажиллагаа юу татвараа төлөх ийм нөхцөл байдалд үүсэж байгаа юм.

Дээр нь татварын өр сүүлийн жилүүдэд бас нэлээн огцом нэмэгдэж байгаа. 2020 онтой харьцуулахаар 2024 оны дүн харахаар 4.7 их наяд буюу 5 жилийн дотор 4 дахин татвар болон нийгмийн даатгалын өр ингээд нэмэгдсэн байгаа юм. Тэгэхээр энэ төсвийн алдагдалтай батлагдсантай холбоотойгоор ААН-үүд дээр энэ данс хаадаг үйл ажиллагаанууд дээр одоо ямаршуу мэдээж одоо хуулийн гүйцэтгэлээ өр байгаа учраас төл гэж шаардах байх. Гэхдээ энэ өнгөрсөн хугацаанд энэ өрүүд ингээд 4 дахин нэмэгдчихсэн байгаа. Татварын данс хаадаг үйл ажиллагаа 30 дахин ингээд нэмэгдчихсэн байгаа. Энэ байдал энэ төсвийн алдагдалд яаж нөлөөлөх вэ? Энэ талаар асуулт байна.

Д.Амарбаясгалан: Эдийн засаг, хөгжлийн сайд Ням-Осорын Учрал хариулт өгье. Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье.

Б.Жавхлан: Энхтүвшин гишүүн хүрээ ярилцаж байгаа үед бас шууд хүрээтэй холбоогүй асуулт тавилаа. Тэгээд би хариулъя аа. Тэр данс хаагддаг процесс болбол яг энэ хууль дээр байдаг л заалт юм байгаа юмаа. Тийм учраас одоо энэ төсвийн орлогыг төвлөрүүлдэг гол байгууллага энэ татварын байгууллага, татварын институцийн ажиллаж байгаа нийт албан хаагчдад бол буруу өгөх ямар ч арга байхгүй. Ялангуяа төсөв орлого ийм хүнд үед бол бас эд нарын ачаалал дарамт болбол нэлээн ихэсдэг, нэлээн том төлөвлөгөөтэй байж байдаг. Төлөвлөгөө нь биелэгдэхгүй ийм асуудлууд гарна. Нөгөө талаар бас яг ийм эдийн засгийн хүнд үед бас хувийн сектор татвар төлөгч ААН-үүд дээр маань ч гэсэндээ одоо баяр ёслолын үеэр цалин мөнгөө тавих гээд л мөн одоо хамтарч ажиллаж байгаа гэрээт байгууллагуудынхаа төлбөр мөнгийг гаргах гээд нэлээн ер нь зовлон байдаг.

Тийм учраас ямар ч байсан баяр наадам дөхөж байгаатай холбогдуулаад татварын байгууллагуудаас бас ирж байгаа хүсэлт харилцагчдаас ирж байгаа хүсэлтийн дагуу болбол энэ төсвүүдийн үед дансан дээр бол ийм хаалт бол хийхгүй байгаа гэдгийг мэдээлье. Харин татварын хувьд бас хүндрэлтэй байгаа ААН-үүдтэйгээ он дуустал хавар намар болтол шинэ хуваарь хийгээд яг энэ нь харин шинэчлэгдсэн хуваарийнхаа дагуу арай явах боломжгүй байвал аль аль талаасаа одоо хуулийн дагуу дараа шатных нь арга хэмжээг авахаас өөр аргагүй болно оо нэгд ийм.

Би энэ одоо байгаа хуулийнхаа талаар л одоо гүйцэтгэлийнх нь талаар л яриад байна шүү хэрэгжилтийнх нь талаар. Тэгвэл татварын реформын хүрээнд дансыг шууд ингээд 100 хувь битүүмжлэх биш хэсэгчилж битүүмжилдэг байхаар ийм зохицуулалтыг одоо шинээр оруулж ирж байгаа. Тэр үед нь Энхтүвшин гишүүн бас дэмжинэ байх аа гэж найдаж байна.

Сүүлийн жилүүдэд төсвийн орлого өөрөө бас нэмэгдэж байгаа. Эдийн засаг маань өөрөө тэлж байгаа. Ингээд бас төсөв нэлээд өндөр ачаалал авдаг болж байгаа. Энийгээ дагаад яг объём нь болбол нийт татварын орлогын нэг 4-5 хувь дээр болбол ер нь нэг ийм өр үүсээд яваад байдаг. Тухайн сар болгон өөр, жил болгон өөр, тэр хэмжээтэй л одоо яг параллельный ингээд өсөж байгаа гэсэн үг.

Д.Амарбаясгалан: Жудагийн Баярмаа гишүүн асуулт асууя.

Ж.Баярмаа: Энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль гэж одоо Монгол Улсад хэрэгжиж байгаа нийт хэд орчим хуулиас хамгийн тогтворгүй хууль нь болчихоод байдаг. Тэгээд нэр нь болохоор тогтвортой гээд бүүр ийм нэртэй. Тэгээд өнөөдрийг хүртэл бараг 18, 19 удаа өөрчлөлт орсон гэж байгаа юм. Тэгээд дахиад одоо ингээд өөрчлөлт орох гээд. Тэгээд би бас нэг асуух гээд байгаа юм нь сая энэ 6 сарын 25-нд хэзээдээ яаж байгаад нэг ийм 2 өөрчлөлт орчихсон юм бол оо. Тэгээд манай Энхбаяр гишүүн ярьдаг байх аа. Төсвийн хулгай гээд биш ээ, хуулийн хулгай билүү? Тэр хуулийн хулгай гэдэг чинь нэг юм хасахаасаа илүү бас юм шургуулаад нэмчихдэгийг бас хуулийн хулгай гэж бодоод байгаа шүү дээ. Тэгээд энэ 2 заалт нэмэгдсэн энэ харгалзах он нөгөөдхөд нь болохоор юу билээ Засгийн газрын бүтцэд өөрчлөлт оруул гээд ийм 2 үг ингээд оруулчихсан байгаад байх юм.

Тэгээд энэ миний ойлгож байгаагаар энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7 буюу тусгай шаардлага чинь ерөөсөө болохгүй шүү, хориглоно шүү гэсэн ийм заалт бүүр шаардлага байсаар атал яаж ийж байгаад л энэ ийм юм байх юм бол хамаарахгүй, ийм юм байх юм бол хамаарахгүй гэсэн ийм саналууд оруулаад яваад байх юм бол энэ тусгай шаардлага чинь огт ажиллахгүй гэсэн үг шүү дээ.

Тэгээд энд би зориуд нэг өгүүлбэр уншъя. Энэ төсвийн тогтвортой байдлын зөвлөл хөөрхий ийм юм бичээд байгаа байхгүй юу. Төсөв дагаж өөрчлөгдсөөр ирсэн төсвийн хүрээний мэдэгдэл нь тодотгол даган өөрчлөгдөж байгаа бөгөөд гээд энэ өгүүлбэр бол бүүр аймаар тийм өрөвдөлтэй өгүүлбэр байгаа байхгүй юу. Төсвийн тодотгол дагаж өөрчлөгдсөөр ирсэн хүрээ маань гээд. Гэтэл энэ төсвийн тусгай шаардлагыг баримтлах гээд энэ 7.4, 7.5 дотор бүүр хоёуланд нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэхгүйгээр төсөв хийж болохгүй ээ гээд заачихсан 7.4-д, 7.5-д дахиад энэ агуулгаа хийчихсэн байгаа шүү дээ. Харгалзах тухайн жилийн төсөв, төсвийн тодотголыг төсвийг өргөн мэдүүлэх, батлахыг хориглоно оо гээд төсвийн хүрээний мэдэгдэлд мэдэгдлээс өөрөөр гээд.

Тэгэнгүүт ийм нэг ийм сонин юм үүсээд байгаа юм. Тэгээд энэ 7.5 дээр энэ харгалзах тухайн жил гэдгийг яагаад оруулсныг хэлээд өгөөч ээ. Миний бодлоор 2025 оны төсвийн хүрээний мэдэгдлийг өөрчлөх гэж байгаа болбол энэ хамаарахгүй юм биш үү? 12 сард тэртээ тэргүй хийгдчихсэн шүү дээ тийм үү? Тэгэхээр тэрнээс хойш 6 сар өнгөрчихсөн байгаа юмыг чинь тэртээ тэргүй хийе гэвэл хийж болох юм биш үү? 7.5. Тэгэнгүүт 7.6 ч гэсэндээ жишээлбэл дахиад л нөгөө 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл чинь 12 сард хийгдчихсэн гэж би ойлгоод байгаа юм. Тэгэхээр хийе гэвэл дахиад хийж болох юм биш үү? Бараг хагас жил өнгөрчихсөн. Тэгэхээр энэ 2 заалт ямар учиртай орсон юм болоо?

Дахиад 2026 он одоо нэг тодотголыг дагаж бүүр 2 төсвийн хүрээний мэдэгдэл өөрчлөхөөр орж ирж байна шүү дээ. 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл бүүр хоёул хоёулаа зэрэгцээд. Тэгэнгүүт нөгөө төсвийн тухай хуулийн нөгөө цаглавар дотор чинь 9 сарын 1-ний дотор өргөн барих ёстой байгаад байгаа тиймээ. Тэгээд одоо хэрвээ дахиад 2026 онд төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулах юм бол 10 сарын 11-нээс нааш дахиад энэ төсөв барьж болохгүй болчхож байгаа шүү дээ.

Тэгэхээр 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулах ямар ч боломжгүй. Хэрвээ оруулах юм бол бид нар 9 сарын 1-ний дотор төсвөө өргөн барих боломжгүй болох юм биш үү? Тэгээд энэ эс бөгөөс энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль гэдэг хуулийнхаа нэрийг нь солимоор юм. Төсвийн тогтворгүй байдлын тухай хууль гэж нэрлэмээр юм. Тэгэхгүй бол одоо энэ чинь одоо...

Д.Амарбаясгалан: Ням-Осорын Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Баярмаа гишүүний асуултад хариулъя аа. Яг одоо яагаад төсөв тодотгох нөхцөл үүссэн бэ гэхээр бид нар энэ оны төсвийг баталж байхад энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нүүрсний үнийг 107 ам.доллар юм уу, 132 ам.долларын 2 хувилбараар ирүүлсэн. 2024 оны дундаж үнэ бол 104 байсан байхгүй юу. Тэгээд тухайн үед нүүрсний үнийг 105 доллар гэж төсвийн хүрээг баталсан. Тэгээд явж байсан чинь ерөөсөө 5 дугаар сар тийм 31 өнгөрөхөд нүүрсний үнэ бүүр одоо 70 болсон. 70 болсон шүү дээ. Тэгэхээр тодотгохоос өөр нөхцөл болбол байхгүй болж байгаа биз. Нэг ёсондоо энэ оны төсөв чинь өөрөө 105

доллараар бодчихсон нүүрс чинь 39 хувь буурчихсан гэсэн үг. Тэгээд 70 болчихсон. Тэгээд энэ дээр төсөв төлөвлөх ямар ч нөхцөл бүрдэхгүй.

Дээрээс нь Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүний хуулийг оруулж ирэхдээ нөгөө хэмнэлтийн горимд шилжье гээд тэр үндэсний хороотой сайд нарыг Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүн дээр өөрчлөлт оруулаад хасаад ингээд явахаар төсвийн ерөнхийлөн захирагч нарын хооронд төсөв мөнгө нь шилжих ийм шаардлага үүссэн. Тэгээд эхлэхээр нөгөө экспортынхоо орлогыг өндрөөр төлөвлөчихсөн төсвийн хүрээн дээрээ хэмнэлт хийх ямар ч одоо бололцоо байхгүй. Нөгөө орлогоо алдчихсан. Тэгэхээр төсвийн хүрээ өөрчлөгдөхөөс өөр зам байхгүй болчихож байгаа байхгүй юу.

Тийм учраас Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүнийхээ хэрвээ өөрчлөгдөж байгаа бол магадгүй одоо яамдуудын тоо буурч байгаа бол, төсвийн ерөнхийлөн захирагч нарын хооронд төсөв мөнгө шилжиж байгаа бол төсвийн хүрээг өөрчлөхгүйгээр энд ямар ч өөрчлөлт хийх бололцоогүй. 5 дугаар сарын 31-нд Их Хурлаар батлагдсан төсвийн хүрээний мэдэгдэл дээр тухайн үед нөгөө макро үнүүдээ гаргахдаа нүүрсний үнийг 80 доллароор тооцсон юм байна лээ 80 доллар. Тэгэхэд Төсвийн тогтвортой байдлын зөвлөл 88 доллар гэж өгч байсан. Гэтэл өнөөдөр нүүрсний үнэ 70 доллартой байгаа шүү дээ. Тэгэхээр 9 дүгээр сарын 1-нд ирэх оны төсвийг төлөвлөхийн үед сая тэр Блүүмбергийн терминал дээр байгаа 14 байгууллагын нүүрсний үнийн төсөөллийг харахаар 13-30 хувь буурна.

Би жишээ нь Эдийн засгийн хөгжлийн сайдын хувиар бол би 9 дүгээр сарын 1-нд нүүрсний үнэ 80 доллар байна аа, эдийн засгийн өсөлт 6 хувь байна аа гэж ийм алдагдалгүй төсөв оруулж ирнэ ээ гэж би худлаа ярьж бол чадахгүй. Энэ чинь наад захын хэн ч ороод өнөөдөр нүүрсний үнийг харж чадна шүү дээ. Гэтэл 80 доллар байна аа ашигтай төсөв би оруулж ирнэ ээ буруу төлөвлөж чадахгүй шүү дээ. Тэгээд энэ дээр нь тохируулаад Сангийн яам төсөв хийх юм уу. Тэртээ тэргүй нүүрсний үнэ нь буучихсан байхад. Тэгэхээр төсвийн хүрээг өөрчилж байж түүнд тэр төлөвлөлт дээрээ төсөв хийхээс өөр арга зам байхгүй байхгүй юу.

Тийм учраас төсвийн сахилга батыг сайжруулахад төсвийн тогтвортой байдлын энэ хууль хэрэгтэй хэдий ч зарим нөгөө хэмнэж байгаа бол, орлого буурч байгаа бол...

Д.Амарбаясгалан: Яах вэ одоо энэ гишүүдийн ярьж байгаа нэг зүйл байгаа шүү дээ. Асуудалдаа тааруулж хууль өөрчлөөд байдаг энэ байдлаа болио л гээд байгаа шүү дээ. Хуульдаа тааруулж ажлаа хий гэдэг зүйлийг яриад байгаа юм. Тэгэхээр одоо нэг асуудал тааруулаад л хууль өөрчлөөд л. Ямар сайндаа УИХ-ын гишүүд чинь одоо Төсвийн тогтвортой байдлын тухай хууль биш Төсвийн тогтворгүй байдлын тухай хууль гээд ёжлоод хэлээд сууж байна гэдгийг л ярьж байна. Энэ дээр гишүүдийн энэ хэлж ярьж байгаа үгийг бас жоохон ойлгож хүлээж авна шүү. Жудагийн Баярмаа гишүүн тодруулж асууя.

Ж.Баярмаа: 2025-ын төсвийн хүрээний мэдэгдэлд бол хийж болох юм шиг надаа харагдаад байгаа юм л даа. Яагаад гэвэл 12 сард батлагдсан гэж би ойлгоод байгаа. Тэгэхээр тэртээ тэргүй 3 сар нь өнгөрчихсөн учраас хийж болох байх байхгүй юу тийм биз. Тэгэхээр энэ 6 сарын 25-нд оруулсан тухайн харгалзах жил 7.5, 7.6-д оруулсан Засгийн газрын бүтцэд өөрчлөлт оруулсан гэдэг 2 заалт чинь ямар ч хэрэггүй юм шиг надад харагдаад байгаа байхгүй юу. Тэртээ тэргүй энэ 2

заалттай, заалтгүй 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл батлагдаад 6 сар өнгөрчихсөн учир хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулж болно гээд байгаа юм. Эсрэгээрээ энэ 2 заалт дараа ажиллаж болно л доо. Батлагдсаны дараа гуравхан сарын дотор засаг огцроод Засгийн газрын бүтцэд өөрчлөлт оруулбал 7.6 ажиллаж болно гээд.

Тэгэнгүүт одоо 2026 төсвийн хүрээний мэдэгдэлд хэрвээ өөрчлөлт орох юм бол за 7 сарын 10-нд батлагдлаа гэж бодоход 10 сарын 11-нээс нааш төсөв өргөн мэдүүлж болохгүй шүү дээ. Тэгэхээр энийг яаж зохицуулъя гэж бодож байгаа юм нэгд. Дахиад...

Д.Амарбаясгалан: Учрал сайд хариулт өгье.

Н.Учрал: Тийм би гишүүдийн энэ саналыг ойлгож байна аа. Хуулийнхаа хүрээнд хийх ёстой. Гэхдээ нэг ийм валют байдалтай байгаад байна л даа. Жишээ нь нөгөө нүүрснийх нь үнэ нь ингээд өдөр өдрөөр буугаад байдаг. Тэгээд байж байсан чинь энэ оныхоо төсвийн хүрээндээ тодотгол хийгээд байдаг. Гэтэл ирэх оны 9 дүгээр сарын 1-нээс өмнө барих төсөв чинь өөрөө өнгөрсөн энэ оныхтойгоо тоонууд нь нийцэхгүй болбол бид нар сарын дараа бараг төсөв барих гээд байна шүү дээ ирэх оны. 9 сарын 1-нээс өмнө. Тэгэхэд тэр үед нүүрс чинь 80 доллар оо, бидний баталсан хууль аа, 5 сарын 31-нд баталчихсан ингээд явахаас өөр аргагүй гээд өөдрөгөөр төсөөлчихвөл ирэх оны 2 сард гэхэд дахиад л тодотгол хийх байхгүй юу. Ийм л юм руу хөтлөөд байгаа юм.

Тэгэхээр энэ 2 тоо болбол зайлшгүй нийцэх шаардлага болбол үүсчхээд байсан. Тийм учраас л энэ төсвийн тогтвортой байдлын хууль дээр хэрвээ хэмнэж байгаа тохиолдолд бол зайлшгүй төсвийн хүрээ төлөвлөлтөө өөрчлөхөөс өөр замгүй...

Д.Амарбаясгалан: УИХ-ын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо Байнгын хорооноос санал хураалгахаар бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураана.

Зарчмын зөрүүтэй 2 санал байгаа. Зарчмын зөрүүтэй саналыг тайлбарлаж түүнийг дэмжсэн эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж мөн аль нэг намын нам эвслийн бүлэгт харьяалагдаагүй тус бүр 2 хүртэл гишүүн үг хэлж болно. УИХ-ын гишүүд санал хураалтад бэлтгэе.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Нэг.Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт дэх ДНБ-ий бодит өсөлтийн хэмжээ 2026 онд 5.7 гэснийг 6 гэж, 2027 онд 6.3 гэснийг 6.5 гэж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ 2026 онд 31 тэрбум 720.4 тэрбум гэснийг 33 тэрбум 479.5 гэж, 2027 онд 33761 гэснийг 35628.6 гэж, ДНБ-ий эзлэх хувь 2026 онд 30.9 гэснийг 31.7 гэж, 2027 онд 29.3 гэснийг 30.4 гэж Нэгдсэн төсвийн нийт

зарлагын дээд хэмжээ 2026 онд 32839.8 гэснийг 33479.5 гэж, 2027 онд 34626 гэснийг 35628.6 гэж, ДНБ-д эзлэх хувь 2026 онд 32 гэснийг 31.7 гэж, 2027 онд 30 гэснийг 30.4 гэж, Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2026 онд 0 гэснийг 1119.4 гэснийг 0 гэж, 2027 онд -865 гэснийг 0 гэж, ДНБ-д эзлэх хувь 2026 онд -1.1 гэснийг 0 гэж, 2027 онд -0.7 гэснийг 0 гэж, Нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээ 2026 онд 29 тэрбум 666.4 сая гэснийг 30 тэрбум 314.5 сая гэж, 2027 онд 31 тэрбум 452.6 сая гэснийг 33 тэрбум 282.2 сая гэж, ДНБ-д эзлэх хувь 2026 онд 28.9 гэснийг 28.7 гэж, 2027 онд 27.3 гэснийг 28.4 гэж, Нэгдсэн төсвийн суурь тэнцэл 2026 онд 2 тэрбум 54 сая гэснийг 3 тэрбум 165 сая гэж, 2027 онд 2 тэрбум 308.4 сая гэснийг 2 тэрбум 346.4 сая гэж, ДНБ-д эзлэх хувь 2026 онд 2 тэрбум гэснийг 3 тэрбум гэж, Засгийн газрын өрийн нийт хэмжээ 2026 онд 51 тэрбум 350 сая гэснийг 52 тэрбум 750 сая гэж, 2027 онд 51 тэрбум 939 сая гэснийг 52 тэрбум 794 сая гэж, Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс хуваарилах зардлын ДНБ-д эзлэх хувь 2026 онд 2.6 гэснийг 2.5 гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан УИХ-ын гишүүн Ганхуяг, Алдаржавхлан, Ариунзаяа, Баасанжаргал, Баатархүү, Бадамсүрэн, Батболд, Батжаргал, Ганзориг, Заяабал, Идэрбат, Мөнхбат, Мөнхсоёл, Номин, Түвшин, Пунсалмаа, Пүрэвдаваа, Сэддорж, Туваан. Цаашид ажлын хэсэг гэх. Санал хураалт.

53 гишүүн буюу 47.3 хувиар санал дэмжигдсэнгүй. Жавхлан сайдад үг өгье.

Б.Жавхлан: Сая уг нь яг дэмжээд дарсан дагуу сөрөг гарчих юм. Дахиж санал хурааж өгөөч.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлангийн гаргасан саналаар санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт явуулъя аа. Эхлээд горимын санал хураагаадахъя. Даваасүрэн гишүүн Төсвийн байнгын хороон дарга.

Ц.Даваасүрэн: Гишүүд ээ, энэ дээр чинь нэг ийм юм болоод байгаа шүү дээ. Төсвөө 9 сарын 1-нд оруулж ирж амжихгүй байх ийм нөхцөл байдал бүрдчихээд байгаа юм. Эсвэл одоо ингээд бид нар энийг нь өөрчлөөд ингээд явуулбал нөгөө алдагдалгүй төсөв орж ирэх ийм нөхцөл байдал үүсэж байна. Ийм 2 заагт орчихоод байгаа юм. Тийм учраас ажлын хэсэг дээр нэлээн сайн ярилцаж байгаад энэ саналуудыг гаргасан байгаа гэдгийг та нар бодоорой. Бид нар төсвөө өргөж чадахгүй болчихвол бүүр хачин юм болно шүү дээ 9 сарын 1-нд.

Д.Амарбаясгалан: Горимын саналаар санал хураалт явуулъя.

66 хувиар санал дэмжигдлээ.

Үндсэн саналаар нь санал хураалт явуулъя. Дэмжье.

58.9 хувиар санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1.Хууль тогтоомжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсгийг тус тус үндэслэн хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

65 гишүүн буюу 58 хувиар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа. Хуулийг буцаасанд тооцлоо. Хууль буцаах тогтоол батлагдсанд тооцлоо.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

17:32

Д.Амарбаясгалан: Дараагийн асуудалд орно.

Эрчим хүч яаралтай нь дэмжигдээгүй учраас хэлэлцэх боломжгүй. Хэлэлцээд явж болох юм уу. Хэлэлцэх эсэхээ явуулчихъя тиймээ.

Д.Амарбаясгалан: Дараагийн асуудалд орёё.

Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна. Хууль санаачлагчийн илтгэлийг Засгийн газрын гишүүн, Эрчим хүчний сайд Баттогтохын Чойжилсүрэн танилцуулна аа. Индэрт урьж байна.

Б.Чойжилсүрэн: Эрхэм УИХ-ын дарга, гишүүд ээ. Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд төрөөс эрчим хүчний салбарын өсөлтийг дэмжинэ. Либералчлал хийх асуудлыг тусгасны дагуу эрчим хүчний томоохон төслүүдийг нэн даруй эхлүүлж, эрчим хүчний найдвартай эх үүсвэрийг бий болгох зайлшгүй шаардлагатай байна аа.

Цахилгаан эрчим хүчний хэрэглээ сүүлийн жилүүдэд дунджаар 7-8 хувиар өсөж байна. Энэ хэрэглээний өсөлтийг хангах дотоодын эрчим хүчний эх үүсвэрийн суурилагдсан хүчин чадлыг нэмэгдүүлэх, нөөц чадлын зохистой хэмжээнд хүрэх буюу одоо байгаа суурилагдсан хүчин чадлыг 2 дахин нэмэгдүүлж, 2030 оны түвшинд 3750 мвт хүргэх хэрэгцээ шаардлага байна аа. Эрчим хүчний төслүүд нь санхүүжилтийн хувьд асар өндөр өртөгтэй бөгөөд үүнийг төр дангаар санхүүжүүлэх боломжгүй тул хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг зайлшгүй шаарддаг. Гэвч санхүүжилтийн дүнгээс хамаарч хөрөнгө оруулагч орж ирэхэд хүндрэлтэй төслүүд төслүүдэд төрөөс тодорхой хэсгийг санхүүжүүлэх шаардлага үүсдэг ээ. Энэ тохиолдолд төрийн санхүүжилттэй холбоотойгоор эрчим хүчний төслийг хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах зайлшгүй шаардлага үүсэж байна аа.

Тухайлбал төрөөс төслийн тодорхой хэсгийг нь санхүүжүүлээд үлдэх төлбөрийг нь тухайн станцын үйл ажиллагааны орлогоос нь буцаан төлөх И Пи Си нэмэх нь F буюу нөхцөлтэй сонгон шалгаруулалт хийх боломж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон

Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулиудаар харилцааг зохицуулах боломжгүй байна аа.

Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн өнөөгийн зохицуулалтын хүрээнд сонгон шалгаруулах тохиолдолд И Пи Си нэмэх нь F буюу барих шилжүүлэх төслийг хэрэгжүүлэхийг хориглосон түншлэлийн бусад хэлбэрээр шалгаруулах бол 36-48 сарын хугацаа шаардагдах нөхцөл байдалтай байна. Мөн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиар түлхүүр гардуулах нөхцөлтэй буюу инженеринг, прокурмент, констракшн гэрээгээр сонгон шалгаруулалт зарлах боломжгүй болсон. Нөгөө талаас И Пи Си нэмэх Файнэнсинг төслийн санхүүжилтийн зарим хэсгийг гүйцэтгэгч нь санхүүжүүлэх нөхцөлтэй бол Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээг худалдан авах тухай хуулиар тендер сонгон шалгаруулалт зарлах боломжгүй байна аа.

Иймээс төрийн болон орон нутгийн өмчид эзэмших эрчим хүчний томоохон төслүүдийг яаралтай хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчныг бий болгох шаардлагын хүрээнд Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, түүнтэй уялдуулан төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсрууллаа.

Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд эрчим хүчний төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах эрх, сонгон шалгаруулалтын нөхцөл шаардлагыг тогтоох харилцааг зохицуулна аа. Сонгон шалгаруулалтыг эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ ээ. Сонгон шалгаруулалт хийх ажлын хэсэгт тавигдах шаардлагыг хуулийн төсөлд тодорхойлсон ба энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан үнэлгээний хороотой ижил нөхцөл шаардлага хангасан гишүүдтэй байна аа. Түүнчлэн түлхүүр гардуулах нөхцөлөөр сонгон шалгаруулалт хийхтэй холбоотойгоор туслан гүйцэтгэгчийн чадавхын үнэлгээнд тооцох асуудлыг хуулийн төсөлд тусгалаа.

Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, төсөл сонгон шалгаруулах замаар эрчим хүчний эх үүсвэр барих этгээдийг тодорхойлж байгаа бөгөөд үүнтэй холбоотойгоор хувийн хэвшилтэй хамтран ажиллах хүрээнд Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж байна аа. Сонгон шалгаруулалтад тэнцсэн төсөл хэрэгжүүлэгчтэй гэрээ байгуулах харилцааг Төр хувийн хэвшлийн тухай хуулиар зохицуулах бөгөөд нэгэнт шалгаруулалт хийсэн төслийн хувьд төр хувийн хэвшлийн түншлэлийн хуулийн процессыг хялбаршуулах, сонгон шалгаруулж гэрээ байгуулах хугацааг богиносгох харилцааг зохицуулахаар тусгалаа.

Мөн төрийн болон орон нутгийн өмчид эзэмших эрчим хүчний төслүүдийн хувьд төслийн санхүүжилтийн хэлбэр төрийн оролцооноос хамаарсан И Пи Си менежмент хийх, санхүүжүүлэх, барих, ашиглах, шилжүүлэх, барьж шилжүүлэх менежмент, санхүүжилт болон барих шилжүүлэх төрөл юу төрлүүдийг зайлшгүй нэмэх шаардлагатай байна аа.

Дагаж гарах хуулийн төслөөр Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа. Тодруулбал эрчим хүчний үнэ тарифыг төрөөс хянаж ирсэнтэй холбоотойгоор төрийн өмчит ААН-үүд алдагдалтай ажиллаж ирсэн бөгөөд Засгийн газрын баталгааны шаардлагыг хангаж чадахгүй байх нөхцөл байдалд байна аа. Мөн эрчим хүчний барилга байгууламжийн төсөл нь түлхүүр гардуулах буюу инженеринг, прогурмент, констракшн хэлбэрээр хэрэгждэг бөгөөд төслийн нарийвчилсан зураг төсөл нь төслийн явцад хийгддэг ээ. Хэрэв Өрийн удирдлагын тухай хуулийн одоогийн зохицуулалтын дагуу нарийвчилсан зураг төслийг урьдчилан хийх тохиолдолд технологи болон үйлдвэрлэгчийг урьдчилан сонгож, өрсөлдөөнийг хязгаарлах, маш өндөр зардал гаргаж зураг төслийг урьдчилж хийх зэрэг үр дагавар гарахаар байна аа.

Иймд хуулийн өөрчлөлтөөр эрчим хүчний төслийн хувьд гаргах Засгийн газрын өрийн баталгааны хувьд тавигдах шаардлагыг өөрчилж, нарийвчилсан зураг төсөв шаардагдахгүй байх, шаардахгүй байх, сүүлийн 3 жил ашигтай ажилласан байх шаардлагыг бууруулж төсөл нь санхүүжилтээ эргэн нөхөх санхүүгийн тооцоотой байхаар хуульд нэмэлт оруулах саналыг боловсрууллаа.

Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар төр, хувийн хэвшил, хөрөнгө оруулагчдад идэвхтэй хүчин зүйлд тулгуурлан эрчим хүчний эх үүсвэр шинээр барьж байгуулна. Эрчим хүчний үйлдвэрлэл, найдвартай байдлыг дээшлүүлэх төрийн бодлогыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдэх ба сонгон шалгаруулалтад оролцогчид нь эрчим хүч нийлүүлэх үнэ, хэмжээ, станцыг төрд хүлээлгэн өгөх хугацаагаар харилцан өрсөлдөж хамгийн сайн үнэлгээтэй төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах юмаа.

УИХ-ын дарга, УИХ-ын эрхэм гишүүд ээ,

Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье ээ. Анхаарал тавьсанд баярлалаа.

Х.Булгантуяа: Төслүүдийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал дүгнэлтийг УИХ-ын гишүүн Шинэбаярын Бямбасүрэн танилцуулна аа. Индэрт урьж байна.

Ш.Бямбасүрэн: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 6 дугаар сарын 26-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2025 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцэх үед УИХ дахь АН-ын бүлгээс бүлгийн зүгээс тухайн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан 5 хоногийн завсарлага авсан бөгөөд 2025 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн үдээс хойш завсарлагын хугацаагаа дуусгаж, хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцлээ.

Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар эрчим хүчнийг либералчлах төрийн бодлогыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдэх ба эрчим хүчний төслийг эрчим хүч нийлүүлэх үнэ, эрчим хүчний эх

үүсвэрийг төрд нийлүүлэх хугацаа, нийлүүлэх хэмжээ зэргээс хамаарч сонгон шалгаруулах боломж бүрдэнэ гэж төсөл санаачлагч үзжээ.

Түүнчлэн төсөл сонгон шалгаруулалтыг санхүүгийн хувьд бүрэн бололцоотой оролцогчдыг үнэлэх замаар хэрэгжүүлэх тул эрчим хүчний гацсан олон төслийг хөдөлгөх бодитой нөлөөлөл үзүүлэх бөгөөд энэхүү хуулийн төсөл батлагдсанаар Засгийн газраас хэрэгжүүлэх мега төслүүдийг хөдөлгөх суурь нөхцөл болж, цаашид улс орны нийгэм, эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх ба үүнийг дагаад ажлын байр нэмэгдэх, иргэдийн ая тухай амьдрал хангагдах боломж бүрдэнэ ээ гэж уг хуулийн төслийг боловсруулсан байна аа. Хуулийн төслийг Ди.парламент.мн цахим сайтад байршуулж, иргэд олон нийтийн саналыг авсан байна.

Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед УИХ-ын гишүүн П.Сайнзориг эрчим хүчний эх үүсвэрүүдийн насжилт, найдвартай ажиллагаа, Таван толгойн станцыг барьж байгуулах ажлын талаар, Дулааны 3 дугаар цахилгаан станцад гарсан ослын улмаас үүсэж болох эрсдэл авах хариу арга хэмжээний талаар Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа ажлын явцын талаар, УИХ-ын гишүүн Алдаржавхлан уг хуулийн төслийг баталснаар эрчим хүчний бүх худалдан авалт тендерийг ЭХЯ төвлөрүүлж, зохион байгуулах эсэх, эрчим хүчний төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн орон тооны талаар, УИХ-ын гишүүн Мандхай уг хуулийн төслийг ямар төсөл хөтөлбөр дээр хэрэгжүүлэх тариф хязгаарлалтын асуудлын талаар, УИХ-ын гишүүн Ж.Ганбаатар Дулааны 3 дугаар цахилгаан станцын үйл ажиллагаа хэвийн ажиллаж эхлэх хугацааны талаар, УИХ-ын гишүүн Сэддорж дотоодын эрчим хүчний мэргэжилтнүүдийн чадавх, дотооддоо эрчим хүчийг үйлдвэрлэх хүчин чадлын талаар, шинээр барьж байгаа цахилгаан станцын санхүүжилтийн талаар асуулт асууж хариулт авлаа.

Мөн УИХ-ын гишүүн Бадамсүрэн Эрчим хүчний тухай хуулийн тодорхой зүйл дээр хязгаар, тааз тавьж батлах, экспортын чиглэлийн эрчим хүчний үйлдвэрийг дэмжих талаар, УИХ-ын гишүүн Энхцэцэг эрчим хүчний эх үүсвэрүүдийг олноор барьж байгуулах талаар хуулийн төслийг дэмжиж саналаа илэрхийлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулахад Эрчим хүчний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 92.9 хувь, Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 92.9 хувь, Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт өөрчлөх тухай хуулийн төслийг 100 хувийн саналаар тус тус хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, хуулийн төслүүдийг УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

УИХ-ын эрхэм гишүүд ээ,

Эрчим хүчний тухай хуульд нэмэлт өөрчлөх тухай хуулийн төсөлд болон хамт өргөн мэдүүлсэн Төр хувийн хэвшлийн тухай хуульд нэмэлт өөрчлөх тухай хууль оруулах тухай, Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх талаар Эдийн засгийн байнгын хорооны санал дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Х.Булгантуяа: Ажлын хэсгийн гишүүдийн нэрсийг танилцуулъя. Эрчим хүчний сайд Баттогтохын Чойжилсүрэн, Батмөнхийн Ерэн-Өлзий ЭХЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын дарга бөгөөд ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Гансүхийн Эрхэмбаяр ЭХЯ-ны Гэрээ эрх зүйн газрын дарга, Баяртогтохын Нямсүрэн ЭХЯ-ны Гэрээ эрх зүйн газрын ахлах мэргэжилтэн, Буянтогтохын Нямаа эрчим хүчний сайдын орон тооны зөвлөх гэсэн ийм ажлын хэсэгтэй байна аа.

Одоо УИХ-ын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилсан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууж, хариулт авна аа. Нийтдээ 8 гишүүн нэрсээ ирүүлсэн байна. Ирцээр дугаарлаад УИХ-ын гишүүн Даваагийн Цогтбаатар. Цогтбаатар гишүүн байхгүй байна. УИХ-ын гишүүн Нанзадын Наранбаатар. Хүлээж байгаарай. Даваагийн Цогтбаатар гишүүн. УИХ-ын гишүүн Даваагийн Цогтбаатар.

Да.Цогтбаатар: Та бүхэнд оройны мэнд хүргэе ээ. Эрчим хүчний энэхүү хуулийг нь болбол дэмжиж байгаа. Гэхдээ энэ дотор асуух хэдэн тоо байгаа сайд аа. Эрчим хүчний одоо энэ мэргэжлийн байгууллагууд болох дулааны станцуудын ажиллах хүчний харьцаатай холбоотой асуудал байгаа. Өнгөрсөн 7 хоногт нэг албан бичгээр ирчихсэн явж байхтай нь би танилцсан юм. Инженер техникийн ажил чинь 30 хувь, одоо энэ УБЦТС 2, 3, 4 тэгээд системийнх нь хэмжээнд харьцуулаад үзсэн тоо ч гэсэндээ 70:30-ын харьцаатай байна лээ. Яг инженер техникийн ажилтан 30 хувь, бусад ажилчид буюу одоо тэр захиргааны ажилтан ч гэдэг юм уу тэд нар нь 70 хувь.

Иймэрхүү байдлаар энэ төрийн албан хаагчийн тоо шаардлагагүй орон тоон дээр нэмэгдэж явсаар байгаад яг ажлаа хийж байгаа нарийн мэргэжлийн тэр төрийн албан хаагчдын нэр хүндэд халдах, тэдгээрт очих цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй байх тэгээд энэ системийн нэр хүндийг унагаах эрсдэлтэй ажлууд байгаад байна аа. Энэ дээр одоо яг сайдынхаа хувьд та сая энэ 14400 төрийн албан хаагчийг цомхотгоно гээд байгаа дээр та ямархуу байдлаар саналаа өгсөн бэ? Энэ 70:30 гэдэг харьцаа эсрэгээрээ байх ёстой юу. Яг ингээд нэг 70:30 гэдэг алдагдчихсан харьцаатайгаа явах ёстой юу? Энэ дээр та нэг тодруулга өгөөч?

Х.Булгантуяа: Даваагийн Цогтбаатар гишүүний асуултад Чойжилсүрэн сайд хариулъя.

Б.Чойжилсүрэн: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Та бас зөв зүйтэй санал, зөв зүйтэй сэдвийг хөндөж байна аа. Би 2022 оны 8 сард Эрчим хүчний сайдаар анх удаа томилогдсоноос хойш салбарын үйлдвэр компаниуд дээр очиж яг энэ асуудлын зохистой харилцаа, илүүдэж байгаа албан тушаалуудыг бууруулах гэдэг шаардлагыг тавиад явж байгаа юм. Бага багаар бууж байгаа. Яг хүссэн хэмжээний үр дүн бас яг өнөөдрийн байдлаар гараагүй байхыг үгүйсгэхгүй. Тийм учраас одоо 6 сарын 10-ны өдрөөс эхлээд ЭХЯ эрчим хүчний салбарын ТӨК-иудын 66 хувийг нь менежмент юу хувьцааны эрхийг хэрэгжүүлж байгаа, 34 хувь дээр нь Эрчис Монгол компани хэрэгжүүлэх ийм шийдвэр гарч байгаа юм.

Эрчис Монгол компани ЭХЯ бид нар юу сая сүүлийн уулзалтаар болбол ямар ч байсан энэ төрийн ТӨК-иудын бүтцийг оновчтой болгоё оо, илүүдэл тэр захиргааны албан хаагчдын тоог гаргаж ирээд бууруулах арга хэмжээг нь 3 дугаар улиралдаа багтаагаад хийе гэдэг ийм тохиролцоотой явж байгаа. Нэмээд тодорхой

хэмжээний төр ажилчдад бол буух байх. Захиргааны эрх хэрэгжүүлж байгаа. Яг үйлдвэрлэлийн фронт дээр ажиллаж байгаа ажилчдын хувьд болбол дутагдалтай байгаа ийм байна.

Х.Булгантуяа: УИХ-ын гишүүн Нанзадын Наранбаатар.

Н.Наранбаатар: Бид ер нь эдийн засгаа тэлж эдийн засгаа солонгоруулахгүй бол ер нь явахгүй нь ээ. Ганцхан ашигт малтмал түүнийхээ дотор нүүрснээс хамаарсан эдийн засагтай, нүүрсний үнэ нь унахаар зэрэг улс орноороо ингээд төрийн албан хаагчдаа ч хална, төсвөө ч танана гээд ингээд сууцгаачихдаг. Тэгээд эдийн засгаа тэлэхэд хамгийн чухал асуудал бол энэ эрчим хүчний асуудал. Хоёрт нь, усны асуудал. Эрчим хүчгүй, тог цахилгаангүй, тэгээд усгүй болбол энэ цаашаагаа бидний яриад байгаа тэр эдийн засгаа тэлэх, аялал жуулчлалаа хөгжүүлэх ХАА-н бүтээгдэхүүнээ боловсруулах, газар тариалан гээд бүх юм явахгүй. Энэ хоёргүйгээр энэ 2-ын тэгээд томоохон төслүүдээ цааш нь явуулах гэж одоо ЭХЯ-наас оруулж ирж байгаа энэ хуулийн төслийг бол одоо миний хувьд дэмжиж байгаа.

Говийн бүсэд Таван толгойн ДЦС 450 мвт-ын тэгээд энэ маань одоо хэчнээн жил одоо маргав, гацав. Тэгээд жил болгон Оюу Толгой компани хамгийн наад зах нь 140 сая ам.долларыг Хятад руу өгөөд ингээд л байж байгаа. Тэгээд Өмнөговь нь өөрөө эрчим хүчний хомсдолтой, зарим сумдууд нь гаднаас Хятадаас импортолдог. Уул уурхайн гол бүс нутаг нь үйлдвэр боомт нь гаднаас авдаг гээд нэг ийм байдалтай. Аймгийн төв нь дулаан эрчим хүчний хомсдолтой. Одоо ингээд 50 мвт-ын ДЦС барихаар зураг төсөв ТЭЗҮ-гээ хийгээд ингээд байж байгаа. Тэгээд тээг болоод байгаа зүйлүүд бол байгаа. Тухайлах юм болбол энэ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар бараа, ажил үйлчилгээ худалдаж авах тухай хууль буюу тендерийн хууль гээд бид нарын хэлж заншсанаар. Үгүй ээ зарим нэг юман дээр энэ ялангуяа энэ 14 мега төсөл томоохон юман дээрээ энэ хуулиасаа өөрөөр явахгүй бол үнэхээр болохоо байчихсан юм байна аа. Тэгээд энэ хуулиар явна гэхээр зэрэг л одоо хугацаа алдаад л ингээд 10, 20 жил. Тэгээд л одоо төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд орон нутаг концесс гаргаад ингээд одоо ажлаа хийе, бүтээн байгуулалтаа хийе гэхээр ингээд энэ хууль нь гацаачих цаг хугацаа алдах юм.

Тэгэхээр зэрэг энэ Эрчим хүчний хуульд оруулж ирж байгаа энэ өөрчлөлтийг зайлшгүй одоо бид нар аль эсвэл бол бусад зөвхөн эрчим хүч гэхгүй бусад төслүүд байгаа шүү дээ. Бусад усны болон бусад төслүүдээ нэгмөсөн явуулъя гээд төрийн болон орон нутгийн өмчийн хуульд өөрчлөлт оруулж оруулаад ирж болоогүй юм уу? Яагаад ганцхан эрчим хүч гээд ингээд давуу үзэж байгаа юм бэ гэдгийг нэг тодруулаадахъя.

Хоёрт гэвэл Чойжилсүрэн сайд аа, энэ сэргээгдэх эрчим хүч чинь их чухал шүү дээ. Ялангуяа энэ говийн бүсэд юу л байна нар байна, юу л байна салхи байгаа шүү дээ. Тийм учраас энэ сэргээгдэх эрчим хүчний төсөл хэрэгжүүлчихье гэсэн одоо ААН-үүд олон байгаа шүү дээ. Тэгээд энэ яамнаас яагаад тэр тусгай зөвшөөрлийг нь өгөхгүй байгаа юм. Маш олон ААН, иргэд энэ ажлыг хийчихье гээд гээд яваад байдаг. Яам дээр очоод тусгай зөвшөөрөл нь олгогдохгүй байна гээд гацчихаад байх юм. Энэ чинь говийн бүсийн зөвлөгөөн дээр энэ сэргээгдэх эрчим хүчийг ярина гээд л учиргүй их бид нар ярьсан. Засгийн газрын мөрийн хөтөлбөр 14 мега төсөл дээрээ сэргээгдэх эрчим хүчийг одоо байгальд ээлтэй хоргүй нүүрсээр

ажилладаггүй, дэлхий нийт одоо нүүрс агаарын бохирдол яриад байдаг, сэргээгдэхээ дэмжье гэж ярьж ярьчаад тэгээд одоо энэнийхээ тусгай зөвшөөрлийг нь өгөхгүй, тэгээд одоо хийгдсэн олигтой юм байхгүй. Өмнөговьд нэг 50 мгвт-ын, Дорноговьд нэг 50 мгвт-ын, Төв аймагт нэг 50 мгвт-ын сэнс л байгаа. Тэгээд еще дорвитой төсөл хэрэгжсэн юм байхгүй. Олон жил болчихлоо шүү дээ. Тэгээд энэ дээрээ яагаад өгөхгүй байгаа юм гэдэг одоо шалтгаанаа бас та хэлмээр байх юм.

Ер нь сэргээгдэх барих гэж байгаа, хийх гэж байгаа хүмүүс ер нь цаашдаа ирээдүй байгаа юм уу, үгүй юм уу гэдэг дээр та бас яамныхаа бодлогыг хэлчихмээр байх юмаа. За тэгээд тодруулъя.

Х.Булгантуяа: Чойжилсүрэн сайд хариулъя.

Б.Чойжилсүрэн: Наранбаатар гишүүний асуултад хариулъя аа. Дэмжиж байгаад баярлаж байна. 2 дугаарт хоёр асуултад хариулъя аа. Яагаад тендерийн хуулийг оруулж ирээгүй юм бэ. Эрчим хүчний хуулиар тендер зарлах гээд байгаа юм бэ гэдэг асуулт тавьж байх шиг байна. Тендерийн хуулийг Засгийн газар дээр боловсруулж байгаа. Улс ардын аж ахуйн бүх салбарыг хамрах учраас тендерийн хуулийн судалгаа бас тодорхой хэмжээний цаг авах шаардлагатай байгаа учраас эрчим хүчний салбарын хувьд тулгамдсан асуудал чадлын дутагдалд орчихсон байгаа учраас энэ эрчим хүчний төсөл байгууламжуудыг болбол Эрчим хүчний хуулиар явуулъя гэдгийг Засгийн газар дээр тохиролцоод, ойлголцоод, Эдийн засгийн хөгжлийн сайд болон Сангийн сайдтайгаа ойлголцоод энэ асуудлыг оруулж ирж байгаа юм нэг.

Хоёр дахь нь Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд ийм хүндрэлүүд бий. Анх 2006 онд Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль батлагдсан. Түүнээс хойш 38 ширхэг тусгай зөвшөөрөл олгогдсон юм байна лээ. 2019 оныг хүртэл. Тэрнээс 10 сэргээгдэх эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигч станцаа бариад, сүлжээнд холбогдчихсон байгаа. Цаана нь хүчинтэй байгаа 11 орчим тусгай зөвшөөрөл эзэмшигч бий. Эдгээр тусгай зөвшөөрөл эзэмшигч нартаа урьд нь хэрэгжиж байсан хуулиараа 1 квт цаг эрчим хүчний үнийг 15 центээс 19 центээр байгуулах ийм өндөр нөхцөлтэй байгаа юм. Энэ санхүүгийн хувьд өндөр хүндрэл дагуулж байгаа юм.

Түүнээс гадна техникийн хувьд нэг айхтар том хүндрэл бий. Яагаад гэвэл энэ нар ороод эсвэл салхи зогсчих юм болбол сэргээгдэх эрч юу төслүүд маань эрчим хүч үйлдвэрлэж чадахгүй байгаа. Энэ хэмжээний чадлыг бид нар төр юу эгшин зуурт одоо маневрлах чадвартай газар станц юм уу, усан станцын хүчин чадал байхгүй учраас энэ асуудлыг болбол бид нарт юу явуулж чадахгүй ийм хүндрэлүүд бий. Харин өнгөрсөн 2024 оны 2 дугаар хагасаас эхлээд сэргээгдэх эрчим хүчний салбарт бас бараг хувьсгалын гэж хэлж болохуйцаар нэг ийм шийдвэр гарсан нь батарей хураагуурын станцын өртөг бууж эхэлсэн. Одоо батарей хураагуурын станцыг өөрөө нарны станц барьчаад барьж цэнэглэхээд, зөвхөн батарей хураагуураас нь төвийн сүлжээнд холбох юм болбол 10 цент орчмоор нийлүүлэх бололцоотой ийм техникийн шийдэл 2024 оны 2 дугаар хагаст дэлхийн сэргээгдэх эрчим хүчний салбарт ийм үнийн өөрчлөлтүүд буусан.

Тэгэхээр бид нар энэ ЭХЯ дээр нэг 400 орчим мгвт 4 цагийн туршид буюу 1600 мгвт цагийн хүчин чадалтай нэг төслүүдийг хэрэгжүүлэхээр хөрөнгө оруулагчийг олж байна. Энэ төсөл амжилтыг хэрэгжүүлэх юм болбол Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн дагуу 2019 оноос хойш орсон өөрчлөлтийн дагуу

тендер зарлаж эхэлнэ. Тендерээр одоо шалгарах юм болбол магадгүй нарны цахилгаан станцын үнэ 3 орчим цент орчим болж буух болов уу гэж ийм одоо хүлээлттэй байна. Манайтай...

Х.Булгантуяа: Чойжилсүрэн сайд нэг нэмж нэг минут өгье.

Б.Чойжилсүрэн: Манайтай ойролцоо бүсэд байгаа энэ Казахстан улс, Узбекистан улсууд дээр болбол нэг 2.7-3.5 центээр нийлүүлэх ийм авагдсан оны үнийн дүнг одоо мэдээллүүд ирээд байгаа. Энэ талаар бол Европын сэргээн босголт хөгжлийн банк нэлээд тийм ач холбогдол өгч хөөцөлдөж байгаа учраас Европын сэргээн босголт, хөгжлийн банк бол бид нарт тийм мэдээлэл өгч байгаа. Тэгэхээр энэ тогтворжуулах техникийн бололцоогоо бүрдүүлсэн тохиолдолд болбол сэргээгдэх эрчим хүчийг болбол жоохон тийм дэмжих бололцоо гарна. Дэлхий ертөнц мэдээж энэ сэргээгдэх эрчим хүчийг болбол нэлээн хөгжүүлээд дэмжье. Байгаль орчинд учруулж байгаа сөрөг нөлөө хоруу чанар бага байгаа учраас энэ дэлхийн хандлагыг бол дагахаас ондоо аргагүй.

Гэхдээ энэ техникийн бололцоогоо хангаж байж энэ шийдлүүдийг хийхгүй болбол яг өнөөдрийн байдлаар бол төвөгтэй байгаа ийм л байна.

Х.Булгантуяа: Наранбаатар гишүүн тодруулъя.

Н.Наранбаатар: Тэгэхээр Өмнөговь аймгийн иргэдийн хурлаар Даланзадгадын 50 мгвт-ын ДЦС-ыг барих зураг төсвийн хөрөнгийн асуудлыг нь шийдээд ингээд бэлэн болсон ТЭЗҮ. Тэгээд хөрөнгийг босгохдоо орон нутгийн концесс гаргаж хийе гэдэг бас шийдвэрийг гаргаад явж байгаа. Тэгээд ер нь болбол энэ эрчим хүчний энэ хуулиараа энэ эрчим хүчний ямар ч хамаагүй одоо энэ нүүрс нь ч бай, сэргээх ч бай, орон нутгийн ч бай бүх төслүүдийг л дэмжмээр байгаа юм. Тэгээд энэ оруулж ирж байгаа энэ хуулиар чинь орон нутгийн одоо саяын энэ 50 мгвт-ын станцыг одоо барихад ямар нөлөө үзүүлэх юм, энэ хууль батлагдсанаараа энэ ажил маань одоо хэрхэн цаашаа явж хэрэгжих боломжтой болох юм гэдэг дээр мэдээлэл авъя аа.

Х.Булгантуяа: Чойжилсүрэн сайд нэмж хариулъя.

Б.Чойжилсүрэн: Наранбаатар гишүүн та бас зөв ойлгосон байна. Энэ хэрвээ энэ хууль энэ 3 хууль батлагдах юм болбол танай аймгийн төв дээр баригдах 50 мгвт-ын хүчин чадалтай цахилгааны хүчин чадалтай 100 мгвт-ын дулааны хүчин чадалтай цахилгаан станцын тендер зарлах эрх зүй бололцоо бүрдэнэ ээ. Одоо байгаа тендерийн тухай хуулиар түлхүүр гардуулах нөхцөл буюу И Пи Си нөхцөлтэй тендер зарлах бололцоогүй болчихсон байгаа. Заавал зурагтай, төсөвтэй байна аа гэсэн ийм шаардлага байгаа юм.

Одоо манай эрчим хүчний салбарт энэ зурагтай, төсөвтэй байна аа гэвэл урьдчилж аль нэг үйлдвэрлэгчийг, аль нэг технологийг сонгож аваад зураг хийнэ. Тэгсэн тохиолдолд болбол ерөөсөө өрсөлдөөн гэж бараг байхгүй болж таарна. Өрсөлдөөнийг шууд өөрөө зураг хийхдээ хязгаарлачхаж байгаа учраас энэ хуулийн төслийг одоо та бүхэн дэмжиж баталбал саяын таны ярьсан төслүүд болон бусад төслүүд хэрэгжих эрх зүйн бололцоотой болж байгаа юм.

Х.Булгантуяа: УИХ-ын гишүүн Цэнгүүн гишүүн байхгүй байна, УИХ-ын гишүүн Жаргалсайханы Золжаргал байхгүй байна. За яана аа уучлаарай.

Ж.Золжаргал: Энэ хуулийн төслөөр эрчим хүчний төсөл хэрэгжүүлэхийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг эрчим хүчний асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн томилно оо. 6.3 буюу сайд одоо нэг ажлын хэсэг томилох нь байна. Тэр нь 5 хүнтэй байна. Тэр 5 хүний хийх ажлууд дотор нэгдсэн сүлжээнд эрчим хүч нийлүүлэх үнэ эрчим хүчний төслийг төрд шилжүүлэх нөхцөл хугацаа болон бусад асуудлуудыг шийдвэрлэнэ ээ гэж орсон байгаа. Агуулгаараа энийг унших юм бол шинэ одоо энэ нүүрсний цахилгаан станцуудын үнийг болбол тэр ажлын хэсэг тохирох юм байна. Тэгээд тодорхой хугацааны дараа төр шилжүүлж авах асуудлыг бас тэр ажлын хэсэг шийдэх юм байна. Тэгэхээр ийм асуулт нь ингэж гарч ирж байна.

Одоо энэ Эрчим хүчний зохицуулах хороо чинь бас нэг хуулийн заалттай. Тарифыг нь тогтоохдоо үйл ажиллагаа явуулах боломжийг хангасан ийм байдлаар тогтооно оо гээд томьёотой. Тэгээд тэд нарын ажил байхгүй болох юм болов уу нэг асуулт. Хоёрт нь энийг ингээд агуулгаар нь харахаар төрд буцааж авах, төрөөс үнийг нь тогтоох гээд нөгөө эрчим хүчний реформ хийнэ гээд ярьсан зүйлээсээ буцаж байгаа алхам мөн үү? Эрчим хүчний реформын үндсэн санаа нь 1 дүгээрт үйлдвэрлэж байгаа өртгөө одоо яах, 2 дугаарт нь салбарын энэ өрсөлдөөнт зах зээл бий болох буюу надад цахилгаан хэрэгтэй байдаг. Нөгөө талд төр дунд нь орчхоод хуваарилах гээд эх үүсвэр байхгүй гээд байдаг. Тэгэхээр тэрний цаана үйлдвэрлэгчдээ би үнээ тохироод нөгөөх нь хоорондоо тохиронгуутаа шууд сүлжээнээсээ авдаг, төр тэрийг нь түгээж дамжуулдаг, тойроод төрийн хувийн хэвшлийн төрөл бүрийн ААН-үүд үйлдвэрлээд нийлүүлээд явдаг ийм байдал руу бид нар орно гэж ойлгосон.

Тийм учраас УИХ-ын даргын захирамжаар Эрчим хүчний хууль эрх зүйн орчныг шинэчлэх сайжруулах ажлын хэсэг гарсан. МАН, АН, ХҮН намаас бусад улс төрийн хүчнүүдээс хүмүүс ороод ажиллаж байгаа. Тэгэхээр агуулга нь энэний яг эсрэг төрөөс шийдсэн, төрөөс үнэ тогтоосон, тэгээд төрдөө буцааж авах ийм агуулгатай хууль орж ирээд байгаа юм. Тэгэхээр энэнтэй холбоотой танаас Чойжилсүрэн сайдаас асуумаар байна. Энэ УИХ-ын ажлын хэсэг гэхдээ ер нь яах юм энийгээ нийцүүлэх юм уу эсвэл ингээд шал хоёр өөр концепц явах юм уу? Та бол бас эрчим хүчний реформ бодлогын шинэчлэлийг бид нар хийх хэрэгтэй гээд яриад байсан. Тэгэхдээ энэ хууль чинь болохоор шинэчлэл биш биз дээ гэдэг ийм асуулт байна. Тэгээд эрсдэлтэй зүйлийг нь бас юу гэж хараад байна гэхээр хэн нэгэн цахилгаан станц бариад тэгээд тэрийгээ өндөр тарифаар нийлүүлээд, урт хугацаанд тэгээд нэг хэдэн жилийн дараа буцаад бүү оруулсан хөрөнгө оруулалтаа зардлаа нэмж байгаад тэр чигээр нь төсөв рүү шахах тэр эрх нь нээгдчих юм биш үү энэ чинь. Тэгээд энэ болбол эрчим хүчний өрсөлдөөнт тарифыг буулгах биш эхлээд үнээ реформ хийнэ гэж байгаад өсгөж аваад дараа нь бүүр том цахилгаан станц шахаж урт хугацаандаа эрчим хүчний үнийг бууруулах боломжийг хаасан өрсөлдөөнт зах зээлийг байхгүй болгосон төрийн төвлөрөл үүссэн юм болчих юм биш үү. Тэгээд Их Хурлын ажлын хэсэгтэйгээ гол нь яаж ажиллах юм бэ гэдгийг сонсмоор байна.

Х.Булгантуяа: УИХ-ын гишүүд ээ, 18 цаг болсон байна. Өнөөдөр үүний дараагаар ахиад 4 асуудал байгаа. Тэгэхдээ одоо харьцангуй гайгүй бидний хувьд

4 тогтоолын нөхцөл байхаар байгаа. Тэгэхээр өнөөдөр асуудлаа хэлэлцэж дуустал хуралдъя аа. Чойжилсүрэн сайд асуултад хариулъя.

Б.Чойжилсүрэн: Золжаргал гишүүний асуултад хариулъя. Ийм юм байгаа юмаа Золжаргал гишүүн ээ. Эрчим хүчний тухай хуулиар эрчим хүчний төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулна аа. Энэ эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж ирж оруулж ирж байгаа энэ хуулийн төсөл дээр одоо бидний ярьж заншсанаар тендерийн тухай, одоо хүчин төгөлдөр байгаа тендерийн тухай хуулийн тендер шалгаруулах бүлгийг зүгээр л одоо байгаа хэмжээнд нь шилжүүлээд биччихсэн байгаа нэг. Та юу тэр тендерийн тухай хууль дээр эрчим хүчний үнэлгээний хороо төсөл шалгаруулах үнэлгээний хороо 5-аас доошгүй гишүүнтэй байна гэдгийг нь яг тэр хэмжээгээр нь аваад суулгасан. Гэхдээ нэг заалт бий. Эрчим хүчний салбарын юу төслүүд өндөр өртөгтэй байгаа учраас зөвхөн нэг яам энэ төслийг сонгон шалгаруулах нь болбол бас авлига янз бүрийн байдалд хөндлөнгийн нөлөөлөлд автах магадлалтай гэж үзсэн учраас энэ юу үнэлгээний хорооны 40-хөн хувийг нь ЭХЯ-наас томилогдоно оо. 60 хувь нь бусад яамдууд юу төр хувийн хэвшлийн төлөөллүүдээс орно оо гэсэн ийм заалт байгаа нэг.

Ингээд Эрчим хүчний тухай хуулиар сонгон шалгаруулалт зарласны дараа Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулиар шалгарсан одоо тендерт оролцогчидтой гэрээ байгуулахын тулд төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай заалтыг оруулаад яагаад энэ дагалдаж оруулж ирсэн юм бэ гэхээр Засгийн газарт танилцуулна аа, ийм тендер зарлаад, ийм юу нөхцөлөөр, ийм одоо ялагч тодорлоо, гэрээ байгуулах уу яах вэ гэдэг асуулт оруулна. Засгийн газар дэмжих юм болбол Засгийн газар дахиад тогтоол гаргана. Бүх яамдуудаас санал аваад Эдийн засгийн хөгжлийн яам, Байгаль орчны яам, Сангийн яам гээд, Хууль зүйн яам гээд бүх яамдуудаас санал аваад Засгийн газар дэмжсэн тохиолдолд гэрээ байгуулах эрхийг шалгарсан одоо тендерт оролцогчтой гэрээ байгуулах эрхийг Эдийн засгийн хөгжлийн сайд болон Эрчим хүчний сайд нарт олгоно оо ийм л заалт байгаа.

Түүнээс биш таны юу та бас танд иргэд сонгогчид чинь иймэрхүү зүйл энд болгоомжлол байна уу, асуу гэж танаар асуулгасан бололтой байна ийм зүйл. 2 дугаарт тэр энэ хууль батлагдсанаас эргэж үйлчлэхгүй ээ. Одоо Таван толгойн цахилгаан станцыг яасан юм бэ гэхээр төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн ийм хабрид санхүүжилтээр явж зарласан 2027 онд. 2 оролцогч орж ирээд хоорондоо маргаад 2 жил гарантай хугацаанд маргаад сая энэ 2025 оны 1 дүгээр сард шүүхийн 3 дахь шатны шийдвэр гараад тендерийг дахин зарла гэдэг ийм шийдвэр гарсан учраас одоо тендер дахин зарлах учиртай. Гэтэл манай одоо байгаа тендерийн хууль дээр И Пи Си нөхцөлтэйг одоо зарлах бололцоо байхгүй учраас өнөөдрийг хүртэл хүлээгээд байгаад байгаа юм. Ийм нөхцөл байгаа юм.

Тэгэхээр одоо янз бүрийн байдлаар энэ төр хувийн хэвшлийн түншлэлүүдийг төрд шахан авна аа гэдэг энэ бололцоо болбол одоо байгаа төсвийн тухай хууль бусад хуулиудаараа хориотой байгаа ямар нэгэн тийм зүйл болохгүй гэдгийг хариуцлагатайгаар хэлье. Энэ бололцоо ч байхгүй гэдгийг хэлье. Ийм байна. Реформоосоо...

Х.Булгантуяа: Чойжилсүрэн сайд нэмэлт нэг минут.

Б.Чойжилсүрэн: Одоо манай Эрчим хүчний тухай хуулиар ийм шүү дээ. Эрчим хүчний төсөл хэрэгжүүлэхээр аливаа хувь хүн компани санал гаргах юм

болбол ЭХЯ-нд хүсэлт гаргаад, ТЭЗҮ-гээ боловсруулаад, манай яамны Шинжлэх ухаан технологийн зөвлөлөөр оруулаад, тэр нь дэмжигдэх юм болбол Эрчим хүчний зохицуулах хороонд тусгай зөвшөөрөл өгөөч гэдэг хүсэлт явуулаад, Эрчим хүчний зохицуулах хороо эрчим хүчний төсөл хэрэгжүүлэх тусгай зөвшөөрлийг олгоод, хүрээд ирэхээр нь техникийн нөхцөлийг нь гаргаад Диспетчерийн үндэсний төвтэй цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ байгуулаад ингээд ажлыг нь эхлүүлэх зөвшөөрлийг өгөөд л явчхаж байгаа Эрчим хүчний тухай хуулиар нээлттэй байгаа юм.

Харин энэ хуулийн төсөл орж ирснээр энэ төсөл хэрэгжүүлэгчдийг хооронд нь аль тааламжтай нөхцөл олгодог сонгон шалгаруулалтаар зарлая гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр тэр эрчим хүчний юу нөхцөлд тэр реформынхоо нөхцөл байдлыг яг таг биелүүлээд, уралдаант сонгон шалгаруулалттай болъё, ил тод байаа. Нэг салбар энийг төслийг хэрэгжүүлдэг асуудлыг уралдаант сонгон шалгаруулалтад оруулчихъяаа гэдэг л ийм л...

Х.Булгантуяа: Золжаргал гишүүн нэмж тодруулъя.

Ж.Золжаргал: За санаа хэлье. Төрд буцааж авах асуудлыг нөхцөлийг шийдвэрлэнэ ээ. Хугацааг гээд заалт орсон байгаа юм. Төрд буцааж авах, төрд цахилгаан дахиад үйлдвэрлэх гээд байна шүү дээ. Тэгээд үнэ нь тэнд орж ирнэ. Тэгээд нөгөө өрсөлдөөнт зах зээл олон эх үүсвэр чинь агуулга нь зөрөөд байна. Одоо нөгөө энэ Их Хурлын ажлын хэсгийн ажиллаж байгаа үндсэн зарчмаас. Тийм учраас энэ чинь буцаад урт хугацаандаа эрчим хүчний үнийг буулгах нээлттэй болгохын чинь эсрэг болчихоод байгаа юм биш үү гэдэг тэр танай зөвлөлд байгаа юм. Тэгээд би дахиад нэг зүйл нэмж хэлмээр байна.

Ер нь бид нар ингээд ямар нэгэн юмыг хийхдээ бодлого яриад өөрчилнө гэххээд яг ийм асуудал яаралтай тулгарч байгаа учраас одоо ийм юм хийнэ ээ гээд өөр зүйл оруулж ирдэг. Одоо энэ эрчим хүчний хууль дээр жишээлбэл тэр алт 3-ын хөтөлбөр үнэхээр шаардлагатай байгаа. Гэтэл хажуугаар нь...

Х.Булгантуяа: Эрчим хүчний сайд нэмж хариулъя.

Б.Чойжилсүрэн: Золжаргал гишүүн ээ. Ийм юм. Амьдрал их өөрөө баян юм. Зарим хөрөнгө оруулагч нар байна. Та нар тэгээд төрд монгол тал нэг 30 хувиа гаргачихаа, 20 хувиа ч юм уу, зарим нь 40 хувиа ч гаргачих. Бид нар дутагдаж байгаа санхүүжилтийг чинь гаргаад, зээлийг нь олж ирээд станцыг чинь бариад та нарт юу бариад өгье өө, 4 жил, 5 жил, 6 жилийн хугацаанд та нар бидний юу авчирсан зээлийг хүүгийн хамт төлчих өө гэдэг ийм нөхцөл байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ ийм нөхцөлтэй хөрөнгө оруулж байгаа, оруулах юу бодолтой байгаа хөрөнгө оруулагч нарын дунд л хамгийн тааламжтай нөхцөлийг сонгох уралдаанд сонгон шалгаруулалт зарлах гэж л ийм зүйл хийгээд байгаа юм.

Түүнээс биш таныд яг нарийвчлаад унших юм болбол тийм төрд буцааж авах тухай ийм асуудал биш. Төрд хүлээлгэн өгөх хугацаагаар ярьж байгаа байхгүй юу. Буцааж авах биш.

Х.Булгантуяа: УИХ-ын гишүүн Мөнхчулууны Энхцэцэг.

М.Энхцэцэг: Сайн байцгаана уу та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Ингээд эрчим хүчний хуульд төр хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар эх үүсвэр барих ийм хуулийн өөрчлөлт бол орж ирж байгаа. Тэгээд бид бүхэнд нэг зүйл маш ойлгомжтой байгаа. Юу гэхээр эрчим хүчний эх үүсвэрүүдийг барих одоо зайлшгүй шаардлагатай байгаа. Гэтэл одоо бусад хууль буюу одоо тендерийн хууль, тэр төр хувийн хэвшлийн хуулиуд дээрх заалтуудаас болоод энэ одоо олон төлөвлөгдсөн Таван толгойн ДЦС, Улаанбаатар хотын 5 дугаар цахилгаан станц гээд ингээд маш олон станцуудыг бид нар барьж чадахгүй байгаа учраас яалт ч байхгүй одоо ингээд эрчим хүчний хуульд өөрчлөлт оруулж, энэ төслүүдийг зарлаяа гэсэн ийм байдлаар орж ирж байгаа. Тэгэхээр энийг зарчмын хувьд бол дэмжиж байгаа.

Гэхдээ энэ нөгөө өөрчлөлт дээр маань орж ирж байгаа заалтууд маань нэлээн олон эрсдэлүүдийг дагуулах байна аа гэдгээр бид нар Эдийн засгийн байнгын хороон дээр нэлээн яриад энэ зөвшилцөлд хүрсэн байгаа. Бас ингээд тодорхой хэмжээний энэ эрсдэлүүдийг бууруулах заалтуудыг одоо оруулж өгөхөөр ажлын хэсэг байгуулъя гэж ярьсан тохирсон байгаа. Тэгээд би яг одоогоор нэг ийм 3 асуултыг Чойжоо сайдаас асууяаа гэж бодож байна л даа.

1 дүгээрт энэ төр, хувийн хэвшлээр барьсан станцыг тэр одоо хувийн хэвшлийн 70 хувийн хөрөнгө оруулалтыг хүүтэй нь төлөөд ингээд станцыг буцаад төрд одоо ингээд шилжүүлэх энэ заалтыг өөрчилж болох уу, заавал одоо төр шилжүүлэх ямар шаардлагатай юм бэ ээ, яагаад гэвэл бид нар чинь ингээд нэг ийм төрийн өмчтэй үйлдвэрийн газрууд маань тэртээ тэргүй одоо ингээд олигтой ажиллахгүй байна аа гэдгийг маш сайн мэдэж байгаа. Тэгэхээр ийм компаниудынхаа тоог өсгөх шаардлага байхгүй байна аа. За яах вэ тэр одоо улс нь болохоор ингээд л 30 хувийн хөрөнгө оруулалттай л байна биз. Тэр хувь нь 70 хувийн хөрөнгө оруулалттай л байна биз. Тэгээд тэр менежментийн хувь нь ингээд цааш нь аваад явах юм бол харин нөгөө хувийн хэвшлийн оролцоо маань нэмэгдээд цаашаа нөгөө өрсөлдөөн зах зээл рүү чинь нэлээн сайн явах юм биш үү гэсэн ийм 1 дүгээр асуулт байна.

2 дугаар асуулт болохоор нүүрсний станцад хөрөнгө оруулах оролцогч одоо ер нь олдохоо больсон. Тэр утгаараа энэ тендер дээр оролцогчийн тоо бол маш бага орж ирнэ. Тэгэхээр оролцогчийн тоо бага учраас ерөнхийдөө өндөр тарифтай орж ирэх магадлал маш өндөр байгаа. Тийм учраас энэ дээр одоо ер нь бол олон улсад ийм дефальт үнэ юу гэдэг юм дээд үнэ гэж тавьж өгдөг. Өөрөөр хэлбэл одоо 7 центээс доошоо л та нар одоо өрсөлд өө гэсэн ийм байдлаар бол бүүр зарим улсуудыг судалж байхад бол хуульдаа хүртэл оруулчихсан байдаг юм байна лээ. Тэгэхээр тийм одоо үнийг тавьж өгөх бас боломж байна уу гээд 2 дугаар асуулт.

3 дугаар асуулт болохоор энэ 5 хүн ерөнхийдөө тендер шалгаруулаад ингээд цаашаа явахаар байгаа. Тэгэхээр нэг талаараа энэ 5 хүнээ маш одоо эрсдэлд оруулж байгаа байхгүй юу. Тийм учраас энэ эрсдэлийг бууруулахын тулд дор хаяж одоо 9 хүнтэй байлгах, дээрээс нь тэр 9 хүн дээрээ одоо эдийн засгийн байнгын, Эдийн засгийн одоо яам, тэр Сангийн яамнаас нь ч юм уу оруулаад ядаж нөгөө нэг цөөхөн хүн одоо нөлөөлөлд орох магадлал маш өндөр. Мэдээж нөгөө арай жоохон олон тоотой хүн болчихвол нөлөөлөлд өртөх магадлал нь бага учир эрсдэлийг багасгах учраас ингээд хүний тоог бас ингэж ихэсгэж өгвөл зүгээр юм болов уу гэсэн ийм 3 асуултыг асууяаа.

Х.Булгантуяа: Чойжилсүрэн сайд хариулъя.

Б.Чойжилсүрэн: Энхцэцэг гишүүний асуултад хариулъя аа. Одоо Таван толгойн цахилгаан станцын тендер зарлаад сая хүчингүй болсон нөхцөл маань юу вэ гэхлээр төр 30 хувийг нь гаргачихъя аа, 70 хувийг нь И Пи Си гэрээг хэрэгжүүлэх ялагч маань 70 хувийнхаа зээлийг босгож ирээд 3 жилийн дотор бариад, барьснаас хойш ашиглалтад орсноос хойш 5 жилийн дотор тэр 70 хувийн зээлийг хүүгийн хамт төлөөд юу төлөөч гэдэг ийм одоо нөхцөлтэй тендер зарласан юм. Шууд станц ашиглалтад орунгуутаа төрийнх байна гэдэг ийм нөхцөлтэй байгаа юм.

Таны ярьж байгаа санал болбол төрд шилжүүлэхгүйгээр хувьд нь цаашаа аваад явж болох уу гэдэг ийм өөрчлөлт хийж болох уу гэсэн ийм асуулт байна. Яг энэ талаар болбол бид бодсонгүй ээ. Би бол жишээлбэл Улаанбаатар хотын ТЭЦ одоо 2-ын суурин дээр баригдах гэж байгаа ТЭЦ 5 станцыг заавал төрд байгаасай гэж бодож байгаа. Улаанбаатар хотын дулааны хангамжийн асуудлыг бүр ийм 2, 3 дүүргээр нь дамнуулаад хувийн салбарт өгчих юм бол тодорхой хэмжээний эрсдэл үүсэхийг үгүйсгэхгүй. Булган аймагт одоо жишээ байна. Хувийн компани дулааны станц барьчхаад яг явж байгаад нэг өвлийн улирал 12 сард юм уу, 1 сард үнээ 30, 40 хувь, заримдаа 40 хувь огцом нэмээд ийм хүндрэлтэй асуудлууд үүсчихсэн маргаан үүсчихсэн асуудал бий.

Тийм учраас нэн ялангуяа энэ хотын төвд баригдах ТЭЦ 5-ыг болбол би шууд төрийн өмчид байгаасай гэж бодож байгаа. Оруулсан хөрөнгө оруулалтаа нөхчих юм болбол магадгүй цахилгаан эрчим хүчний үнэ 2 цент рүү бууна аа. Магадгүй нэг 5 жилийн дараа ашиглалтад орсноос хойш 6 жилийн дараа оруулсан хөрөнгөө нөхчихсөнийхөө дараа ийм хямд эх үүсвэр төрд байхгүй болбол бид нар нөгөө жигнэсэн дунджаар нь одоо ТЭЦ 4-өөс бид нар жишээлбэл нэг 2.5 центээр л сүлжээнд нийлүүлээд дундаж цахилгаан эрчим хүчний үнэ энэ өртгийг 285 төгрөг дээр барьж байгаа шүү дээ. Тэгэхгүй болбол яг шинээр станц барих юм болбол одоо энэ 0 зууны, бараг 0.9 центээр сүлжээнд нийлүүлчих гээд байгаа учраас энэ хоёрыг дундчилж байж тодорхой хэмжээний гайгүй өртөгтэй ийм цахилгаан эрчим хүчийг болбол хэрэглэгчдэд нийлүүлэх нэн ялангуяа ахуйн хэрэглэгч талдаа өртгийг буулгахын тулд төрийн оролцоог бол бүрэн хааж хэрэггүй. Төр нь ч оролцоод явж байг. Хувь нь одоо янз бүрийн байдлаар хувийн салбар нь эрсдэлд орсон тохиолдолд төр талаасаа энийг бас сэлгэн залгадаг, орлодог ийм зохистой харилцаанд явах юм болов уу гэсэн ийм бодлого барьж байгаа гэдгийг хэлье ээ.

Тэр юу 3 дахь заалт тэр тендер шалгаруулах болбол 5 хүн гэдэг нь болбол энэ одоо байгаа тендерийн хууль дээр Үнэлгээний хороо хамгийн багадаа жижиг тендерүүд дээр 5-аас доошгүй хүнтэй байна аа гэсэн энэ заалтыг оруулсан. Гэхдээ эрчим хүчний салбарын тухайд болбол том станцуудын тухайд нэг...

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

Б.Чойжилсүрэн: Одоо Таван толгойн ДЦС-ын тендерийг бид нар зарлахдаа нэг 21 хүний бүрэлдэхүүнтэй байгаа. Энэний 40 хувь нь ЭХЯ-аасаа, 60 хувь нь болбол дан ганц ЭХЯ гэх биш хувийн салбарынхан, бусад яамдууд, бусад төрийн байгууллагуудын оролцоо, тагнуул, цагдаа, Байгаль орчны яам, Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яам, Хууль зүйн яам гэх мэт ийм яамдуудын төлөөллийг оруулсан ийм л нөхцөл байгаа юм. Тавхан хүн гэдгийг болбол 5-аас доошгүй гэж бичиж оруулж ирсэн. Яг одоо байгаа тендерийн хууль дээр байгаа заалт учраас 5 гэж ойлгож болохгүй гэдгийг бас танд учирлаж тайлбарлая аа.

Д.Амарбаясгалан: Мөнхчулууны Энхцэцэг гишүүн тодруулж асууя.

М.Энхцэцэг: Тэр нөгөө нүүрсний станц учраас оролцогч цөөн орж ирнэ ээ. Тийм учраас өндөр одоо тарифтай орж ирэх магадлал өндөр учраас тэр нөгөө дээд тариф буюу одоо юу гэдэг юм 7 центийг ингэж тавьж өгье. Тэндээс доошоо л та нар өрсөлдөх ёстой гэдэг байдлаар тавьж өгөх гэдэг асуултад бас хариулт авъя гэж бодож байна. Тэр нөгөө таны 1 дүгээр асуулт бол бас ер нь бол зөв. Нөгөө дулаан станцын Улаанбаатарын хувьд бол тийм онцлогтой байж болох юм байна. Зүгээр бусад станцуудын хувьд бол үнэхээр тэр 70 хувийг төр буцаагаад төлнө гэдэг чинь төсөв дээр маш их ачаалал учраас ерөөсөө л тэр нэг хувийн одоо хөрөнгө оруулагч нь цаашаа аваад явбал зүйтэй юм биш үү? Тэрийг ингэж оруулъя аа тэр ажлын хэсэг нь гэж ингэж бодож байна аа. Тэгэхээр энэ дээр хариултдаа хариулт авъя. Зүгээр тэр нөгөө 5 хүний хувьд бол бас 9 болгоод өсгөчихвөл ер нь л эрсдэлийг багасгана шүү гэдгийг л хэлэх гэсэн юм.

Д.Амарбаясгалан: Чойжилсүрэн сайд хариулт өгье.

Б.Чойжилсүрэн: Энхцэцэг гишүүний асуулт нэмээд хариулъя аа. Яг өнөөдрийн байдлаар Энхцэцэг гишүүн ээ, 4 төсөл эрчим хүчний салбар дээр хэрэгжээд явж байна аа. Бөөрөлжүүтийн цахилгаан станц маань эхний жилдээ 7 центр, 2 дахь жилээсээ 28 дахь жилдээ нэг юу 1 квт цаг эрчим хүчийг сүлжээнд 8.95 центээр нийлүүлэхээр ийм гэрээ 2016 оны 3 сард байгуулагдсан. Үүний дараа Баян сум дээр 660 мвт-ын цахилгаан станц явж байгаа. 1 квт цаг эрчим хүчийг 28 жилийн хугацаанд 8.4 центээс нийлүүлнэ ээ гэсэн. Түүний дараа Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хотод 70 мвт-ын цахилгаан станцын төслийг Райд Монголиа гэдэг компани хэрэгжүүлээд явж байна. Сүлжээнд нийлүүлэх үнэ нь 8.4 цент. Тосонцэнгэл сум дээр Завхан аймгийн Тосонцэнгэл сум дээр 30 мвт-ын ДЦС мөн ялгаагүй 8.5 центээр нийлүүлэх ийм тооцоолол байгаа юм. Бид нар энэ цахилгаан...

Д.Амарбаясгалан: Нэг минут нэмж өгье.

Б.Чойжилсүрэн: Нийлүүлэх энэ нөхцөлийг одоо бүх олон улсын судалгаа хөрөнгө оруулалтын нөхцөлийг тооцож үзээд судалгаа хийсэн. Эрчим хүчний зохицуулах хороо манай ЭХЯ диспетчерийн үндэсний төвтэй бас хамтраад ажлын хэсэг байгуулагдаад бид нар 2022 оны төгсгөлөөс 2024 он гартал дэлхийн улс орнуудын цахилгаан эрчим хүчний нүүрсний цахилгаан станцуудын үнэ өртгийг судалсан. 7 центээр үнэхээр ямар ч хөрөнгө оруулагч орж ирэхгүй юм байна лээ. Энэ дотор бид нар ямар тооцоолол 8.4 цент дээр ямар тооцоолол хийсэн гэхээр өөрийн хөрөнгийнх нь одоо оруулах хэмжээ станцынхаа 30 хувьтай тэнцүү байна, 70 хувийг нь жилийн 8 хувиар бодоод 3 жилийн хугацаанд станцыг барина. Түүнээс хойш нэг 5-6 жилийн дотор энэ 8 аравны юу оруулсан нөгөө зээлийг хүүгийн хамт төлөхөд хамгийн доод хэмжээ нь 8.4 цент байна аа гэсэн ийм л тооцоо гарч ирсэн ийм л байгаа юм. Тэгэхээр нэг 8.4 цент гэдэг нүүрс...

Д.Амарбаясгалан: Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуулт асууя үг хэлье. Энэ үг хэлэх хүмүүс үү? Уучлаарай. За гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа.

Хуулийн төслүүдийн талаар Байнгын хорооноос гаргасан санал дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагддаггүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу дэмжсэн,

дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлнэ ээ. 3 гишүүний нэр ирсэн байна. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн 2 дугаар индрээс үг хэлье.

С.Эрдэнэболд: Чойжилсүрэн сайдад хандаад, ажлын хэсэгт хандаад хэлэхэд мэдээж энэ эрчим хүчний салбар бол стратегийн салбар аа. Энэ бол цаг агаарын шинж чанартай, улирлын шинж чанартай асуудал биш урт хугацаанд Монгол Улсын хөгжлийн тогтвортой байдлыг хангах стратегийн чухал салбар. Гэтэл 2012 оны үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай холбоотой зүйлийг бас өмнө нь Байнгын хорооны хурал дээр та бид 2 санал солилцож байсан. Тухайн үед болбол яасан гэхлээр 10 жилийн хугацаанд буюу 2020 он гэхэд Монгол Улс эрчим хүчний бие даасан тусгаар тогтнолоо олно гээд заачихсан. Ингээд тэрнээс чинь хойш 15 жилийн хугацаа өнгөрөөд өнөөдрийн нөхцөл байдал дээр асуудал бахь байдгаараа хэцүү байгаад байгаа юм. Тэгэнгүүт салбарын сайдын хувьд та юу гэж хэлж байгаа вэ гэхлээрээ илүү бид нар прагматик байх ёстой юм байна аа. Манай улсын хөгжлийн бодлого болбол амны бэлгээс ашдын бэлгэ гэдэг томъёогоор яваад байгаа юм. Гэтэл яг бодит байдал болох юм болбол эзэн хичээгээд ч, заяа хичээгээд бүтэхгүй нөхцөл байдалтай ийм сорилт бэрхшээл нөхцөл байдалд байгаад байгаа юм.

Тэгэхээр одоо бид нар энэ төрийн бодлогыг ялангуяа энэ стратегийн томоохон бодлогуудыг бид нөгөө амны бэлгээс ашдын бэлгэ гэдэг зарчмаар биш хүйтэн логигоор маш прагматик хандаж хийх ёстой болчихож байгаа юм нэг. 2 дугаарт энэ намраас магадгүй намрын чуулганаар магадгүй үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал ороход одоо шинээр дараагийн 10-20 жилийн энэ бодлогын бичиг баримт ороход та энэ хариуцлагатай салбарыг толгойлж байгаагийн хувьд яг тэр үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг боловсруулж байгаа ажлын хэсэг, тэр экспертүүдэд салбарын энэ зовлон сорилт, бэрхшээл шийдэл, түүний хувилбар өгөгдлүүдийг маш сайн ойлгуулмаар байгаа юм. Манайх алсын хараа 2050, дунд хугацааны 2040 гээд баахан хөтөлбөр гаргангуутаа ямар асуудал гаргаад байна вэ гэхлээрээ нэг тийм романтик гэгээлэг юмнууд л өрөөд тавьчихдаг. Яг нарийн юмны тэр гүн рүү нэвчсэн тэр зовлон, жаргал, эрсдэл, түүний үнэлгээ, хэмжих нэгж байхгүй. Яагаад байхгүй вэ гэхлээр энд бол симуляц ерөөсөө ашиглахгүй байгаад байгаа. Төсөөтэй арга буюу төсөөтэй загварчлалын судалгаа байхгүй.

Эрчим хүчинд ямар хэмжээний хөрөнгө оруулалт хийснээр, ямар хэмжээний дэд бүтцийн шинэчлэл явагдаад тэр нь ямар хэмжээний бүтээмж бөгөөд аюулгүй байдал нэмэгдүүлэх юм, энэ нь эдийн засагт ямар хэмжээний үр өгөөж өгөх юм бэ гэдгээ тэр болгон тодорхойлдоггүй байгаад байгаа. 3 дугаар асуудал бол яг хүйтрээд одоо ингээд удахгүй наадам болно оо. Ингээд монголчууд зуны сарыг 6 юм шиг явна аа. Намар болно оо, утаа гарна аа, хүйтэрнэ ээ, халтиргаа гулгаа бий болно оо, тог тасарч магадгүй гэж байна. Яг ингээд асуудал тулаад ирэхээрээ л бүгдээрээ энэ асуудал руу мэддэг нь ч тэр, мэддэггүй нь ч тэр, бүгд улс төрждөг туйлширдаг. Тэгээд тодорхой хүмүүсийг улс төрийн юм уу, ямар нэгэн зорилгоор буруутгадаг. Тэгээд л дуусчихдаг асуудал шийдэгддэггүй.

Тийм учраас та энэ хариуцлагатай стратегийн салбарыг бас толгойлж байна. Багагүй хугацаанд толгойлж байгаагийн хувьд одоо яг бодит байдлуудыг асар тодорхой яримаар байна. Сонгууль хол байна. Тийм учраас яг энэ бодит байдлуудыг тодорхой яриад энэ Их Хурал дээр ч тэр, Байнгын хороон дээр ч тэр яг тодорхой шийдлүүдээ яриад юмаа явахгүй болбол ерөнхийдөө бид нар нэг тийм

уриа лоозонгийн маягтай нөгөө л Монгол хүний амны бэлгээс ашдын бэлгэ гэдэг зарчмаараа асуудалд хандаад л байгаа учраас юм шийдэгдэхгүй байна аа гэж. Тэр зарчмын хувьд бол үзэл санааг дэмжиж байгаа. Тэр утгаараа болбол энэ дээр 7 хэмжиж, нэг огтолж асуудал нухацтай байх талаас нь анхаараач ээ.

Эцэст нь дахиж хэлэхэд болбол яг энэ төслийнхөө энэ одоо эрх зүйн шийдэл УИХ-аас гарлаа гэхэд симуляц түвшинд ямар байх вэ гэдэг дээрээ илүү сайн мэдээллүүдийг өгөх ёстой гэж бодож байна. Баяр хүргэе, амжилт хүсье.

Д.Амарбаясгалан: Ренчинбямбаагийн Сэддорж гишүүн үг хэлье. 2 дугаар индэрт урьж байна.

Р.Сэддорж: Энэ хуулийн өөрчлөлтийг яагаад дэмжиж байгаа вэ гэхээр энэ тендерийн тухай хуулиар, худалдан авалтын тухай хуулиар бол үнэхээр станцыг бол барьж болохгүй байгаа юм байна лээ. Тэгээд түлхүүр гардуулахаар барих ёстой станц бол их онцлогтой. Замыг бол зураг зургийн дагуу барьж болно. Барилгыг бол зургийн дагуу барьдаг, станцыг бол одоо яг тийм орны тийм тоног төхөөрөмжийг энд нь одоо авна аа гэж хийж хэлж одоо зааж болдоггүй. Энэ заах юм бол бас өөрөө хууль зөрчих учраас энэ хуулийг одоо оруулж ирж байгаа гэж ойлгож дэмжиж байгаа.

Бид бол энэ Таван толгойн станцыг барих гэж олон жил олон Засгийн газар ярьсан. Одоо Таван толгойн бүлэг орд дээр юу л байна эрчим хүчний нүүрс байна. Тэнд одоо хамгийн хямдхан эрчим хүч бий болгох боломж байна. Тэгээд энийг одоо яагаад хийдэггүй вэ гэхээр энэ хийх цаг нь одоо ирсэн юм байлгүй. Одоо энэ хуулийн өөрчлөлтөөр энэ боломж нь бүрдэнэ ээ л гэж найдаж дэмжиж байгаа. Дээрээс нь бол одоо УИХ-ын гишүүдийн хардлага байгаа. Энийг ингээд нээгээд маш олон одоо яригдаагүй тийм янз бүрийн эрх ашгийн хөндсөн ийм төслүүдийг явуулчих вий гэж айж байгаа. Одоо Чойжилсүрэн сайд бол ажлын хэсэг гаргаад ингээд ажлын хэсэг дээрээ төслүүдийг жагсаагаад, нэрийг нь, хүчин чадалтай нь байршилтай нь жагсаагаад, яг энэ энэ төслүүдийг энэ хуулийн өрөөнд хийнэ ээ гэсэн ийм жагсаалт гаргана аа гэж та олон удаа хэлсэн. Энийг одоо Их Хурлын гишүүд бүгдээрээ ойлголоо.

Тэгээд Монгол Улс бол эрчим хүчний асар их нүүрстэй мөртөө станцаа барьж чаддаггүй, тэгээд станц барих бүрэн бололцоо байгаа. Тийм учраас энэ олон нүүрсний уурхайнууд байна. Энэ олон нар, салхины эрчим хүчнүүд байна. Тийм учраас одоо эрчим хүчээр бүрэн хангагдсан ийм улс орон болоход бол одоо биднээс жоохон хичээл чармайлт шаардлагатай байна аа. Тэрний тулд бол энэ хуулийн өөрчлөлт гэж бид нар ойлгож дэмжиж байгаа. Тэгээд одоо та энэ ажлын хэсэгтээ ЭХЯ-ныхан хэлсэндээ байж, энэ төслүүдийнхээ жагсаалтыг товч тодорхой болгоод ингээд одоо ажилдаа шуурхай ороод, энэ олон жил гацсан энэ төслүүдээ ялангуяа Таван толгойн ДЦС гэж олон жил ярьсан. Энийг одоо 1 дүгээрт хийж, ингээд энд үйлдвэрлэсэн цахилгаанаар нийслэл Улаанбаатар хот болон одоо төвийн эрчим хүч тэжээлээ авч ингээд эрчим хүчний гол одоо хямралаас гарах, дээрээс нь бас Хятад улсаас импортоор авч байгаа цахилгааныг орлож, дотоодын эрчим хүчээ, дотоодын үйлдвэрүүдээ хангах гээд энэ ажлууд байгаа.

Дээрээс нь говийн бүсийн аймгууд энэ аймгуудын 10 аймгийн станц бас санхүүжилт нь гацчихсан байгаа. Одоо Солонгос улсын Эксим банкны хурлыг 7

сарын хурлыг хүлээж байгаа тиймээ. Тэгэхээр энэ 10 аймгийн төвийн ДЦС-ын зогсчихсон байгаа барилгын ажил бас энэ дээр хамт шийдэгдээд явна гэж бас гишүүд ойлгож байгаа. Тэгээд эдгээр зүйлүүдийг бататган хэлж, та бүгдийн ажилд амжилт хүсье ээ. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Жаргалсайханы Золжаргал гишүүн алга байна. УИХ-ын гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалтыг маргааш үдээс өмнөх чуулган дээр уг хуулийн төслийг уг хуулийн төслийг яаралтай хэлэлцэх эсэхээ шийдсэний дараа санал хураалтаа явуулсан нь дээр үү. Нэг ирц бүртгээдэхье. Гишүүд санал хураалтад бэлдье. Ирц бүртгэлийн санал хураалт явуулъя.

Одоо Байнгын хорооны саналаар Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна аа. Гишүүд санал хураалтад бэлдсэн байна. Санал хураалт.

1.Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя аа. Санал хураалт.

77 гишүүн буюу 68.8 хувиар санал дэмжигдлээ.

2.Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя аа. Санал хураалт.

74 гишүүн буюу 66.1 хувиар санал дэмжигдлээ.

3.Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна аа. Санал хураалт.

73 гишүүн буюу 65.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Эрчим хүчний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ.

Одоо тэгээд Чойжилсүрэн сайд. Алга таших яах вэ. Энэ маргааш өглөө намын бүлгүүдийн бүлгийн дарга нарын саналаар дахиж яаралтай хэлэлцэх эсэх санал хураалтыг явуулна аа гэдгийг би бас түрүүнд хэлсэн. Яагаад гэхээр Их Хурал горимынхоо дагуу өнөөдөр санал хураалт явуулаад цөөнх болчихсон байж байгаа. Тэгэхээр маргааш өглөө намын бүлгийн дарга нар санал горимын санал гаргасан тохиолдолд яаралтай хэлэлцэх асуудлаар санал хураах ийм хурал дэгтэй шүү. Тийм учраас энэ асуудлыгаа та бүхэн маань ярилцана биз. Тэгээд тэр яаралтай хэлэлцэх нь дэмжигдэхгүй болбол ердийн горимоор гэхээр энэ хаврын чуулганд энэ асуудал хэлэлцэгдэж багтахгүй.

Д.Амарбаясгалан: Одоо 8 тогтоол батлах юм байна гишүүд ээ. Зээлийн хүүг бууруулах хүрээнд авах зарим арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Тогтоолын төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн Лхагвасүрэнгийн Соронзонболд танилцуулна аа. Индэрт урьж байна.

Л.Соронзонболд: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ,

УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 2 дугаар тогтоолоор байгуулагдсан хянан шалгах үүрэг бүхий ажлын хэсэг 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдрөөс 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн хооронд ажиллаж, Зээлийн хүүг бууруулах стратеги батлах тухай УИХ-ын 2020 оны 21 дүгээр тогтоолын хэрэгжилтийн талаар санал дүгнэлт гарган, 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдөр Монгол УИХ-ын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэгт заасны дагуу Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд танилцуулсан бөгөөд хуралдаанд оролцсон гишүүдийн олонх ажлын хэсгийн санал дүгнэлтийн дагуу тогтоолын төсөл боловсруулж, хэлэлцэхийг дэмжсэн хэлэлцүүлэхийг дэмжсэн болно оо.

Эдийн засгийн байнгын хороо 2025 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаараа Монгол УИХ-ын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6, 9.8 дахь хэсгүүдийг баримтлан хянан шалгах ажлын хэсгийн санал, дүгнэлтийн дагуу Зээлийн хүүг бууруулах хүрээнд авах зарим арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолын төсөл боловсруулах асуудлыг хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед УИХ-ын гишүүн Мягмарсүрэнгийн Бадамсүрэн Ирээдүй өв сангийн хөрөнгийн хэдэн төгрөгийг ямар банкнуудад, хэдэн хувийн хүүтэйгээр, хэдэн жилийн хугацаатай хадгалж, үр шим хүүгийн өгөөжийг хэрхэн хүртэх талаар, Ирээдүй өв сангийн хуримтлагдсан хүүгийн өссөн дүнг хүүхдийн хөгжлийг дэмжих чиглэл рүү хэрхэн шилжүүлэх талаар хийгдсэн судалгаа тооцоолол байгаа эсэх, энэ хөрөнгийг дотооддоо эргэлтэд оруулах, хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрт ашиглах боломжтой эсэх талаар, УИХ-ын гишүүн Сайнзориг арилжааны банкнуудын зээлийн хүү батлах аргачлалын талаар, зээлийн хүү өндөр байгаагийн шалтгаан, авах арга хэмжээний талаар, арилжааны банкна дахь иргэдийн хадгаламжийн дундаж хугацааны талаар арилжааны банкнууд дахь ББСБ ломбардад олгосон зээлийн хэмжээ, давтамж, ипотека, цалингийн зээлийн хураамжтай холбоотой шийдвэрийн талаар. УИХ-ын гишүүн Эрдэнэбат ахмадын тэтгэврийн зээл, зээлдэгчийн эрх ашгийг хамгаалах институтыг хэрхэн байгуулах талаар асуулт асууж хариулт авлаа.

Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсэг, Монгол УИХ-ын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8 дахь хэсгийг баримтлан Эдийн засгийн байнгын хорооноос боловсруулсан тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулах эсэх асуудлаар санал хураалт явуулахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно оо.

Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 2 дугаар тогтоолоор байгуулагдсан Зээлийн хүүг бууруулах стратеги батлах тухай УИХ-ын 2020 оны 21 дүгээр тогтоолын хэрэгжилт, үр дүнтэй танилцаж, санал дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн санал дүгнэлтийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос боловсруулсан Зээлийн хүүг бууруулах хүрээнд авах зарим арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолын төслийг та бүхэнд хүргүүлсэн болно оо.

УИХ-ын эрхэм гишүүд ээ,

Зээлийн хүүг бууруулах хүрээнд авах зарим арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолын төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал дүгнэлт, тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Бядрангийн Лхагвасүрэн Монгол Банкны ерөнхийлөгч, Түндэвийн Жамбаажамц СЗХ-ны дарга, Ганболдын Энхтайван Монгол Банкны дэд ерөнхийлөгч, Өлзийбатын Мөнх-Ундарга Монгол банкны Банк санхүүгийн эрх зүйн хэлтсийн захирал, Бэгзийн Итгэлсүрэн СЗХ-ны Банк санхүүгийн байгууллагын газрын дарга, Жаргалсайханы Мөнх-Оргил СЗХ-ны Хууль эрх зүйн хэлтсийн дарга, Баттулгын Дөлгөөн СЗХ-ны үнэт цаасны газрын дарга.

Байнгын хорооны санал дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх УИХ-ын гишүүд нэрээ өгье өө. 11 гишүүнээр тасаллаа. Ирцийн дарааллаар. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуулт асууя, үг хэлье. За Жигжидийн Батжаргал гишүүн үг хэлье, асуулт асууя.

Ж.Батжаргал: Гишүүдийнхээ оройны амар амгаланг айлтгая аа. Тэгэхээр зээлийн хүүгийн түвшин бол үнэхээрийн өндөр байгаад байгаа. Тийм учраас зээлийн хүүг бууруулах талаар нэлээн томоохон судалгаа юмнууд хийгдээд бас тодорхой саналууд яригдаад, тэгээд тогтоолын төсөл яригдаж байгаа юм байна. Зээлийн хүүг бууруулах бодлогын чиглэл дээр авч хэрэгжүүлэх гэж байгаа арга хэмжээнүүдийн тавиад байгаа зорилтууд ер нь хэрэгжих бололцоо боломж нь ямархуу байна вэ?

Дэлхийн улс орнууд бол энэ хадгаламжийг буюу тодорхой татан төвлөрүүлж байгаа эх үүсвэрээ өөрийг нь хүү багатай байлгаад түүнийг нь барьцаалаад олгож байгаа зээлийнх нь хүү өөрөө бага байх зарчим нь угаасаа энэ банк санхүүгийн байгууллагын зээлийн хүүгийн түвшнийг буулгахад нэлээн том нөлөө үзүүлээд байх шиг байна аа. Нэгэнт татан төвлөрүүлж байгаа эх үүсвэрийн чинь бараг 60 гаруй хувь нь наад хадгаламжийн чинь хөрөнгө байгаад байдаг.

Тэгэхээр үндсэндээ тэр хадгаламжийн хүү нь өөрөө бага байж чадах юм бол зээлийн хүү бага байх тухай асуудал байгаад байгаа. Эргээд тэр нь энэ эдийн засгийн салбараа тэтгэх гэдэг юм уу, үнэхээрийн юм хийж бүтээх гээд байгаа улсуудаа дэмжих хөрөнгийн эх үүсвэр болж ашиглагдах бололцоо боломж нь бүрдэгдээд байгаа юм шиг байгаа юм. Энэ Казакстан эд нарыг бол тэр тал руу нэлээн Турк, Казакстан эд нарыг бол тэр тал руу нь нэлээн гайгүй алхчихсан юм

байна гэж улсууд яриад байна аа. Энэ судалгаа тооцооллуудыг та хэд ямархуу байдлаар бас ажигласан анзаарсан юм байна. Энүүнийг Монголд биднүүс нутагшуулах бололцоо боломж ер нь байх нь уу гэдэг ийм асуудал.

3 дахь зүйл бол биднүүс тодорхой тодорхой Засгийн газар гэдэг юм уу тусгай сангууд байгуулаад байгаа улсууд аа. НДШ-ийн тодорхой хэсгийг мөнгөжүүлэх байдлаар авч явж байгаа. Шинэ хуулийн орчноор одоо энэ Үндэсний баялгийн сангийн хуримтлалын сан байна гэх мэтчилэнгээр энэ тогтвортой хадгалагдаж байгаа сангуудын эх үүсвэрийг баталгаат өгөөжтэй байлгах тэр өгөөж нь өөрөө бас тийм өртөг өндөртэй биш байж, эргэлтэд орж чадах юм бол зээлийн хүүгийн түвшнийг бууруулах бололцоо байх юм байна гэж би бол хараад байгаа юм. Энэ талаар ямар одоо бодлого чиглэл байна вэ гэж. За нэг ийм 3 зүйл дээр тодорхой хариулт авъя.

Д.Амарбаясгалан: Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууж, үг хэлье. За уучлаарай хэн хариулах юм? За Лхагвасүрэн Ерөнхийлөгч. 4 дүгээр индэр.

Б.Лхагвасүрэн: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Ерөнхийдөө манай хийсэн судалгаагаар одоо хадгаламжийн зээлийн хүү, бүтэц, бүтцийг ингээд дотор нь үзэхэд 60 хувь нь эх үүсвэрийн хүү буюу одоо хадгаламжийн хүү, нэг 18 хувь нь болохлоор банкны өөрийнх нь үйл ажиллагааны зардал, 12 хувь нь болохлоор одоо дижитал хөгжил буюу банкны өөрийнх нь хөрөнгө оруулж байгаа үйлчилгээндээ. Үлдсэн хэсэг нь бол эрсдэлийн зардал гэсэн ийм хэсгүүдээс бүрдэж байгаа юм. Тэгэхлээр энэ дотор хамгийн том хэсэг нь таны яг хөндөж байгаа эх үүсвэрийн зардал байгаа 60 хувь.

Тэгэхлээр өнөөдөр одоо Монгол Улсын энэ банкны системийн дундаж одоо их хадгаламжийн хүүгийн дундаж хүү нь 11-12 хувьтай байгаа юм. Тэгэхлээр энэ дээрээ одоо нөгөө банк үйл ажиллагааныхаа зардлын маржныг нэмээд тэгээд одоо дундаж хүү бол өнөөдөр 17-18 хувь, зээлийн хүү гээд гараад ирчхэж байгаа юм. Тэгэхлээр мэдээж 60 хувь үүсэж байгаа энэ эх үүсвэрийн хүүг л буулгавал энэ зээлийн хүү доошоо буух боломж нь байгаад байгаа юм. Тэгэхдээ бас нэг Монгол Улсын өөрийнх нь суурь шалтгаан нь өнөөдөр ингээд Монгол Улсад эдийн засагт эргэлдэж байгаа энэ санхүүжилт маань өөрөө нийт эрэлтийнхээ 80 хувь л байгаа юм. Тэгэхлээр зайлшгүй гаднаас 20 хувийн эх үүсвэр татах ийм шаардлага байгаад байгаа нь одоо Засгийн газар бонд босгох ч юм уу, банкнууд бас гаднаас эх үүсвэр татаад явж байгаа.

За яг өнөөдрийн цаг үе нь одоо ковидын дараах энэ олон улсын хурцадмал нөхцөл байдал нь өөрөө гадна байгаа эх үүсвэрийн хүүг бас тийм нам доор түвшинд авчрах боломжийг бүрдүүлэхгүй байна. Одоо хамгийн сүүлд Хөгжлийн банк сая эх үүсвэр 350 сая доллар ингээд татаж оруулж ирж байгаа. Тэрний одоо хүү нь өөрөө ингээд 9 гаруй хувьтай байх жишээтэй. Тэгэхлээр доллароор гадаад валютын эх үүсвэр нь өөрөө 9 байгаа энэ үед эргээд бас бага хүүтэй зээл болгож гарах боломж нь энийг бас хориод байна уу л гэж л харж байгаа юм. Тэгэхлээр энэ цаг үедээ бол яг хүүг бол өнөөдөр шууд огцом буулгах боломж байхгүй. Харин саяын нөхцөл байдал зөөлрөөд ирэх юм бол хадгаламжийн хүү, зээлийн хүү бол буурч болно оо л гэж харж байгаа юм.

Таны хөндсөн бас тэр 2 орон байгаа. Турк, Казахстан гээд. Эдгээр орны бас тоо баримтуудыг үзэж бас шалгаж байгаа. Тэгэхдээ энэ 2 орны хүүнүүд бол

манайхаас бараг өндөр шахуу бас байгаад байгаа. Тэгэхлээр энэ дээр бол яг тийм харьцуулахад бол жишээ авахаар биш болчхоод байгаа юм. Мөн бас таны бас хөндөж байгаа нийгмийн даатгалын сан, тэр Ирээдүйн өв сан ч гэдэг ч юм уу, эс үгүй бол хуримтлалын сан гэж ийм сангууд бий болоод явж байна. Өнөөдөр бол Ирээдүй өв сан бол гадаад валютын ийм хэлбэрээрээ хадгалагдаж байгаа. 1.2 тэрбум долларын хэмжээнд очсон. Энэ оны эцэст хэрвээ уул уурхайн салбарын ашигт малтмал ашигласны НӨАТ нь ингээд ороод явах юм бол 2 тэрбум доллар руу очих. Тэгэхдээ яг хуулийнх нь зохицуулалтаар энэ Ирээдүй өв сан бол 2030 он хүртэл хөндөхгүй, гар хүрч болохооргүйгээр, зарцуулалт хийхээргүйгээр. Тэгээд гадна байршихаар ингээд зохицуулагдсан байгаа.

Одоо харин дотроо ашиглаж байгаа нэг сан маань хуримтлалын сан. Өнгөрсөн онд бол 498 тэрбум төгрөгийн хуримтлалын сангаар бүрдсэн. Энийг бол ипотекийн зээлийн санхүүжилтэд оруулаад явж байгаа. Энэ онд бол бас нэг 500-гаад тэрбумын энэ эх үүсвэр гарч ирнэ ээ гэсэн ийм бас Засгийн газраас тооцоолол өгсөн тийм.

Д.Амарбаясгалан: Жигжидийн Батжаргал гишүүн тодруулж асууя.

Ж.Батжаргал: Тийм. Тэгэхээр наад Ирээдүй өв сангийн хөрөнгө энэ тэр чинь бол танай дээр доллар хэлбэрээрээ хадгалагдаад байгаа. Гэхдээ тэрийг танайх мөнхийн дансанд нь царцаачаагүй байхгүй юу. Танайх бол эх үүсвэр болгон ашиглаад яваад байгаа. Бид энд эх үүсвэр эрх зүйн юу гаргахдаа энүүнийг өгөөж өгдөг хэлбэрээр нь эргэлтэд оруулах юмыг нь л хуулиар хязгаарлалчихсан болохоос биш тодорхой хэмжээний баталгаа гэдэг юм уу, тийм юугаараа яваад байгаа зүйл байхгүй юу? Тэгэхээр энүүнийг амь оруулах шаардлагатай байгаа юм. Бид тэрнээс мөнгө гаргаж өөр юманд зарахгүй. Гэхдээ улс орныхоо эдийн засгийг идэвхжүүлдэг үйл ажиллагаа руу нь эргэлтийг нь авдаг хэлбэрээ зөв шийдэх тухай асуудал байх юм уу гэж.

Дараагийн нэг зүйл энэ манай банкнуудын чинь ашгийн түвшин энэ улс орнуудын банкнуудын ашгийн түвшнээс ямар зөрүүтэй юм бэ. Энэ чинь одоо ярихаараа жаал улсуудын...

Д.Амарбаясгалан: Нэмж хариулт өгье 4 дүгээр индэр.

Б.Лхагвасүрэн: Батжаргал гишүүний асуултад тодотгож хариулъя. Тэгээд энэ Ирээдүйн өв сангийн хөрөнгө бол энэ Сангийн яамны төрийн сангийн дансан дотор байдаг. 1.2 тэрбум доллар гээд. Тэрийгээ Монгол банкаар удирдуулж байгаа манай нөөцөөр. Тэгээд бидний энэ удирдаж байгаа нөөц бол ерөнхийдөө нэг 3-4 хувийн өгөөжтэй. Олон улсад байршаад явж байгаа. Яах вэ, эндээ, Монгол банкны дансанд нөгөө Ирээдүй төрийн сангийн данс Монгол банкны дээр байршдаг гэдэг утгаараа манай дээр байгаа. Тэр нь манай нөөцтэй хамт удирдагдаад явж байгаа гэж ойлгож болно. Тэгэхлээр өгөөж бол байгаа. Одоо өнөөдөр бол олон улсад бол 3-4 хувийн өгөөжтэй ингээд байршуулаад явж байгаа.

Дараачийнх нь асуулт дээр нь банкны ашигтай холбоотой. Тийм яах вэ энэ марж нь гээд байгаа. Одоо хадгаламжийн хүү, зээлийн хүү хоёрын зөрүү нь бол одоо банкны ашиг болж байгаа. Тэгэхлээр бол олон улсад бол ерөнхийдөө марж нь бол нэг 3-4, манайд бол 4-5. Тэгэхлээр олон улсын түвшнээс бол бас 1, 2 нэгж...

Д.Амарбаясгалан: Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууж, үг хэлье.

П.Сайнзориг: Би бас Байнгын хорооноос асууж байсан асуултаа асууна. Тэгэхдээ энэ өнөөдрийн орж ирж байгаа тогтоолыг зарчмын хувьд дэмжиж байгаа гэдгээ хэлье. Энэ чиглэлээр бас ажиллаад үзэх ёстой л гэж би бодож байгаа.

1 дүгээрт энэ шүүхийн шийдвэрүүд гарсан. Энэ арилжааны банкнуудаас олгож байгаа зээлийн бүтээгдэхүүн дээр тогтоож байгаа шимтгэл хураамж чинь бас заримдаа үндэслэлгүй тогтоогоод байна аа. Огтоосоо авч болохгүй гэж хэлж байгаа юм биш. Үндэслэлгүй тогтоогоод байна. Уг асуудлуудыг бас үндэслэлтэй эргэж харах ёстой гэдэг зүйл байгаа. Сүүлийн үед энэ зээлийн мэдээллийн сантай холбоотойгоор үйлчилгээ чинь бараг хэрэглэгч өөрөө мөнгөө төлөөд лавлагаа энэ тэрээ өгч байхад энэ зээл дээрээс нь нэг хувийн шимтгэлийг нь шууд суутгаад авчаж байгаа байхгүй юу. Бүх төрлийн зээл дээр. Ипотекийн зээл дээр энэ бас үргэлжлээд байгаа юм шиг байна. Уг нь банкны шийдвэр гарчихсан, тийм шүүхийн шийдвэр гарчихсан байгаа. Энийг мөрдүүлэх чиглэлд Монгол банк төв банк юу хийж байгаа юм бэ? Шүүхийн шийдвэрийг энэ биелүүлэх асуудал дээр ямар арга хэмжээ авч байгаа юм. Энийг нэг хэлээдхээч.

2 дугаарт энэ сүүлийн үед энэ арилжааны банкнаас ББСБ ломбардууд руу зээлж байна аа. Энэ нь өөрөө эргээд цаашаа нөгөө мөнгө хүүлэлтийн схемийг л өөрөө төв арилжааны банкнуудаараа дамжуулж энэ бодлого чинь дэмжигдээд байгаа байхгүй юу. Тэгээд энэ Байнгын хорооны түвшин дээр энийг бид нар Монгол банкны Ерөнхийлөгчийн шийдвэрээр ингээд хориглож байгаа гэж хэлж байна лээ. Энэ өөрөө Захиргааны ерөнхий хуультай нийцэхгүй, хууль давсан журам болж болно. Тийм учраас уг асуудлыг бас намрын чуулганаар арилжааны банкнаас ББСБ ломбардууд руу зээл олгодог энэ үйл ажиллагааг хуулиар хориглоё гэдэг асуудлыг одоо Батсүмбэрэл гишүүн бид 2 ярьж байгаа. Энэ асуудал дээр ер нь хэмжээ дамжаа ямар байгаа юм, давтамж хэр байгаа юм. Энийг нэг хэлээдхээч.

2 дугаарт өнөөдөр ч гэсэн та бас харж байгаа байлгүй дээ. Энэ төсвийн уур амьсгал хэмнэлтийн горимд явж байдаг. Монгол банк 690 орон тоо батлуулаад авчихсан юм байна. Өнөөдөр 641 орон тоотой ажиллаж байгаа гэж мэдээлэл авсан. Би одоо Байнгын хороон дээр 700 гэж хэлсэн. Ер нь төв банк одоо бараг энэ төрийн байгууллагуудаас ганцаараа орон тооны дээд хязгаараа тогтоохгүй явж байгаа ганц байгууллага байгаа. Хараат бус байдал гэдэг зүйлийг буруу ойлгочихсон, өөрөө мөнгө хэвлэдэг, өөрөө төсвөө баталдаг ийм байдлаараа ингээд яваад энэ бусад төрийн байгууллагадаа хэр үлгэр жишээ үзүүлж байгаа юм бэ? Та энэ төрийн хэмнэлтийн бодлого дээр төв банк дээр энэ чиг үүргийн давхардлыг арилгах арга хэмжээг авах уу гэдэг асуудлыг би бас одоо ерөнхийлөгчөөс асуумаар байна.

Ер нь бол одоо төв банк бол төсвөө баталж байгаа. Тэрийгээ мөнгө хэвлэж байгаа. Энэ хэвлэсэн мөнгөний асуудал дээр аудит ордог л байх. Тэгэхдээ аудит ч ингээд ерөнхийдөө нэг аргалаад л өнгөрчихдөг юм шиг байгаа юмаа. Олигтой ч юм хэлдэггүй. Хяналтын хороо маань одоо бас сул ажиллаж байх шиг байна. Одоо УИХ-аас томилогдож байгаа. Тэгээд энэнээсээ юу хараад байна гэхээр төсвийн мөнгө биш энэ тэр гээд бид нарт бас зарим тайлбаруудыг хэлдэг. Эцсийн дүндээ энэ мөнгийг чинь инфляц болж нөлөөлнө. Нэг бол энэ чинь ард түмэн бас одоо төлөх л энэ тэр лүүгээ явж байгаа шүү дээ. Тэгэхээр ер нь зүгээр энэ нэг талдаа энэ одоо

ханшаа алдахгүй гээд л та нар доллар бас интервенц хийж байгаа. Арилжааны банкнууд свопын үйлчилгээгээр та нар орлого олж байгаа. Тэгээд нөгөө...

Д.Амарбаясгалан: Сайнзориг гишүүнд нэг минут өгье.

П.Сайнзориг: Нөгөө гараараа та нар свопын арилжааны банкнууд өгчхөөд нөгөө талаараа очиж шалгаж байгаа. Тэгээд ингээд conflict of interest буюу ашиг сонирхлын зөрчил гаргаж байгаа юм. Ер нь төв банк бол цаашдаа мөнгөний бодлогын асуудлаа ярьдаг байгууллага байхгүй бол хяналт мөнгөний бодлогоо ч барьдаг, хяналт шалгалт гээд банкнуудаа ингээд 2 үзүүртэй байдлаар орж байгаа шүү. Тэгээд ер нь зүгээр энэ хяналтын байгууллагыг цаашдаа энэ СЗХ-той нэгтгээд ч юм уу ер нь зүгээр энэ бид хэд бас энэ УИХ-аас байгуулагддаг байгууллагын эрх зүйн байдал эд нарыг тодорхой шийдэж явахгүй бол ерөөсөө ингээд дээд хязгаар нь байдаггүй. Тэгээд үе үе дандаа ингээд хараат бус байдал энэ тэр гэж одоо гишүүдийг дандаа төөрөгдүүлдэг. Төсвийн мөнгө гэж биш гэж дандаа хэлж буруу ташаа мэдээлэл өгдөг, тэгээд мөнгө хэвлэхдэг. Дураараа орон тоо тогтоодог, маш өндөр цалинтай. Ийм байгаа шүү. Энэ дээр одоо яаралтай хэмнэлтийн бодлогыг одоо бас хэрэгжүүлэх ёстой. Шаардлагатай бол орон тооны хязгаарыг ерөнхийдөө баталж өгдөг хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх гэж гэмгүй гэж үзэж байгаа.

Д.Амарбаясгалан: Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуулт асууж, үг хэлье. Монгол банкны Ерөнхийлөгч 4 дүгээр индрээс хариулт өгье.

Б.Лхагвасүрэн: Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Ерөнхийдөө хууль эрх зүйн орчны хувьд бол арилжааны банк тодорхой хэмжээгээр бүтээгдэхүүн үйлчилгээн дээр хураамж шимтгэл авахыг бол зохицуулаад өгчихсөн байгаа. Мэдээж тэр ямар хэмжээний хураамж шимтгэл байх вэ гэдэг дээр нь хуулийн нарийн зохицуулалт байхгүй. Тэгэхдээ Монгол банкнаас одоо Монгол банкны хяналт шалгалтын хороон дээр яригдаад гарсан шийдвэр юу байна вэ гэхлээр ер нь дээд хязгаарыг нь тогтоож өгье нэг хувиас хэтэрч болохгүй ээ гээд. Тэгэхлээр бол одоо аливаа зээл ипотекийн зээл байна уу, аливаа зээл авлаа гэхэд банк бол одоо нэг хувиас хэтрэхгүйгээр хураамж авна. Тэгэхдээ тэр хураамж нь бол банк болгон өөр өөр янз янз. Өөрөө л мэдэж гаргахаар л ийм зүйл байгаа.

Тэгэхлээр Төв банкны хууль дээр ч гэсэн одоо арилжааны банкны тэр зээлийн хүү тогтоож байгаа, хураамжийнхаа хувь хэмжээг тогтоож байгаа энэ дотоод үйл ажиллагаанд нь Монгол банк бол оролцохыг бол хуулиар хориглочихсон байгаа. Тэгэхлээр энэ бол энэ утгаараа бидний хувьд бол дээд хязгаарыг нь тогтоогоод өгчихсөн л явж байгаа гэж ойлгож болно.

Таны 2 дахь асуудлын хувьд бол банк болон ББСБ-ын хувьд бол тодорхой хэмжээний эх үүсвэр бие биедээ байршуулж явдаг ийм практик үйл ажиллагаа байсан. Тэгээд өнгөрсөн өнгөрсөн онд УИХ-аас бол мөнгөний бодлогын үндсэн чиглэлийг баталж өгөхдөө ялангуяа энэ хэрэглээний зээлийг танах тал руу нь бол хатуу бодлого баримтлахыг ингээд чиглэл болгосон байгаа. Энэ хүрээндээ СЗХ, ББСБ-ыг банкнаас эх үүсвэр татахыг бол хориглосон шийдвэр гарсан. Тэрэнтэй нь Монгол банк нийцүүлээд 4 сарын 23-нд мөн банкнаас ББСБ-д эх үүсвэр шилжүүлэх эх үүсвэр байршуулахыг бас хориглосон бас ийм адилхан шийдвэр гараад ингээд явж байгаа. Тэгэхлээр бол хяналтын 2 байгууллагын хувьд бол одоо таны хэлж байгаатай санал нэг байна. Ерөнхийдөө энэ хязгаарласан шийдвэр гараад явж байгаа.

Бүтэц орон тоогоо цааш нь нэмэгдүүлэхгүй байх энэ одоо энийг хэмнэх тал руу нь ямар ажил хийгдэж байгаа вэ гэхлээр одоо УИХ-аас гарсан ажлын хэсгийн хүрээнд ажлын хэсэг гарчихсан байгаа процессын дахин инженерчлэл гээд. Энэ хүрээнд бүтээмжээ нэмэгдүүлэх тал руу нь манай дээр ажлын хэсэг гараад ажиллаж байгаа. Тэгэхлээр энэ ажлын хэсгийнхээ хүрээнд тодорхой хэмжээний хэмнэлт хийхээр мөн орон тоонуудыг хэмнэхээр ингээд ажлын хэсэг гарчихсан ажиллаж байгаа. Тэгэхлээр тэрэн дээрээ бол ахиц дэвшил гараад явна байх. Мэдээж одоо энэ төсвийн байгууллагууд дээр бас хэмнэлтийн хувьд бол бас тодорхой шийдвэрүүд гарсан. Тэгэхлээр энэ шийдвэрүүдтэй төстэй хэлбэрээр тэр хэмжээнд нь бас өөрөө энэ хэмнэлтийн горимыг хийж чадна аа гэж төв банкны зүгээс бол харж байна аа.

Монгол банкны үйл ажиллагаа энэ санхүүтэй холбоотой хэсэг дээр бол хяналт шалгалтууд бол байнга давтамжтай явдаг. Монгол банк дээр өөр нь дотоод хяналтын нэгж ажилладаг. Энэ дотоод хяналтын нэгж бол өөрөө энийг бол хянаад явж байгаа. Монгол банкны санхүүгийн тайланг жил болгон гаднын хөндлөнгийн аудитын байгууллагаар бас хянуулаад явдаг. Пи даблью Си байгууллага сая энэ жил бол олон улсынх нь нягтлан бодох бүртгэлийн тэр тайлагналын аргачлалын дагуу ингээд аудитын тайлангаа гаргасан. Үндэсний аудит бол бас мөн тодорхой хэмжээнд нийцлийн болон гүйцэтгэлийн аудит хийгээд явж байгаа. Мөн УИХ-аас томилсон хяналтын зөвлөл манай дээр ажилладаг. Хяналтын зөвлөл бол бас Монгол банкны үйл ажиллагаа, ялангуяа тэр санхүүгийн тайлан дээр нь түлхүү анхаарч ингээд ажиллаад явж байгаа.

Та бас мөн энэ своп хэлцлийн талаар асуусан. Своп хэлцэл бол ерөнхийдөө ААН-үүд болон санхүүгийн байгууллагууд гаднаас бол гадаад валютын эх үүсвэр татаж оруулж ирээд тэрийгээ төгрөгөөр одоо санхүүжилтээ олгохдоо ханшийн зөрүү болон бусад эрсдэлээ хамгаалах үүднээс Монгол банкттай своп хэлцэл байгуулдаг. Тэгэхлээр ерөнхийдөө өнөөдөр бол своп хэлцлийн хүүгийн зардал бол маш өндөр зөрүүтэй явж байгаа. Учир нь гэвэл АНУ-ын долларын өнөөдрийн банк хоорондын зах буюу төв банкны одоо хүү бол 4.5 хувь, Монгол банкны төгрөгийн бодлогын хүү 12 хувь, тэгэхээр энэ 2-ын хоорондын зөрүү нь ингээд 7 гараад явж байгаа нь өөрөө свопыг хийх ялангуяа гаднаас хөрөнгө оруулж ирж дотооддоо санхүүжилт хэлбэрээр цааш нь ингээд дамжуулан...

Д.Амарбаясгалан: Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуулт асууя.

С.Эрдэнэбат: Зээлийн хүүгийн нөлөөлж байгаа гол нь эх үүсвэрийн зардлууд байж байгаа. Эх үүсвэрийн хүүнүүд. Тэгээд би сая энэ статистик тоон мэдээлэл Монгол банкнаас аваад үзэхээр 500 сая төгрөгөөс дээш хадгаламжтай иргэд нийт хадгаламжийн 40 хувийг эзэлж байна. Нэлээн өндөр одоо хувийг эзэлж байгаа гэсэн үг. Тэгэхээр энэ том хэмжээний хадгаламжтай хүмүүс банкнуудад тусгай гэрээ хэлцлээр арилжааны банкнуудын хадгаламжийн хүүгээс илүү өндөр хүүгээр хийгээд байгаа тал байна уу? Энэ тал дээр одоо хэрхэн хяналт шалгалт хийдэг вэ? Статистик тоо байвал хэлж өгөөч ээ. Энэ өөрөө эргээд буцаад зээл олгоход, буцаад тэр эх үүсвэрээр зээл олгоход бол шууд хүүгийн түвшинд бол нөлөөлж байгаа гэж бол би харж байгаа.

2 дугаарт энэ зээлийн эрсдэлийн сан багатай. Одоо яг дунджаар хэдий хавьцаагаар байгуулж байгаа вэ? Тухайлбал одоо тэтгэврийн зээл гэхэд бол

үндсэндээ зээлийн эрсдэлийн сан бараг үндсэндээ байхгүй гэсэн үг. Шууд төрөөс олгож байгаа баталгаат сар болгон тогтмол олгодог ийм зүйл учраас энэ тэтгэврийн зээлийн хүүг одоо бууруулах чиглэлээр тодорхой арга хэмжээ авах гэдэг саналыг бол хүргүүлсэн. Тэгээд энэ тал дээр өнөөдөр бас Ерөнхий сайдтай Монгол банкны ерөнхийлөгч уулзаад ойлголцол зөвшилцөл бас хүрсэн гэж би бол ойлгосон. Тэгэхээр энэ тал дээр ойрын хугацаанд яг хамгийн наад зах нь яг ямар арга хэмжээ авахаар төлөвлөж байна вэ?

Мөн энэ зээлийн хязгаарууд тавьж байгаатай холбоотойгоор эргээд бас сөрөг үр дагавар үр дагаврууд гарч байна аа. Сая бараг үндсэндээ 6 сар одоо маргаан дагуулсны эцэст энэ асуудал эргэн бас одоо шийдэгдэж байгаад бол бас нэг талаар бол талархалтай байна. Нөгөө талаар иймэрхүү шийдвэр гаргахдаа энэ зээлдэгчдийн эрх ашгийг хамгаалсан хяналтын бүтцийг энэ Монгол банкны хяналт болон бодлогын зөвлөлд оруулах боломж бололцоо байна уу? Тэгэхгүй болохоор бас энэ тал дээр бол хэт нэг талыг хараад мэргэжлийн байгууллагууд маань нийгмийн сөрөг эффект эрсдэлүүдийг харахгүйгээр одоо гэнэтийн гэнэтийн шийдвэр гараад байгаа нь бас ингээд цаашдаа ийм асуудлууд гаргахад бол эрсдэлтэй байгаад байна аа. Тэгээд шаардлагатай бол энэ дээр бол одоо хуулийн төсөл бас санаачилъя гэж бодож байгаа.

Дараа нь энэ моргейжийн зээлүүдэд та бүгд маань хяналт хийж үзэж байгаа юу? 80 м.кв-аас дээш ихэнх зээлүүд маань тансаг буюу үнэтэй моргейжийн зээлүүд рүү гарчихсан гэдэг нэг ийм юм яваад байна. 152-т тэрийг нь гэрчилгээг нь болохоор одоо аргалаад үндсэндээ ийм байгаад байна. Энэ тал дээр одоо ингээд явах юм бол бид нар яг нөгөө зорилтот бүлэг буюу анх удаагаа байрууд болох гэж байгаа, байраа жоохон томруулах гэж байгаа ч гэдэг юм уу ийм хүмүүст хүрнэ гэхээсээ илүү илүү олон хүмүүст тансаг хэрэглээтэй ийм зээлүүд рүү яваад байх ийм эрсдэл байгаад байгаа учраас энэ моргейжийн зээлийг цаашдаа эхний ээлжид анх удаагаа байр болох гэж байгаа тэгээд дундаж одоо тэр 80 м.кв-тад барих талаар ямар юуг хянаж байгаа вэ гэдгийг бас асуумаар байна аа.

Д.Амарбаясгалан: Лхагвасүрэн Ерөнхийлөгч 4 дүгээр индрээс хариулт өгье.

Б.Лхагвасүрэн: Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. Тийм ерөнхийдөө Монгол банкн дээрээс одоо энэ саяын энэ зээлийн хүү бууруулах стратеги дотор нэг заалт орчихсон байгаа юм. Тэр заалт нь бол эх үүсвэрийн хүүгийн дунджаас өндрөөр буюу одоо таны хэлж байгаа тэр арай том хадгаламжтай тусгай нөхцөл авч байгаа эдгээр энэ эх үүсвэрүүд дээр ямар нэг арга хэмжээ авах шаардлага байна аа гэдгээрээ хөшүүргийн арга хэмжээ авч байгаа. Тэгэхлээр ямар хөшүүрэг байна вэ гэхлээр арилжааны банк одоо нийт иргэдээс татсан 100 төгрөгийнхөө эх үүсвэрийн одоо 8 хувиар нь заавал байлгах нөөц байршуулдаг. Тэгэхлээр 8-ыг нь бол хаа нэг тийшээ хөдлөхгүйгээр одоо харилцагчийн эхний шаардлагаар мөнгийг нь гаргахаар байршуулдаг байгаа. Тэгэхлээр хэрвээ өндөр хүүтэй хадгаламж татсан бол илүү өндөр заавал байлгах нөөцийг тооцох арай хөшүүргийн арга хэмжээ авъя гээд заалт орчихсон явж байгаа. Тэгэхлээр энэ одоо өнөөдрийн тогтоол батлагдаад гарвал энэ дээр ингээд арга хэмжээ хийгдээд явна аа гэж харж байгаа.

Тэтгэврийн зээл дээр одоо энэ авсан арга хэмжээ бол ерөнхийдөө эргээд хуучин хэвдээ орно. Одоо ирэх нэг дэх өдөр Монгол банкны Мөнгөний бодлогын хороо хуралдах гэж байгаа. Тэгэхлээр энэ хуралдах асуудал дээр энэ тэтгэврийн

зээлийг хөндөж ярих гэж байгаа юм. Ер нь бол манай судалгаагаар бол тэтгэврийн зээл гэдэг ойлголт бол дэлхийд бол байхгүй байгаад байгаа юм. Зүгээр тэтгэврийн зээл олгодог цөөхөн дөрөв, тавхан улс байгаа. Одоо Бразил, Энэтхэг, Индонез ч гэдэг юм уу ингээд тэдгээр улсуудад бол нэг ийм хэлбэрийн зээл байгаа. Тэгэхдээ тэнд бол одоо нөгөө өр орлогын харьцаа гэсэн үзүүлэлтүүд нь байгаад байгаа. Тэгэхлээр Монголд бол энэ харьцааны үзүүлэлтийг ашиглахлаар өнөөдрийн манай амьдралын энэ хэв маягтай нийцэхгүй байгаа учраас ер нь бол тэтгэврийн зээлийг олон улсынхаа жишгээр бол хэрэглээний зээлээсээ хасъя гэдэг ийм саналын томъёоллоор нэг дэх өдөр хурал хийх гэж байгаа. Тэгэхлээр энүүгээрээ шийдвэр гараад явчих байх. Тэгэхлээр бол одоо дахиж тэтгэврийн зээлтэй холбоотой асуудал гарч ирэхгүй байгаа байх аа гэж харж байгаа юм.

Манай мөнгөний бодлогын хороонд бол хараат бус 4 гишүүн байдаг. МУИС-ийн 2 багш, УИХ-ын Байнгын хороо бүлгээс нэг гишүүн. Тэгээд СЭЗДС-аас нэг гишүүн. Тэгэхлээр Монгол банкны мөнгөний бодлогын хороон дээр гарч байгаа шийдвэрүүд бол ерөнхийдөө нөгөө 4 гишүүн нь дийлэнх болдог гэдэг утгаараа хараат бус гишүүдийн нөлөө бол их өндөр байдаг. Өнөөдөр Монгол банкн дээр Ерөнхийлөгч болон дэд ерөнхийлөгч 2 байгаа. Тэргүүн дэд ерөнхийлөгчид бол 3 гээд 7 байх ёстой. Тэгэхдээ одоо ингээд 2 байгаа учраас бол ямар ч тохиолдолд бол дандаа олонхын саналаар ингээд шийдвэр гараад явж байгаа.

Ипотекийн зээлийн хувьд бол энэ хяналт өөрөө яг энэ механизм нь өөрөө өөрөө өөрийгөө хянадаг механизм байгаа. Ялангуяа энэ ипотекийн зээл банкаар олгогдоод дараа нь энэ олгосон зээл нь өөрөө үл хөдлөх хөрөнгөөр барьцаалсан үнэт цаасны хэлбэрт ороод энэ үнэт цаасыг нь МИК-ээс гаргаад ингээд зээлийг нь худалдаж авдаг. Тэгэхлээр МИК буюу Монголын Ипотекийн Корпорац нөгөө банкн дээр олгосон ипотекийн зээлийг худалдаж авахдаа саяын таны хэлж байгаа шалгууруудыг бүгдийг нь үздэг байгаа. 80 м.кв-тад байна уу? Нөгөө анх удаагаа. Тэгэхлээр энд угаасаа өөрөө нөгөө зах зээл нь өөрөө схем нь өөрөө өөрийгөө хянадаг механизм байгаа учраас энэ дээр бол бүүр тусгайлан яг энийг шалгая гэдгээр бол Монгол Банкнаас бол шалгалт хийдэггүй байгаа тийм.

Д.Амарбаясгалан: Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн тодруулж асууя.

С.Эрдэнэбат: Би тэгэхээр нөгөө зээлдэгчийн эрх ашгийг хамгаалдаг субъектээс энэ мөнгөний бодлогын хороондоо оруулбал ер нь зүгээр юм биш үү гэж би бол санал хэлээд байгаа юм. Одоо үндсэндээ сая тэр тэтгэврийн зээлийг тэгвэл тэр манай МУИС-ийн 2 багш тэгээд санхүүгийн нэг багш, тэгээд одоо нэг нь хэн байдаг гэчихэв ээ, бүлгээс гэсэн үү? Тийм. Тэр намын бүлгийн нэг 4 хүн одоо үндсэндээ бараг олонх нь болоод шийдчихсэн юм шиг. Тэгэхээр нөгөө амьдралаас бас жоохон холдчихсон шийдвэрүүд гараад одоо эргэж буцаад маш олон хүнийг бухимдуулаад ахмадуудыг ийм цаашдаа ийм шийдвэр гаргахгүйн тулд би энийг хэлээд байгаа.

Дээрээс нь энэ тэтгэврийн зээлээс гадна орон сууцны зээл, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэх зээлийг ахмадуудад олгож байхгүй бол тэд нарт хүний тооноос хасагдсан юм шиг хаачихсан учраас ганцхан эх үүсвэр байгаа учраас л энийгээ хөөцөлдөөд байгаа юм билээ. Тийм учраас энэ тал дээр бол Ерөнхийлөгч бас та анхааралдаа авч бас өмнө нь Байнгын хороон дээр санал хэлсэн. Зээлийн зарим бүтээгдэхүүнүүдийг дөнгөж 50-тай гарч байгаа хүмүүс чинь одоо ахмад гээд зээлийг

авч болохгүй, өөр зээл авч болохгүй болчихсон асуудлыг бол анхаараач ээ гэдгийг бас хэлмээр байна.

Д.Амарбаясгалан: Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асууж, үг хэлье.

Ц.Идэрбат: Өдрийн мэнд хүргэе. Юуны түрүүнд өнөөдөр бас Монголын ахмадуудын бараг 4 сар одоо бухимдуулсан асуудал нэг тийшээ шийдэгдэж байх шиг байна. Тэгээд ирэх 7 хоногийн хурлын шийдвэр гарах байх. Гэхдээ тэрэн дээр та бас нэг энэ арилжааны банкнууд руу одоо дотоод үйл ажиллагаанд нь оролцдоггүй ч гэлээ гэсэн маш тодорхой болгоод өгөөрэй. Тэгэхгүй бол одоо маш ойлгомжгүй ойлгомжгүй олон зүйлүүд болж, ахмадуудыг маш их чирэгдүүлдэг ээ. Тэрийг бас та бүхэн сайн анхаараарай гэж. Ер нь тэгээд гэнэтийн шийдвэр гаргана гэдэг өөрөө ямар их хортой үр дагавартай вэ гэдэг нь бол бас энэ тэтгэврийн зээлийн асуудлаар гарч ирж байна. Тэгэхээр цаашдаа ч гэсэн ер нь энэ тэтгэврийн зээлийн асуудлын бодлого юмнууд нь бас нэлээн урт хугацаандаа тодорхой байвал хэн хэндээ бас амар юмаа л гэж энэ амьдрал дээр харагдаж байгаа юм.

Ингээд энэ УИХ-ын тогтоолыг бол зарчмын хувьд дэмжиж байгаа. Тэгээд энэ УИХ дээр одоо бас хүү бууруулах асуудлыг ингээд бүүр бодитой ажил хэрэг болгох гээд ажлын хэсэг гаргаад манай Соронзонболд гишүүн зүүн бүсийн гишүүн ахлаад ингээд ажиллаад, тодорхой саналууд оруулж ирж байна. Ер нь бол энэ хүү бууруулах асуудлыг энэ урьд нь харж байх нь ээ зөвхөн нөгөө мөнгөний бодлого яригдах үеэр л нэг халти дурдагдаад л ингээд л өнгөрдөг шүү дээ. Харин энэ удаа бол ингээд бүүр тусгайлан ингээд ярьж байгаа нь бол би бас нэлээн дэвшил гарна аа гэж ингэж бас харж байгаа гэдгээ хэлье.

Тэтгэвэртэй холбоотой дараагийн нэг тодруулах зүйл бол энэ зээлийн хүүгийн асуудал байгаа. Жавхлан сайд аа би наад хүмүүсээс чинь асуулт асуугаад байгаа шүү дээ. Жавхлан сайд аа би наад хүмүүсээс чинь асуугаад байгаа шүү дээ. Зээлийн хүү бууруулах асуудал урт хугацаандаа явах байх. Гэхдээ хамгийн хурдан хийх бололцоотой нь бол энэ тэтгэврийн зээлийн хүүгийн асуудал. Яагаад гэвэл найдвартай эх үүсвэртэй гээд ингээд яригддаг. Энэ асуудал магадгүй энэ УИХ-ын тогтоолоос одоо хэрэгжилтийг хангахаас өмнө та бүхэн бас нэг өөрсдийн зүгээс Монгол банкны зүгээс санаачилга гаргаад ажиллах бололцоо байгаа юу гэж би бас хүсэх гэж байгаа юм. Өнөөдөр Ерөнхий сайд бас та бүхэнд тодорхой чиглэл өгсөн байх.

Дараагийн нэг зүйл бол энэ банк бус санхүүгийн байгууллагуудад сая зээлийн эх үүсвэр олгохгүй нэг 6 сар болж байна шүү дээ үндсэндээ тийм ээ. Тэгээд одоо ер нь тодорхой үр дүн гарч байгаа юу? Энэ хэрэглээний зээлийн хумигдах талын юм байна уу? Энэ 500 гаран ББСБ чинь 5, 6 их наяд төгрөгийн хэрэглээний зээл гаргачхаад байгаа юм байна лээ шүү дээ. Тэгэхээр эндээс гаргаж байгаа шийдвэр бас үр дүнд хүрч байна уу, үгүй юү гэдгийг би лавлаж асуугаад байна.

Дараагийн нэг асуудал бол энэ юутай холбоотой асуудал байна. Гадаад банктai холбоотой гадаад банкны салбар байгуулахтай холбоотой асуудал. Тэгээд сая энэ тогтоолын төсөлд орж ирж байна л даа. Энэ ер нь яг ямар түвшинд явж байгаа вэ гэдэг дээр би бас нэг тодруулга авах гээд байна. СЗХ-ноос одоо сүүлийн үед их яригдаад байгаа. За би энэ цаг дуусаж байна дараа нь тодруулъя. Хариултаа авчхаад тодруулъя.

Д.Амарбаясгалан: 4 дүгээр индрээс хариулт өгье.

Б.Лхагвасүрэн: Идэрбат гишүүний асуултад хариулъя. Тийм нэг дэх өдөр хуралдах Мөнгөний бодлогын хорооноос мэдээж тодорхой шийдвэр гараад, тэрийгээ гарсан өдрөө шууд хэвлэлийн хурлаар бас олон нийтэд танилцуулдаг байгаа. Гарсан өдрөө жишээлбэл гарсан шийдвэрийг баталгаажуулж, арилжааны банкнуудад хүргүүлдэг байгаа. Тэгээд хүргүүлж байх тэр албан тоот одоо захиандаа бас тодорхой чиглэл гарна гэж харж байгаа. Тэгээд таны яг асууж байгаа ялангуяа тэр тэтгэврийн зээлийн хүүгийн асуудал дээр бол Монгол банк бол одоо бас нэг ажлыг хийгээд явж байгаа. Ялангуяа энэ арилжааны банк бол өнөөдөр хууль эрх зүйн орчныхоо хүрээнд бол суурь хүү гэдгээ л зарлах ёстой юм. Тэгэхлээр хамгийн сайн харилцагчийнхаа хүү, дараа нь нөгөө эрсдэлээ тооцоод дараа нь дараагийн харилцагч нар ямар ямар эрсдэлийн жингээрээ хүү нь дээшээ өсөж байх вэ гэдэг ийм зүйл байгаа юм.

Тэгэхлээр өнөөдөр бол одоо манай банк бол банкнууд бол суурь хүүгээ ерөөсөө зарлаагүй байгаа. Тэгэхлээр Монгол банкны хувьд бол одоо та бүхэн энэ суурь хүүгээ зарлах ёстой гэдгээр яаж байгаа. Тэгэхлээр хамгийн сайн харилцагчдадаа өгдөг хүүгээрээ одоо тэтгэврийн зээлийн хүү бол тийшээ ойртох ёстой л гэсэн ийм бас байр суурьтай. Тэгэхлээр энэ тал руу нь биднүүс тодорхой ажил хийгээд явна аа. Өнөөдөр Ерөнхий сайдтай уулзсан. Тэгээд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтраад энэ дээр тодорхой одоо санал тавихыг ийм ярилцсан байгаа. Тэгээд энэ хүрээндээ биднүүс тодорхой санал гаргана аа гэж харж байна.

ББСБ-д банкнаас эх үүсвэр өгөхгүйгээр хэрэглээний зээлийн тэлэлтийг хязгаарлах ажиллагааг СЗХ-той хамт хийгээд явж байгаа. Түрүүчийн дүнгүүд нь бол гарч эхэлж байна. Ялангуяа хэрэглээний зээлийн тоо хэмжээ өсөлт нь бол нэлээн буурч байгаа. Дээр нь импорт бол өнгөрсөн сүүлийн 3 жил бол Монгол Улсад бол одоо өнгөрсөн оны импорт бол 26 хувиар өсөж байсан. Одоогийн ингээд хагас жилийн хүртэл энэ мэдээллээр бол импорт бол ерөөсөө өнгөрсөн оноос өсөлтгүй гарч ирж байгаа. 0 хувийн. Тэгэхлээр энэ бол одоо түрүүчийн шийдвэрийн үр дүн нь ингэж гарч ирж байна аа. Тэгэхлээр хэрэглээ танагдаж байна. Импортоор хэрэглээний бараа орж ирэх нь багасаж байна аа гэж харж байгаа.

Гадаад банктай холбоотой асуудлаар бол Монгол банк бол эрх зүйн орчноо нэлээн суллагдсан явж байгаа. Тэгээд яг өнөөдрийг хүртэл бол Монгол банканд бол одоо гаднын банкны салбар нээе гэсэн ийм санал ирээгүй. За тэгэхдээ гаднаас бол 2, 3 бас санхүүгийн байгууллагууд ирж уулзалт хийж байгаа. Зарим нь бол олон улсын бас хоригтой холбоотой асуудлууд бас яригдаж байгаа. Зарим нь бол одоо яг тухайн банк маань арилжааны үйл ажиллагаа эрхлэхгүйгээр одоо тэр шинэ хуультай Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулах боломжтой гэдгээр мэдээллийг бол сайн гаргаж өгч байгаа. Тэгээд бидний хувьд бол одоо Монгол Улсын эдийн засаг өөрөө ингээд ковидын дараа сэргээд явж байгаа учраас энэ ондоо багтах нь уу, багтахгүй бол ямар ч байсан нэг эхний саналууд бол орж ирэх байх аа гэж харж байгаа.

Д.Амарбаясгалан: Идэрбат гишүүн тодруулж асууя.

Ц.Идэрбат: Ингээд хэрэглээний зээлийг хумих тал дээр Монгол банк ганцаараа үүрэг хүлээгээд авах биш СЗХ-тойгоо ингэж явахгүй бол зөвхөн Монгол

банк хэрэглээний хүүг бууруулах, хэрэглээний зээлийг багасгахын тулд ингээд нөгөө тэтгэврийн зээлээс эхлээд байхаар наадах чинь нөгөө нэг дийлсэн дэлдийснээ гэдэг шиг юм болоод байна аа гэж ингэж хэлж байгаа. Би СЗХ-ноос нэг зүйл асуух гэж байна. Энэ ипотекийн зээлийн олголттой зэрэгцээд энэ 8 сарын 1-нээс тэр амьдралын даатгал гэдэг нэг зүйл бас орж ирнэ ээ гэдэг ийм мэдээлэл яваад байгаа. Энэ хэр үндэслэлтэй вэ? Заавал тэгэх шаардлага байгаа юу? Энэ амьдралын даатгал одоо албан журмын даатгал шиг заавал даатгуулах уу, сонголттой байна уу нэгд.

Хоёрт, даатгалд даатгуулсан хүн эрсдэлд орлоо, амьдралын чанар муудлаа гэж үзэхэд тэр ипотекийн зээлийг одоо цуг зээлсэн одоо гарын үсэг зурж авч байгаа шүү дээ хүн тийм ээ. Тэр хүмүүст одоо хамаарахгүй байх уу, тэр хүмүүсийн санхүүгийн ачаалал буурах уу энэ заавал байх ёстой юм уу? Яагаад ингээд байгаа юм бэ гэж.

Д.Амарбаясгалан: Лхагвасүрэн ерөнхийлөгч хариулт өгье. За Жамбаажамц дарга.

Т.Жамбаажамц: Идэрбат гишүүний асуултад хариулъя аа. Моргейжийн зээл зээлийн даатгалын бүтээгдэхүүн гэж бий. Манай СЗХ-ны зохицуулалтын хүрээнд ялангуяа энэ даатгалын хууль тогтоомжоор бол энэ төрлийн даатгалын бүтээгдэхүүн бол сайн дурын даатгалын хэлбэрээр явдаг сайн дурын. Банкнууд бол моргейжийн зээлийг олгохдоо тухайн зээлдэгчийн одоо амь нас болон тухайн одоо хөрөнгийг эд хөрөнгийн даатгалд бол даатгаад явдаг. Одоо өнөөдрийн байдлаар бол ерөнхийдөө зөвхөн зээлдэгчийн гэнэтийн осол даатгагдаад байгаа юм. Зөвхөн гэнэтийн ослоор нас барсан тохиолдолд даатгагдаж байгаа. СЗХ энийг энэ сайн дурын даатгалын бүтээгдэхүүнийг даатгуулагчийг илүү эрсдэлийг нь хамгаалах үүднээс бүх төрлийн одоо өвчнөөр гэдэг юм уу ямар нэгэн байдлаар шалтгаан үл хамаараад одоо зээлдэгч нас барсан тохиолдолд үлдсэн хугацааных нь даатгалын одоо...

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

Т.Жамбаажамц: Үлдсэн хугацааных нь одоо төлбөрийг даатгалын компани зээлдэгчийн өмнөөс банканд төлөх ийм одоо зохицуулалтыг бол оруулсан. Гэхдээ энэ бол сайн дурын даатгалын бүтээгдэхүүн байгаа. Өнөөдрийн байдлаар нийтдээ 120 гаруй мянган ипотекийн зээлийн одоо зээлдэгч байж байгаа. Энэ дотор бол одоо 6 хувийн хүү хөтөлбөрөөр олгосон ч байгаа. Банк өөрийнхөө эх үүсвэрээр олгосон зээлдэгч ч байгаа юм. Тэгэхээр энэ 123 мянган одоо даатгуулагч бол анх даатгалынхаа гэрээгээ өнөөдрийн байдлаар хийчихсэн явж байгаа. Энэ улсууд бол заавал энэ рүү одоо шилжих ийм бол үүрэггүй.

Цаашид илүү өөрийгөө нийтдээ энэ нас баралтын нэг 20 хүрэхгүй хувь нь гэнэтийн ослоор нас бараад байгаа юм. Өөрөөр хэлбэл хамгаалагдаад байгаа юм. Тэгэхээр өөрийнхөө тэр эрсдэлийг цаашаа хамгаалаад илүү сайн түвшинд эрсдэлээ хамгаалъя гэвэл энэ рүү шилжих боломж нь нээлттэй. Ийм л даатгалын бүтээгдэхүүн. Нөгөө талдаа хөдөлмөрийн чадварыг түр алдалт, 70-аас дээш хувь алдсан тохиолдолд мөн орлого нь тасалдаг учраас энэ тохиолдолд бас даатгалд хамруулдаг болж байгаа ийм л бүтээгдэхүүн байгаад байгаа юм. За баярлалаа.

Д.Амарбаясгалан: Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн асуулт асууя.

Х.Булгантуяа: Зээлийн хүүгийн асуудал бол манай иргэдийн хамгийн их бухимдаж байгаа асуудлын нэг ээ. Тэгээд би нэг ийм юм асуух гэсэн юм Лхагваа ерөнхийлөгч өө. Өмнөх парламентад бид нар зээлийн хүүг бууруулах стратеги гэж баталж байсан. Энүүнийг манай СЗХ өнөөдрийн манай Жадамбаа дарга, дээрээс нь нэмээд Лхагваа ерөнхийлөгч өөрснөө ч гэсэн оролцож байгаад энийг баталж байсан. За энүүний хэрэгжилтийг та бүхэн маань өөрснөө юу гэж дүгнэж байгаа юм бэ? Энд дандаа Монгол банк, СЗХ дээрээс нь нэмээд зарим нь Засгийн газар луу чиглэсэн үүрэг даалгаврууд өгсөн. Үүний хэрэгжилтийг та бүхэн юу гэж харж байгаа юм? Энэ зээлийн хүүгийн стратеги уг нь биелсэн бол зээлийн хүү буурах ёстой байтал одоо ингээд бүүр эсрэгээрээ өсчихлөө. Тэгэхээр одоо үүнийхээ хэрэгжилтийг та бүхэн хэн нь, хаана, ямар алдаа гаргав аа. Тэрүүнийгээ нэг хараач ээ.

2 дахь нь ингээд бид нар зээлийн хүү ярихаар нэг 2, 3-хан юм руу ерөнхийдөө бол бурууг нь чихчихдэг юм. Ингээд улсын төсөв хэт тэлээд байна аа тэгээд энэ нь бас ингээд одоо манай зээлийн хүү инфляц дээр ялангуяа нөлөөлж байна аа, өдөөгдөж байна аа гээд одоо 32 их наядын бол бараг 3-ны 1 нь ер нь бол импортыг өдөөж байгаа. Тэгэхээр энэ бол мэдээж инфляц дээр бол нөлөөлж байгаа байх. Тэгэхдээ төсвийн, санхүү төсвийн тогтвортой байдлын зөвлөл тиймээ, санхүүгийн зөвлөл, тэр зөвлөл маань, ер нь та бүхэн маань уг нь бол өөрснөө хуралдаад энэ бүгдийг бас харж байх ёстой биз дээ. Өнгөрсөн жил чинь 2 удаа та бүхэн бодлогын хүүгээ бууруулаад, зээлийн хэмжээ нэлээн огцом нэмэгдээд араас нь инфляц нь эсрэгээрээ нэмэгдээд, магадгүй зээлийн хүүг бууруулахад зээл авдаг хэдэн том ААН-үүдэд ашигтайгаар байж магадгүй. Харин инфляц үзэгдэнэ гэдэг бол нийт Монгол Улсын бүх хэрэглэгч хүн амд очиж нөгөөдөх нь нялзаадаг тийм хүнд үр дагавартай.

Тэгэхээр энэ дээрээ та бүхэн маань ямар үр дагавар, ямар өөрснөө дүгнэлт хийсэн юм бэ нэгдүгээрт. Ингээд 2 дугаарт зээлийн хүүгээ бууруул аа гээд л тэгэнгүүт шууд хөөрхий хамгийн түрүүнд нөгөө муу ахмадын тэтгэврийн зээлээр л оролдоод эхлэх юм. Тэр чинь танай гарсан хэдэн их наядын зээл дотор тэр чинь одоо 20, 30 их наядаар яригдаж байгаа зээлүүд дотор зээлийн хүүгийн тэтгэврийн зээлийн одоо хэмжээ үлдэгдэл бол өчүүхэн жоохон мөнгө байна лээ шүү дээ. Та бүгдийн мэдээллээс нэг 1 аравны хэдэн хувь билүү их наяд билүү тийм мөнгө ярьж байсан. Тэгэхээр хамгийн бага үр дагавартай, дээрээс нь нэмээд хамгийн бага хэмжээтэй, яг хамгийн одоо ахмад настай хүн бол тэтгэврийн зээл авч байна аа гэдэг бол энэ бол үнэхээр амьдралд нь шаардлагатай болоод л авч байгаа. Тэрнээс нэг монгол хүний санаа сэтгэл чинь ялангуяа ахмадууд үр хүүхдүүддээ зээл үлдээхгүйг л боддог хүмүүс шүү дээ. Тэгэхээр ийм юмаар оролдох шаардлага байсан юм уу? Энийг та бүхэн өөрснөө гэнэт санаж сэдээд ийм юм хийчихэв үү? Одоо хаанаас ийм санал санаачилга гараад яваад өгөв өө Лхагваа ерөнхийлөгч өө. За одоо энэ ямар ч байсан засагдах юм шиг байна. Тэгэхдээ нийгмээр юу гэж бухимдаад байна вэ гэхээр зүгээр байсан юмыг муутгаж хаячхаад одоо буцаад нэг байранд нь оруулсныгаа нэг их юм хийчихсэн юм шиг битгий пиардаад бай гэж шүүмжлээд байх шиг байна лээ. Тэгэхээр энэ хэдэн асуултад...

Д.Амарбаясгалан: Лхагвасүрэн ерөнхийлөгч хариулт өгье 4 дүгээр индэр.

Б.Лхагвасүрэн: Булгантуяа гишүүний асуултад хариулъя. Тийм 2019 онд зээлийн хүүг бууруулах стратегийг баталж гаргаж байсан. Тэгээд УИХ-аас. Тухайн

үед бол одоо зээлийн дундаж хүү 16 хувьтай, тэгээд энийг бол одоо ер нь буулгахаар л ингэж гарсан. Тэгээд зээл энэ стратеги бол эхний 1, 2 жилдээ маш сайн хэрэгжиж явсан. Ялангуяа 2021 оны эхний хагас жилд. Зээлийн дундаж хүү 12 буюу сарын 1 хувьд хүрээд ингээд ирж байсан ийм. Цаг хугацааны хувьд бол ингээд үр дүнгээ өгөөд явж байсан. Тэгээд 2020 оноос эхлээд ковид гарсан, бүх хил хорио хаагдаад, бизнес зогссон хамгийн төвөгтэй үе эхэлсэн учраас эргээд ингээд бизнес зогсоод зээл шинээр гаргах биш харин ковидын үед одоо олгочихсон зээлийгээ яаж аж ахуй зээл авчихсан ААН-үүдийг яаж зээлийн хүү болон зээлийн дарамтгүй байлгах вэ гэдгээрээ дандаа шийдвэрүүд нь дандаа тэрэнд зориулж шийдвэр гараад ингээд явчихсан.

2022 онд ингээд эргээд геополитикийн хурсан нөхцөл байдал буюу одоо Орос, Украины дайн эхэлсэн. За энэ үед бол инфляц одоо хамгийн дээд түвшин буюу 2022 оны 6 сард 16.9 хувьд хүрээд инфляц ингээд эргээд манай Монгол банк бодлогын хүүгээ өсгөж ингээд явуулсан. Тэгэхлээр эргээд бидний хүрсэн зорилт маань өөрөө эндээс эхлээд ковидын болон геополитикийн хурцадмал нөхцөл байдлаас ингээд эвдэгдээд ингээд явсан.

Өнөөдрийн байдлаар бол зээлийн хүү бол ингээд 17 хувьтай байна гэдэг маань яг тэр 2019 оны яг тэр түвшин дээр ингээд эргээд буцаад оччихсон байгаа юм. Тэгэхлээр эргээд одоо өнөөдөр гарч байгаа зээлийн хүү бууруулах стратеги бол одоо ингээд эдийн засаг макро эдийн засгийн орчин хэвийн байдалд ороод ингэж байгаа учраас одоо энэ стратегиа шинэчлээд эргээд явъя аа гэсэн ийм л шинэ стратеги батлагдаж байна аа гэж Төв банкны зүгээс харж байгаа юмаа.

Бодлогын хүүтэй холбоотой таны асуусан асуултад ерөнхийдөө ОУВС-ийн дүрийн 4 дүгээр заалтаар сая баг ирээд ажиллаад явсан. Одоо ингээд удахгүй дүрмийн 4 дүгээр заалтынхаа тайланг бол олон нийтэд мэдээлэх байх. Тайлан дээр юу гэж дурдагдсан бэ гэхлээр ерөнхийдөө Монгол банк бол мөнгөний хатуу бодлогоо баримталж явж байгаа нь хэвээрээ ингээд явна. Энийгээ үргэлжлүүлэх нь зүйтэй. Гэхдээ тэр ялангуяа өнгөрсөн онд тэр зээлийн хүүг одоо бас бодлогын хүүгээ 2 нэгжээр буулгасан нь арай эртэдсэн алхам болсон байх аа гэсэн ийм дүгнэлт гарсан байгаа. Урьдчилсан байдлаар. Тэр маань өөрөө Монгол банкны зүгээс бол бид энэ шийдвэрийг гаргахдаа бас юуг бодолцсон бэ гэхлээр Монгол банкны үндсэн зорилго бол мэдээж инфляц буюу үнийн тогтвортой байдлыг хангах энэ зорилгын үүднээс мөнгөний бодлого хэрэгжүүлж байгаа.

Тэгэхлээр зэрэгцээд эдийн засгийн өсөлт бол бас тодорхой хэмжээнд бас манай зүйл зайлшгүй анхаарах зүйл байдаг. Ялангуяа Төв банкны тухай хууль дотор бол санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах замаар эдийн засгийн өсөлтөд дэмжлэг үзүүлнэ ээ гэсэн зүйл байгаа юм. Тэгэхлээр бид бодлогын зөвхөн инфляцаа хараад мөнгөний хатуу бодлого явуулахаас гадна бас эдийн засгийнхаа тодорхой өсөлтийг хадгалах зорилгоор өнгөрсөн онд бол нэг бодлогын хүүг 2 нэгжээр буулгасан байгаа. Сая бол буцаагаад ингээд өсгөсөн. Яагаад гэвэл инфляц өөрөө нам доор түвшинд очихгүй ээ. Тэгэхлээр энэ маань өөрөө бол яг нэг инфляцыг өдөөгдсөн гэж биднүүс бол Монголын банкны зүгээс бол харахгүй байгаа.

Тэтгэврийн зээлтэй холбоотойгоор ерөнхийдөө өнгөрсөн оны 11 сард Гэр бүл, нийгмийн хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас Монгол банканд хүсэлт тавьсан байгаа. Тэр нь бол одоо тэтгэврийн зээлтэй ахмадуудын одоо амьдралын түвшин нэлээн доройтчихсон байна, энэ нь өөрөө тэтгэврийн зээл бол нэлээн ийм

хэмжээ хязгааргүй олгогдож байгаатай холбоотой байна гэдгээр энийг хязгаарлах талаар ингээд арга хэмжээ аваач гэсэн санал ирүүлсэн. Энэний дагуу энэ 2025 оны 3 дугаар сард Монгол банк одоо энэ хэрэглээний зээлийн дотор ялангуяа тэр тэтгэврийн зээл авч байгаа иргэдийн амьжиргааны баталгаажих доод түвшин буюу тэр 470 мянган төгрөг нь өөр дээрээ зайлшгүй үлдэх ёстой юм байна аа гэдгээрээ ийм зохицуулалтын арга хэмжээ авсан. За энэ нь...

Д.Амарбаясгалан: Булгантуяа гишүүн тодруулж асууя.

Х.Булгантуяа: Одоо ерөөсөө бид нарын маш том зорих ёстой юм бол иргэдийн хэрэглээг хязгаарлахаасаа илүүтэйгээр инфляцаа бууруулахад бүгдээрээ анхаарах ёстой юм байна аа. Тэгээд энийг бол хэдүүлээ хэд хэдэн удаа авч үзсэн шүү дээ. Лхагваа ерөнхийлөгч тиймээ. Бид нар иргэдийн хэрэглээний зээлийг одоо бууруулах арга хэмжээг аваад аваад энэ бол ялангуяа сая өнгөрсөн 2 жилд магадгүй бид нар цалин тэтгэврийн нэмэгдлүүд нэлээдгүй хийсэн. Цар тахал ковидын дараа байж таарсан. Хэрэглээ өдөгдсөн зүйлүүд бас байж магадгүй. Гэхдээ нийтдээ одоо 2024 оны сүүлээр 36 их наядын нийт зээл дотор тэтгэврийн зээлийн зээл 1.8 их наяд энэ бол өчүүхэн жоохон тоо байхгүй юу. Тэгэхээр ийм юмаар битгий та бүхэн маань дахиж битгий их оролдоорой. Ахмадын тэтгэврийн зээл энэ бол одоо эмчилгээний зардалд, дээрээс нь нэмээд заримдаа амьдралынхаа хүүхдүүдийн одоо хүүхдүүдийнхээ амьдралд нэмэрлэж байгаа зүйлүүд байгаа байх. Тэгэхдээ хүүхдүүд нь ч гэсэн ээж аавынхаа амьдралд эрүүл мэндэд нэмэрлэж байгаа зүйлүүд бас байгаа.

Тэгэхээр ийм зүйлээр 1 дүгээрт бас битгий оролдоорой. 2 дугаарт ер нь энэ инфляцыг бууруулахтай холбоотой зээлийн хүү...

Д.Амарбаясгалан: Гончигдоржийн Уянгахишиг гишүүн асуулт асууж үг хэлье.

Г.Уянгахишиг: Оройн мэнд хүргэе ээ. Тэгэхээр ер нь болбол тогтоолд тусгасан асуудлууд бас нэлээн хэрэгтэй буюу цаашдаа яг үр дүн гаргавал гаргах боломжтой бас даалгаврууд орж ирж байна уу даа гэж харж байна. Энэчээнээс нэг тодруулмаар байгаа нь болбол яг 4 дүгээр заалт байгаад байгаа. Энэ дээр зээлийн үнэлгээг үл хөдлөх эд хөрөнгийн барьцаанд тулгуурлан тооцох аргачлалыг судалж, сайжруулах санал боловсруулан танилцуулах гэхчхэн. Гэтэл энэний цаана миний ойлгож байгаагаар болбол зөвхөн үл хөдлөх хөрөнгийн барьцаанд буюу нөгөө өндөр хувь тогтоодгийг нь арай бууруулаад тиймээ өөр төрлийн барьцаа хөрөнгүүд мөн одоо зээлдэгчийн зээлжих зэрэглэлийн тооцооллыг оруулах гэдэг юм уу тиймээ иймэрхүү байдлаар сайжруулахыг хэлж байна аа гэж ойлгоод байна. Тийм учраас яг энэ тогтоол дээр уг нь өөрчлөөд илүү тодорхой болгоод оруулбал яасан юм бэ? Жишээлбэл би ингэж тодорхойлоод байна.

Зээлийн үнэлгээг үл хөдлөх хөрөнгийн барьцаанд тулгуурлан тооцох аргачлалыг шинэчлэх, зээлдэгчийн зээлжих зэрэглэл болон бусад төрлийн барьцаа хөрөнгийг харгалзан үзэх боломжийг судлан санал боловсруулан танилцуулах гэсэн иймэрхүү тодорхой үгээр авахгүй бол яг одоо байгаа санал нь бол нөгөө тийшээгээ одоо яг аль тийшээгээ сайжруулах гээд байгаа юм. Юугаар орлуулах гээд байгаа юм гэдэг чинь тодорхойгүй байгаад байна. 2 дахь асуулгын хувьд болбол Сангийн яамнаас Жавхлан сайд аа танаас асуумаар байгаад байгаа Сангийн яамнаас. Одоо бид нар зээлийн хүүг бууруулъя гэвэл нөгөө талдаа эх үүсвэрийнхээ зардлыг

багасгах ёстой байгаад байгаа. Жишээлэх юм болбол ААНОАТ-ын тухай хуулийн 20.2.6-д арилжааны банкны хувьд бол дотоод, гадаадын эх үүсвэрээс татсан зээл, өрийн хэрэгслийн хүүгийн орлогод 5 хувийн татвартай байгаа. Бусад санхүүгийн байгууллагуудын хувьд бол жишээлбэл гадаадынх байвал 20 хувьтай, дотооддоо бол 10 хувьтай байгаа.

Тэгэхээр энийг адилхан болгох боломж байдаггүй юм уу. Тэгэх юм бол одоо яг энэ тогтоолын гол зорилго бол зөвхөн банк гээд байлгүйгээр бусад санхүүгийн байгууллагууд болон тиймээ хөрөнгийн зах зээл, хөрөнгө оруулалтын сангуудаас оролцоог нь нэмж байж энэ одоо зээлийн хүү бууруулах боломжит бусад бүтээгдэхүүнтэйгээ бас одоо хоршуулах энэ нөхцөл байдлыг үүсгэх гээд байна гэж хараад байгаа учраас энэ татвар талаасаа өөрчлөлтүүдийг оруулаад явах боломж байдаггүй юм уу? Энэ тогтоол дээрээ бас үүрэг аваад явчихвал бас болдоггүй юм болов уу гэж бас асуумаар байна Жавхлан сайд аа_

Д.Амарбаясгалан: Соронзонболд гишүүн хууль санаачлагч тогтоолын төсөл санаачлагч хариулт өгье.

Л.Соронзонболд: Би энэ Уянгахишиг гишүүний эхний асуултад хариулчихъя. Тэгээд дээрээс нь нэмээд Монгол банк хариулчихна биз. Яах вэ энэ тогтоолын 4 дүгээр заалтын гол утга санаа нь юу гэж байгаа вэ гэхээр зээлийг судлаад олгох шийдвэр гаргахдаа үл хөдлөх эд хөрөнгөд хэтэрхий их тулгуурлаад байна аа гэдэг санаа 1 дүгээрт байгаа. 2 дугаарт болохоор бол одоо арилжааны банк болон ББСБ-ын зээлийн үйл ажиллагааг үнэлэхдээ тухайн зээл нь үл хөдлөх хөрөнгийн барьцаатай байх юм бол илүү одоо хувийн жин өгөөд байгаа гэдэг ийм аргачлалын асуудал байна аа. Тийм учраас тухайн зээлийг бол зөвхөн одоо үл хөдлөх хөрөнгийн барьцаа гэхгүйгээр бусад тийм ээ тухайн төсөл нь илүү үр ашигтай байж болно, яг одоо мэргэжлийн төсөл, сайн төсөлтэй өөр хөдлөх хөрөнгийн барьцаатай ч гэдэг юм уу, бусад зүйлүүдийг харгалзаж үзэх асуудлыг анхаараасай гэдэг талаас нь оруулсан ийм заалт шүү гэдгийг тайлбарлаж хэлэх гэсэн юм. Тэгээд бусдад нь Монгол банк хариулах уу.

Д.Амарбаясгалан: Лхагвасүрэн ерөнхийлөгч нэмж хариулт өгье 4 дүгээр индэр.

Б.Лхагвасүрэн: Уянгахишиг гишүүний асуултад хариулъя. Тийм яг энэ Соронзонболд гишүүнтэй яг адилхан санаа байгаа. Ер нь бол өнөөдрийн манай банкны үйл ажиллагаа бол ер нь зээл олгохдоо барьцаа хөрөнгийг шууд хараад л за барьцаа хөрөнгийг нь тодорхой хэмжээнд үнэлээд тэр хэмжээгээр бас тодорхой хэмжээгээр хямдруулаад тэгээд зээлээ олгоод явж байгаа юм. Монгол банкны хувьд бол угаасаа энийг олон улсынхаа жишигт нийцүүлэх тал руу нэлээн өөрийнхөө дотоод дүрэм журмыг өөрчилж байгаа. Ялангуяа бидэнд бол нэлээн туршлага хуримтлагдсан. ОУВС-тай хамтраад хөтөлбөр хэрэгжүүлж байхад активын чанарын үнэлгээ гэж үнэлгээг хийсэн. Дараа нь Монгол банк өөрөө энэ банкнуудыг нээлттэй ХК-ийн хэлбэрт шилжүүлэхээсээ өмнө бас энэ активын чанарын үнэлгээг хийсэн байгаа. Тэгэхлээр активын чанарын үнэлгээ тэр ялангуяа тэр Европын Төв банкны аргачлалын дагуу хийгдэхдээ тэр барьцаа хөрөнгийг илүү яахаасаа үнэлэхээсээ илүү тэр бизнесийнх нь үйл ажиллагаа нь хэр өөрөө мөнгөн урсгал нь хэр байдаг юм, тэрэн дээр илүү анхаардаг.

Д.Амарбаясгалан: Тодруулж асууя.

Г.Уянгахишиг: Эхнийх болбол асуулт гэхээсээ илүүтэйгээр санал байсан. Одоо ерөнхийдөө өөрчлөн найруулах боломжууд байна уу гээд. 2 дахь нь гол нь асуулт байгаад байгаа юм. Тэрэн дээр одоо хэрвээ Сангийн яам хариулж болохгүй юм бол нөгөө яг энэ чинь ажлын хэсгээс хариулах боломж байхгүй гэсэн үг үү? Яана гэсэн үг вэ? Тийм.

Д.Амарбаясгалан: Жавхлан сайд хариулт өгье.

Б.Жавхлан: Уянгахишиг гишүүний асуултад хариулъя. Зээлийн хүү бууруулна гэдэг дээр болбол одоо тийм ийм механик бууралтууд нэг их урт насгүй шүү. Ер нь эдийн засаг өөрөө тогтворжиж байж, макро тэнцвэр одоо урт хугацаанд тогтвортой байж байж л аяндаа энэ зээлийн хүү бууж ирдэг. Яг энэ үзэгдэл уг нь сүүлийн 30 жилийн хугацаанд яг энэ ковидын өмнө болж ирж байсан юм. Одоо ингээд 17, 8 руу ирчихсэн байна. Яг 2019 онд буюу ковидын өмнөх жил зээлийн дундаж хүү сарын 1, буюу жилийн 12 хувь руу яг ирж байсан байхгүй юу. Ер нь бол макро эдийн засгийн тэнцвэр их аятайхан болж орж ирж байсан. Олон улсын валютын сангийн хөтөлбөрийн дараахан. Гэтэл ингээд одоо биднээс үл шалтгаалсан ийм юм руугаа яваад ороод буцаад нэг бид нар ийм байдалд орчихлоо. Яах вэ одоо тэр зардлуудаас хэдүүлээ буулгана гээд тэгж байна. Саяын таны хэлдэг тэр нөгөө банкны эх үүсвэр дээр гаднаас орж ирээд Монголоос орлого олоод гадагшаа гарч байгаа бол 5 хувь болчихсон шүү дээ.

Д.Амарбаясгалан: Дахин тодруулж асууя. Уянгахишиг гишүүн.

Г.Уянгахишиг: Харин зөвхөн арилжааны банкуудын хувьд болохоор 5 хувь байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ нь бусад санхүүгийн байгууллагуудын хувьд бас дотоод, гадаадын эх үүсвэрээс татсан зээл, өрийн хэрэгслийн хүүгийн орлого нь адилхан 5 хувь байж болохгүй юу? Тэгэхгүй бол одоо гадныхнх гэхэд л 20 хувь шүү дээ. Тэгэхээр 20, 5-ын ялгаа чинь өөрөө 15 хувь байгаа биз. Тэгэнгүүт одоо бусад яг тэр зээлийн хүүгээ бусад зээлийн хүүгээ ч гэсэн бууруулъя. Бас хөрөнгийн оруулалтын сангуудаас болон хөрөнгийн зах зээл дээрээс босгож байгаа өрийн хэрэгслүүд дээрээсээ хүүг нь багасгая гэвэл энэ нөгөө орлогын татварын хувь чинь бас хамтдаа буугаад явчихвал эх үүсвэрийн зардал буурахад бас нөлөөтэй юм уу л гэж харж байхгүй юу. Тэгээд тэрийг л асуугаад байгаа юм. Банкнаас бусад санхүүгийн байгууллагын хувьд.

Д.Амарбаясгалан: Жавхлан сайд хариулт өгье.

Б.Жавхлан: Гол масс эх үүсвэр нь банкаар дамжаад манай хэрэглэгч дээр ирж байгаа учраас хамгийн эхний ээлжид банкн дээр ингэсэн байгаа. Өмнө нь бол нөгөө нэг Сингапур гээд нэг улс дээр ингээд заачихсан тийм харилцаанууд байсан шүү дээ. Тэгээд ингээд банкн дээр болбол нөгөө Сингапураар дамжиж орж ирээд байдаг нэг ийм урсгал үүсээд байсан учраас ингээд жигд тавьсан юм байна лээ. Банкнаас гадуур гэхихээр энэ яг олон улсын яг нөгөө вебсийн зарчим нөгөө үнэ шилжүүлэх эдгээр асуудлууд дээр зөрчил үүснэ ээ. Ер нь бол дэлхийн нийтээр болбол дундаж татвар болбол энэ чинь яг энэ төрлийн татвар чинь 10-15 байгаа байхгүй юу. Одоо давхар татварын гэрээгээр ч гэсэндээ энийг зохицуулж болно. Гэтэл өөр улсууд дээр бид нар 5 болгочихлоо ч гэсэн цаад талдаа 10-15 тийм л байгаа.

Тэгэхээр тэрийг бид нар өөрсдөө цоолж ингэх юм болбол энэ ой си ди-гийн ийм зарчмууд зөрчигдөөгүй учраас энэ ерөөсөө боломжгүй асуудал. Харин бид нар яаж харин банкн дээр ингээд гол яг масс эх үүсвэр дээрээ ингэчихсэн юм. Тэр 2019 онд орсон өөрчлөлтөөр тийм болчихсон юм байна лээ тийм.

Д.Амарбаясгалан: Цэндийн Баатархүү гишүүн асуулт асууя.

Ц.Баатархүү: Та бүхэнд оройн мэнд хүргэе. Энэ Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн маш чухал асуудал яг энэ тогтоол болгож оруулж ирж байна. Тогтоол гаргах нэг хэрэг, үүний хэрэгжилтийг хангах бас нэг хэрэг байгаад байна аа. Зээлийн хүүг бууруулах чиглэлээр хэд хэдэн тогтоол гарсан. Энэний хэрэгжилтийг бид нар бол илүү сайжруулах хэрэгтэй. Гэхдээ бид нарын арга барил нэг арай буруу тийшээ яваад байна. Утааг бууруулъя гэхээр яндан, зуух, түлш, дотоод орчны агаар шүүгчтэй ажилладаг. Зээлийн хүүг бууруулъя гэхээр цэвэр ингээд нэг бодлогын хүүтэй ажилладаг. Зээлийн хүү гэдэг бол миний ойлгож байгаагаар суурь эдийн засгийн асуудлыг илэрхийлж байгаа илрэл гэж байна гэж боддог. Тэгэхээр илрэлтэй нь бид нар хүчээр тэмцэх гээд байдаг, механикаар тэмцэх гээд байдаг, тогтоол гаргаад байдаг, эцсийн дүндээ үр дүн гардаггүй. Тэгэхээр би ийм 2, 3 тодорхой зүйлийг асууя аа гэж бодож байна.

Өнөөдөр энэ бодлогын хүү инфляцын балансыг авч явна гэдэг бол маш чухал хэцүү асуудал гэж бодож байна. Монгол банк цаашдаа энэ банк санхүүгийн салбарт Монголын банкнуудыг төрөлжүүлэх асуудал дээр ямар бодол санаатай явдаг юм бэ? Дэлхийн зарим улс орнуудад бол банкнууд нь төрөлжсөн байдаг. Өнөөдөр Монголын банк болон ББСБ бүх салбарт оролцдог бүх салбарт бүтээгдэхүүн гаргадаг, зээл өгдөг, зээл нь хүрэлцдэггүй. Монголын зарим нэгэн бүтээн байгуулалтын ажил улирлын чанартай байдаг. Тухайн улиралдаа хангалттай хөрөнгө оруулалт татаж чадаагүйгээсээ болоод энэ одоо дулааны улиралд бүтээн байгуулалтын ажлаа хийж дийлдэггүй. Гэтэл зарим улс оронд бол зөвхөн зам тээврийн банк, барилгын банк, Хөдөө аж ахуйн банк гэж төрөлждөг. Ингэснээрээ тухайн салбар илүү хөгжиж байгаа ийм тохиолдлууд байна аа. Тэгэхээр цаашдаа банкнуудыг төрөлжүүлэх асуудал дээр Монгол банк ямар бодлого барьдаг юм бэ, ер нь ямар байр суурьтай юм бэ гэдгийг асууя.

2 дугаарт нь энэ банк санхүүгийн салбар банкны ил тод байдал, засаглалыг сайжруулах чиглэлээр 20 хувийг нь нээлттэй болгох хууль хэрэгжсэн. Үр дүн ямар байгаа юм бэ? Цаашдаа 40 хувийг нь нээлттэй болгож хувьцаа гаргах, олон нийтэд нээлттэй болгох ийм бодлого байгаа юу гэж асууя.

3 дугаарт нь, энэ банк санхүүгийн салбарыг тойрч яриад байвал зээлийн хүү буурахгүй ээ. Зээл авахаас өөр одоо арга замгүй байна аа. Монголчууд бизнес хийе ээ, цалингаас цалингийн хооронд, цалингийн зээлтэй, ахмадууд нь тэтгэврийн орлого барьцаалсан зээлтэй байна аа. Бусад санхүүгийн эх үүсвэрийг татах тэр зах зээлүүдийг хөгжүүлэх чиглэлээр СЗХ ер нь ажил хийж байна уу? Энэ хөрөнгийн зах зээл гэдэг зүйлээ хөгжүүлэх юм уу, бондын зах зээл гэдэг зүйлээ хөгжүүлэх юм уу, хөрөнгө оруулалт татах бусад эх үүсвэрийг бий болгох чиглэл дээр...

Д.Амарбаясгалан: 4 дүгээр индрээс Лхагвасүрэн Ерөнхийлөгч хариулт өгье.

Б.Лхагвасүрэн: Баатархүү гишүүний асуултад хариулъя. Тийм энэ 1991 онд Банкны тухай хууль гарсан. 1991 оны Банкны тухай хууль дээр бол төв банк

арилжааны банк 2 нэг хуультай явсан. 1996 онд энэ 2 хууль салсан. Төв банкны тухай хууль болон Арилжааны банкны тухай хууль гээд. Энэ хууль ингээд анхнаасаа явахдаа нийтлэг үйл ажиллагаа буюу одоо олон улсын хэллэгээр бол Универсал гэдэг ийм л үйл ажиллагаагаар ингээд явж байгаа. Тэгээд сая 2 жилийн өмнө бол одоо Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хууль гээд бас гарлаа. Энэ бол үнэт цаасны зах дээр үйл ажиллагаа явуулах ийм чиглэлээр ийм хууль эрх зүйн орчин бий болсон. Тэгэхдээ өнөөдрийг хүртэл бол яг энэ хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үйл ажиллагааны зөвшөөрлийг бол дотоодоос болон гаднаас хэн ч одоо хүсэлт гаргаж аваагүй байна.

Тэгэхлээр одоо өнөөдөр манайд үйл ажиллагаа явж байгаа 12 банк бол 12-уулаа нийтлэг буюу одоо бүгдээрээ л ингээд л нэг ийм ижилхэн үйл ажиллагаатай байгаа юм. Тэгэхлээр таны саналтай бол ер нь бол Төв банк бол ижил байр суурьтай л байгаа юм. Ер нь төрөлжсөн банкиг л хөгжүүлэх ёстой ялангуяа гаднын орнуудад бол худалдааны банк, одоо барилгын банк, замын банк ч гэдэг юм уу, Хөдөө аж ахуйн банк гээд нэлээн тэр салбар луугаа төрөлжөөд явдаг юмнууд байгаа юм. Тэгэхлээр хууль эрх зүйн орчныг л шинэчлэх зайлшгүй шаардлага гарна аа л гэж хэлье. Төв банкны зүгээс харж байгаа. Өнөөдөр бол нэг л хууль байгаа. Банкны тухай хууль гээд.

2 дахь асуултын хувьд бол одоо 2021 онд Банкны тухай хуульд өөрчлөлт оруулаад банкиг бол одоо нээлттэй ХК-ийн хэлбэрт шилжүүлнэ. Тэгээд ХК-ийн хэлбэрт шилжүүлэхдээ нэг хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчийн дээд хязгаарыг 20 хувиар байна аа гэдгээр ингээд тогтоогоод өгчихсөн. Энэний дагуу ингээд 2 жилийн өмнө бол одоо 2023 онд манай арилжааны 5 одоо системийн нөлөө бүхий гэдэг 5 банк бол үнэт цаасны зах зээл дээр гараад хувьцаат ХК-ийн хэлбэрт шилжсэн. Тэгээд одоо бол ингээд цаашаа энийг энэ шинэчлэлтийг үргэлжлүүлэх зайлшгүй шаардлага байгаа хэдий ч одоо хөрөнгийн зах дээрээс нэмж хөрөнгө босгох боломж нь бол гүйцсэн байна аа гэдгийг нь харж байгаа. Яагаад гэвэл өнөөдөр энэ хувьцааны үнэ ханшид хөдөлгөөн байхгүй болсон. Нэмж хувьцаа авъя гэсэн хүсэлт нь ч орж ирэхгүй байгаа. Тэгэхээр гаднын зах зээл рүү гарах л ийм шаардлага л гарч байгаа юм.

Тэгэхлээр өнөөдөр бол манай банкнууд бол Нью-Йоркийн хөрөнгийн бирж, Лондонгийн хөрөнгийн бирж, Хонконгийн хөрөнгийн биржид нэмж хувьцаа гаргахаар ингээд ажлаа хийгээд явж байна. Тэгэхдээ гаднын хөрөнгө оруулагчтай уулзахад бол 20 гэдэг тоог бол нэлээн бас шүүмжилж байгаа. Яагаад гэвэл хэрвээ хяналтын багц буюу одоо компанийн тухай хууль дээр байдаг 34 хувийг, 33 хувийг л авахгүй юм бол бид нь бол одоо манай Монголын банкнаас бол хувьцаа авах тийм шаардлага бол гарч ирэхгүй байна аа. Тэгэхлээр бол та энэ хууль дээрээ та бүхэн энэ хууль дээрээ тодорхой хэмжээний өөрчлөлт оруулаач ээ гэж байгаа юм.

Тэгэхлээр хэрвээ ингэх юм бол тодорхой хэмжээний гаднын хөрөнгө оруулагч нарт нэмж орж ирэх боломж нь байна. За еще нэг заалт нь бол нэг хувьцаа, нэг банкны хяналтын багцыг эзэмшдэг хувьцаа эзэмшигч нөгөө банкны хяналтын багцыг авч болохгүй ээ гэсэн ийм хуулийн хориг болсон заалт байгаа. Энэ заалт дээр ялангуяа олон улсын санхүүгийн байгууллагууд буюу одоо дэлхийн банкны доор байдаг Олон улсын санхүүгийн корпорац, Европын сэргээн босголт хөгжлийн банк бол энэ хуулийнхаа гарцыг нээж өгөх юм бол бид бас танай бусад банкнуудад хөрөнгө оруулах бас боломж бүрдэх юм байна аа. Энэ дээрээ бас хуулийн шинэчлэл хийж өгөөч гэсэн хүсэлтүүд тавьж байгаа.

Д.Амарбаясгалан: Санхүүгийн зохицуулах хороо Жамбаажамц дарга хариулт өгье.

Т.Жамбаажамц: Баатархүү гишүүний асуултад хариулъя аа. Жамбаажамц СЗХ. Зээлийн хүүг бууруулах УИХ-ын тогтоол 2020 оны 21 дүгээр тогтоолоор баталсан. Энэний бас нэг чухал хэсэг нь бол энэ хөрөнгийн зах зээл дээрээс санхүүжилт татах энэ боломжийг нээж өгсөн. Тэгээд энэ хүрээнд бол СЗХ-ноос хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн байгууллагуудтайгаа бол нягт хамтарч ажилласан. Үүний үр дүн бол нэлээдгүй гарсан. Учир юу вэ гэхээр 2020 онд зах зээлийн үнэлгээ 3 их наядын зах зээлийн үнэлгээтэй байсан. Монгол Улсын хөрөнгийн зах зээл. 2024 оны жилийн эцсийн байдлаар 13 их наядын зах зээлийн үнэлгээтэй ийм зах зээл болсон байж байгаа. Өөрөөр хэлбэл одоо 5, 6 дахин, 5 дахин одоо зах зээл бол ингээд тэлсэн байж байгаа. Зөвхөн нэг тоо хэлэхэд бондын зах зээл ялангуяа энэ ААН-үүд, жижиг дунд ААН-үүд бол зээлээс гадна бонд...

Д.Амарбаясгалан: За нэг минут нэмж өгье.

Т.Жамбаажамц: Бондын санхүүжилтээр бол одоо эх үүсвэрээ татдаг. Энэ бол бас банктai харьцуулахад их тийм нааштай санхүүжилтийн хэрэгсэл байгаа. Тэгтэл 2020 онтой харьцуулахад нийтдээ бондын санхүүжилт бол 24.2 их наядаар 2 дахин өссөн. Өөрөөр хэлбэл 2020 онд бол 65 тэрбум төгрөгийн бондын арилжаа хийгддэг байсан бол 2024 оны жилийн эцсийн байдлаар үндсэндээ 1 их наядын бондын арилжаа үүссэн. Зэрэгцээд бол бондын одоо жижиг дунд хэлбэрийн компаниудын хөрөнгө татдаг. OTC Market гэж бий. Өөрөөр хэлбэл биржийн бус зах зээлийг 2021 онд үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоотой санхүүгийн зохицуулахаар хамтарч хэрэгжүүлсэн. Энэ OTC Market дээр бол хаалттай хүрээнд шууд хөрөнгө оруулалт одоо хаалттай мэргэжлийн хөрөнгө оруулалтаас татаж бизнесээ санхүүжүүлдэг нийтдээ 150 гаруй үндэсний ААН-үүд, 3.8 их наядын санхүүжилтийг амжилттай татаж босгоод өөрийнхөө бизнесийг санхүүжүүлээд ингээд...

Д.Амарбаясгалан: Цэндийн Баатархүү гишүүн тодруулж асууя.

Ц.Баатархүү: Хөрөнгийн зах зээл дээр ингээд бас хөгжүүлэх чиглэл тэлэх чиглэлд ажиллаж байгаад баярлалаа. Ер нь энэ хөрөнгийн зах зээл гэдэг зүйлийг энэ УИХ, Засгийн газар бүх салбарт анхаарахгүй бол бид хоцорч байна аа. Төв Азийн улсууд руу шинэ үеийн технологийн бизнес эрхлэгчид нүүж байна. Өнөөдөр Монгол толгой компаниа байгуулах биш өөр улсад байгуулах юм бол илүү хөрөнгө мөнгө татна аа гэдэг ийм зорилгоор залуучуудын урсгал бол гадагшаа явах хандлага өндөр байна. Бид харин Монголд гаднын компаниуд үйл ажиллагаагаа явуулдаг, монгол компаниудад хамгийн таатай орчин бүрдүүлэх чиглэлд илүү их ойрхон хамтарч ажиллах шаардлага байна. Монголын эдийн засаг бол зөвхөн банкны зээлээс хамааралтай эдийн засаг бий болсон. Өнөөдөр бол хөрөнгө оруулагчид нь ирдэг, хөрөнгө оруулдаг ийм орчин соёлыг бий болгоё гэж байгаа. Тэгээд би Их Хурлын даргад бол албан ёсоор хэлмээр байна.

Энэ нэг топ 100 компани шалгаруулахдаа зөвхөн нэг татвар төлснөөр нь эрэмбэлмээргүй байна. Нээлттэй болж...

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн асуулт асууя, үг хэлье.

М.Бадамсүрэн: Энэ зээлийн өнөөгийн нөхцөл байдлын талаар нэг судалгаа байна аа. Тэгээд Монгол Улсын одоо нийт өрх айлын 65 хувь нь ямар нэгэн зээлтэй тэгээд иргэдийн дундаж өрийн хэмжээ бол 18 сая төгрөг, ипотекийн дундаж зээл үндсэндээ нэг дундаж нь 68 сая төгрөг тэгээд зарим тохиолдолд үүнээс илүү, тэгээд цахим зээлийн хэрэгжилтийн дундаж зээл 2.3 сая гэсэн ийм дүн байгаа. Тэгээд энэ дотроос нэг их анхаарал татаж байгаа нь энэ аппликэйшний зээл буюу одоо цахим зээлийн хүү сарын 6.1 хувь, жилийн 72 хувь. Тэгэхээр энэ зүйл дээр ер нь одоо цаашид бид энэ судалгаан дээр үндэслэж ер нь юунд анхаарч байгаа вэ гэдгийг Монгол банк, СЗХ-ноос асууя.

Хоёрт нь тогтоолын төслийн одоо боловсруулж байгаа ажлын хэсгийн ахлагчаас асуулт байна. Энэ бол цаашид хууль эрх зүйн орчинд ер нь ямар өөрчлөлт оруулах вэ гэдэг дээр бас хариулж өгөөч. Тэгээд одоо гол нь энийг цогцоор нь авч үзэх хэрэгтэй байгаа юм. 1 дүгээрт иргэдийн санхүүгийн боловсролыг яаж дээшлүүлэх вэ? Хүүхэд оюутан энэ дээр ер нь хандсан ямар бодлого арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа вэ? Мөн хоёрт нь өрийн дарамтад өртсөн иргэдэд зориулсан тийм дэмжлэгийн тусгай хөтөлбөрүүд ер нь Монголын төрд ер нь байна уу, байхгүй юу? Монгол банканд ийм одоо тусгай хөтөлбөр байна уу, байхгүй юу? Энэ одоо ингээд өрийн дарамтад орсон иргэд санхүүгийн боловсрол багатайгаас болоод энд одоо залилуулсан эсвэл энд өртсөн ийм хүнд байдалд орсон иргэддээ зориулсан ер нь ямар арга хэмжээг өнгөрсөн хугацаанд Монгол банк манай төр хэрэгжүүлсэн бэ? Энийг би одоо жирийн дундаж иргэдийг төлөөлж асууж байгаа юм.

Дараагийнх нь болбол энэ бизнесийн хувьд бол хамгийн гол тулгамддаг асуудал нь зээлийн хүртээмж дээр нь нэмэх нь хугацаа. Богино хугацаатай олгохоор ингээд үр дүн гарахгүй болчихоод байгаа юм. Тэгээд энэ хүрээндээ түрүүн бас зарим гишүүд хэллээ. Энэ төрөлжсөн банкнуудыг ер нь яаж байгуулах юм бэ? Хууль дээр байгаа. Одоо жишээлбэл Төрийн банкныг Хөдөөгийн хөгжлийг дэмжих банк болгох эрхтэй. Хөдөөгийн хөгжлийг дэмжих банк өмнөх нийгмийн үед байсан, хоршоо нэгдлийг дэмждэг байсан. Харамсалтай нь хувьчлагдаад тэгээд сүүлдээ нэр нь Хаан нэртэй болоод ингээд одоо бүүр өөр болоод явчихлаа л даа. Тэгээд одоо байгаа Төрийн банкны энэ сүлжээг ашиглаад сум болгонд нэгжтэй, хөдөөгийн хөгжил болбол эрсдэлтэй салбар учраас ХАА-н зээл гээд ингээд олон янз янзын тус тусдаа хөтөлбөр гаргаж байснаас энэ дээрээ төвлөрүүлээд ажиллах нь зүйтэй.

Мөн одоо энэ Үндэсний баялгийн сангийн хөгжлийн сангаас энэ жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжихэд зориулж эх үүсвэрийг жил болгон хуваарилдаг байхгүй бол ингээд нэг төсвөөс хараат байдалтай энд ерөөсөө мөнгө хуваарилагдахгүй болохоор энэ зээлийг шаталж олгож чадахгүй байна. Хүртээмж бага байгаа учраас чамд нэг удаа олгосон. Дахиад 3, 5 жилийн дараа дахиад олгохгүй ээ гэдэг ийм зүйл...

Д.Амарбаясгалан: Лхагвасүрэн Ерөнхийлөгч хариулт өгье.

Б.Лхагвасүрэн: Бадамсүрэн гишүүний асуултад хариулъя. Тэгэхлээр Монгол Улсад бол ерөнхийдөө бас хэдийгээр 12 банк байгаа, 3.5 сая хүндээ үйлчлээд ингээд тоогоор нь харах юм бол их юм шиг ингээд харагдаад байгаа юм. Гэхдээ яг бүтээгдэхүүн үйлчилгээ одоо тэр зээл авч байгаа байдал банкны үйлчилгээнд

хамрагдаж байгаа энэ байдлаасаа болоод одоо зээлийн хүртээмж бол муу байна аа л гэсэн зүйл байгаа юм. Тэгэхлээр хүртээмж муу байна гэдэг маань өөрөө зээлийн хүү өндөр байна аа л гэдэгтэй ингээд таараад явж байгаа юм. Тэгээд одоо таны хэлсэн 65 хувь нь зээлтэй байна гээд. Ер нь бол дэлхийн одоо эдийн засаг нь өндөр хөгжсөн санхүүгийн зах зээл өндөр хөгжсөн улсуудад бол энэ хувь хэмжээ нь бүүр энэнээс илүү байгаа. Ийм ч учраас тэр зээлийн оноо гэдэг зүйл гарч ирсэн. Ялангуяа ерөөсөө зээл авч байгаагүй хүн дээр бол оноо байхгүй, бүүр эрсдэлтэй ч гэж үзэгдэхээр ийм үнэлгээний дүн гарч явдаг.

Тэгэхлээр ямар нэг хэмжээгээр, тодорхой хэмжээгээр зээл аваад зээлийн карттай байдаг өөртөө оноо аваад явж байдаг ийм систем л одоо дэлхий нийтэд нэвтрээд явж байгаа учраас бидний хувьд бол энэ рүү нь чиглэсэн л арга хэмжээ аваад байгаа юм. Төрийн банктэй холбоотойгоор Төрийн банкиг цааш нь төрөлжүүлэх ялангуяа орон нутагт үйл ажиллагаа явуулдаг ч гэдэг юм уу ийм зүйлүүд бас ингээд яригдаж байгаа. Одоо сая сүүлд Засгийн газраас өгч байгаа мэдээллээр бол Төрийн банкиг бол ипотекийн банк болгохоор ингэж чиглүүлэх үйл ажиллагааг нь зохицуулахаар ийм бас санал гараад явж байх шиг байна. Тэр утгаараа бас явж байгаа.

Монгол банкны хувьд бол мэдээж олон улсын туршлагыг нэвтрүүлэх үүднээс бас ажиллаж байгаа. Германы Шпаркассе банктэй хамтраад шинэ төсөл хэрэгжүүлж эхлэхээр ярьж байна. Ялангуяа орон нутгийн гэсэн ийм жижиг банк Германд бол энэ хоршооллын банкнууд байдаг юм байна. Тэгэхлээр энэний туршлагыг яагаад орон нутагт байгаа эх үүсвэр нь хадгаламж нь тухайн орон нутагтаа байхаар дээр нь бас орон нутгийн удирдлагаас нь тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт хийгээд явах юм бол энэ орон нутгийнх нь банк нь санхүүжилтийн эх үүсвэртэй болоод эргээд орон нутгийнхаа иргэд ААН-үүдэд одоо санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ гаргахаар ийм олон улсын жишгийг бас нутагшуулах маягаар эхний төсөл одоо ингээд хэрэгжээд эхлэх гэж байна. Тэгэхлээр бол одоо түрүүчийн зөвлөхүүд нь ирж ажилласан. Дараа нь энийгээ бол нэлээн түлхүү ажиллуулахаар ингэж зорьж байгаа төв банкны зүгээс тийм.

Д.Амарбаясгалан: Соронзонболд гишүүн хариулт өгье.

Л.Соронзонболд: Бадамсүрэн гишүүний асуултад хариулъя аа. Ер нь ажлын хэсэг бол ажиллаад энэ хууль эрх зүйн орчинд бас нэлээд өөрчлөлт оруулах шаардлагатай юм байна аа гэж үзсэн. Тэгээд манай эдийн засгийн байгууллагаас томилогдсон ажлын хэсэг маань өөрөө энэ хаврын чуулганы хугацаанд ажлаа дуусгаж тайлагнах ёстой учраас бол эхний ээлжид Монгол банк болон СЗХ-той холбоотой энэ тогтоолын төслөө санаачилсан юмаа. Тэгээд хууль эрх зүйн хүрээнд болохоор бол ер нь одоо эх үүсвэрийн зардлыг бууруулах зорилгоор энэ харилцах болон хугацаагүй хадгаламжийн дансанд хүү, түүнтэй адилтгах төлбөр тооцохгүй байх талаар Банкан дахь мөнгөн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулъя.

Мөн гадаад валютын хадгаламжийг даатгалд хамруулахгүй байх, гадаадаас эх үүсвэр татах зорилгоор одоо энэ факторингээр олгосон санхүүжилтийг Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх, мөн зээлийн мэдээллийн сангийн хамрах хүрээг өргөжүүлж, зээлдэгчийн эрсдэлийг бодитой үнэлэх, зээлийн чанарын үнэлгээг сайжруулах зорилгоор даатгал, үнэт цаас, худалдаа арилжааны гэрээ хэлцлийн үр дүнд үүссэн зээлтэй холбоотой авлага, өглөгийн мэдээллийг Зээлийн

мэдээллийн сангийн тухай хуульд оруулъя гэх мэтчилэнгээр ингээд нэлээн хэдэн ийм хуулийн төслийг бол намрын чуулганаар ажлын хэсгийн гишүүд...

Д.Амарбаясгалан: Бадамсүрэн гишүүн тодруулж асууя.

М.Бадамсүрэн: Хүү өндөр байх нь иргэдэд дарамт болохоос гадна бизнес эрхлэхэд одоо зах зээлээ тэлэхэд нь асар их том сөрөг нөлөө үзүүлээд байгаа юмаа. Өөрөөр хэлбэл жишээлбэл өмнөд хөрш одоо ийм бага хүүтэй зээлээр бизнес эрхэлж байгаа хүмүүстэй Монголын бизнес эрхлэхэд яаж өрсөлдөх юм бэ? Тэгээд энэний цогцоор нь томоор нь ингээд энэ макро түвшний хувьд бүүр нэг томоохон цогц шинэчлэл хийхгүй бол ингээд болоод л байдаг юм гээд энүүгээрээ яваад байвал ингээд дахиад бид нар 100 жил явна. Тийм учраас энэ дээр зоригтой реформ хийх хэрэгтэй.

Хоёрт нь энэ жижиг, дунд үйлдвэрлэлийн сан гэдгийг санхүүгийн корпорац болгодог юм уу эсвэл тусад нь хараат бус тийм болгож одоогийн байгаа ЖДҮ санг зүгээр бичил сан болгоод ингээд ийм шатлаад явах хэрэгтэй. Хөдөлмөр эрхлэлтийн сан, бичил бизнесийн сан, тэгээд одоо санхүүгийн корпорац гэсэн байдлаар. Дээр нь ингээд энэ сая ахмадуудын тэтгэврийн зээлтэй холбоотой шийдвэр гаргалаа. Битгий ийм гэнэтийн шийдвэр гарга аа. Энийг одоо бүүр онцгойлон анхааруулж хэлье. Тэгээд ингээд тэрнээсээ буцах юм болбол тэгээд энэ чинь энэ шийдвэр чинь буруу байна аа гэдэг нь ингээд нотлогдож байгаа гэсэн үг байхгүй юу. Тэгээд өрийн дарамтад...

Д.Амарбаясгалан: Соронзонболд гишүүн хариулт өгье.

Л.Соронзонболд: Манай энэ УИХ-аас 2020 онд баталсан энэ 21 дүгээр стратеги зээлийн хүүг бууруулах стратегийн маань бол уул нь хүрээ нь бол нэлээн сайн гарсан. Дотроо одоо 47 даалгавартай. Энийг одоо Засгийн газар, Монгол банк, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын банкны холбоонд өгсөн юм байна лээ. Энэ дундаас бол Монгол банк, СЗХ, Монголын банкны холбоо бол яг өөрсдийн хүлээж авсан ажлуудаа бол 100 хувь хийсэн байсан. Засгийн газарт бол 27 даалгавар өгсөн. Үүнээс бол нэг тал хувийг нь бол хэрэгжүүлсэн. Ер нь бол өгөгдсөн даалгавар болгон нь бол тодорхой ажлууд хийсэн. Гэхдээ хамгийн гол нь тэр нь түрүүн Бадамсүрэн гишүүний хэлж байгаа яг эдийн засагт яг бодитой нөлөө үзүүлэхүйц тийм одоо ажлууд бол бас байж чадаагүй. Энд бол мэдээж цаана нь бол суурь эдийн засгийн нөхцөл байдал маань их нөлөөлөөд байгаа юмаа. Өөрөөр хэлбэл манай улсын эдийн засаг уул уурхайгаас хэт хамааралтай. Төсөв маань дотоодын нийт бүтээгдэхүүн өсөнгүүт дагаад бид нар тэлээд байна. Гадаад валютын албан нөөц минь хангалттай биш байна гээд яг бас нэлээн бодлогын хувьд ч, макро орчны хувьд Эдийн засгийн хөгжлийн яамнаас авах ёстой арга хэмжээнүүд, Сангийн яамнаас авах ёстой арга хэмжээнүүд бас байна аа гэж харж байгаа.

Д.Амарбаясгалан: Бадамсүрэн гишүүнд тодруулга өгье. Нэг минут.

М.Бадамсүрэн: Би нөгөө хүүхэд, оюутнууд, иргэдэд ер нь санхүүгийн боловсрол олгох чиглэлээр ямар ажил арга хэмжээ зохион байгуулж байгаа вэ гэдгийг 1 дүгээрт асуусан. Эндээ хариулт авч чадсангүй. 2 дугаарт нь энэ өрийн дарамтад өртөж болзошгүй эсвэл өртөж байгаа иргэдэд зориулсан тийм дэмжлэгийн тусгай хөтөлбөр гэж юм ер нь одоо Монголын төрд ер нь байна уу? Энэ яагаад энэ зүйлийг асуугаад байна гэхээр энэ иргэдээ соён гэгээрүүлэх, иргэдээ

мэдээллийн ил тод байдлаар хангах нь төрийн үүрэг байхгүй юу. Тэгээд энэ дээр ерөөсөө тийм дорвитой хийж байгаа юм бол харагдахгүй байгаад байгаа юм. Тийм учраас энэ зүйлийг одоо тусгайлан асуугаад байгаа юмаа.

Тэгээд ахмадуудын тэтгэврийн зээлтэй холбоотой асуудлаар ч гэсэн тэр. Тэгээд нэг газраас бичиг ирэхээр ингээд гэнэтийн шийдвэр гаргаж болдог юм уу? Ер нь цаашдаа ингэх юм уу? Дахиад ийм барих сюрприз ер нь Монгол банканд байна уу? Одоо чи үх гэвэл одоо юу билээ гал руу оръё гэвэл оръё гэдэг шиг ингээд нэг газраас санал ирэхээр нь шийдээд байх юм уу? Тэгээд дахиад нэг газраас санал ирэхээр нь болиод байх юм уу? Тэгээд энийг ер нь яаж тогтвортой явах юм бэ? Яаж ойлгомжтой энэ иргэдтэй болох юм бэ? Ахмадуудынхаа тэр тэтгэвэр...

Д.Амарбаясгалан: За хариулт өгье.

Б.Лхагвасүрэн: Бадамсүрэн гишүүний асуултад тодотгож хариулъя. 2016 оноос хойш иргэдийн санхүүгийн боловсрол гэдэг хөтөлбөрийг Монгол банк санаачлаад СЗХ, Сангийн яам, Соёл, боловсрол, шинжлэх ухааны яамтай ингээд хэрэгжүүлээд явдаг жил болгон. Мэдээж энэ нь өөрөө одоо хүүхэд багачууд, оюутан залуучууд, ахмад настан, залуу гэр бүл ч гэдэг юм уу ингээд тусгайлан хөтөлбөр гаргаад ингээд хэрэгжүүлээд явж байгаа юм. Тэгэхдээ Монгол Улсын санхүүгийн боловсрол бол олон улсын жишигтэй харьцуулахад бол сул бага хэмжээтэй байгаа учраас биднүүс бол илүү их ажил хийхийг шаардаж байгаа. Тэгээд энэний хүрээнд бол тодорхой ажлууд зохион байгуулаад явна аа гэдгээ бас Бадамсүрэн гишүүнд хэлье.

Өрийн дарамттай холбоотойгоор энэ нөгөө арилжааны банк маань өөрөө хувийн салбар. Тэгэхлээр хувийн салбар 2 одоо банк зээл олгохдоо гэрээ байгуулаад л хоорондоо хийж байгаа учраас тэр нь гэрээний харьцааны зохицуулалт болчихдог. Тэгэх дээр Монгол Улсад өнөөдөр байгаа байхгүй байгаа нэг эрх зүйн зохицуулалт бол тэр дампуурлын хэрэг буюу төлбөрийн чадваргүйдлийг тооцох гэсэн ийм асуудал байгаа юм. Тэгэхлээр...

Д.Амарбаясгалан: Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууя үг хэлье.

О.Цогтгэрэл: УИХ-аас зээлийн хүүг буулгах тийм ээлжит баримт бичиг гаргах гэж байна л даа. Одоо өмнө нь санаж байгаагаар зээлийн хүү бууруулах стратеги гээд мөрийн хөтөлбөрүүд дээр суусан сарын 1 хувь болгоно гээд баахан л бичиг цаас гардаг. Бодит байдал өөр л байгаа шүү дээ. Тэгээд Монгол банк нь одоо хариултыг сонсож байхад ер нь зээлийн хүү буурихгаар ч юм шиг л юм яриад байна л даа. Яг үнэндээ бодит байдал яг юун зээлийн хүү буух тухай биш яаж бага өсөх тухай наад нөхцөл байдал эдийн засгийн нөхцөл байдал чинь байгаа юм биш үү. Ер нь бодит үнэнээ бас энэ дээр бид нар ингээд тал талдаа ярьцгаавал яадаг юм? Одоо гишүүд ч гэсэн нэг л зээлийн хүү буух ёстойг буувал гоёйг бүгдээрээ мэдэж байна л даа. Энэ бодит байдал энэ эдийн засгийн нөхцөл байдал чинь энэ бодлогын үр дүнгүүд чинь одоо яг юу болчихоод байгаа билээ?

Ер нь энэ зээлийн хүү бууна гэдэг чинь тэр эх үүсвэр нь тогтвортой, эх үүсвэр нь хямд байх, доллар валютаа ордог байх, энэ улс орны чинь инфляц нь ядаж нэг оронтой тоонд байдаг байх. Нэг тогтвортойдуу байдаг байх. Ингэж байж нэг гадна дотнын банк нь орж ирдэг байх. Түүнээс одоо 2 оронтой инфляцтай оронд ямар одоо тийм нөхдүүд доллар валютаа авчраад, буцаагаад жилийн дотор 10, 20 хувиар

нь зөвхөн ханшийн алдагдлаас алдаад энэ оронд чинь тэр нийлүүлэлт эх үүсвэр гэдэг юм нөхцөл байдал тэр үнэндээ байхгүй л байна шүү дээ. Тэгээд байсан зах зээл дээр байсан жаахан мөнгийг нь төр төсвөө тэлээд, ТӨК-иуд хэлж байгаад бүгдийг нь булаагаад авчихдаг. Тэгээд нөхцөл байдал ийм байхад нэг ийм зээлийн хүү одоо буух гээд байгаа ч юм шиг нэг ийм зүйл тал талдаа зүгээр одоо яриад Монгол банк нь энийгээ бодит боломжтой юм шиг ярих биш харин эсрэгээрээ Монгол банкны зүгээс үнэхээр яг энэ танхимаас тэр шударга ёс чинь эхэлнэ гэдэг шиг энэ танхимаас та нар тэр нэг бодлогын асуудлаа яриач ээ. Бодлогын асуудлаа та нар наад төрийн зардлаа багасгаач ээ, бодлогын тогтвортой байдлуудаа бас хангаач ээ гэдэг энэ хууль эрх зүйн шинэчлэлүүдээ хийж өгөөч ээ. Яг энэ хэлсэн ярьсан дээрээ та нар байгаач ээ гэдэг зүйлийг л ярихгүй болбол одоо нэг ийм буруу хүлээлт буучихмаар ч юм шиг буруу хүлээлт л өгсөн ийм л ярианууд болж байна.

Яг үнэндээ УИХ-аас зээлийн хүү буулгах гэдэг шийдвэр гарах юм байна аа гэвэл бараг энэ чинь өөрөө төгрөгийн ханшийг унагаах нэг өөрөө нэг нөхцөл болно шүү ер нь. Энэ төгрөг өгөөжгүй болох юм байна. Нээрээ би доллар л авах ёстой юм байна. Эргээд долларын ханшаар чинь дамжаад нөгөө зээлийн хүү чинь харин жинхэнээсээ зээлийн хүү чинь өсөх бол одоо тийм хөшүүрэг энэний цаана гарч ирнэ ээ. Тэгэхлээр энэ дээр бас ер нь тэгээд бодит байдлыг хэлсэн үнэн үг өөрөө бас хүчтэй шүү дээ. Тэгээд Монгол банк та нар энэ мэргэжлийн байгууллагынх энэ УИХ-ын гишүүдийн бас хэт дур зоргын бид нарын энэ ярьдаг үгэнд заримд нь хязгаар тавиад бодит байдлаа энэ чинь боломжгүй ээ. Харин та нар тэр бодлогын шийдвэрүүдээ энэ төрөөс гарч байгаа энэ төрийн төсвийн энэ нэг данхар олон мега төсөл есөн жорын энэ нэг ийм дур зоргын шийдвэрүүдээ та нар болиоч ээ. Зах зээлд хувийн хэвшилд нь мөнгийг нь үлдээгээд...

Д.Амарбаясгалан: Нэг минут нэмж өгье. Цогтгэрэл даргад.

О.Цогтгэрэл: Тийм бодит үгийг та нар энэ яг одоо улс төрчдөд болоод олон нийтэд бодит байдлыг бас хэлбэл яадаг юм бэ? Яг одоо Монгол банкных нь энэ тогтоол шийдвэрийн дараа зээлийн хүүг буулгах боломжтой гэж та нар одоо итгэл үнэмшил та нарт ер нь байна уу? Үнэхээр итгэл үнэмшил та нар нэг яг бодит байдлаас үнэхээр итгэл үнэмшил байгаа. Зээлийн хүүг буурах боломжтой гэж бодож байвал би ч гэсэн яг үндэслэлийг нь бас сонсмоор байна. Үнэхээр яг одоо болбол тийм боломж бололцоо чинь байхгүй шүү дээ. Тэгэхээр энэ дээр та нэг байр суурь илэрхийлж өгөөч. Тал талдаа ингэж биеэ хуураад бол үнэндээ яах вэ дээ.

Д.Амарбаясгалан: Лхагвасүрэн ерөнхийлөгч хариулт өгье.

Б.Лхагвасүрэн: Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Энэ 2025 онд инфляцын түвшнийг одоо 8 хувь руу оруулах ийм зорилго бариад явж байна. Өнөөдөр бодлогын хүү 12 хувьтай байна. Энэ бол одоо 8 хувь гэсэн манай зорьж байгаа түвшнээс бол эерэг түвшинд ингээд өндөр байгаа. Тэгэхлээр бол одоо сая 5 сарын инфляцын дүн 8.3 хувьтай гарсан. Тэр нь манай зорилтын дээд хязгаар буюу 8-аас бол багахан өндөр байгаа юм. Тэгээд энэ зуны улиралд бол Монгол Улсын эдийн засгийн хувьд бол хамгийн идэвхждэг ийм хэсэг байгаа. Тэгэхлээр энэ идэвхжилийн хэсэг дээр бол бас мөн улирлын нөлөөгөөр инфляц буурч ирдэг. Энэ утгаараа бидний хувьд бол зорилтот түвшин рүү ороод ирэх байх аа гэж харж байгаа юм.

Тэгэхлээр хэрвээ 2025 ондоо инфляцынхаа түвшнийг зорилтот түвшиндээ хадгалж чадах юм бол бид өнгөрсөн онд одоо УИХ-аар мөнгөний бодлогынхоо үндсэн чиглэлийг батлуулж байхдаа дунд хугацаандаа буюу 2027, 2026 оноос инфляцын түвшнийг одоо өөрийнхөө зорилтыг 6 нэмэх хасах хоёрыгоо 5 нэмэх хасах 2 болгож доош нь бууруулахаар ийм зорилт ингээд тавиад явж байгаа. Тэгэхлээр мөнгөний бодлого хатуу хэвээрээ үргэлжилж байгаа нь одоо инфляцынхаа түвшнийг нам доор түвшинд барих л ийм зорилго.

Тэгэхлээр хэрвээ инфляцын түвшин манай зорилтот түвшний хэмжээнд орж ирэх юм бол бодлогын хүү өнөөдөр 12-оосоо цаашаа буух орон зай гарч ирнэ ээ л гэж харж байгаа юм. Тэгэхлээр ямар ч байсан зүгээр энэ 2025 оныхоо хувьд бол мэдээж хүлээлт байгаа учраас одоо бодлогын хүүн дээр бол одоо сая өөрчлөлт оруулсангүй. Сая 2 дугаар улирлын мөнгөний бодлогын хороо хуралдаад 2 дугаар улирлаа бол 12 хувиар нь хэв хэвээр нь хадгалсан. Хэрвээ оны төгсгөлд инфляц 8 хувийнхаа түвшний доор орж ирээд бидний зорилтот түвшинд байлгах юм бол 2026 оноос хойш бодлогын хүү бол доошоо буух орон зай бий болно оо. Тэгэхлээр 2026, 2027 онд хэрвээ бодлогын хүү доошоо буугаад ороод ирэх юм бол эх үүсвэрийн хүү доошоо бууна. Мөн зээлийн хүү буух орон зай нь байна аа гэж харж байгаа.

Өнөөдөр бол Монгол Улсын одоо валютын нөөц 2.5 тэрбум доллар байна. Одоо бас Хөгжлийн банк 350 сая доллар оруулж ирж байгаа. Тэгэхлээр ингээд 5.5 буюу одоо оны өмнө байсан түвшин рүүгээ очих гэж байгаа юм. Тэгэхдээ энэ бол одоо өнөөдрийн түр зуурын тоо л гэж харж байгаа. Тэгэхлээр бол хамгийн гол экспортын бүтээгдэхүүн нүүрсэн дээр байгаа одоо төвөгтэй байдал арилах юм бол энэ ондоо бол ер нь бол эдийн засаг эргээд хэвийн хэмжээндээ очих боломжтой. Эдийн засгийн өсөлтийг бол Монгол банк энэ онд бол 5-6 хувийн өсөлттэй гарах байх гэсэн төсөөлөлтэй байгаа. Тэгэхлээр макро эдийн засгийн орчны хувьд бол одоо зөвхөн нүүрснээс бусад хэсэг дээрээ бас хэвийн байх боломж нь байна аа л гэж харж байгаа юм.

Д.Амарбаясгалан: Цогтгэрэл гишүүн тодруулж асууя.

О.Цогтгэрэл: Яах вэ тэгээд Монгол банкны ерөнхийлөгч зах зээлд сөрөг биш хүлээлт өгөх зорилго байдаг байлгүй дээ. Тэгээд бодит байдал дээр наад экспортын орлого олон зүйлүүдийг чинь харахад ханш өөрөө төвөгтэй, инфляц та нар 9 аравны хэдэн хувь гээд тавьчихсан. Үнэндээ 2 оронтой тоонд орох нь тодорхой болчихсон. Та нар бараг л 9.99 гэхдээ хүрээд нэг тоо тавьчихсан. Бодлогын хүүгээ одоо сүүлийн шийдвэрээрээ та нар нэмээд нөхцөл байдал одоо ийм байгаа л даа. Тэгээд танилцуулгыг харахад жигнэгдсэн дундаж хүү 15 билүү 6 билүү гэж байна лээ. Тэгэхдээ энэ жигнэгдсэн дундаж хүүд чинь та нар 6 хувийн ипотекийн зээл энэ хөнгөлөлттэй зээлүүд, энэ есөн жорын бүх зээлүүдээ нэмж байгаад л дунджийг нь гаргаад банк бус болоод тэр бусад өндөр хүүнүүдийг хасаж байгаад тэрэндээ 6 хувийн хүү нэмж байгаад нэг жигнэсэн дундаж гээд багадуу юм тавьчихсан нь яг бодит байдал тэр бизнесийн хэрэглээний иргэдийн зээлийн чинь дундаж болбол асар өндөр л байгаа шүү дээ. Гэтэл нөхцөл байдал чинь улам дордож байна. Бодит эдийн...

Д.Амарбаясгалан: За санал хэллээ. Болдын Жавхлан гишүүн асуулт асууя.

Б.Жавхлан: Лхагва эрхлэгч ээ, би та хэдийн яг институцийн хувьд нөгөө бодлогын хэв шинжийг чинь л дэмжиж үг хэлэх гээд байна шүү. Одоо бодлогын хүү

чинь 12 хувь, инфляц 8-аас дээш байгаа, 9 орчим байгаа. Ийм үед сая та хэд маань хуралдаад бодлогын хүүгээ хэвээр нь хадгалаад өөрөөр хэлбэл мөнгөний бодлогынхоо хатуу төлөвийг хэвээр нь хадгалсан. Зээлийн хүү бууруулна гэж байгаа Соронзонболд гишүүн ээ, зээлийн хүү буурахгүй байгаа зээлийн хүү өндөр байгаад байгаа хамгийн том суурь шалтгаан чинь ерөөсөө л инфляц шүү дээ. Өөр юм юу ч биш. Тэгээд энэ макро ийм дисбаланс үүсчихсэн ийм үед энэ одоо зээлийн хүү өндөр байгаад байгаа юм. Яах вэ ийм захиргааны механик ийм арга хэмжээнүүд нөлөө багатай. Бид нар инфляцаа буулгаж байж л аяндаа энэ зах зээл чинь өөрөө өртгөө бууруулаад ирнэ. Зээлийн хүү өөрөө аяндаа бууруулаад ирнэ. Ийм өндөр бодлогын хүүтэй инфляц суурь өөрөө ийм өндөр байгаа үед ямар ч хүчээр ийм механик захиргааны арга хэмжээ аваад үр дүн гарахгүй байхгүй юу.

Энийг одоо яг энэ арга хэмжээнүүдийг аваад энүүний үр дүнд одоо зээлийн хүү тогтвортойгоор одоо хэдэн хувь буурах вэ ч гэдэг юм уу тийм ээ зорилтот түвшингээ бас тооцсон зүйл байгаа юу? Лхагваа ерөнхийлөгч энэ дээр юу гэж бодож байна? Одоо жишээ нь ингээд сая ингээд та нар бодлогын хүүгээ буулгаагүй мөнгөнийхөө хатуу төлөвийг үргэлжлүүлнэ ээ гэхсэн. Тэгтэл энэ дотор чинь буцаагаад зөөлрүүлэх арга хэмжээнүүд орж ирж байна шүү дээ. Хар аа, энэ нөөцийг чинь багасга гэж, нөөцөө багасга гэж байна, харьцааг нь багасга гэж байна. Свопынхоо өртгийг зардлыг нь бууруул гэж байна. Бүүр ингээд зээлийн хүүгийн тааз тогтоох юм байна. Өөрөөр хэлбэл нөгөө нийлүүлэлтийг чинь дэмжих гээд байна шүү дээ. Зээлийг чинь дэмжих гээд байна. Гэтэл та нар чинь бодлогын хүүгээ өндөр тавиад зээлээ хумиад байгаа.

Дээрээс нь сая бүүр ингээд яг хатуу төлөвтэйгөө бүүр харшийн харш тэтгэврийн зээлээ ингээд сул тавьчихлаа. Тэтгэврийн зээл корпор зээлтэй чинь харьцуулахад хэд дахин бага нь үнэн. Гэхдээ инфляцад нөлөөлдөг хүч нь хэд дахин илүү хүчтэй. Тэрнийх чинь үр дүнд ингээд сүүлийн 2, 3 сар уг нь ингээд инфляц чинь ингээд нам доор гарч ирээд та бодлогын хүүгээ одоо яваандаа буулгах ийм орон зай бий болж байна гэж байгаа. Тэр үр дүн чинь тэндээс гарч ирж байгаа шүү дээ. Одоо буцаагаад тавьчихаар чинь ойрын хугацаанд та нар бодлогын хүүгээ буулгах ямар ч орон зай гарч ирэхгүй. Уг нь бид нар төсвийн тодотгол хийж байгаа чинь мөнгөний бодлогын хатуу төлөвтэй уялдуулж маш их олон үйл ажиллагаагаа татааж хумиад, энэ одоо сайд нар ямар хүнд байдалд орж байна энэ үйл ажиллагаагаа жилийн дундуур хумиад энэ бол одоо мөнгөний бодлогын хатуу төлөвтэй нийцүүлж байгаа төсвийн бодлого байхгүй юу.

Гэтэл ингээд зарим юунаасаа ингээд ухрах гээд байгаа чинь хэр нийцтэй вэ? Яг мөнгөний бодлогынхоо хатуу төлөвөө хадгалахтай чинь ингээд нөгөө агрегатууд чинь эсрэг хөдлөөд байгаа юм биш үү? Уг нь тэр юуны тэтгэврийн зээл чинь болбол нэг л одоо бодлогын хэрэгсэл шүү дээ. Уг нь хатуу төлөв рүүгээ шилжүүлчихсэн байсан юм. Мөнгөний бодлогыг чинь бодлогын хүүг чинь бодох юм болбол хамгийн өндөр эффе́кттэй богино...

Д.Амарбаясгалан: Жавхлан гишүүнд нэг минут нэмж өгье.

Б.Жавхлан: Уг нь тэрнээсээ ухрамгүй л байсан юм. Тэр чинь ингээд бодлогын хүү өндөр байна, энэ чинь ингээд хэдэн сарын хугацаатай нөлөөллүүд нь ингэж удаан явдгийг та бүхэн маань хамгийн сайн мэднэ. Одоо яг макро пруденшил энэ арга хэмжээнүүд чинь маш богино хугацаанд үр дүнтэй явдаг ийм арга хэмжээнүүд шүү дээ хэрэгслүүд. Тэгээд энийгээ нэг жоохон ухрах гээд байгаа чинь жоохон

тиймхэн л санагдаад байна. Тэгээд үнэхээр одоо яг бодлогын хүүгээ буулгах тийм орон зай нь бий болчихсон юм уу? Надад бол бас тэгж харагдахгүй байгаад байгаа шүү. Тийм ч учраас одоо төсвийн бодлогоо мөнгөний бодлоготой нийцүүлж ингэж бид маш их олон үйл ажиллагаагаа золиосолж, одоо хэмнэлтийн горим руу ингээд шилжиж байгаа шүү. Энийг бас бодолцоорой. Тэгээд өөрөөр хэлбэл энэ бодлогынхоо төлөв дээр хатуу байсан нь л дээр дээ л гэж хэлэх гэсэн юм. Хариулах зүйл байвал хариулна биз дээ тийм.

Д.Амарбаясгалан: Лхагвасүрэн ерөнхийлөгч хариулт өгье.

Б.Лхагвасүрэн: Тийм. 2024 оны 10 сард 2025 онд хэрэгжүүлэх Мөнгөний бодлогын үндсэн чиглэлийг бол Монгол банкнаас өргөн бариад Их Хурлаас ингээд батлуулаад явсан байгаа. Тэрэн дээр бол яг хэлэлцэж явж байхад бол Их Хурлын гишүүдээс гарч байсан санал нь бол бизнесийнхээ зээлийг түлхүү олгооч, хэрэглээнийхээ зээлийг бол хумих тал руу нь хатуу бодлого явуулах ёстой гэдгээрээ ингээд ер нь бол хэрэглээний зээл дээр өнөөдрийн авч байсан арга хэмжээнүүд бол зориод явсан. Тэрэн дотор нь бол одоо ингээд тэтгэврийн зээл бол цалин барьцаалсан зээл, хадгаламж барьцаалсан зээлтэй адилхан хэлбэрийн гэдгээрээ хэрэглээний зээлийн шаардлагад ороод явсан. Тэгээд өнөөдрийн үүссэн нөхцөл байдал нь төвөгтэй байгаа.

Дээр нь олон улсад байдаг жишгийн дагуу бол тэтгэврийн зээл гэдэг бүтээгдэхүүн бол ер нь байдаггүй гэдгээр нь ер нь Монгол банк бол энэ дээр зохицуулалт хийх шаардлагагүй юм байна аа гэж харсан. Ер нь бол тэтгэврийн зээл дээр авсан арга хэмжээ маань өөрөө ямар үндэслэлтэй байсан бэ гэхлээр нийт хэрэглээний зээл өнгөрсөн онд дунджаар 33 хувиар өссөн байгаа. Тэрэн дотроо тэтгэврийн зээлийн өсөлт нь өөрөө 47 хувь буюу жилийн дотор 50 хувиар өссөн ийм зүйл байсан учраас бол хамгийн өндөр өсөлттэй ийм хэсэг дээр нь арга хэмжээ бол ер нь анх түрүүлж л авч эхэлсэн л дээ. Тэгээд энэ нь бол өөрөө ингээд өнөөдрийн нөхцөл байдлаар одоо арай өөрчлөгдөөд явахаар ингээд болж байгаа юм.

Бидний хувьд бол одоо энэ ажлын хэсэгтээ бол мэдээж санал зөрөх асуудлууд бол байсан өөрийн Монгол банкны байр сууриа бол хэлээд явж байгаа. Гэхдээ бол энэ маань зээлийн хүү бууруулах стратеги. Стратеги бол өөрөө дунд хугацаандаа буюу одоо 3-5 жил хэрэгжихээр биднүүс ингэж харж байгаа учраас одоо өнөөдрийн орж ирж байгаа энэ төслүүд дээр энэ дээр бол тодорхой хугацааны дараа тодорхой арга хэмжээ авч, үр дүн гарах боломжтой гэдгээрээ л бас байр суурь бол тийм ойлголцсон маягийн байр суурьтай байгаа. Тийм.

Д.Амарбаясгалан: За тогтоолын төсөл орж ирээд хэлэлцэгдэж байгаа. Тэгээд яах вэ энэ хүрээнд Монгол банкны ерөнхийлөгч бас гишүүдийн асуултад хариуллаа. Тэгээд сая бас Жавхлан сайд ч хэлж байна. Одоо энэ өр орлогын харьцаатай холбоотой асуудлаа хэдхэн сарын дотор ингээд дахин дахин өөрчлөлт хийгээд байдаг. Анх өр орлогыг 50, 50 руу явуулж байх үедээ инфляц хөөрөгдөхгүй, ханш алдахгүй гэсэн том зорилго тавиад шийдвэр гаргаж байсан бол хэдхэн сарын дараа буцаагаад шийдвэр гаргаж байгаа байдал энэ тэр болбол байж болохгүй л зүйл болж байна л даа.

Тэрнээс манай банкны салбар болбол богино хугацаатай өндөр хүүтэй хэрэглээний зээл дээр явж байх сонирхолтой. Урт хугацаатай, хүү багатай хөрөнгө оруулалтын зээл өгөх юм дээр бас аль аль талдаа ийм сонирхол багатай, богино

хугацааны өндөр ашгийг л их боддог ийм л салбар болчихсон байгаа. Бусад орнуудын жишээг харахад хүү харьцангуй бага, гол нь урт хугацаатай зээл олгодог байх тэр боломжийг эрэлхийлдэг. Манай Монголд ерөөсөө байдаггүй. Одоо малчны зээл гэж маш том загвар байна шүү дээ. Нэг жилийн хугацаатай, 24 хүртэл хувийн хүүтэй зээл авдаг. Жилийн дотор банкны мөнгийг 24 хувиар өсгөж өгөхийн төлөө малаа маллаж амьдардаг ийм л ажил хийж байгаа юм. Хүн чинь ажил хийвэл уул нь цалин авдаг хөлс авдаг. Манай малчид ажил хийснээрээ хүү төлдөг ийм л байдалтай болцгоочихсон.

Тэгээд одоо нэг бодлогын хүү бас нэг ААН, бизнес эрхлэгч иргэдэд ээлтэй байх тэр нөхцөл боломжийг урт хугацаанд жоохон тогтвортой байлгахын төлөө энэ нэг өр орлогын харьцааг бас нэг бодлого нь, шийдвэр нь тогтвортой байж иргэд нь зөвхөн хэрэглээний зээл нь төлөгдсөн ард түмэн байлгахгүйн төлөө Монгол банк одоо энэ мөнгөний бодлогоо чиглүүлж ажиллаж байх учиртай шүү дээ.

Өнөөдөр Засгийн газраас төсвийн тодотгол оруулж ирээд л төсөв тодотгоод л асуудлаа яг шийдвэрлэж байгаа үе дээр бас одоо өр орлогын харьцаатай холбоотой хэрэглээний зээлийг еще илүү олон төрлөөр нь өгөх бодлогыг хэрэгжүүлэх ийм шийдвэрийг бас Монгол банк гаргаад сууж байгаа нь энэ бодлогын асар том зөрүү биш үү. Засгийн газар нь тодотгол хийе, элдэв 7 зардлуудаа хэмнэе, таная гээд сууж байтал нөгөө талдаа бас энэ өр орлогын харьцааг ингэж өөрчилж байгаа шийдвэр өөрөө тийм зөв шийдвэр юм уу, буруу юм уу. Энэ дээр одоо Монгол банк мөнгөний бодлогын зөвлөл шийдвэр гаргахдаа олон талаа бодож гаргаж баймаар байна аа. Тэгээд Монголын ард түмнээр одоо ингээд жилийн дотор 2, 3 удаа шийдвэрээ өөрчилж тогтворгүй байдлаар ард иргэдийн амьдралд сөрөг нөлөө үзүүлдгийг бол таслан зогсоох хэрэгтэй гэж ингэж хэлмээр байна.

За тэгээд өнөөдөр гишүүдийн үг хэлж байгаа байдалтай холбогдуулаад дээрээс нь Байнгын хороогоор хэлэлцэгдээд гарч ирсэн тогтоолын төсөл дээр бас тодорхой хуулийн зөрчлүүд бас байна аа. Монгол банк болбол тусгай хуулиар үйл ажиллагаагаа явуулдаг, хараат бусаар үйл ажиллагаагаа явуулах чиг үүргийг хэрэгжүүлдэг ийм байгууллага. Өнөөдрийн тогтоолын төсөл дээр бас зарим дотоод ажил зохион байгуулалтыг нь УИХ-ын тогтоолын төслөөр зааж чиглүүлж байгаа ийм зүйл бас энэ заалтууд дээр байна. Тийм учраас УИХ-ын дэгийн тухай хуулийн 45.4-т зааснаар нэгдсэн хуралдаан шаардлагатай гэж үзвэл уг асуудлыг дахин хэлэлцүүлэхээр холбогдох Байнгын хороонд буцааж болно оо гэсэн энэ заалт байгаа.

Тэгэхээр энэ заалтын дагуу Байнгын хороонд буцаалаа. Тэгээд ирэх 7 хоногийн 2 дахь, 3 дахийн чуулганы хуралдаанаар дахин оруулж ирж хэлэлцүүлж эцэслэн батална аа гэдгийг хэлье ээ.

20:06

Д.Амарбаясгалан: Дараагийн асуудалд оръё.

Бусад асуудлыг алгасаад хамгийн сүүлийн асуудлыг хэлэлцээд өнөөдрийн чуулганыг өндөрлүүлнэ.

Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсоно.

Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3-т УИХ Энэ хуулийн 46.1.2-т заасан хууль тогтоолын эцсийн найруулгатай танилцаж ёсчлохыг зөвшөөрөх гэж заасны дагуу тогтоолын эцсийн найруулгыг Байнгын хороод бэлтгэж УИХ-д танилцуулахад бэлэн болсон байна.

1.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүд байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Дагалдан гарсан Захиргааны ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

3.Монгол УИХ-ын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

4.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний УИХ-ын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

1.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Дагалдан гарсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Ногоон санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх эрх зүйн орчныг сайжруулах талаар авах арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай УИХ-ын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? За эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Монгол Улсын 2024 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай УИХ-ын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Хянан шалгах түр хороо байгуулах тухай УИХ-ын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул чуулганы хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

19.35 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА